



Европын Холбоо  
санхүүжүүлэв



Food and Agriculture  
Organization of the  
United Nations  
НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага



Олон Улсын  
Хөдөлмөрийн  
Байгууллага



**“Монгол Улсад Тогтвортой Хөгжлийн Зорилттой уялдсан төсвийн төлөвлөлтөөр  
хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төсөл**

## **Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын үнэлгээний шалгуур, аргазүй**

Зөвлөхийн тайлан

2022 оны 12 дугаар сар

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АМЛ	Ажил мэргэжлийн лавлах
АМС	Ажил мэргэжлийн стандарт
АХБ	Азийн Хөгжлийн Банк
БАЗТ	Бүсийн аргагүйн төв
БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэлийн Үндэсний зөвлөл
БШУЯ	Боловсрол, Шинжлэх Ухааны Яам
ГХАН	Германы Хамтын Ажиллагааны Нийгэмлэг
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕХ	Европын Холбоо
КОЙКА	БНСУ-ын Засгийн газрын олон улсын хамтын ажиллагааны агентлаг
МАОЭНХ	Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо
МБС	Мэргэжлийн боловсрол, сургалт
МБСБ	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага
МБСҮЗ	Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл
МБСҮМАЗТ	Мэргэжлийн боловсрол, сургалтын Үнэлгээ, мэдээлэл, аргагүйн төв
МҮХ	Мэргэшлийн үндэсний хүрээ
МСС	Мянганы Сорилтын сан
МСҮТ	Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв
МҮХАҮТ	Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ТМБССД-1	Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын салбарыг дэмжих төсөл-1
УИХ	Улсын Их Хурал
ҮМТТ	Үндэсний мэргэшлийн түвшний тогтолцоо
ҮМТШС	Үндэсний мэргэшлийн түвшний шатлалын систем
ХНХСҮСИ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт
ХНХЯ	Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам
ЧДБ	Чанарын дотоод баталгаажуулал
ЧСС	Чадамжид суурилсан сургалт
ШХА	Швейцарийн Хөгжлийн Агентлаг
ЮНЕВОК	НҮБ-ийн Мэргэжлийн Боловсролын Олон Улсын Төв
ЮНЕСКО	НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллага

## ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны тайланг НҮБХХ-ийн “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих төсөл” (SDG-Aligned Budgeting to Transform Employment in Mongolia project, UNDP)-ийн захиалгаар МБС-ын чанарын баталгаажууллын шалгуур, механизмыг сайжруулах зөвлөмж боловсруулах ажлын хүрээнд бэлтгэсэн болно.

Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт улсын төсвөөс зарцуулах хөрөнгийн хэмжээ тасралтгүй нэмэгдэж, хөгжлийн түнш хандивлагчдын тусламж дэмжлэгтэй томоохон хөтөлбөрүүд хэрэгжүүлсэн ч суралцагчдын тоо төдийлэн өсөхгүй, төгсгөгчдийн ажил эрхлэлт бага бөгөөд тогтворгүй, МБСБ-ын удирдлага, бүрэлдэхүүнд олон удаагийн өөрчлөлт орж, шинэ мэдлэг таниулж, чадавхи бүрдүүлсэн хүчин чармайлт үр дүнгүй болсон шинжтэй байна. Ийнхүү Монгол Улсын төр засаг, түүний хөгжлийн түншүүд мэргэжлийн боловсрол, сургалтын үр өгөөжийг дээшлүүлэх хүчин чармайлт, хөрөнгө зардлыг тууштай нэмэгдүүлж байгаа боловч ажил хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, чадамжтай хүний нөөц бүрдүүлж чадахгүй байгааг энэ салбарын үйлчилгээний чанар, түүний баталгаажууллын механизмын үр дүнтэй холбон үзэхээс аргагүй юм. Нөгөө талаас Монгол Улсын эдийн засаг дэлхийн хамтын нийгэмлэгтэй интеграцчилагдаж, глобал зах зээлийн оролцогч болсон тул иргэдийн мэдлэг, ур чадвар нь глобал эдийн засагт өрсөлдөх хэмжээнд байж зориулалтын шаардлагаа хангах учир боловсрол сургалтын талаар баримтлах бенчмарк нь олон улсын жишиг байх шаардлагатай болж байна.

### Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын баталгаажуулал

Чанарын баталгаажуулал нь МБС-ын үндсэн зорилгын хэрэгжилт, үр дүнд хүрэх үйл явцыг үнэлж, шаардлагатай тохиргоо хийж, удирлагын шийдвэрийн үндэслэлийг сайжруулах цогц систем болно. Энэ нь сургах, суралцах процессийн үр дүнг сайжруулах аливаа бодлогын санаачилга нь чанарын талаар үндэсний хэмжээний дэмжлэгийг хүлээсэн тогтвортой бодлоготой байхад үйлчилнэ. Чанарын баталгаажууллын үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлсэнээр МБС-ын үйл ажиллагааг олон нийтэд ил тод болгож, оролцогч талуудын итгэлцлийг бататган, хамтын ажиллагааг идэвхижүүлж, нэр хүндийг бэхжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Монгол Улсын мэргэжлийн боловсрол сургалтын хүрээнд чанарын стандартыг хэрэгжүүлэх процесст чанарыг баталгаажуулах ажил эрх бүхий төрийн захиргааны байгууллагын тусгай зөвшөөрөл, хяналт шалгалт, магадлан итгэмжлэл, аттестатчилал, аудит зэрэг олон арга хэрэгслээр хөндлөнгийн үнэлгээгээр хэрэгжиж байгаагийн зэрэгцээ сургалтын байгууллагууд өөрөө дотооддоо чанарын баталгаажууллын чадавхи, тогтолцоо бүрдүүлэх үйл явц өрнөж байна. Хөндлөнгийн үнэлгээ нь сургалтын байгууллагын өөрийн үнэлгээнд суурилж, үүнтэй уялдаа холбоотой явагдах нь бодит шаардлага юм. МБСБ-ууд сүүлийн жилүүдэд чадамжид суурилсан хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, Сингапурын Темасек сан, Сингапурын Политехник коллеж, ГХАН-тэй хамтран боловсруулсан *чанарын баталгааны тогтолцоо*ны аргазүйг эзэмшихэд суралцаж, олон улсын чанарын удирдлагын ISO серийн стандартуудаас сонгон туршиж нэвтрүүлэх алхмуудыг эхлүүлсэн байна. Эдгээр нь бүгд үзэл баримтлал, зохион байгуулалт, аргачлалын хувьд ижил төстэй, чанарын иж бүрэн удирдлага – PDCA (*Төлөвлө – Хэрэгжүүл – Үнэл – Сайжруул*) мөчлөгт суурилсан тул өөр хоорондоо зөрчилдөхгүй, харин ч сургалтын байгууллагын санаачилга, идэвхи сонирхол, өөрийн онцлогт тохируулан нутагшуулах хүсэл эрмэлзлээс үүдэлтэй тул дэмжин урамшуулах нь зүйтэй байна.

Монгол Улсын МБС-ын хүрээнд чанарыг баталгаажуулж буй өнөөгийн практик, эрхзүйн зохицуулалт, хандивлагчдын дэмжлэгтэй хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд сүүлийн жилүүдэд олон улсын болон үндэсний зөвлөхүүдийн боловсруулж санал болгосон чанарын баталгаажуулалтын тогтолцооны загвар, олон улсад өргөн хүрээнд хүлээн зөвшөөрч нийтлэг жишиг болгож буй ЕХ-ны ЧБНК-ийг харьцуулан шинжилсэний үндсэн дээр манай орны мэргэжлийн боловсрол, сургалтын хүрээнд чанарыг баталгаажуулах эрхзүйн зохицуулалтыг дараах хүснэгтэд үзүүлсэнээр тодотгон шинэчилбэл зохистой гэж үзэж байна.

Өнөөдөр Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг БШУЯ бэлтгээд байна. Энэ төсөлд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн үндсэн үзэл баримтлалыг цаашид үргэлжлүүлэх чиг баримталсан гэж харагдаж байна. Иймд 2009 оны хууль хэрэгжсэн хугацаанд хуримтлагдсан туршлага, сургамжид үндэслэн МБС-ын үр өгөөжийг дээшлүүлэх чанарын баталгаажууллын тогтолцоог бэхжүүлэхэд дараах саналыг анхааран үзэхийг зөвлөж байна.

**ЗӨВЛӨМЖ 1:** МБС-ын Үндэсний зөвлөл нь МБС-ын удирдах дээд байгууллага байх статусыг бүрэн баталгаажуулж, хөгжлийн бодлогыг тодорхойлох, жишиг шаардлага, стандартыг тогтоох, нийтлэг зохицуулалт хийх, МБС-ыг дэмжих санг удирдах чиг үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхийг олгох; МБС нь иргэдэд насан туршдаа мэдлэг, ур чадвараа баяжуулан шинэчилж, ахиулан хөгжүүлэхэд нь нийцсэн уян хатан, олон хувилбартай байх; чадамжид суурилсан боловсролын зарчимд нийцүүлэн иргэдийн эзэмшсэн ур чадварыг үнэлэн баталгаажуулах хараат бус, хүртээмжтэй үнэлгээний систем бүрдүүлэх, удирдлага, чанарын баталгаажууллын бүх шатанд мэргэжлийн олон нийт, ажил олгогчдын оролцоог бодитой, үр нөлөөтэй болгох эрхзүй, эдийн засгийн механизм бий болгох зохицуулалтыг тусгах. Ажил мэргэжлийн тодорхойлолт нь МБСБ-аас харгалзах МБС-ын хөтөлбөрийг боловсруулахад баримтлах албан ёсны үндсэн баримт бичиг байхаар албажуулах. МБСҮЗ-ийн ажлын алба нь МБС-ын асуудал эрхэлсэн салбар дундын агентлаг хэлбэрээр 2012 оныг хүртэл ажиллаж байсан практикийг сэргээх боломжийг засгийн газар, ажил олгогчид, хувийн салбарын төлөөлөлтэй хэлэлцэн зөвшилцөх.

МБС-ын чанарын баталгаажууллын эхлэлийн цэг нь чанарыг илэрхийлэх жишиг буюу иргэдийн эзэмших мэргэжлийн мэдлэг, ур чадвар, чадамжийг тодорхойлсон мэргэшлийн стандартыг албажуулан баталгаажуулахтай холбоотой.

**ЗӨВЛӨМЖ 2:** Хөдөлмөрийн хуульд *“17.1. Ажил мэргэжлийн үндэсний ангилал, тодорхойлолт, ажил мэргэжлийн стандартыг батлах, мэргэшлийн түвшнийг тогтоон хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах үйл явц мэргэшлийн үндэсний хүрээнд хамаарна”* гэсэн нь үндсэндээ ЧБ-ын хүрээг тодорхойлсон байгааг нэг мөр ойлгож хэрэглэх, харин мэргэшлийн шатлалыг тодорхойлсон баримт бичгийг улсын хэмжээнд боловсролын бүх салбарыг хамруулсан үндэсний мэргэшлийн түвшний шатлалын систем (ҮМТШС) гэх агуулгаар батламжлан албажуулахыг Засгийн газарт, үүнд үндэслэн МБС-ын стандартыг боловсруулж, баталгаажуулах бүрэн эрхийг МБСҮЗ-д, эдгээрт нийцүүлэн техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөрийн боловсруулахад арга зүйн удирдамж зөвлөмжөөр хангах үүргийг БАЗТ, мэргэжлийн сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийх үүргийг мэргэжлийн холбоодод хариуцуулах. Мэргэжлийн мэдлэг, ур чадварыг эзэмшсэн арга хэлбэрээс нь хамааралгүй үнэлж баталгаажуулах ажлыг мэргэжил аргагүйн удирдлагаар хангах үүргийг БҮТ-д шилжүүлж, сургалтын хөтөлбөрөө боловсруулахад МБСБ-ын мэргэжлийн санаачилга, эрх чөлөөг хүндэтгэхийн хамт үр дүнг нь хариуцах үүрэг хариуцлагыг тодотгон журамлах. БАЗТ-ийг чиг үүргийн

адил төстэй бөгөөд уялдаа холбоотой байдлыг харгалзан БСҮХ-нд харьяалуулан бэхжүүлбэл боловсролын бүх түвшинд иргэдийг хөдөлмөрийн харилцаанд бэлтгэн, насан туршийн боловсролын үйлчилгээнд хамруулахад баримтлах аргагүйн нэгдмэл удирдлага хангагдана.

Сургалтын байгууллагын Удирдах зөвлөлийн чиг үүрэг, эрх мэдлийг бодитой, нөлөөтэй, хариуцлагатай болгосноор хөгжлийн бодлогын тогтвортой байдлыг хангаж, МБСБ-ын түвшинд чанарын баталгаажууллыг хэрэгжүүлэх мөчлөгийг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

**ЗӨВЛӨМЖ 3:** МСҮТ, Политехник коллеж, тэдгээртэй адилтгах хэв шинжийн МБСБ-ийн Удирдах сургуулийн хөгжлийн стратегийг тодорхойлох, түүнд нийцүүлэн үйл ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгө оруулалт, санхүүжилтийг хуваарилах, сургуулийн менежментийн бүтэц зохион байгуулалтыг чанарыг баталгаажуулах зорилттой уялдуулан оновчтой тогтоох, хөгжлийн болон үйл ажиллагааны зорилт, түүний хүрэх түвшний үзүүлэлтийг чанарын үзүүлэлттэй холбон баталж, хэрэгжилт, үр дүнд хяналт тавихад мэргэжлийн туслалцаа үзүүлэх.

Чанарын баталгаажууллын тогтолцооны бүрдэл хэсгүүдийн чиг үүргийг санал болгож буй бүдүүвчид тусгаснаар хуваарилж, холбогдох зохицуулалтыг хууль тогтоомж, бусад баримт бичигт тусган албажуулж, эдгээр чиг үүргээ гүйцэтгэхэд шаардагдах дэмжлэгийг хандивлагчидтай хамтран зохион байгуулах нь зүйтэй байна.

**ЗӨВЛӨМЖ 4:** МБС эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, бүртгэхэд техникийн боловсрол, мэргэжлийн боловсрол, мэргэжлийн сургалтын онцлогийг тусгаж зохицуулсан журам тогтоох,

МБС-ын хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж хянах, чанарыг тасралтгүй сайжруулах чиглэлээр тусгай зөвшөөрөл олгосон субъект хяналт шинжилгээ, аттестатчилал, үр дүнгийн гэрээний үнэлгээ, дүгнэлт, магадлан итгэмжлэлийн хэрэгслийг уялдаа холбоотойгоор давхардал, орхигдолгүйгээр хэрэгжүүлэх. Политехник коллеж, техникийн боловсролын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг заавал хийж байх шаардлага тавих нь Боловсролын тухай хуулийн зохицуулалттай нийцэх бөгөөд энэ тохиолдолд аттестатчиллыг давхардуулан хэрэглэх шаардлагагүй болно. Харин МСҮТ, мэргэжлийн боловсролын хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарыг үнэлэхэд аттестатчиллын механизм илүү тохиромжтой. Цаашид чанарын удирдлагын нэр хүндтэй стандартыг хэрэгжүүлж, магадлан итгэмжлэгдсэн, аттестатчилагдсан МБСБ нь тодорхой шаардлагыг хангаж, нөхцөл бүрдүүлсэнээ нотолсон тохиолдолд өөрийгөө магадлан итгэмжлэх эрх олгох (австралийн TAFE-тэй төстэйгээр) боломжийг судлах хэрэгтэй байна. Мэргэжлийн сургалтын төв, чадамжийн сургалтын хөтөлбөрийг 2 хүртэл жилд заавал аттестатчилж байх, төгсгөгчдийн нь ур чадварын үнэлгээг голлох шалгуур болгох нь тохиромжтой болно. Техникийн боловсролын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг цаашдаа харгалзах дээд боловсролын мэргэжлийн зөвлөлд түшиглэн хэрэгжүүлэх чиглэл баримталж, энэ чиг үүргийг үе шаттай шилжүүлэх тусгай хөтөлбөр хэрэгжүүлбэл илүү зохимжтой байна. Мэргэжлийн боловсролын чадамжид суурилсан хөтөлбөрт харгалзах мэргэжлийн чадамж, ур чадварыг үнэлэх тестийн сан бүрдүүлэх, МБСБ-д түшиглэсэн үнэлгээний төвүүдийг байгуулан итгэмжлэх үйл ажиллагааг зүгшрүүлж, чадавхийг нь сайжруулахад ХНХСҮСИ-ийн үнэлгээний алба, түүний дэргэд байгуулсан мэргэжлийн зөвлөлүүдийн үйл ажиллагааг БҮТ-ийн үйл ажиллагаатай ойртуулах, цаашид аль байгууллагад хариуцуулах талаах БШУЯ, ХНХЯ зөвшилцөж шийдэл гаргавал зохино.

БАЗТ-ийг БСҮХ-гийн харъяанд удирдлага, менежментийн хувьд бие даан ажиллаж, хөтөлбөр боловсруулах, үнэлж шинжлэх, багш нарт аргагүйн туслалцаа үзүүлэх мэргэжлийн чиг үүргийг хариуцаж, хяналт шалгалтын шинжтэй захиргааны чиг үүргээс нь чөлөөлбөл зохимжтой болно.

Мэргэшил, ур чадвар, чадамжийг үнэлэх, гэрчилгээжүүлэхэд МБСҮМАЗТ-ийн хэрэгжүүлж байсан үүргийг БҮТ-ийн мэргэжлийн экспертизтэй зохистой хослуулж, харгалзах мэргэжлийн холбоод, МБСБ-ын хариуцах үүрэг, зохион байгуулалтыг тодотгон, иргэдэд хүртээмжтэй үйлчлэх тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай. Үүнд цаг хугацаа, үйл ажиллагааны алдагдал гаргахаас сэргийлж үе шаттай алхмууд төлөвлөн хэрэгжүүлбэл зохилтой.

**ЗӨВЛӨМЖ 5:** Мэргэжлийн боловсролын үнэмлэх, техникийн боловсролын дипломыг сургууль олгохдоо улсын шалгалтын комиссын үнэлгээнд үндэслэх, комиссыг мэргэжлийн хөндлөнгийн экспертийн оролцоотой байгуулж байх; Мэргэжлийн ур чадварын үнэлгээ хийх, гэрчилгээжүүлэх ажлын мэргэжлийн удирдлагыг БҮТ-д хариуцуулж, үнэлгээний сорил, тест бэлтгэхэд МБСҮМАЗТ-тэй хамтран ажиллаж байсан мэргэжлийн холбоодын харилцааг уламжлан бэхжүүлж хөгжүүлэх. Ийнхүү чадамжийн гэрчилгээг итгэмжлэгдсэн үнэлгээний төв олгох журамд шилжих, гэхдээ итгэмжлэгдсэн байгууллагад эрх өгөхийн хамт гүйцэтгэлд нь мета үнэлгээ хийж байх: итгэмжлэгдсэн байгууллага нь мэргэшсэн үнэлээчтэй, тестийг явуулах шаардлага хангасан төвтэй, мэдээг бүрэн дүүрэн системд оруулдаг гэрээтэй байх бөгөөд ихэвчлэн энэ шаардлагыг хангасан Политехник коллежид түшиглэсэн байвал зохимжтой байна.

Чанарын удирдлагын стандартыг нэвтрүүлэх, чанарын соёл бүрдүүлэх талаар МБСБ-ын санаачилга, бүтээлч хандлагыг дэмжсэн бодлого, зохицуулалтыг албажуулбал зохилтой.

**ЗӨВЛӨМЖ 6:** Үнэлгээний шалгуур, процедур, шинжээчдийн чадавхи нь хөндлөнгийн чанарын үнэлгээний албан ёсны механизмтай адил төстэй, нэр хүндтэй, нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн ISO9001, 21001:2018 серийн чанарын удирдлагын стандарт, TQM буюу чанарын удирдлагын иж бүрэн системийн үзэл баримтлал, аргачлалтай төстэй нийтлэг шинжтэй практикийг туршин нэвтрүүлэхийг дэмжиж, үр дүнг нь хүлээн зөвшөөрч албан ёсны аттестатчилал, магадлан итгэмжлэлийн дүгнэлттэй адилтган дүйцүүлэх зохицуулалт бий болгох.

Чанарыг баталгаажуулахад хэрэглэгч, мэргэжлийн олон нийтийн үүрэг оролцоог бодитой, үр нөлөөтэй болгох зохицуулалтыг сайжруулах шаардлага байна.

**ЗӨВЛӨМЖ 7:** Мэргэжлийн холбоодын зүгээс мэргэжлийн стандартыг боловсруулах, батламжлах, ур чадвар, чадамжийн үнэлгээ хийх, дүгнэлт гаргахад оролцоо нь нэмэгдэж, эдгээр үүргээ хэрэгжүүлэхэд туршлагажиж байна. Гэхдээ байнга, тогвортой ажиллуулах нөхцөлийг сайжруулах шаардлагатай. Идэвхитэй, нэр хүндтэй цөөн хүн мэргэжлийн хэд хэдэн байгууллагад уригдаж давхар үүрэг хүлээх нь олонтаа тохиолдож байгаа бөгөөд үүний дүнд тухайн хүний цаг боломж хүрэлцэхгүй болох, сонирхлын зөрчилд өртөх магадлал өндөр байна. Иймд ижил төстэй, нийтлэг зорилго чиглэлтэй ажлын хэсэг, зөвлөлийг нэгтгэх, уялдуулах, төлөөлөх ажилтныг өргөтгөх, гишүүд мэргэшиж ажиллах, зөвлөлүүдийн ажиллагааг тогтвортой, үр нөлөөтэй болгох зохицуулалт шаардлагатай.

Үнэлгээ дүгнэлт гаргах, үүндээ үндэслэн чанарын баталгаажуулалтын гэрчилгээ баримт бичиг олгох эрх мэдлийг мэргэжлийн холбоо байгууллагад шилжүүлбэл тогтвортой ажиллагаатай, үнэлгээ бодитой байх, салбарт хүлээн зөвшөөрөгдөж, итгэл бэхжих илүү

нөхцөл бүрдэнэ. Энэ тохиолдолд шилжүүлэн өгсөн чиг үүргийг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх чадавхитай бүрэлдэхүүн, тогтвортой бүтэцтэй, үнэлгээ дүгнэлтийг хараат бусаар бодитой хэрэгжүүлэх хариуцлага хүлээх, гаргасан дүгнэлт, шийдвэрийн үр дагаврыг хариуцах чадварыг нь үнэлж, чиг үүргээ хэрхэн биелүүлж байгаад мета үнэлгээ хийж байх журмыг тогтоох шаардлагатай болно. Шилжүүлэн өгсөн чиг үүргийн хэрэгжилтэд хяналт тавих, meta-evaluation хийх боломжтой субъект нь яам, БМИҮЗ, мэргэжлийн холбоодын зөвлөл байж болох хувилбарыг харьцуулан үзэх хэрэгтэй.

Олон жилийн турш улсын төсөв, хөрөнгө оруулалт, хандивлагч, хөгжлийн түншүүдийн дэмжлэг, хүчин чармайлтаар бүрдүүлсэн чадавхийг үнэлж, үр дүнтэй ашиглах, институцийн ой санамжийг алдагдуулахгүй байхад анхаарах: мэргэжлийн сургалтад хамрагдсан багш ажилтнууд, нийлүүлсэн өндөр өртөгтэй лаборатори, багаж тоног төхөөрөмж, олон улсын болон үндэсний зөвлөхүүдийн судалгааны тайлан, баримт бичгийн бүртгэл, гүйцэтгэлийн мэдээллийн санг БСҮХ болон МБСТүншлэл зэрэг холбогдох бусад байгууллагад хариуцуулан байгуулах, хөтлөх хэрэгтэй байна.

## Гарчиг

ХУРААНГУЙ.....	3
<b>УДИРТГАЛ.....</b>	<b>9</b>
Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын баталгаажуулал .....	10
<b>МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН СИСТЕМИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ .....</b>	<b>13</b>
Монгол Улсын боловсрол, сургалтын системийн үндсэн үзүүлэлт .....	13
1990 оноос боловсролын тогтолцоонд гарсан гол өөрчлөлт.....	14
Боловсролыг хөгжүүлэх бодлогын үндсэн чиглэл .....	16
<b>МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ.....</b>	<b>22</b>
Монгол Улсын мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоо .....	22
Мэргэжлийн боловсрол, сургалтын засаглал, удирдлага, тулгамдаж буй асуудал .....	33
Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын баталгаажууллын өнөөгийн байдал .....	40
Мэргэжлийн боловсрол сургалтын чанарын баталгаажууллын эрх зүйн зохицуулалт .....	43
Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын баталгаажууллын одоогийн байдал .....	47
МБС-ын чанарын баталгаажууллын тогтолцоо бүрдүүлэхэд хандивлагчдын дэмжлэг .....	78
<b>МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР, АРГАЗҮЙГ БОЛОВСРУУЛСАН НЬ.....</b>	<b>88</b>
Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагааг үнэлж буй өнөөгийн практикт дүн шинжилгээ хийх, үнэлгээний шалгуурын тойм шинжилгээ.....	89
<b>БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ .....</b>	<b>103</b>
<b>ХАВСРАЛТ 1: МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ЧАНАРЫГ ҮНЭЛЭХ НЭГДСЭН АРГАЧЛАЛ (ТӨСӨЛ).....</b>	<b>107</b>
<b>ХАВСРАЛТ 2: НЭР ТОМЪЕОНЫ ТАЙЛБАР .....</b>	<b>116</b>
Уулзаж ярилцсан, мэдээлэл солилцсон хүмүүс.....	118
ЛАВЛАХ МАТЕРИАЛ, АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....	119
Мэргэжлийн боловсрол сургалтад холбогдох хууль, эрх зүйн болон бодлогын баримт бичиг .....	119
Холбогдох судалгааны тайлан: .....	120
Гарын авлага, материал .....	122
Олон улсын судалгаа, гарын авлага материалууд.....	123



## УДИРТГАЛ

Энэхүү судалгааны тайланг НҮБХХ-ийн “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих төсөл” (SDG-Aligned Budgeting to Transform Employment in Mongolia project, UNDP)-ийн захиалгаар МБС-ын чанарын баталгаажууллын шалгуур, механизмыг сайжруулах зөвлөмж боловсруулах ажлын хүрээнд бэлтгэсэн болно.

Монгол Улсын төр засаг, түүний хөгжлийн түншүүд мэргэжлийн боловсрол, сургалтын үр өгөөжийг дээшлүүлэх хүчин чармайлт, хөрөнгө зардлыг тууштай нэмэгдүүлж байгаа боловч ажил хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, чадамжтай хүний нөөц бүрдүүлж чадахгүй байгааг энэ салбарын үйлчилгээний чанар, түүний баталгаажууллын механизмын үр дүнтэй холбон үзэхээс аргагүй юм.

Монгол Улсын эдийн засаг дэлхийн хамтын нийгэмлэгтэй интеграцчилагдаж, глобал зах зээлийн оролцогч болсон тул иргэдийн мэдлэг, ур чадвар нь глобал эдийн засагт өрсөлдөх хэмжээнд байж зориулалтын шаардлагаа хангах учир боловсрол сургалтын талаар баримтлах бенчмарк нь олон улсын жишиг байх шаардлагатай болж байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт улсын төсвөөс зарцуулах хөрөнгийн хэмжээ тасралтгүй нэмэгдэж, хөгжлийн түнш хандивлагчдын тусламж дэмжлэгтэй томоохон хөтөлбөрүүд хэрэгжүүлсэн ч суралцагчдын тоо төдийлэн өсөхгүй, төгсгөгчдийн ажил эрхлэлт бага бөгөөд тогтворгүй, МБСБ-ын удирдлага, бүрэлдэхүүнд олон удаагийн өөрчлөлт орж, шинэ мэдлэг таниулж, чадавхи бүрдүүлсэн хүчин чармайлт үр дүнгүй болсон шинжтэй байна. Мэргэжлийн боловсрол, сургалтанд хамрах хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор 2007 онд 20 мянган төгрөгөөр эхлүүлсэн тэтгэлэгийн хэмжээг 2020 оноос 200 мянган төгрөг болгож нэмэгдүүлсэн нь энэ салбарын зардлыг эрс өсгөсөн боловч элсэлтийн тоонд багахан нөлөөтэй, төгсгөгчдийн ажил эрхлэлтэд төдийлэн өөрчлөлт гаргаагүй болохыг судалгааны дүн илтгэдэг.

Сүүлийн жилүүдэд мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төрөл хэлбэр өргөжиж, хувийн санаачлагаар үүссэн төрийн бус өмчийн сургалтын байгууллага бий болсон нь суралцах хүмүүсийн бүрэлдэхүүн, сургалтын хөтөлбөр, сургалтын арга хэлбэрийг шинэ хандлагаар баяжуулж байна. МБС-ын хөтөлбөрт насанд хүрэгчдээс элсэх нь нэмэгдэж байгааг статистик мэдээ харуулж байна. 2021-2022 оны хичээлийн жилд элсэгчдийн 58 хувь нь 23-аас дээш буюу “уламжлалт бус” насны иргэд (30-аас дээш насны иргэд шинэ элсэгчдийн 27 хувьд хүрсэн) байжээ. Энэ нь МБС-ыг насан туршийн боловсролын институт болж хөгжих хэрэгцээний илэрхийлэл хэмээн үзэж хөтөлбөрийг энэхүү шинээр үүсч буй шаардлагад нийцүүлэн олон хувилбартай, хүртээмжтэй уян хатан болгох хэрэгцээ улам бүр нэмэгдэж байгааг илтгэнэ.

МБС-ын хөгжлийн бодлогыг улс орны болон орон нутаг, байгууллагын түвшинд тодорхойлох, мэргэшил, ур чадварын стандартыг тогтоох, түүнийг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэй байгууллагын өөрийн удирдлагыг бүрдүүлэн ажиллуулахад сонирхлын бүлгүүд, ялангуяа ажил олгогчид, үйлдвэрлэл, үйлчилгээний төлөөллийг оролцуулсан МБСҮЗ, түүний салбарын болон орон нутгийн зөвлөлүүд, МБСБ-ын удирдах зөвлөл зэрэг засаглалын субъектүүд ажиллах эрхзүйн орчин бүрдсэн гэж үзэж болно. Түүнчлэн мэргэжлийн ур чадварыг үнэлэн баталгаажуулах, мэргэжлийн боловсрол, сургалтын магадлан итгэмжлэхэд харгалзах мэргэжлийн экспертүүдийг оролцуулсан мэргэжлийн зөвлөлийг байгуулан ажиллуулж байна. Харин эдгээр эрх бүхий субъектүүдийн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхэд нь шаардагдах чадавхи бүрдүүлэх, үйл ажиллагааны уялдаа холбоо, харилцан хяналтыг тодотгон төлөвшүүлж, удирдлагын үр нөлөөг сайжруулах нөхцөл бүрдүүлэх шаардлагатай

байна. Засаглалын энэ орчинд мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь МБС-ын хөгжлийн бодлогыг тодорхойлохоос эхлэн энэ чиглэлийн үйл ажиллагааны стандарт, нийтлэг хэм хэмжээг тогтоож, энэ тогтолцоонд хамаарах гол байгууллагуудын удирдлагыг томилох, салбарын нийт хөрөнгийг удирдах эрх мэдлийг хэрэгжүүлж байна. Харин эдгээр ажлын үр дүн нь яамны бүрэн эрхэд хамаарах МБС-ыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, МБСҮЗ-өөр батлуулан хуваарилж, зарцуулах, хэрэгжилтийг зохистой хянаж удирдахаас ихээхэн хамааралтай болно.

### Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын баталгаажуулал

Чанарын баталгаажуулал нь МБС-ын үндсэн зорилгын хэрэгжилт, үр дүнд хүрэх үйл явцыг үнэлж, шаардлагатай тохиргоо хийж, удирлагын шийдвэрийн үндэслэлийг сайжруулах цогц систем болно. Энэ нь сургах, суралцах процессийн үр дүнг сайжруулах аливаа бодлогын санаачилга нь чанарын талаар үндэсний хэмжээний дэмжлэгийг хүлээсэн тогтвортой бодлоготой байхад үйлчилнэ. Чанарын баталгаажууллын үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлсэнээр МБС-ын үйл ажиллагааг олон нийтэд ил тод болгож, оролцогч талуудын итгэлцлийг бататган, хамтын ажиллагааг идэвхижүүлж, нэр хүндийг бэхжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Манай оронд байгууллагын түвшинд чанарын удирдлагын талаар баримтлах үзэл баримтлал зарчмыг Стандартчиллын үндэсний зөвлөлөөс 2016 онд баталсан *MNS ISO 9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо: шаардлага* үндэсний стандартад тодорхойлсоноор ойлгож хэрэглэхээр тогтоожээ. Олон улсын стандартчиллын байгууллагаас 2018 онд баталж, 2021 онд Монгол Улсын үндэсний стандарт болон мөрдөж буй *MNS ISO 21001:2021 Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо - Шаардлага, хэрэглэх арга зүйн заавар* стандарт нь боловсролын байгууллагын сургах, сурах үйл явц, түүний үр дүнгийн тохирлыг баталгаажуулах замаар суралцагч, үйлчлүүлэгч, ажилтны сэтгэл ханамжийг дээшлүүлэх зорилгод нийцсэн чанарын менежментийн хэрэгсэл болж байгааг харьцуулан хэрэглэх боломж бүрдээд байна.

МБС-ын хүрээнд сүүлийн жилүүдэд засгийн газраас дэмжин МСС, Сингапурын Темасек, ЕХ-ны МБССДТ-1 төсөл болон бусад хөгжлийн түншүүдтэй хамтран боловсруулсан чанарын баталгаажуулал, менежментийн механизм нь дараах үндсэн зарчмуудад тулгуурласан нь дээрх үндэсний стандартын үзэл баримтлалтай нийцэж байна. Үүнд:

- Чанарын баталгаажуулал, чанарын менежментийн үндсэн зорилго нь чанарыг тасралтгүй сайжруулж байхад чиглэнэ;
- Чанарын баталгаажууллыг удирдан зохион байгуулах нь үйл ажиллагааны эцсийн үр дүнд чиглэсэн байх ба үүнийг төрийн захиргааны болон зохицуулах байгууллага, МБСБ, үйлдвэрлэл үйлчилгээний салбар, нийгмийн түншүүд хамтран тодорхойлж, боловсруулж, хэрэгжүүлнэ;
- МБСБ нь өөрийн сургалт, үйлчилгээний чанар, түүнийг баталгаажуулах ажлын үр дүнг шууд хариуцна;
- МБС-ын дотоод чанарын баталгаажууллын тогтолцоог холбогдох удирдамж, зөвлөмж, хэрэглэгдэхүүн, мэдээллээр хангаж, хөндлөнгийн хараат бус үнэлгээ шинжилгээ хийж, дүгнэлт гаргах бүтэц тогтолцоо бүрдсэн байна;
- Чанар, үр дүнд өөрийн үнэлгээ хийх ажил нь **“төлөвлө – хэрэгжүүл – үнэл – сайжруул”** гэсэн мөчлөг бүхий цогц үйл явц бөгөөд өөрийн үнэлгээний тайланг жил бүр гаргана;
- Суралцагчид болон бусад сонирхлын бүлгүүдийн эрх ашиг, хэрэгцээг тусгана;
- Чанарыг баталгаажуулах үйл ажиллагааны зохион байгуулалт нь сургалтыг дэмжихүйц үр ашигтай, үр дүнтэй байна;

- Чанарыг баталгаажуулах үйл явц, үр дүн нь ил тод байна;
- Гадны хөндлөнгийн үнэлгээ нь байгууллагын өөрийн үнэлгээний үйл явцыг баталгаажуулахад чиглэнэ.

Чанарын баталгаажууллын дээрх чиг үүрэг, холбогдох эрхзүйн болон судалгааны баримт бичиг, эх сурвалжид харьцангуй нийтлэг хэрэглэж буй тайлбарт түшиглэн чанар, чанарын баталгаажууллыг дараах байдлаар тодорхойлсоныг ашиглахыг санал болгож байна:

**Чанар** – зорилгодоо нийцсэн байхын илэрхийлэл; сургалтын байгууллага, хөтөлбөрийн чиг үүрэг, үндсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх процессийг үр дүнтэй болгоход чиглэсэн, магадлан итгэмжлэх эсхүл чанарыг баталгаажуулах эрх бүхий бусад байгууллагаас тогтоосон, нийгээр хүлээн зөвшөөрсөн стандартыг хангах, түүнд нийцүүлэх нь чанарын илэрхийлэл болно.

**Чанарын баталгаажуулал** – боловсрол, сургалтын систем, байгууллага, түүний хөтөлбөрийн чанарыг хангах (орц, явц, үр дүнг шалган дүгнэх, хянан шинжлэх, баталгаажуулах, үйлчлэх, ахиулан сайжруулах)-ад чиглэсэн тасралтгүй үргэлжлэх процесс. Чанарын баталгаажуулал нь зохицуулах шинжтэй механизм учир сайтар боловсруулсан шалгуурыг ашиглан холбогдох талууд зөвшилцөн тохиролцсон процессоор дамжуулан мэдээлэл өгч, дүгнэлт гаргах замаар чанарын төлөөх хариуцлага, түүнийг сайжруулах чиглэлийг тогтооно.

Ийнхүү тодорхойлбол, боловсрол, сургалтын хүрээнд чанарын баталгаажуулал нь чанарын хэмжүүр (бенчмарк)-ийг илэрхийлэх боловсрол, мэргэжлийн стандарт, энэхүү хэмжүүрийг хангах үйл явцыг зохион байгуулах, үнэлж дүгнэх хэрэгсэл болох тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэл, хяналт шалгалт, батламжлал/гэрчилгээжүүлэлтийн зохицуулалтаас бүрдэж байна.

Монгол Улсын мэргэжлийн боловсрол сургалтын хүрээнд чанарын стандартыг хэрэгжүүлэх процесст чанарыг баталгаажуулах ажил эрх бүхий төрийн захиргааны байгууллагын тусгай зөвшөөрөл, хяналт шалгалт, магадлан итгэмжлэл, аттестатчилал, аудит зэрэг олон арга хэрэгслээр хөндлөнгийн үнэлгээгээр хэрэгжиж байгаагийн зэрэгцээ сургалтын байгууллагууд өөрөө дотооддоо чанарын баталгаажууллын чадавхи, тогтолцоо бүрдүүлэх үйл явц өрнөж байна. Хөндлөнгийн үнэлгээ нь сургалтын байгууллагын өөрийн үнэлгээнд суурилж, үүнтэй уялдаа холбоотой явагдах нь бодит шаардлага юм. МБСБ-ууд сүүлийн жилүүдэд чадамжид суурилсан хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, Сингапурын Темасек сан, Сингапурын Политехник коллеж, ГХАН-тэй хамтран боловсруулсан *чанарын баталгааны тогтолцооны* аргазүйг эзэмшихэд суралцаж, олон улсын чанарын удирдлагын ISO серийн стандартуудаас сонгон туршиж нэвтрүүлэх алхмуудыг эхлүүлсэн байна. Эдгээр нь бүгд үзэл баримтлал, зохион байгуулалт, аргачлалын хувьд ижил төстэй, чанарын иж бүрэн удирдлага – PDCA (*Төлөвлө – Хэрэгжүүл – Үнэл – Сайжруул*) мөчлөгт суурилсан тул өөр хоорондоо зөрчилдөхгүй, харин ч сургалтын байгууллагын санаачилга, идэвхи сонирхол, өөрийн онцлогт тохируулан нутагшуулах хүсэл эрмэлзлээс үүдэлтэй тул дэмжин урамшуулах нь зүйтэй байна.

Чанарын баталгаажууллын тогтолцооны чанарын стандартын загварт нийцэж буй эсэхийг үнэлэн дүгнэж, дүгнэлтийг албажуулах үйл ажиллагаа нь МБС-ын хүрээнд ажил мэргэжлийн тодорхойлолтод заасан мэдлэг, ур чадвар, чадамжийг эзэмшсэн байдлыг үнэлж дүгнэн гэрчилгээжүүлэх сургуулийн болон хөндлөнгийн үнэлгээгээр хэрэгжиж байна. Үүнд хамаарах процессийг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд “чанарын үнэлгээ” хэмээн нэрлэж тусгай бүлэг болгон хуульчилжээ.

Өнөөдөр МБС-ын хүрээнд чанарыг баталгаажуулах тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүд байгуулагдаж, үйл ажиллагааны зааг ялгаа, уялдаа холбоо тогтож эхэлж байгаа боловч систем болж үр өгөөжтэй, үр ашигтай, итгэл даахуйц, хүлээн зөвшөөрөгдсөн байх шаардлагыг бүрэн хангаж хараахан чадахгүй байна. МБС-ын хүрээнд чанарыг баталгаажуулахад хэрэглэж буй олон механизм нь сургалтын байгууллагын зүгээс гарах шинэ санаачилга, шийдэл, олон төрөл, хэлбэрийг хааж боогдуулж болохгүй<sup>1</sup> гэдгийг энэ чиглэлээр ажилласан олон улсын зөвлөхүүд анхааруулсан байна. Чанарын баталгаажууллын нэгэн чухал функц нь мэдээллээр хангах явдал билээ. Бүхий л түвшинд мэдээлэл дутмаг байгаа нь боловсрол сургалтын чанарын талаар олон нийтэд ноттой ойлголт өгөхгүй, үүгээрээ МБС-ын системд итгэх нийгмийн итгэлийг дэмжих бэхжүүлэх нөлөө үзүүлж чадахгүй байна.

---

<sup>1</sup> Hammink (2017). *Quality Assurance and Quality Management in TVET: POLICY and GUIDELINES*, draft version 1.2 (drafted by STVET international senior non-key expert)


# МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН СИСТЕМИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улсын боловсрол, сургалтын системийн үндсэн үзүүлэлт

Монгол Улсын боловсролын өнөөгийн систем нь хүн амын боловсрол, мэргэжил эзэмших хэрэгцээг тооны хувьд хангаж хүрэлцэхүйц тогтолцоо болж төлөвшжээ.

Монгол Улсад боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролоос бүрддэг (зураг 1).

Зураг 1: Монгол Улсын боловсролын тогтолцооны бүдүүвч



Дээрх зурагт үзүүлсэн боловсролын түвшин хоорондын уялдаа холбоо, агуулгын ялгаа заагийг цэгцтэй илэрхийлж, нэг утгатай тодорхойлох зорилготой National Qualifications Framework (NQF)-ийг Хөдөлмөрийн хуульд “мэргэшлийн үндэсний хүрээ”<sup>2</sup> хэмээн нэрлэсэн байна. Үүнийг судлаачдын дунд “мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц” (УИХ-д өргөн барьсан Боловсролын ерөнхий хуулийн төсөлд тодорхойлсоноор), “мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоо” (Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8.4.21-д

<sup>2</sup> Хөдөлмөрийн тухай хуулийн “17 дугаар зүйл. Мэргэшлийн үндэсний хүрээ”

дурдсанаар), “мэргэшлийн түвшний шаталсан бүтэц”, “үндэсний мэргэшлийн түвшний шатлал” гэхчлэн өөр өөрөөр нэрлэж байна. Боловсролын аль түвшний хөтөлбөрийг боловсруулах, үр дүнг үнэлж дүгнэх, хүлээн зөвшөөрөх лавлагаа, удирдамж болох энэхүү баримт бичгийн талаарх байр суурийг улс орны хэмжээнд ойлголцон зөвшилцөж, албажуулан баталгаажуулах ажил нэлээд олон жил үргэлжилж байгаа юм. Харин мэргэжлийн боловсрол, сургалтын хүрээнд мэргэшлийн түвшин (Vocational Qualifications Framework)-ийг 6 шатлалтай гурван төрлийн хөтөлбөртэй байхаар Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөл 2011 онд баталсан байна.

### 1990 оноос боловсролын тогтолцоонд гарсан гол өөрчлөлт

Ерөнхий боловсролын бага, дунд шатны насны хүүхдийг сургуульд хамралт 90 гаруй хувь, залуу хүмүүсийн сургуульд суралцсан дундаж хугацаа 14.3 жил болсон байна<sup>3</sup>. 2006-2014 онд ерөнхий боловсролыг 10 жилээс 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, бага сургуульд орох насыг 8-аас 6 хүртэл доошлуулсан ч хамран сургалтын хувь хэмжээ нэмэгдсэн нь хүн амын боловсролыг эрхэмлэх уламжлалт үнэлэмж өндөр, төрөөс боловсролд зориулах хөрөнгө оруулалт, хөдөөгийн сургуулийн дотуур байрны хүрэлцээ нэмэгдсэн, бага ангид үдийн цай хөтөлбөр хэрэгжүүлсэн нь зохих хэмжээгээр нөлөөлсөн гэж үзэж болно. Өнөөдөр ерөнхий боловсролын түвшинд үндэсний хөтөлбөртэй төрийн болон хувийн өмчийн сургуулиудын зэрэгцээ олон улсын хөтөлбөртэй болон гүнзгийрүүлсэн сургалттай төрийн ба хувийн өмчийн 85 сургууль ажиллаж байгаа<sup>4</sup> нь бага дунд боловсрол олон талын оролцоо, төрөл хэлбэртэй болж буйг илтгэнэ.

Ерөнхий боловсролын буюу бага, дунд боловсролд хамрагдах насны хүүхдийн 96-аас дээш хувь нь ерөнхий боловсролын сургуулийн өдрийн ангид суралцаж байна. Нэгдүгээр ангид 6 настай элссэн хүүхдийн 97 хувь нь бүрэн бус дунд сургууль дүүргэж байна. Тэдний 80 хувь нь ахлах сургуульд дэвшин суралцаж, харин 20 хувь нь МСҮТ, Политехник коллежид элсэж байна. Бүрэн дунд боловсрол эзэмшин төгсгөгчид анх бага сургуульд элссэн хүүхдийн 70 гаруй хувийг эзэлж байгаа бөгөөд тэдний 70-аас дээш хувь нь сургууль төгссөн жилдээ их, дээд сургууль, коллежид элсэж байна.

### Зураг 2: Суралцагчдын боловсролын замналын бүдүүвч



1990 оноос өмнө мэргэжлийн сургуулийг улсын төсвөөс бүрэн санхүүжүүлж, суралцагчдад нь стипенд олгож байсаныг улс орон зах зээлийн эдийн засагт шилжиж эхэлсэн үеэс ихээхэн өөрчилжээ. Ажиллах хүчний төвлөрсөн төлөвлөлт зогсож, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг хувьчилсанаар мэргэжилтэй ажилчин, ажилтаныг захиалж, төгсгөгчдийг ажлын

<sup>3</sup> Энгел, Прицзон, Гэрэлмаа (2014). Уналтаас сэргэлтэнд: Монгол Улсын багаас дээш шатны боловсрол, Хилийн чанад дахь хөгжлийн хүрээлэн (ODI), Лондон.

<sup>4</sup> БШУЯ (2014). Боловсролын салбарын статистик мэдээ 2021-2022, Улаанбаатар: х.51.

байранд шууд хуваарилах төвлөрсөн зохицуулалт байхгүй болов. Иймд техник-мэргэжлийн сургуулиудыг үйлдвэрлэлийн сургалтын бааздаа түшиглэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, орон нутгийн болон иргэдийн ажил хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд нийцсэн сургалтыг уян хатан зохион байгуулж явуулах эрхтэй мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв болгон өөрчилж, энэ хэлбэрийн зарим сургуулийг инженер техникийн дээд боловсролын сургалттай сургуулиудад шаталсан хөтөлбөртэй болгон нэгтгэжээ. Үүнтэй төстэй өөрчлөлтийг тусгай мэргэжлийн дунд сургуулийн хүрээнд ч хийж их, дээд сургуулиудтай нэгтгэн, бакалаврын хөтөлбөр бүхий сургууль болгосон байна.

1990-ээд оны эхээр төрийн өмчийн дээд сургуулиудыг их сургууль болгож, гадаад харилцаа, орон тоо, зохион байгуулалт, оюутан элсүүлэх, багш нарыг сонгон шалгаруулж авахад бие даасан шийдвэр гаргах эрх мэдлийг нь олгожээ. 1993 оноос дээд боловсролыг төлбөртэй болгож, улсын төсвөөс хуваарилж байсан хөрөнгийг захиргаа, ашиглалтын тогтмол зардал, оюутны тооноос хамаарсан хувьсах зардлын нормативд үндэслэн тооцох болов. Үүний хувьсах зардлын хэсгийг сургалтын төлбөрөөр санхүүжүүлэхээр журамлажээ. Тухайн үед суралцаж байсан оюутнуудад олгож байсан стипендийг эргэн төлөгдөх зээлийн хэлбэрт шилжүүлжээ. Төвлөрсөн төлөвлөгөөний дагуу урьдчилан төлөвлөсөн ажлын байранд зориулж мэргэжилтэн бэлтгэж ирсэн сургалтын зохион байгуулалтыг өөрчилж, оюутны сонголтод нийцүүлэн багц цагт үндэслэсэн бакалавр, магистр, докторын шатлалтай боловсролын хөтөлбөрт шилжиж эхэлсэн байна.

1990-ээд оны эхэн үеэс голчлон гадаад хэлний сургалтын төв хэлбэрээр үйл ажиллагаа нь эхэлсэн боловсрол дахь хувийн хэвшил өргөжин тэлж, анхны хувийн сургуулиуд 1992 онд дээд боловсролын хүрээнд нээгдэв. Боловсролын бүх шатанд хувийн өмчийн сургуулийн эзлэх хувь хурдтай өссөний дотор дээд боловсролд эрс нэмэгдсэн байна. Өнөөдөр дээд боловсролын суралцагчдын 47% буюу 70 мянга орчим оюутан хувийн өмчийн их, дээд сургууль, коллежид суралцаж байна. Хэдийгээр төлбөртэй болсон ч 1990 онд нийтдээ 14 мянга орчим оюутантай байсан монголын дээд боловсрол өнөөдөр 150-иад мянган оюутантай болтлоо огцом тэлсэн нь манай орны үзүүлсэн онцгой үзэгдэл болж байна. Үүний учир шалтгааныг олон улсын хөгжлийн судалгааны байгууллага судалж боловсролыг эрхэмлэн чухалчлах хүн амын хүсэл эрмэлзэл голлох хувь нэмэр болсоныг тогтоосон (Engel et al, 2014) байна.

Монгол Улсын боловсролын салбарын өсөлтөд социализмын он жилүүдэд улсын төсвийн хөрөнгө оруулалт, ЗХУ-ын зээл тусламж (улсын төсвийн гуравны нэг хүртэл хувийг ЗХУ-аас зээл авч бүрдүүлж байсан бөгөөд энэхүү төсвийн зардлын 20 гаруй хувийг боловсролд зориулж байв) голлон нөлөөлсөн бол 1990 оноос хойш Ази (Япон, БНСУ), Европ (Европын холбоо, ХБНГУ, Их Британи, Дани, Швейцар), Умард Америк (АНУ, Канад)-ийн орнууд, АХБ, Дэлхийн банк, ЮНЕСКО, ЮНИСЕФ зэрэг олон улсын байгууллагууд хөгжлийн дэмжлэг үзүүлж иржээ. Энэхүү дэмжлэгийн голлох хэсэг нь эдийн засаг, нийгмийн шинэ орчинд бага, дунд боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, бүтцийн өөрчлөлт хийхэд зориулагдсан байна. Харин сүүлийн жилүүдэд дээрх хандивлагчдаас гадна томоохон хөрөнгө оруулагчид мэргэжлийн боловсрол, сургалтад зориулсан дэмжлэгийг эрс нэмэгдүүлсэн байна.

Өнөөдөр боловсролын бүх шатанд чанарын асуудал олон нийтийн шүүмжлэлийн төвд байна. Дээд болон мэргэжлийн боловсролын сургууль төгсгөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт (ХНХСИ)-ээс судалсан дүнгээс үзэхэд 2020 оны байдлаар 2015-2016 оны хичээлийн жилд их, дээд сургууль болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгсгөгчдийн 74.8 хувь нь хөдөлмөр эрхэлж байжээ. Үүний дотор их, дээд сургууль төгсгөгчдийн хөдөлмөр эрхлэлт 76.9 хувь, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага (МБСБ) төгсгөгчдийн хөдөлмөр эрхлэлт 71.5 хувь байсан



байна. Хөдөлмөр эрхэлж буй МБСБ төгсгөгчдийн тал хувь нь мэргэжлээрээ ажиллаж байсаны дотор эрүүл мэнд, эрчим хүч, үйлчилгээний салбарт 67-83 хувь нь мэргэжлээрээ ажиллаж байсан нь бусад салбараасаа өндөр үзүүлэлт байжээ<sup>5</sup>.

### Боловсролыг хөгжүүлэх бодлогын үндсэн чиглэл

1990 оноос хойш Монгол Улсын боловсролыг хөгжүүлэх талаар төр засгийн бодлого стратегийг тодорхойлсон дараах баримт бичгийг УИХ, Засгийн газрын түвшинд батлан хэрэгжүүлж байна. Үүнд:

- Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого – УИХ 2008 онд баталсан
- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 – УИХ 2016 онд баталсан
- “Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого – УИХ 2020 онд баталсан
- Боловсролын хууль – БНМАУ-ын бага хурлаар 1991 оны 8 дугаар сард баталсан
- Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, Боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай, Дээд боловсролын тухай хуулиуд – УИХ 1995 онд баталсан
- Боловсролын тухай (шинэчилсэн найруулга), Бага, дунд боловсролын тухай (шинэчилсэн найруулга), Дээд боловсролын тухай (шинэчилсэн найруулга), Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль – УИХ 2002 онд баталсан
- Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль (шинэчилсэн найруулга) – УИХ 2009 онд баталсан
- Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024) – УИХ 2015 онд баталсан
- Боловсрол, хүний хөгжлийн хүчин зүйлийн мастер төлөвлөгөө – Засгийн газар 1994 онд баталсан
- Монголын боловсролын салбарыг 2000-2005 онд хөгжүүлэх стратеги – Засгийн газар 2000 онд баталсан
- Монгол Улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө – Засгийн газар 2006 онд баталсан
- Мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (2016-2021) – Засгийн газар 2016 онд баталсан
- Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030 – Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/96 дугаар тушаалаар баталсан

Манай оронд үндэсний хөгжлийн стратеги, урт хугацааны зорилтыг тодорхойлоход олон нийтийн санаа бодлыг тусгах, мэргэжлийн хэлэлцүүлэг зөвлөгөөнд түшиглэн олон талын оролцоог хангах үйл явц хэлбэршин тогтож байна. УИХ-аас 2020 онд баталсан “Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого нь төр засгийн зүгээс эдийн засаг, нийгэм, байгаль орчны тогтвортой хөгжил, тэгш, хүртээмжтэй өсөлтийг хангахад чиглэсэн зорилго, зорилт, хүрэх үр дүнг тодорхойлсон гол баримт бичиг билээ. “Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод ойрын гучин жилд хүрэх хөгжлийн түвшнийг:

**“АЛСЫН ХАРАА: Монгол Улс 2050 онд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар Азид тэргүүлэгч орнуудын нэг болно.**

**Эрхэм зорилго:**

<sup>5</sup> ХНХСИ (2020). *Төгсгөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа – 2020*



- үндэс язгуур, төрт ёс, өв соёлоо дээдэлж,
  - үндэсний нэгдмэл үнэт зүйлээ эрхэмлэж,
  - хүн төрөлхтний дэвшилтэт ололтыг дэмжиж,
- ... эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, эх оронч, хөрвөх чадвартай, оюунлаг, бүтээлч иргэнтэй улс болж хөгжинө” хэмээн тодорхойлжээ.

Энэхүү урт хугацааны хөгжлийн бодлогын эхний хэсэгт хүний хөгжлийн зорилтуудыг дараах байдлаар тодорхойлсон байна:

#### ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ

Зорилго 2. **Чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалтай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ.**

Ийнхүү хүн бүрт чанартай боловсрол эзэмшүүлэх зорилт нь дараах үе шатаар товлосон үр дүнд хүрнэ:

#### Боловсрол

Зорилт 2.1. Хүн бүрд **чанартай боловсрол эзэмших тэгш боломж** бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ.

Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн

**I үе шат (2021-2030):** Хүн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцооны шинэчлэлийн үе.

1. Салбарын хүрээнд [судалгаа, нотолгоонд суурилсан бодлого, хөгжлийн төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээ](#) хийх удирдлагын тогтолцоо болон олон талт түншлэл бэхэжсэн байна.
2. Иргэн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлэн, тэгш хамруулж, бүх шатны боловсролын залгамж холбоог хангаж, [сургалт, үйл ажиллагааны чанарыг дээшлүүлсэн](#) байна.
3. Суралцагчийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг хангасан, бүтээлч, чадварлаг багш, хүний нөөцөөр хангана.
4. Боловсролын салбарын удирдлагын мэдээллийн системийг бүрэн хөгжүүлж, хэрэглэж хэвшсэн байна.
5. Нээлттэй боловсролын тогтолцоог хөгжүүлж, цахим сургалтын нэгдсэн платформ бий болгон хүн бүр орон зай, цаг хугацаанаас үл хамааран өөрийн хүссэн чиглэлээр [насан туршдаа суралцах боломжийг](#) бүрдүүлсэн байна.
6. Олон улсын хөдөлмөрийн зах зээлд хүлээн зөвшөөрөгдөхүйц мэдлэг, ур чадвартай төгсөгчдийг бэлтгэн гаргадаг дээд боловсролын тогтолцоотой болсон байна.

**II үе шат (2031-2040):** Чанартай боловсрол олгох, насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлэх үе.

1. Бүсийн төв, аймаг, орон нутаг дахь ерөнхий боловсролын сургууль, [мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, политехник коллеж, технологийн коллеж](#), их, дээд сургуулиудын үүрэг, оролцоо нэмэгдсэн байна.
2. Бүх насны иргэд, нийгмийн салбар бүрийг хамарсан насан туршийн боловсролын нээлттэй, уян хатан тогтолцоо бэхэжсэн байна.
3. Олон улсын шаардлага хангасан дээд боловсролын сургалтын байгууллагын тоог нэмэгдүүлж, чанарыг дээшлүүлэн олон улсад эрэмбэлэгдсэн, хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөр бүхий үндэсний судалгааны их сургуультай болсон байна.
4. Боловсролын засаглал, удирдлагын тогтолцоог тодорхой болгож, тасралтгүй сайжрах хариуцлагын тогтолцоог бүрдүүлсэн байна.

**III үе шат (2041-2050):** Насан туршдаа суралцахуйг дэмжсэн нээлттэй боловсролын тогтолцоог бэхжүүлэх үе.

1. Сургалтын уян хатан арга замуудтай, харилцан уялдаа бүхий бусадтай хамтран амьдрах, ажиллах чадавх (үнэт зүйлс, зан үйл, амьдралын хэв маяг) бүхий иргэнийг бэлтгэнэ.
2. Нээлттэй сургалтын хөтөлбөр, агуулгыг баяжуулж, боловсролын бүх шатанд хиймэл оюун ухаанд суурилсан технологийг нэвтрүүлсэн байна.

Иргэд эзэмшсэн боловсролоо ашиглан баялаг бүтээж, аз жаргалтай амьдралаа цогцлон бүтээх үндсэн талбар болох хөдөлмөрийн зах зээлийг хөгжүүлэх зорилт нь:

#### **Хөдөлмөрийн зах зээл**

**Зорилт 2.6. Хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, иргэн бүрийг ажилтай, орлоготой болгоно.**

Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн

**I үе шат (2021-2030):** Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангах, хэрэгцээнд суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бэхжүүлэх үе.

1. Мөнгө, санхүүгийн бодлогоор ажлын байрыг нэмэгдүүлж, ажлын байрны статистик мэдээллийг аймаг, сум, дүүргээр гаргадаг болно.
2. Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй, ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж, нээлттэй боловсролын зарчимд тулгуурласан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн тэгш, хүртээмжтэй орчныг бүрдүүлнэ.
3. Хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
4. Оюуны хөдөлмөрийг дэмжсэн цахим, зайн ажлын байрыг нэмэгдүүлэн тогтолцоог нь дэмжиж хөгжүүлнэ.
5. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээлэл сайжирсан байна.
6. Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, дэд бүтцийн томоохон төслүүдийн хөдөлмөрийн хэрэгцээ, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн ажилчдыг бэлтгэж, төгсөгчид ажлын байрыг өөрөө бий болгоход чиглэсэн мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг хөгжүүлнэ.
7. Зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхтэй байдал нэмэгдэж, ажилгүйдлийн түвшин буурч, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгийн хэмжээ нэмэгдсэн байна.

**II үе шат (2031-2040):** Бүтээмжид суурилсан, хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бэхжүүлэх үе.

1. Эдийн засгийн тэргүүлэх чиглэл, ажлын байрны шингээлт ихтэй аж үйлдвэр, хөнгөн үйлдвэрлэл, бүтээмжтэй үйлчилгээний салбарууд, орчин үеийн цахим салбар, эдийн засгийн тэргүүлэх чиглэлээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөдөлмөрийн үнэлгээ, цалин хөлсний оновчтой хэлбэрийг бүрдүүлнэ.
2. Олон улсад оюуны бүтээл, мэдээллийн технологийн болон зөвлөх үйлчилгээг дэмжих зуучлагч компани, төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.

**III үе шат (2041-2050):** Мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, хүн бүр ажилтай, орлоготой болох орчин, нөхцөлийг бүрдүүлэх үе.

1. Цахим эринд шаардагдах үр чадварыг эзэмшүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр бий болгох төр, хувийн хэвшлийн түншлэлийн оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.

#### **Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес**

**Зорилт 3.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх арга, үр чадварыг хөгжүүлж, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.**

Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн

**I үе шат (2021-2030):** Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон үр чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх үе.

1. Залуучуудад бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай бүх төрлийн дэмжлэг, туслалцааг үзүүлэх, орчин, нөхцөл бүрдсэн байна.
2. Бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих орчин бэхжиж, төлөвшсөн байна.
3. Бүтээмжтэй, зохистой ажлын байр бий болгох, аж ахуй эрхлэх, бүтээлч байдлыг хөхиүлэн дэмжиж, ядуурлын түвшин буурч, нийгмийн дундаж давхарга өргөжсөн байна.
4. Нийгмийн бүх салбарт тэгш бус байдлыг багасгаж, дундаж орлоготой иргэдийн тоог нэмэгдүүлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ.

5. Малчин, тариаланчдын 75 хүртэл хувийг өрхийн аж ахуй эрхлэхэд нь хүрэлцэхүйц чадалтай цахилгааны эх үүсвэр, техник, технологиор хангах, хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл болон бусад төрлийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх, малчин өрх, тариаланчдын бэлтгэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх оновчтой тогтолцоог бий болгосон байна.

6. Малчид, тариаланчид бизнесийн тогтвортой орлогын эх үүсвэртэй болсон байна.

**II үе шат (2031-2040):** Жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх үе.

1. Инновац, технологи нэвтрүүлэх, мэдлэг хуваалцах чиглэлээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн нөхцөл бүрдэж, экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, экспортын зах зээлд нэвтрэхэд дэмжлэг үзүүлж, бичил, жижиг, дунд бизнес олон улсад өрсөлдөх боломжтой болсон байна.

**III үе шат (2041-2050):** Бичил, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх үе.

1. Олон улсад өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэлтийн соёл бүрэн төлөвшиж, инновац, шинэ технологи, мэдлэг шингэсэн бичил, жижиг, дунд бизнесийн хөгжил дэлхийн жишигт хүрсэн байна.

Ийнхүү улс орны урт хугацааны хөгжлийн стратегид дэвшүүлсэн зорилтууд нь МБС-ын чанартай шууд холбоотойгоор шийдэгдэх асуудлууд байна. Эдийн засгийг мэдлэгт суурилан хөгжүүлэх, үүний тулд иргэд насан туршдаа тасралтгүй суралцах хэрэгцээнд нийцсэн боловсролын тогтолцоо бүрдүүлэхийг чухалчилсан байна. Ялангуяа энэхүү урт хугацааны хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх эхний арван жилд хөдөө аж ахуй, аж үйлдвэр, дэд бүтцийн томоохон хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мэргэжилтэй ажилтан ажилчдын хэрэгцээ, тэдний мэргэжил боловсролоо шинэчлэх эрэлт шаардлага улам бүр нэмэгдэх болно. Мэргэжлийн боловсрол, сургалтыг төгсгөгчид нь өөрөө ажлын байр бий болгох чадамж эзэмшүүлэхийг зорьж байна.

Монгол Улсын гадаад харилцаа сүүлийн жилүүдэд ихээхэн өргөжиж, дэлхийн томоохон зах зээл болж буй хил залгасан хөрш БНХАУ, ОХУ-ын эдийн засагтай худалдааны нэн таатай нөхцлөөр хамтран ажиллах, Япон болон АНУ, Европын зэрэг стратегийн ач холбогдол бүхий зах зээлд онцгой нөхцлөөр хөнгөлөлт эдлэх түншлэлийн таатай нөхцөл бүрдээд байгаа нь өндөр ур чадвартай мэргэжилтэн бэлтгэх, дахин мэргэшүүлэх, давтан сургах, энэ чиглэлийн судалгааг шинжилгээг өргөжүүлэх эрэлт хэрэгцээг эрс нэмэгдүүлж байна. Манай орны эдийн засаг дэлхийн хамтын нийгэмлэгтэй интеграцчилагдаж, глобал зах зээлийн оролцогч болсон тул иргэдийн мэдлэг, ур чадвар нь глобал эдийн засагт өрсөлдөх хэмжээнд байж зориулалтын шаардлагаа хангах учир боловсрол сургалтын талаар баримтлах бенчмарк нь олон улсын жишиг байх шаардлагатай болж байна.

Монгол Улсын төрөөс *“Боловсрол нь иргэн бүрийн насан туршийн амьдралын чанарыг дэмжин баталгаажуулах, улс орны нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн түлхүүр хүчин зүйл, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа” болохыг иш үндэс болгон “нийгмийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ”* хэмээн Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024 он)-д заажээ. Үүний тулд иргэн бүрийг “авьяас, чадвараа хөгжүүлэн, үр бүтээлтэй хөдөлмөрлөж, аз жаргалтай амьдрахад шаардагдах мэдлэг, чадвар, чадамжийг эзэмшин, ёс суртахуун, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахиж, үндэсний нийтлэг үнэт зүйлсийг өвлөн насан туршдаа суралцах боломжоор хангах зорилго бүхий үйл ажиллагааны цогц тогтолцоо бүрдүүлэх”-ийг төрийн үүрэг гэж тодорхойлсон байна.

Энэхүү бодлогыг:

- боловсролыг хөгжүүлэх бодлого, стратеги, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжүүлэхэд бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч, мэргэжлийн холбоо, эрдэм шинжилгээний байгууллага, судлаач, иргэний оролцоог хангах;

- боловсролын талаар шийдвэр гаргах үйл явц нь нээлттэй, ил тод, судалгаа, нотолгоонд суурилсан, сайн засаглалын зарчимд нийцсэн байх;
- боловсролын байгууллагын хөгжлийн бодлого, төлөвлөлтийг бүтэц, байршил, онцлог хэв шинжид уялдуулан уян хатан тогтоож байх;
- боловсролын удирдлагын бүх түвшинд төрийн болон орон нутгийн, мэргэжлийн, олон нийтийн төлөөллийн байгууллагын бүрэн эрх, үйл ажиллагааны зааг ялгаа, уялдаа холбоог тогтоож, эрх зүйн хувьд баталгаажуулах замаар хэрэгжүүлэхээр заажээ.

Боловсролын талаар төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим нь боловсролын хууль тогтоомжид нэгэн адил тусгалаа олсон бөгөөд олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц чанартай, хүртээмжтэй байх; боловсролын үйл хэргийг төрийн зүгээс нэгдсэн бодлого зохицуулалт, санхүүгийн тогтвортой эх үүсвэрээр хангаж, аж ахуйн нэгж, олон нийт, иргэдийн оролцоог дэмжин, ил тод, нээлттэй, хяналттай байлгах; иргэдийн насан туршид суралцах хэрэгцээ, суралцагчийн сонирхол, авьяас, чадвар, хөгжлийн онцлогт нийцсэн, тэдэнд тэгш боломж олгосон, олон хувилбартай, чөлөөтэй, нээлттэй байх; албан болон албан бус боловсролын нийт байгууллагыг бүх насны иргэдийн боловсролын хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх чадамжтай болгох нь аливаа үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, үр дүнг тооцох үндсэн шалгуур, хэм хэмжээ болох ёстой байна. Түүнчлэн *“Боловсролын үйл хэргийг удирдахад төрийн болон нутгийн захиргааны, иргэний нийгмийн байгууллага, гэр бүл, нийгмийн бүх салбарын оролцоонд суурилсан хамтын ажиллагааг бэхжүүлнэ”* хэмээн заасан нь боловсролын салбар дахь засаглал, удирдлагын гол зарчим болж байна.

Боловсрол, сургалтын агуулгыг мэргэшлийн түвшин бүрт харгалзах зориулалттай холбон тодорхойлсоны дотор ажил хөдөлмөр эрхлэхэд чиглэсэн мэргэжлийн бэлтгэлийг бүрэн дунд боловсролын шатнаас “сонголттой, уян хатан хөтөлбөрөөр мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах чадвар бүхий, ирээдүйд эзэмших мэргэжлийн суурь баримжаа” олгож, мэргэжлийн боловсрол олгох шатанд “хөдөлмөрийн даяарчлагдсан зах зээлд амжилттай өрсөлдөх, бие даан ажлын байр бий болгох”, үндэсний инновацийн чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах чадамж эзэмшихэд чиглэсэн цогц үйл ажиллагаа байхаар заасан байна. Үүний дүнд бүрэн дунд, мэргэжлийн, дээд боловсролын агуулга, боловсролын зэргийг бусад улс оронтой болон бүс нутагт харилцан хүлээн зөвшөөрөх тогтолцоог бүрдүүлж, мэргэжлийн боловсролын чанарын баталгаажилт, магадлан итгэмжлэлийн тогтолцоог төгөлдөржүүлэн 2024 он гэхэд тэргүүлэх чиглэлийн дээд болон мэргэжлийн боловсролын 20-иос цөөнгүй хөтөлбөрийг олон улсад магадлан итгэмжлүүлэх зорилтыг тусгасан байна.

Мэргэжлийн боловсролыг хөгжүүлэх бодлогыг үндэсний хөгжлийн стратеги, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулж, бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагаанд өөрийн үнэлгээ, дотоод мониторингийн тогтолцоог хэвшүүлж, боловсрол сургалтын байгууллагад өмчийн хэлбэр харгалзахгүй адил тэгш шаардлага тавьж, хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлэхээр заасан байна.

Боловсролд зориулан зарцуулах хөрөнгө, төсвийн төлөвлөлт, хуваарилалт нь Монгол Улсын Үндсэн хууль, боловсролын тухай хуулиуд, төсвийн тухай хууль болон үндэсний хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тодорхойлсон зорилт, арга хэмжээнд үндэслэдэг. 1990 оныг хүртэл боловсрол, сургалтын бүх үйл ажиллагааг улсын төсвөөс бүрэн санхүүжүүлж байсаны зэрэгцээ ТМС, ТМДС, их, дээд сургуульд суралцагчдад сар бүр мөнгөн тэтгэлэг (стипенд) олгож байв. Харин 1990-ээд оны эхнээс улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг нэр төрөл, хэмжээний хувьд бууруулсаар 1993 оноос дээд боловсролыг үнэ төлбөртэй болгож, сургалтын төлбөрийг суралцагч өөрөө хариуцах журамд шилжжээ.

Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт төр засгийн зүгээс үзүүлэх анхаарал дэмжлэг сүүлийн жилүүдэд нэмэгдсэний зэрэгцээ хандивлагчид ихээхэн анхаарал хандуулж, АНУ-ын Мянганы сорилтын сан, Азийн хөгжлийн банк, Европын холбоо, ХБНГУ, Швейцари, БНСУ болон Оюу Толгой төслийн шугамаар ихээхэн тусламж үзүүлж, хөтөлбөр хэрэгжүүлсэн ч дараах асуудал бүрэн шийдэгдээгүй байна<sup>6</sup>:

- сургалтын агуулга, хөтөлбөр нь ялангуяа дээд болон МБС-ын шатанд хөдөлмөрийн зах дээр гарч буй өөрчлөлт, ажил олгогчдын эрэлт шаардлагыг тусгаж чадахгүй байна. Сүүлийн жилүүдэд зарим сургууль, хөтөлбөрийг олон улсын хэмжээнд магадлан итгэмжлүүлсэн (дээд боловсролын 17 байгууллага, 89 хөтөлбөр, мэргэжлийн боловсролын 4 сургууль олон улсад магадлан итгэмжлэгдсэн<sup>7</sup>) боловч нийт хөтөлбөртэй харьцуулахад хэт цөөн байна.
- хэдийгээр хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлсээр байгаа боловч сургалтын шаардлагатай орчин бүрдүүлэх, холбогдох стандартад нийцсэн ур чадвар, чадамж эзэмшүүлэх техник, тоног төхөөрөмж, тавилга, барилга байгууламж, дэд бүтэц хүрэлцээгүй хэвээр байна.
- багшийн хөгжлийг дэмжих, тэдний аргазүйг сайжруулахад шаардлагатай аргачлал, мэргэжлийн хэвлэл, мэдээлэл дутмаг
- сургууль, боловсролын байгууллагын удирдлага менежмент нь улс төрийн өөрчлөлтөд өртөмтгий, бодлого нь тогтвортой биш, мэргэжлийн болон сонирхлын бүлгүүдийн оролцоо дэмжлэг сул. МБСБ-ын Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн нь улс төрөөс хараат, чиг үүргээ хэрэгжүүлэх эрх мэдэлгүй, нийтийн эрх ашгийн үүднээс засаглалыг хэрэгжүүлэх туршлага чадавхи суугаагүй байна.
- богино настай олон өөрчлөлт дараагийн шинэтгэлийн санаачилгад итгэл алдруулж, аливаа өөрчлөлтийг эсэргүүцэх уур амьсгал давамгайлах болсон.

---

<sup>6</sup> Bat-Erdene et al. (2013). *Capability Supply Landscape Study - Mongolia Report I: Assessment of Current and Future Mongolian Education System Capacity for Labour Force Supply in Mongolia*

<sup>7</sup> БШУЯ (2022). *Боловсролын салбарын статистикийн мэдээлэл 2021-2022*, х. 94.

## МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

### Монгол Улсын мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоо

Монгол Улсад мэргэжилтэй ажилчин, ажилтан бэлтгэх зохион байгуулалттай сургалт 1922 оноос эхтэй бөгөөд хөгжлийн үе шатууд нь улс орны эдийн засгийн бодлого төлөвлөлттэй шууд холбоотой явж иржээ. Өнөөдөр мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоо нь техникийн боловсрол, мэргэжлийн боловсрол, мэргэжлийн сургалт эрхэлдэг байгууллагаас бүрдэж байна. Эдгээр байгууллага, түүнд суралцагчдын тооны өсөлтийг дээд боловсролын суралцагчдын тооны өөрчлөлттэй харьцуулан дараах хүснэгтэд харуулав.

**Хүснэгт 1: Монгол Улсын техникийн болон мэргэжлийн боловсролын байгууллага, түүнд суралцагчдын тоонд гарсан өөрчлөлт, 1922-2021**

Он	Сургуулийн тоо		Суралцагчийн тоо		
	ТМС*	ТМДС**	Техник мэргэжил*	Тусгай дунд**	Дээд (бакалавр)
1922		1		15	
1925		3		105	1
1930		3		145	1
1935		3		375	10
1940		7		1,332	197
1945		13		1,744	309
1950		12		3,186	1,476
1955		15		4,493	3,039
1960		15		8,811	6,909
1965	10	18	4,761	9,231	10,677
1970	28	19	10,628	11,121	8,427
1975	34	22	13,483	13,465	13,643
1980	37	25	22,109	18,734	23,214
1985	40	28	27,718	22,978	24,597
1990	44	31	29,067	18,478	17,338
1995	38	27	7,987	5,584	31,973
2000	36		12,177	4,224	77,281
2005	35		23,249	4,771	125,642
2010	63		46,071	4,045	151,612
2015	81		42,675		140,296
2018	86		38,526	362	130,545
2019	80		40,011	98	119,203
2020	75		42,073	124	119,108
2021	76		42,594	3,155	117,037

**Тайлбар:** \* ТМС – Техник мэргэжлийн сургууль, 1992 оноос Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, политехник коллежийн мэдээг нэгтгэсэн.


\*\* ТМДС – Тусгай мэргэжлийн дунд сургууль буюу техникийн боловсролтой жишихүйц хөтөлбөр бүхий сургууль, суралцагчид. Энэ төрлийн боловсрол эзэмшихээр суралцагчдын тоог 2010 оноос техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтанд суралцагчидтай нэгтгэн гаргаж байна. Харин 2017 оноос энэ ангилалд дүйцэх “дипломын” дээд боловсролын хөтөлбөрт суралцагчдын тоог тусад нь тайлагнах болжээ.

**Эх сурвалж:** БСШУЯ (2001). *Монгол Улсын боловсролын салбарын үүсэл хөгжил 80 жилд*, Үндэсний статистикийн хороо, БШУЯ болон ХНХЯ-ны статистик мэдээ



Монгол Улс 1990-ээд оны эхнээс эдийн засгийн бүх салбарыг либеральчилж, хувийн секторын оролцоог албан ёсоор зөвшөөрч, төрийн мэдлийн зарим байгууллага, үйлчилгээг хувьчлах бодлого хэрэгжүүлсэний дүнд нийгмийн институциудын бүх шатанд бүтцийн болон тооны өөрчлөлт гарав. Хүмүүсийн шинээр үүссэн хэрэгцээг мэдэрч гадаад хэл, авто жолооны болон засвар үйлчилгээний ур чадвар олгох төлбөртэй сургалтыг иргэд, аж ахуйн нэгж 1980-аад оны сүүлээс эхэлсэн боловч тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн боловсролын албан ёсны хөтөлбөр бүхий хувийн өмчийн сургууль боловсролын бусад салбараас нэлээд хожим, 2000 оноос хойш байгуулагдаж эхэлжээ.

**Зураг 3: Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын тооны өсөлт, 2004-2021**



Эх сурвалж: БШУЯ-ны статистик мэдээ, 2022

Мэргэжлийн боловсрол, сургалтын хүрээнд сургууль болон суралцагчдад төсвөөс шилжүүлэх хөрөнгө санхүүжилт шууд болон шууд биш хэлбэртэй болсоноос гадна гадаадын санхүүжилттэйгээр төсөл хөтөлбөр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, хандив, дэмжлэг тусламж олон сувгаар хэрэгжиж байна. Суралцагчдад олгож байсан стипенд, байр, хоол, хувцасны тэтгэлэгийг 1990-ээд оны эхээр зогсоосон боловч сургалтыг төлбөргүй хэлбэрээр үргэлжлүүлж, 2007 оноос мөнгөн тэтгэлэгийг дахин өгч эхлэв<sup>8</sup>. Мэргэжлийн боловсрол, сургалтанд хамрах хэмжээг нэмэгдүүлэхэд тэтгэлэг хамгийн үр дүнтэй гэсэн ойлголт улс төрийн дээд албан тушаалтнуудад нийтлэг байна. Ийм ч учраас 2007 онд сэргээн эхлүүлэхдээ 20 мянган төгрөг<sup>9</sup>-өөр тогтоосон тэтгэлэгийн хэмжээг дараагийн жилийн эхнээс 45 мянга, 2013 онд 70 мянган төгрөг<sup>10</sup> болгон нэмэгдүүлжээ. Харин 2016-2018 онд энэ тэтгэлэгийг зогсоосны дараа 2019 оны эхнээс 100 мянган төгрөгийн тэтгэлэг<sup>11</sup>, 2020 оноос тэтгэлэгийн хэмжээг 200 мянган төгрөг<sup>12</sup> болгож политехник коллеж, МСҮТ-ийн мэргэжлийн болон техникийн боловсрол олгох хөтөлбөрийн өдрийн ангид суралцагчид, “улс орны бүтээн байгуулалтад шаардлагатай мэргэжилтэй ажилтанг ажил олгогчийн захиалгаар 4-6 хүртэлх сарын сургалтанд” хамрагдах 45 хүртэлх насны иргэнд олгож өгч байхаар шийдвэрлэсэн байна. Үүнээс хоёр жилийн тэтгэлэгийн хэмжээг сард 200 төгрөгөөр тооцон мэргэжлийн болон техникийн боловсролыг анх удаа эзэмшихээр холбогдох тусгай зөвшөөрөл бүхий сургуульд өдрийн ангид суралцаж буй 45 хүртэлх насны иргэнийг ямар нэг зөрчил гаргалгүйгээр сургуулиа төгсгөхөд нь олгож байхаар (суралцаж байхад нь бус, сургуулиа төгсгөсний дараа олгож буй энэ мөнгийг “тэтгэлэг” гэж тодорхойлоход

<sup>8</sup> Засгийн газрын 2007 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 294 дүгээр тогтоол

<sup>9</sup> Засгийн газрын 2008 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 30 дугаар тогтоол

<sup>10</sup> Засгийн газрын 2013 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 329 дүгээр тогтоол


<sup>11</sup> Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 12 дугаар тогтоол

<sup>12</sup> Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн 44 дүгээр тогтоол

зохимжгүй юм) журамлажээ<sup>13</sup>. Ийнхүү тэтгэлэг олгох, түүнийг зогсоох шийдвэр нь үнэхээр элсэлтийн тоонд нөлөөлж байсаныг *Зураг 4*-д харуулсан суралцагчдын тооны өөрчлөлтөөс ажиглаж болно. Харин энэ нь төгсгөгчдийн ажил эрхлэлтэд төдийлэн өөрчлөлт гаргаагүйг ХНХСИ-ийн мөшгөх судалгааны дүн илтгэдэг.

2006 онд Засгийн газраас баталсан “Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-нд мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрт суралцагчдын тоог арван жилд 2005 оны түвшнээс 56 хувиар өсгөх зорилт дэвшүүлж байсан бол 2008 онд тэтгэлэг өгч эхэлсэнээр 2009 он гэхэд суралцагчдын тоо 2007 оны түвшнээс 50 хувь нэмэгдэж зорилт үндсэндээ биелсэн, харин тэтгэлэгийг 2016 онд зогсоосноор элсэлт мэдэгдэхүйц буурч, 2019 оноос тэтгэлэгийг сэргээснээр өсөлт гарсан нь харагдаж байна (*Зураг 4*-ийг үз). Суралцагчдын тоо өсөхөд суралцагчид тэтгэлэг, сургуульд нь хувьсах зардал олгох болсонтой холбоотойгоор хувийн өмчийн мэргэжлийн сургуулийн тоо 2007 оноос эрс нэмэгдсэн нь мөн нөлөөлсөн гэж үзэж болно.

**Зураг 4: МБС-ын суралцагчдын тооны өсөлт, 2007-2021**



*Эх сурвалж:* БШУЯ-ны статистик мэдээ, 2022

2009 онд шинэчлэн найруулж баталсан Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд “Мэргэжлийн боловсрол, сургалтын зорилго нь иргэний авьяас, сонирхол, хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн мэргэжлийн ур чадвар, боловсрол эзэмшүүлэх, мэргэшлийг дээшлүүлэх, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэхэд оршино” (5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт) хэмээн заасан нь энэхүү боловсрол нь бүх насны хүмүүсийн ажил хөдөлмөр эрхлэх мэдлэг, ур чадвараа тасралтгүй дээшлүүлэх хэрэгцээнд нийцсэн насан туршийн боловсрол, сургалтын систем болохыг илэрхийлж байна. Энэ агуулгаараа албан болон албан бус боловсролын бүх шатанд олон төрөл хэлбэрээр хэрэгжих үйл ажиллагаа хэмээн ойлговол зохилтой бөгөөд ЮНЕСКО/ЮНЕВОК-ийн тодорхойлсон агуулгатай бүрнээ нийцэж байна.

#### **Шигтгээ 1. Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт гэж юу вэ?**

Үйлдвэрлэл, үйлчилгээний ажлын байранд мэргэжлийн ажилбарыг гардан гүйцэтгэхэд шаардагдах боловсрол, ур чадварыг эзэмшүүлэх үйл ажиллагааг бүхэлд нь Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт (ТМБС) хэмээн нэрлэх нь зохимжтой хэмээн 1999 онд БНСУ-ын Сөүл хотноо чуулсан Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын дэлхийн хэмжээний конгресст оролцогчид зөвшилцөн тогтсон байна.

<sup>13</sup> Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 122 дугаар тогтоол



ТМБС–ын анхны зорилго нь тодорхой ажлын байранд зориулсан бэлтгэл байсан бол хорьдугаар зууны технологийн хувьсгал, шинжлэх ухаан, технологийн инновацийн эринд мэдлэгийн шинэ домэйн, түүний хэрэглээний шинэ чиглэлүүд хөгжихийн хэрээр боловсрол, сургалтын зориулалт, мөн чанарт ихээхэн өөрчлөлт гарсан байна. Үүний дүнд ТМБС нь анх үүсэхдээ боловсролын шатлалын нэгдүгээр шатанд хамаардаг байсан бол хоёрдугаар, дараа нь гурав дахь түвшнийг дамнасан систем болж өргөжжээ. Өнөөдөр дэлхий нийтээр мэдлэгийн эдийн засагт дэвшин орж байгаатай уялдан аж үйлдвэржилтийн үеийн ажилчнаас мэдээллийн эрин үеийн мэдлэгийн ажилчин бэлтгэх цогц систем болох шилжилтийн үе хэдийнээ эхлээд байна. Иймд ТМБС нь мэргэжлийн боловсрол, сургалтын уламжлалт байгууллагууд төдийгүй ерөнхий боловсролын дунд, ахлах болон дээд боловсролын хөтөлбөр, ажлын байран дээрх сургалт болон мэргэшил дээшлүүлэх, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх олон төрөл хэлбэрийн сургалтыг хамарсан тасралтгүй мэргэшүүлдэг насан түршийн боловсролын тогтолцооны нэг хэсэг юм

(*UNEVOC TVETipedia Glossary*

<https://unevoc.unesco.org/go.php?q=more+about+What+is+TVET&context=> )

НҮБ-аас боловсролын талаар дэвшүүлсэн зорилтыг илэрхийлсэн “Боловсрол–2030” Инчеоны тунхаглалын үзэл баримтлал нь “*бүх нийтийг бүрэн хамарсан, тэгш чанартай боловсрол эзэмшүүлэхийг баталгаажуулж, насан туршдаа суралцах боломжийг дэмжих*” тухай Тогтвортой хөгжлийн 4 дэх зорилтыг дэлгэрэнгүй тусгажээ. Энэ үзэл баримтлалд техникийн болон мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, ТМБС-ын чанарыг холбогдох талууд хүлээн зөвшөөрөх түвшинд хүргэж, хөдөлмөр эрхлэх, хийж буй ажилдаа сэтгэл ханамжтай, бүтээлч хандахад илүү сайн бэлтгэх тэгш хүртээмжтэй болгоход онцгой ач холбогдол өгсөн байна.<sup>14</sup> Энэ нөхцөлд ТМБС нь хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдийн ажил хөдөлмөр эрхлэх, түүндээ сэтгэл ханамжтай, бүтээлч санаачлагатай хандах, эдийн засгийн тэгш оролцоотой, тогтвортой хөгжлийг дэмжих, байгаль орчны тэнцвэртэй байдлыг тэтгэсэн ногоон эдийн засагт шилжихэд бэлтгэж чадавхижуулах замаар эдийн засаг, нийгэм, хүрээлэн байгаа байгаль орчны тулгамдсан асуудлыг шийдэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ хэмээн үзэж байна. ТМБС нь бага боловсролын дараах шатны боловсролыг бүхэлд нь хамарсан цогц системийн бүрэлдэхүүн хэсэг учир сургалтын олон төрөл хэлбэр, үе шатыг хамарсан стандарттай, системтэй хяналт, үнэлгээний үндсэн дээр чанарыг баталгаажуулах, иргэдийн эзэмшсэн ур чадвар, чадамжийг гэрчилгээжүүлэх тогтолцоотой байх шаардлагыг тодорхойлсон байна.<sup>15</sup>

Ийнхүү дэлхий нийтэд ТМБС-ын талаар баримтлах хандлага, үнэлэмж өөрчлөгдөж байгаа үйл явцтай харьцуулан үзвээс Монгол Улсын Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд тодорхойлсон зорилго, агуулга нь дээрх чиг хандлагыг тусгасан байна. Энэ үзэл баримтлалын үүднээс иргэдийн насан туршдаа суралцах системийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг болох МБС-ыг хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлэх нь боловсролын бүх шатны байгууллагын харилцан уялдаа холбоотой үүрэг, оролцоонд тулгуурлах шаардлагатай болж байна.

Өнөөдөр МБС-ыг эрхэлдэг үндсэн байгууллагыг техникийн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх *Политехник коллеж (ПК)*, мэргэжлийн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх *Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв (МСҮТ)*, тодорхой чиглэлийн ур чадвар эзэмшүүлэх богино хугацааны сургалт бүхий *Мэргэжлийн сургалтын төв* гэсэн гурван төрлийн

<sup>14</sup> UNESCO Strategy for Technical and Vocational Education and Training (TVET) 2016-2021  
<https://unevoc.unesco.org/go.php?q=UNESCO+TVET+Strategy+2016-2021>

<sup>15</sup> Report by UNESCO Director-General on the Execution of the Programme adopted by the General Conference Progress on the Implementation of the Strategy for Technical and Vocational Education and Training (TVET), 2009:  
<https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000183317>

байгууллагад ангилан хуваадаг. Дээрх бүдүүвчид мэргэжлийн сургалт нь техник технологи, ажлын байрны хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлагыг тусгасан, хамгийн шинэлэг бөгөөд нарийн төвөгтэй мэдлэг, ур чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн харьцангуй өндөр түшний сургалт бөгөөд хамрагдах суралцагчдын тоо, сургалтыг явуулахад шаардагдах хэрэглэгдэхүүнээс хамааран сургуулийн, эсвэл үйлдвэрлэлийн нөхцөлд зохион байгуулбал зохихыг харуулж байна. Өнөөдөр үүнтэй дүйцэх суралтыг ихэвчлэн томоохон аж ахуйн нэгж өөрийн хүчээр зохион байгуулж буй. Харин практикт “хөдөлмөр эрхлэх сургалт” нэрээр голчлон хувиараа хөдөлмөр эрхлэх хүмүүст зориулсан ур чадвар эзэмшүүлэх болон гадаад хэл, жолооны зэрэг сургалтыг эрхлэх байгууллагыг сургалтын төв хэмээн нэрлэж харьцаж байна. Түүнчлэн 2015 оноос Япон улсын туршлагад түшиглэн байгуулж эхэлсэн техникийн боловсролтой дүйцэх хөтөлбөр бүхий коосэнийг МБС-ын байгууллагад хамаарах эсэхийг тогтоогоогүй байна. Мөн инженер, техникийн дээд боловсрол олгож буй их, дээд сургууль ч политехник коллежтэй хөтөлбөрөө уялдуулах, техникийн боловсролын хөтөлбөрөөр эзэмшсэн мэдлэг чадварын шатанд шилжүүлэн дүйцүүлж тооцох нөхцөл бүрдээгүй байна.

Дээрх байдлыг МБС-ын албан ёсны статистик мэдээнээс харж болно. Энэ мэдээнд МБСБ-ыг *Политехник коллеж, Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, Их, дээд сургуулийн салбар* гэсэн ангиллаар ялгаж харуулах боловч дээр дурдсан Коосэн болон мэргэжлийн сургалтын төвийн мэдээ албан ёсны статистикт тусахгүй байна. Түүнчлэн их, дээд сургуулийн салбарт суралцагчдыг суралцаж буй хөтөлбөрийн төрөл, мэргэжлийн чиглэлээр нь ангилан харуулж, бодлого, төлөвлөлтийн суурь мэдээлэл болгон ашиглах нь дутмаг байна.

## Хүснэгт 2: МБС-ын үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	Хичээлийн жил											
	2011- 2012	2012- 2013	2013- 2014	2014- 2015	2015- 2016	2016- 2017	2017- 2018	2018- 2019	2019- 2020	2020- 2021	2021- 2022	
<b>Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага</b>												
<b>нийт</b>	<b>71</b>	<b>78</b>	<b>79</b>	<b>76</b>	<b>81</b>	<b>86</b>	<b>83</b>	<b>86</b>	<b>80</b>	<b>75</b>	<b>76</b>	
1а.-төрийн өмчийн	49	50	53	52	49	50	50	51	50	46	43	
-хувийн өмчийн	22	28	26	24	32	36	33	35	30	29	33	
1b. Байршил: -хотод	28	34	34	32	38	42	42	43	39	36	37	
-орон нутагт	43	44	45	44	42	44	41	43	41	39	39	
-гадаадад	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	
<b>Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчид</b>												
<b>2. Нийт</b>	<b>48,134</b>	<b>45,225</b>	<b>42,798</b>	<b>42,797</b>	<b>42,675</b>	<b>40,134</b>	<b>35,831</b>	<b>38,526</b>	<b>40,011</b>	<b>42,073</b>	<b>42,594</b>	
<b>үүнээс эмэгтэй</b>	<b>21,694</b>	<b>20,643</b>	<b>19,189</b>	<b>18,252</b>	<b>17,286</b>	<b>15,900</b>	<b>13,941</b>	<b>15,077</b>	<b>16,440</b>	<b>16,821</b>	<b>17,063</b>	
2а. хотод	18,720	19,286	18,182	18,404	20,079	19,725	16,868	19,689	19,594	20,640	20,919	
орон нутагт	29,414	25,939	24,616	24,393	22,564	20,409	18,963	18,837	20,417	21,433	21,675	
гадаадад	-	-	-	-	32	-	-	-	-	-	-	
2b. Төрийн өмчийн сургуульд	37,227	35,256	33,525	32,896	31,572	29,145	25,707	27,712	29,148	30,118	30,194	
үүнээс эмэгтэй	16,267	15,798	15,028	13,820	12,622	11,018	9,528	10,598	11,622	11,429	11,216	
2с. Хувийн өмчийн сургуульд	10,907	9,969	9,273	9,901	11,103	10,989	10,124	10,814	10,863	11,955	12,400	
үүнээс эмэгтэй	5,427	4,845	4,161	4,432	4,664	4,882	4,413	4,479	4,818	5,392	5,874	
<b>3. Шинээр элсэгч</b>	<b>19,417</b>	<b>19,607</b>	<b>20,921</b>	<b>20,804</b>	<b>20,961</b>	<b>18,769</b>	<b>19,519</b>	<b>24,999</b>	<b>24,853</b>	<b>24,628</b>	<b>22,554</b>	
<b>үүнээс эмэгтэй</b>	<b>8,213</b>	<b>8,635</b>	<b>8,821</b>	<b>8,445</b>	<b>8,214</b>	<b>7,631</b>	<b>7,854</b>	<b>9,485</b>	<b>10,396</b>	<b>10,613</b>	<b>10,017</b>	
3а. тухайн жилд 9 дүгээр анги төгсгөгч	11,116	10,741	9,944	10,928	10,388	5,455	5,809	7,521	8,435	9,095	7,913	

3в. тухайн жилд 12 дугаар анги төгсгөгч	4,094	4,123	5,738	5,130	3,195	4,416	3,246	4,905	2,892	2,112	1,560
<b>4. Нийт төгсгөгч</b>	<b>23,120</b>	<b>23,393</b>	<b>18,358</b>	<b>18,978</b>	<b>19,488</b>	<b>19,531</b>	<b>20,379</b>	<b>21,206</b>	<b>18,887</b>	<b>19,734</b>	
4а. ажил эрхэлж буй төгсгөгч	12,855	13,334	11,508	10,759	7,665	9,034		12,322	9,724	10,204	
4б. Ажил эрхэлж буй төгсгөгч, %	55.6	57	62.7	56.7	62.3	46.2	62.3	58.1	51.5	51.7	
<b>Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагад ажиллагчид</b>											
<b>5. Нийт ажиллагч</b>	<b>3,735</b>	<b>4,004</b>	<b>4,613</b>	<b>4,409</b>	<b>4,520</b>	<b>4,714</b>	<b>4,227</b>	<b>4,624</b>	<b>4,403</b>	<b>4,061</b>	<b>3,944</b>
үүнээс эмэгтэй	2,347	2,552	2,878	2,774	2,894	2,906	2,656	2,985	2,864	2,605	2,559
<b>6. Үндсэн багш</b>	<b>2,093</b>	<b>2,236</b>	<b>2,498</b>	<b>2,327</b>	<b>2,504</b>	<b>2,503</b>	<b>2,230</b>	<b>2,469</b>	<b>2,388</b>	<b>2,242</b>	<b>2,124</b>
үүнээс эмэгтэй	1,330	1,461	1,608	1,497	1,621	1,569	1,369	1,564	1,551	1,433	1,387

Эх сурвалж: БШУЯ-ны статистикийн мэдээнээс авав.

2021-2022 оны хичээлийн жилд суралцагчдын 11 хувь нь техникийн боловсрол, 88 хувь нь мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт, үлдэх 1 хувь нь чадамжийн үнэмлэх, гэрчилгээ олгох мэргэжлийн сургалтанд суралцагчид (Хүснэгт 3) байгаа нь гурван жилийн өмнөхтэй харьцуулахад техникийн боловсролын хөтөлбөрт суралцагчид 7 хувиар, чадамжийн сургалтанд хамрагдагчид 4 дахин буурч, мэргэжлийн боловсролын хөтөлбөрт суралцагчид нэмэгдсэн байна.

### Хүснэгт 3: Мэргэжлийн боловсрол, сургалтын суралцагчид, сургалтын хөтөлбөрөөр, 2021-2022 оны хичээлийн жил

	Нийт суралцагч	Техникийн боловсрол		Мэргэжлийн боловсрол		Мэргэжлийн сургалт		
		1.5 жил	3 жил	1 жил	2.5 жил	1 сар хүртэл	1-3 сар	4-6 сар
<b>Бүгд</b>	<b>42,594</b>	<b>2,742</b>	<b>2,104</b>	<b>12,559</b>	<b>24,751</b>	<b>341</b>	<b>59</b>	<b>38</b>
Төрийн өмчийн								
- МСҮТ - 21	7,395	-	-	3,233	4,129	-	7	26
- Политехник коллеж - 20	20,185	1,627	1,328	3,655	13,485	38	52	
- ИДС-ийн харьяа сургалтын байгууллага - 5	2,614	146	540	945	735	248		
Төрийн бус өмчийн								
- МСҮТ - 25	5,553			3,533	1,953	55		12
- Политехник коллеж - 8	6,847	969	236	1,193	4,449			

Эх сурвалж: БШУЯ-ны статистикийн мэдээ

Суралцагчдын 99.7 хувь нь өдрийн ангид, Дорноговь аймаг дахь Төмөр замын МСҮТ-ийн 43 суралцагч хосмог сургалтанд хамрагдсан гэжээ. Политехник коллежид суралцагчдын 15-17 хувь нь л техникийн боловсролын хөтөлбөрт, 83-85 хувь нь мэргэжлийн боловсролын хөтөлбөрт суралцдаг, зарим политехник коллежид техникийн боловсролын хөтөлбөр байдаггүй нь энэ ангиллын сургууль эрхэлж буй сургалтын чиг үүргээр МСҮТ-ээс төдийлэн ялгаагүйг харуулж байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрт суралцагчдын албан ёсны мэдээнд сургуулиас ирүүлсэн мэдээг нэгтгэж тайлагнадаг, харин сургуулиас бусад байгууллага, орчинд иргэдийн эзэмшиж буй ур чадвар, түүнд хамаарах мэдээлэл орхигддог. Суралцагчдын мэргэшиж байгаа хөтөлбөрийг үйлдвэрлэлийн салбараар ангилан бүлэглэж тайлагнаж байсан үеийн мэдээг дор харуулав (Хүснэгт 4). Энэ мэдээнд хамгийн олон суралцагчтай “аж үйлдвэр” гэсэн бүлэгт гагнуурчин, техникч, механикч, технологичийн хамт хүнс, ноос, ноолуурын үйлдвэрлэлийн мэргэжил, оёдолчин, тогооч, зөөгч, бармен, кофе бэлтгэгчийн зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний олон мэргэжлийг хамруулсан нь бодлогын шинжилгээ, төлөвлөлтөд төдийлэн тохиромжгүй ажээ. Гэтэл хэдийгээр салбарын онцлогтой боловч

мэргэжлийн хувьд нийтлэг агуулга ихтэй (мэргэжлийн үндсэн чадвар нь ижил суурьтай) хүнд машин механизмын засвар, техник үйлчилгээ, оператор, цахилгааны мэргэжлээр суралцагчдын мэдээг барилга, уул уурхай, тээвэр, ХАА-н салбарт тус тусад нь хамааруулан ангилсан байна. МБС-ын үндсэн зорилго хэрхэн хэрэгжиж буйг үнэлэх, үүнд үндэслэн бодлогын шийдвэр гаргахад мэдээлэл, ялангуяа албан ёсны статистик мэдээлэл бүрэн дүүрэн, үнэн бодитой, анализ шинжилгээ хийх шаардлагад нийцсэн байх ёстой. Энэ тохиолдолд суралцагч, хөтөлбөрийн талаарх мэдээлэл нь салбараар бус, мэргэжлийн бүлгээр ангилагдсан байх нь илүү зохимжтой болно.


**Хүснэгт 4: Политехник коллеж, МСҮТ-д суралцагчид, сургалтын хөтөлбөрөөр, 2018-2019 оны хичээлийн жил**

№	салбарын нэр	нийт суралцагч	Техникийн боловсрол		Мэргэжлийн боловсрол		Мэргэжлийн сургалт	
			Техникийн боловсролын хөтөлбөр		Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр			
			Мэргэжлийн диплом		Мэргэжлийн боловсролын үнэмлэх		Мэргэжлийн үнэмлэх & чадамжийн гэрчилгээ	
			хөтөлбөр/мэргэжил	суралцагч	хөтөлбөр/мэргэжил	суралцагч	хөтөлбөр/мэргэжил	суралцагч
1	аж үйлдвэр	10,456	8	1,402	31	8,738	8	316
2	барилга	7,135	11	814	13	6,057	7	264
3	тээвэр	4,281	7	921	14	3,328	2	32
4	уул уурхай	2,519	8	457	14	1,905	3	157
5	үйлчилгээ	2,254	2	231	5	1,952	2	71
6	эрүүл мэнд	2,033	9	1,863	2	170		
7	соёл урлаг	2,019	12	404	22	1,615		
8	мэдээллийн технологи	1,751	4	164	10	1,587		
9	хөдөө аж ахуй	1,546	4	277	12	1,269		
10	цагдаа, батлан хамгаалах, онцгой байдал	1,052			19	237	5	815
11	байгаль орчин, аялал жуулчлал	812	1	85	7	727		
12	санхүү, бизнес, худалдаа	547	1	73	4	474		
13	эрчим хүч	277	2	87	4	190		
14	боловсрол	155	1	55	1	100		
15	шуудан харилцаа холбоо	101			2	101		
16	хот байгуулалт	101			1	101		
	бүгд	37,039	70	6,833	161	28,551	27	1,655

Эх сурвалж: ХНХЯ-ны статистикийн мэдээнээс авав.

2021-2022 оны хичээлийн жилийн элсэгчдийн 35 хувь нь өмнөх хавар бүрэн бус дунд сургууль (9 дүгээр анги)-ийг төгсгөгчид, 7 хувь нь бүрэн дунд сургууль (12 дугаар анги)-ийг төгсгөгчид, бусад 58 хувь нь насанд хүрэгчид байжээ. МБС нь боловсролын бусад салбартай харьцуулахад эрэгтэйчүүд илүүтэй суралцдаг (60 хувь нь эрэгтэй) ганц салбар болно. 2011 оноос хойш элсэгчдийн дотор ерөнхий боловсролын сургуулийг төгсгөгчдөөс элсэгчдийн хувийн жин 78 хувиас 2021 онд 42 хувь болтлоо буурч, ажил эрхэлж байгаа болон ажилгүй хүмүүсийн элсэн суралцах нь мэдэгдэхүйц нэмэгдсэн байна. Нийт суралцагчдын 28 хувь нь 23-аас дээш насны иргэд, харин шинээр элсэгчдийн 46 хувь 23-аас дээш буюу харьцангуй “уламжлалт бус” насны суралцагчид байна. 23-аас дээш насныхан техникийн боловсролын хөтөлбөрт суралцагчдын 39 хувийг, мэргэжлийн сургалтын хөтөлбөрт суралцагчдын 84 хувийг бүрдүүлж байна. Шинээр элсэгчдийн 22 хувь нь 31-40 настай, 5.4 хувь нь 40-өөс дээш настай иргэд байжээ. Ийнхүү сүүлийн арав гаруй жилд суралцагчдын насны бүлэгт гарч буй өөрчлөлт нь МБС “уламжлалт бус” насны иргэдийг хамарч насан туршийн боловсролын институц болох шилжилт явагдаж байна гэж үзэж болох юм.

**Зураг 5: МБС-ын сургуульд элсэгчдийн тооны өсөлт: 2011-2021 он**



Эх сурвалж: ХНХЯ, БШУЯ-ны статистикийн мэдээнээс авав.

Мэргэжлийн боловсрол, сургалтын мэдээнд хамруулдаггүй байгууллагууд бол шинэхэн байгуулагдсан коосен, ХНХЯ-ны шугамаар үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авч ажилладаг сургалтын төвүүд юм. 2014 онд ШУТИС, Шинэ Монгол Технологийн дээд сургууль (ШМТДС), Техник Технологийн дээд сургууль (ТТДС)-ийн харъяанд тус бүр нэг Коосен нээгджээ. Энэ хөтөлбөрт ерөнхий боловсролын сургуулийн 9 дүгээр ангийг дүүргэсэн сурагчдаас элсүүлж, 5 жилийн хөтөлбөрөөр инженерийн дээд боловсролын диплом олгодог. Эдгээр сургуульд эхний 3 жилдээ суралцаж байгаа сурагчдын тоо мэдээг бага дунд боловсролын, харин сүүлийн хоёр жилд суралцагчдын мэдээг дээд боловсролын мэдээнд хамааруулдаг хэмээн холбогдох ажилтнууд тайлбарлав. Энэ нь мэдээг хэрхэн ашиглах зорилготой холбох бус, хаанаас цуглуулах боломжийг илүүтэй чухалчилж, боловсрол сургалтын үйл ажиллагаанаас илүүтэй сургалтын байгууллагын тухай мэдээ гаргах нь хялбар дөхөм байдагтай холбоотой байж болох юм.

2022 оноос МБС-д хамаарах төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх Боловсрол, шинжлэх ухааны яаманд шилжсэн, харин мэргэжлийн сургалтын асуудлыг ХНХЯ-ны харьяанд үлдээсэн байна. Энэхүү журмын дагуу бүртгэснээр мэргэжил олгох буюу ур чадвар олгох 426 сургалтын төв, тээврийн хэрэгслийн жолоо бэлтгэх 383 сургалтын төв, хэлний дагнасан сургалтын 238 төв ажиллаж байгаа ажээ.

Хөдөлмөрийн захын барометрийн судалгаагаар хамгийн их эрэлттэй нь тогтоогдсон мэргэжлээр үнэ төлбөргүй, харин ч мөнгөн тэтгэлэгтэй суралцах боломжтой хөтөлбөрт урьсаар атал МБС-ыг сонгож суралцах сонирхол бага хэвээр байна. Түүнчлэн өмнөх жилүүдэд МБС-ын сургуулийг төгсгөгчдийн сурсан мэргэжлээрээ ажил хөдөлмөр эрхлэх нь бага (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын “төгсөгчдийн судалгаа 2020”-д дурдсанаар 1/3 нь) байгаа нь энэ салбарын эдийн засгийн үр өгөөж хангалтгүй байгааг илтгэнэ.

2015-2016 оны хичээлийн жилд ИДС болон МБСБ төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн мөшгих судалгааны дүнгээс<sup>16</sup> үзэхэд (панел судалгааны дөрөв дэх жилийн дүн) 2020 онд эдгээр төгсөгчдийн 74.8 хувь нь хөдөлмөр эрхэлж, 4.5 хувь нь ажилгүй, 20.7 хувь нь ажиллах хүчнээс гадуур (эдийн засгийн идэвхигүй төлөвт) байжээ. ИДС төгсөгчдийн 76.9 хувь, МБСБ

<sup>16</sup> ХНХСИ (2018). *Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа – 2020*



төгсөгчдийн 71.5 хувь нь хөдөлмөр эрхэлж байсан байна. Түүнчлэн энэ судалгаанд хамрагдсан МБСБ төгсөгчдийн 38.5 хувь нь л 2017 оноос хойш тасралтгүй хөдөлмөр эрхэлж байгаа гэжээ. Хөдөлмөр эрхэлж буй МБСБ төгсөгчдийн тал хувь нь мэргэжлээрээ ажиллаж буйн дотор эрүүл мэнд, эрчим хүч, үйлчилгээний мэргэжил эзэмшсэн 67.5-83.0 хувь мэргэжлээрээ ажиллаж байгаа нь бусад салбарынхаас өндөр байсан ажээ. Энэхүү судалгаанд хамрагдсан МБСБ төгсөгчдийн 14.1 хувь нь 2018 онд суралцаж байсны 80.4 хувь нь ИДС-д бакалаврын ангид, 9.0 хувь нь мэргэжлийн түр сургалтын байгууллагад, 5.6 хувь нь МБСБ-д техникийн боловсрол эзэмшихээр суралцаж байсан байна. МБСБ-ын эрүүл мэнд, эрчим хүч, барилга, уул уурхай, тээвэр, үйлчилгээ аж үйлдвэрийн салбарын мэргэжлийн чиглэлээр төгсөгчид сүүлийн 4 жилд бусадтайгаа харьцуулахад илүү эзэмшсэн мэргэжлээрээ тогтвортой хөдөлмөр эрхэлсэн, харин хөдөө аж ахуй, боловсрол, байгаль орчин, аялал жуулчлал, мэдээллийн технологи мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт тогтворгүй, мэргэжлийн бус хөдөлмөр эрхлэлт өндөр байна.

ХНХСИ-ээс 2017 онд МБСБ-аар бэлтгэдэг найман мэргэжлийн хүрээнд<sup>17</sup> ажил олгогчоос ажилтанд тавих шаардлагыг судалсан дүнгээс харахад сүүлийн жилүүдэд мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийг авч ажиллуулсан уул уурхай, барилга, боловсруулах үйлдвэрлэл, эрүүл мэнд, үйлчилгээний салбарын ажил олгогчдын 93 хувь нь шинээр ажилтан авахдаа сургаж, дадлагажуулж авдаг гэжээ. Үсчин, сувилагч, барилгын сантехникч мэргэжлийн ажилтныг шинээр авсан бүх ажил олгогч тэднийг сургаж дадлагажуулжээ. Уг судалгаанд хамрагдсан ажил олгогчид шинэ ажилтнуудынхаа мэргэжлийн голлох 6-8 ур чадварыг эзэмшсэн байдлыг дунджаар 2.4 (14% нь “1-маш муу”, 41% нь “2-муу”, 37% нь “3-сайн”, 8% нь “4-маш сайн”) буюу “сайн биш” гэж үнэлжээ. Ялангуяа үсчин мэргэжлээр төгсөгчдийн ур чадвар “маш муу” гэсэн байна. Нийт ажил олгогчдын 16 хувь нь төгсөгчдийн онолын мэдлэг “хангалттай” гэж үзсэн бол 58 хувь нь “дунд зэрэг”, 26 хувь нь “хангалтгүй” гэжээ. Төгсөгчдийн практик ур чадвар ажлын шаардлагад нийцдэг гэж ажил олгогчдын 6 хувь, дунд зэрэг гэж 44 хувь, нийцдэггүй гэж 51 хувь нь хариулжээ. Хүнд машин механизмын оператор, үсчин, гагнуурчин мэргэжлээр төгсөгчдийн ихэнхийн практик ур чадвар нь “ажил олгогчдын шаардлагад нийцэхгүй байна” гэжээ.

МБСБ-ын сургалтын хөтөлбөрийн талаар “сэтгэл ханамжтай” гэж ажил олгогчдын 9 хувь, “дунд зэрэг” гэж 57 хувь, “хангалуун бус” гэж 34 хувь нь хариулсан. МБСБ-ын багш нарын ур чадвар, тоног төхөөрөмж, дадлагын орчин, суралцагчдын идэвхи хандлага нь төгсөгчдийн ур чадварт сөргөөр нөлөөлдөг байх талтай гэж ажил олгогчид онцолсон байна. Үсчин, гагнуурчин, барилгын сантехникч мэргэжлийн сургалтын хөтөлбөрт “сэтгэл хангалуун” гэж хариулсан ажил олгогч байгаагүй байна.

МБСБ-ыг төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг судалсан өөр нэг судалгааны дүнгээр<sup>18</sup> 2016 оноос хойш ажиллаж байсан 426 үйлдвэр, аж ахуйн нэгжийн 136 нь буюу 31.9 хувь нь МБСБ-ыг төгсөгчдөөс ажилд авчээ. Үүнийг салбараар нь ангилж үзвэл 2016 оноос хойш барилгын компаниудын 31.1 хувь, зам тээврийн компаниудын 50 хувь, хөдөө аж ахуйн компаниудын 26.4 хувь нь МБСБ төгсөгчдөөс ажилд авсан байна. Гэхдээ судалгаанд хамрагдсан компаниудын 34 хувь нь сүүлийн 6 сард ажиллах хүчний хомсдолтой байсан гэжээ. Салбараар нь харвал барилгын компаниудын 30.3 хувь, зам тээврийн компаниудын 29.6 хувь, хөдөө аж ахуйн компаниудын 41.7 хувь ажиллах хүчний хомсдолтой байв. (Ёо, 2017).

<sup>17</sup> Энэхүү судалгаанд МБСБ-аар бэлтгэдэг үсчин, сувилагч, оёдолчин, тогооч, барилгын цахилгаанчин, барилгын сантехникч, хүнд машин механизмын оператор, гагнуурчны мэргэжлийг сонгон хамруулжээ.

<sup>18</sup> Томас Ёо (2017). *Хөдөлмөр эрхлэлтийн судалгааны тайлан*; АХБ-ны Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төслийн “МБС-ын удирдах ажилтан, багш нарын сургалтын тогтолцоо бүрдүүлэх” зөвлөх үйлчилгээний дунд хугацааны хоёрдугаар тайлан.

МБСБ төгсгөгчдийн ажил эрхлэлтийн байдалд нарийвчилсан судалгааг АХБ-ны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн шугамаар хийсэн байна.<sup>19</sup> Энэ судалгаанд хамрагдсан төгсгөгчдийн 22.8 хувь нь цалинтай ажиллаж байсны 38.7 хувь нь суралцсан мэргэжлийнхээ дагуу ажиллаж байсан байна. Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын 65 хувь нь шинэ ажилчин ажилд авсан хэдий ч тэдний 30 хувь нь ажилчин дутагдалтай байгаа гэжээ. Үүнээс үзэхэд ажлын байрны эрэлт нь нөхөгдөөгүй хэвээр байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын талаар олон нийт төдийгүй холбогдох шийдвэр гаргагчид, эрх мэдэл хэрэгжүүлдэг ажилтнуудын хүрээнд ойлголт, нэр томъёог нэг мөр тодорхойлж, цэгцтэй хэрэглэх шаардлага байна. Хуулийн нэрэнд “техникийн боловсрол” хэмээн оруулаагүй ч англи хэлээр түгээж буй баримт бичигт TVET буюу Technical and Vocational Education and Training хэмээн оноож, дотооддоо ч албан ёсны бичиг баримтад “техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт”, “мэргэжлийн анхан болон дунд шатны боловсрол”, “мэргэжлийн боловсрол, сургалт”, “хөдөлмөр эрхлэх сургалт” зэрэг нэршлийг ижил утга, хамааралтай хэрэглэх эсэхийг цэгцэлбэл зохино.

Нэр томъёо ойлгомжтой болж байж холбогдох зохицуулалт ойлгомжтой, хэрэгжихэд тустай болдог. Техникийн боловсрол нь мэргэжлийн, дипломын болон дээд боловсролын хөтөлбөр, зэрэглэлтэй хэрхэн холбогдох, эдгээр хөтөлбөрийн хүрээнд иргэдийн эзэмшсэн мэдлэг, ур чадвар, чадамж (credentials, credits and competencies)-ийг хөдөлмөр эрхлэх, дараагийн шатанд дэвшин, эсвэл бусад мэргэжилээр шилжин суралцахад нь хэрхэн үнэлж, тооцохыг жигдлэн журамлах шаардлагатай байна. Үүний тулд одоо УИХ-д өргөн бариад буй боловсролын хуулиудын шинэчилсэн найруулга, түүнд үндэслэн албажуулах “мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц” (“үндэсний мэргэшлийн хүрээ”)-ийг боловсруулахдаа иргэдийн эзэмшсэн боловсрол, чадамжийг зохистой үнэлэх, ялангуяа мэргэжлийн болон техникийн боловсролын үнэ цэнэ, нэр хүндийг дээшлүүлэх зорилготой нягт холбон тусгавал зохилтой болно.

Удирдлагын шийдвэр гаргах, бодлогын шинжилгээ хийх, иргэд сонголтоо хийхэд мэргэжлийн боловсрол, сургалтын албан ёсны статистик мэдээлэл хангалттай, зохистой биш байна. Энэ мэдээлэл, төр засгийн гаргаж буй шийдвэр нь үндсэндээ МСҮТ, ПК-ийн мэргэжлийн боловсролын өдрийн ангийн хүрээнд төвлөрч байна. Харин өөр бусад хэлбэрээр ур чадвар шинээр эзэмшиж, шинэчилж байгаа иргэд, үүнийг нийлүүлж буй байгууллага институцийн тухай мэдээлэл тодорхойгүй, үүнд чиглэсэн бодлого, шийдвэр хомс байна. МСҮТ, ПК-ийн өдрийн ангид суралцагчдыг дэмжсэн тэтгэлэг нэмэгдэж, хандивлагчдын тусламж ихээхэн өссөн хэдий ч эдгээр сургуулийг төгсгөгчдийн мэдлэг ур чадварын үнэлэмж, хэрэглээ (хөдөлмөр эрхлэлт) төдийлэн өсөхгүй байна. Иймд хөрөнгө, хүчин чармайлт хэр оновчтой байгааг бодитой, бүрэн дүүрэн мэдээлэлд үндэслэн үнэлж цэгнэх, ийм үнэлгээ шинжилгээний дүнг бодлогын болон удирдлагын аливаа шийдвэрт заавал хэрэглэх соёл, журам дэглэм тогтоон хэвшүүлэх шаардлагатай.

Өнөөдөр МБС-ын гол институц болж буй сургалтын байгууллагыг МСҮТ, ПК хэмээн ангилахын үндэслэл ойлголт сул, харин ч үндсэндээ нэгэн ижил чиг үүрэг хэрэгжүүлж байгаа сургуулиудын зохиомол зэрэглэл шатлал болж ойлгогдож байна. МБС-ын байгууллагыг ангилах журамд МСҮТ нь багш нарынхаа мэргэшил туршлагыг сайжруулж, сургалтын үр дүнгээ дээшлүүлсэн тохиолдолд политехник коллеж болж “дэвших”-ээр заажээ.<sup>20</sup> Эдгээртэй

<sup>19</sup> *Төгсгөгчдийн мөшгих судалгаа, ажил олгогчдын сэтгэл ханамжийн суурь судалгааны тайлан*, АХБ-ны хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл, 2018

<sup>20</sup> Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд: “12.3. Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага нь мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв байна.  
12.5. Техникийн боловсролын сургалтын байгууллагын хэв шинж нь политехник коллеж байна.

харьцуулахад дээд боловсролын хөтөлбөртэй илүү холбогдож, багшлах бүрэлдэхүүн, тоног төхөөрөмж, сургалтын орчин, соёлын хувьд илүү институцлэгдсэн сургуулиудыг МСҮТ-ийн ангилал (“түвшин”)-д хамааруулж байгаа нь албан ёсны статистик мэдээнээс харагдана. Энэ нь сургалтын байгууллагын хувьд ч төр захиргааны байгууллагаас ангиллаа “дээшлүүлсэн” шийдвэр гаргуулахыг эрмэлзэхэд түлхэж байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төрөл хэлбэр өргөжиж, хувийн санаачлагаар үүссэн төрийн бус өмчийн сургалтын байгууллага бий болсон нь суралцах хүмүүсийн бүрэлдэхүүн, сургалтын хөтөлбөр, сургалтын арга хэлбэрийг өөрчлөлт, шинэ хандлагаар баяжуулж байна. Сүүлийн жилүүдэд ерөнхий боловсролын 9, 12 дугаар анги төгсгөгчдөөс элсэгчдийн тоо, хувийн жин буурч, насанд хүрсэн иргэдээс элсэх нь нэмэгдэж байгааг албан ёсны статистик илтгэнэ. Өмнөговь аймагт байгуулагдсан Скилтех МСҮТ Оюу Толгой компаний шаардлагад нийцсэн, австралийн TAFE-ийн хөтөлбөртэй жишихүйц хөтөлбөрийг нутагшуулсан, Дорноговь дахь төмөр замын МСҮТ хосмог сургалт (dual apprenticeship)-ын хэлбэрээр сургалтыг зохион байгуулж эхэлсэн, Баянхонгор дахь Өлзийт МСҮТ японы мэргэжилтнүүдтэй хамтран ургамлыг навчаар нь тэжээх n-power азотын бордоо бэлтгэн ашиглах, года бяслагийг нутгийн түүхий эдэд түшиглэн үйлдвэрлэх, польшийн мэргэжилтнүүдтэй хамтарсан биомассын бургас буюу эрчим хүчний модны тарьцыг нутагшуулах, болгарын мэргэжилтнүүдтэй хамтарсан олон улсын стандартын тарагны хөрөнгө бэлтгэх технологийг эзэмшиж, сургалтын хүлэмж талбайдаа туршин нэвтрүүлж байгаа нь шинэ үзэгдэл юм.



## Мэргэжлийн боловсрол, сургалтын засаглал, удирдлага, тулгамдаж буй асуудал

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль (2009 онд шинэчлэн баталсан)-д МБС-ыг хөдөлмөрийн захын эрэлтэд нийцүүлэх, шийдвэр гаргах бүх шатанд хэрэглэгчийн оролцоог бодитой болгохыг төвд нь тавьж, хөгжлийн бодлогын тогтвортой байдлыг хангах, үүнд чиглэсэн засаглал, удирдлагын шинэ бүтэц бүрдүүлэх эрхзүйн үндсийг тавьсан байна. Өмнө нь яамны түвшинд салбарын удирдлагыг хариуцуулж байсан бол “төр, хувийн хэвшлийн тэнцүү оролцоо”-той дээд удирдлагыг хэрэгжүүлэх МБС-ын Үндэсний Зөвлөл (МБСҮЗ)-ийг байгуулах, МБС-нд зориулсан нийт хөрөнгийг нэгдсэн удирдлага зохицуулалттай сан болгон хөгжлийн бодлого стратегид чиглүүлэн хуваарилалт, зарцуулалтыг оновчтой болгох зохицуулалтыг тусгажээ. Энэхүү төр, хувийн хэвшлийн тэнцүү оролцоо бүхий удирдлага, салбар дундын зохицуулалтыг дэмжих бие даасан агентлаг байгуулсан боловч хоёр жилийн дараа энэ агентлагийг яаманд нэгтгэжээ. МБС-ын удирдлагын одоогийн бүдүүвчийг дараах зурагт харуулав.

### Хүснэгт 5: МБС-ын салбарын удирдлагын бүтэц

	Бодлого, стратеги, захиргааны удирдлага	Мэргэжил, аргазүйн удирдлага	Тохируулагч агент
<b>Улсын хэмжээнд</b>	<b>МБС-ын Үндэсний зөвлөл</b>		
<i>Салбарын түвшинд</i>	БШУЯ, ХНХЯ	МБСҮЗ-ийн салбарын зөвлөл - 6	МБС-ын ҮМАЗТ <sup>21</sup>
<i>Орон нутагт</i>	Аймгийн МБС-ын зөвлөл – 21	Бүсийн аргазүйн төв – 6	
<i>Сургуулийн түвшинд</i>	Удирдах зөвлөл	Чадамжийн төв/ мэргэжлийн зөвлөл	

Хуульд “МБС-ын дээд удирдлагыг [хэрэгжүүлэх]” байгууллага нь МБСҮЗ хэмээн тодорхойлсон (хуулийн 6.2 дахь заалт) боловч “дээд удирдлага”-ын эрх хэмжээ ямар байх нь өнөөгийн хууль, тогтоомжийн хүрээнд тодорхойгүй байна. Энэ зөвлөлийн бүрэн эрх нь хэлэлцсэн асуудлаараа дүгнэлт, санал зөвлөмж гаргах бөгөөд бүрэлдэхүүнийг нь Засгийн газар баталж байхаар заасан нь “дээд удирдлага”-ыг хэрэгжүүлэгч байгууллага гэж үзэх боломжгүй болгож байна. Хэдийгээр “мэргэшлийн түвшний хүрээ<sup>22</sup>, ажил мэргэжлийн лавлахыг батлах”-аас өөр эцсийн шийдвэр гаргах эрх мэдэл олгоогүй боловч “МБСБ, ажил олгогчид, яамдын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах” үүрэг ногдуулсан нь хэрхэн хэрэгжих нь тодорхойгүй байна. МБСҮЗ-ийн ажлын алба нь МБС-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байхаар<sup>23</sup> заасан нь эдгээр байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээтэй зөрчилтэй болжээ. МБСҮЗ нь салбарын дээд удирдлага бөгөөд түүний ажлын албаны үүргийг салбар дундын агентлаг шинжтэй Мэргэжлийн боловсрол, сургалтын газар гүйцэтгэж, МБСҮЗ-ийн шийдвэрийн дагуу МБС-ыг дэмжих сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг хариуцан ажиллаж байсан 2010-2012 оны үеийн зохицуулалт илүү зохистой байсан гэж олон судлаач ажиглагчид дүгнэж байна. Үндэсний аудитын газраас хөдөлмөр

<sup>21</sup> МБС-ын Үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийг ХНХСИ-тэй нэгтгэн ХНХ-ын Сургалт, үнэлгээ, судалгааны институт байгуулах тухай Засгийн газрын 2022 оны 251 дүгээр тогтоолын дагуу хуулиар өмнөх төвд хариуцуулсан чиг үүргийг энэхүү шинэ бүтэц өвлөн хэрэгжүүлнэ гэсэн хүлээлттэй байна.

<sup>22</sup> Боловсрол, мэргэжлийн түвшнийг илэрхийлэх “National Qualifications Framework” хэмээх нэр томъёог Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд “мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоо” (6.3.3), “мэргэшлийн түвшний хүрээ” (6.3.8) гэж хоёр өөрөөр оноон хэрэглэжээ.

<sup>23</sup> Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8.3 дахь заалт

эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх төрийн бодлогыг 2016-2021 онд хэрэгжүүлсэн байдалд аудит хийсэн дүгнэлтэд “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих үндэсний зөвлөлөөс МБСДС-ийн тухайн жилийн орлого, зарлагын төсвийг батлаагүй, хуульд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй”, улирал бүр хуралдаж, үйл ажиллагааныхаа үр дүнг Засгийн газарт тайлагнах үүргээ биелүүлдэггүй<sup>24</sup> хэмээн тэмдэглэжээ.

### Мэргэжлийн Боловсрол, Сургалтын Үндэсний Зөвлөл

- 6.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) нь мэргэжлийн боловсрол, сургалтын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн тэнцүү оролцоог хангаж, тогтвортой ажиллах баталгааг бүрдүүлсэн орон тооны бус байгууллага мөн.
- 6.2. Энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөл **мэргэжлийн боловсрол, сургалтын дээд удирдлагыг** хэрэгжүүлнэ.
- 6.3. Зөвлөл нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
  - 6.3.1. мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх урт, дунд болон богино хугацааны бодлого, хөтөлбөрийг хэлэлцэж дүгнэлт гаргах;
  - 6.3.2. ажиллах хүчний талаар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, ажил олгогчид, яамдын үйл ажиллагааг үялдуулан зохицуулах;
  - 6.3.3. мэргэжлийн боловсрол, сургалттай холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилт, мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоог хөгжүүлэх талаар мэдээлэл, илтгэл хэлэлцэх, тогтоол, зөвлөмж гаргах, чиглэл өгөх;
  - 6.3.4. улсын хэмжээнд мөрдөх ажил, мэргэжлийн үндэсний ангилал, тодорхойлолт, мэргэжлийн стандарт, мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгыг хэлэлцэж дүгнэлт гаргах;
  - 6.3.5. мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих;
  - 6.3.6. мэргэжлийн боловсрол, сургалттай холбогдолтой олон улсын гэрээ, конвенцид Монгол Улс нэгдэн орох асуудлыг судалж, санал гаргах;
  - 6.3.7. гаргасан шийдвэр, зөвлөмжийнхээ хэрэгжилтэд хяналт тавих.
  - 6.3.8. ажил олгогч болон салбар зөвлөлийн хамтарсан дүгнэлтийг үндэслэн мэргэшлийн түвшний хүрээ, ажил мэргэжлийн лавлах батлах.
- 6.4. Зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар батална.
- 6.5. Зөвлөлийн бүрэлдэхүүн дэх хувийн хэвшлийн төлөөллийг ажил олгогчид болон Худалдаа, аж үйлдвэрийн танхим хамтран зохион байгуулсан төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын нэгдсэн хурлаас сонгоно.

*(Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулиас)*

“МБС-ын тогтолцоо нь [Үндэсний] зөвлөл, мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, үнэлгээ, мэдээллийн болон бүсийн арга зүйн төв, сургалтын байгууллагаас бүрдэнэ” (хуулийн 6<sup>1</sup>.1 дэх заалт) хэмээн хуульд тодорхойлж, нийтлэг удирдлага, зохицуулалтын үндсэн асуудлыг МБС-ын асуудал эрхэлсэн төрийн

<sup>24</sup> Үндэсний аудитын газар (2022). *Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн* <https://audit.mn/wp-content/uploads/2022/08/Хөдөлмөр-эрхлэлт-хураангуй-тайлан.сайтad.pdf>

захиргааны байгууллагын бүрэн эрхэд хамааруулсан байна. Өнөөдөр МБСҮЗ-ийг БШУ-ны сайд даргалж, бүрэлдэхүүнд 8 яамны төрийн нарийн бичгийн дарга, ажил олгогчдыг төлөөлсөн МҮХАҮТ, МАОЭХ, мэргэжлийн холбоодыг төлөөлсөн Барилгачдын нэгдсэн холбоо, Уул уурхайн үндэсний ассоциац, Авто замчдын холбоо, Эрчим хүчний ассоциац, МБСБ-ыг төлөөлсөн МБС-ын үндэсний ассоциац, Техникийн болон мэргэжлийн сургуулиудын холбоо, түүнчлэн Мэргэжлийн боловсрол, сургалт түншлэлийн төлөөлөл, нийт 17 гишүүнтэй<sup>25</sup>.

Төрийн захиргааны төв байгууллагууд МБСҮЗ-ийг бодлогоор дэмжиж<sup>26</sup> ажиллах үүрэгтэй бөгөөд энэ үүргийг Зөвлөл дэх өөрийн төлөөлөл болон яамдын дэргэдэх МБСҮЗ-ийн салбар зөвлөлийн үйл ажиллагаагаар хэрэгжүүлэхээр тогтжээ. МБСҮЗ ажиллах хүчний талаар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд яамд, ажил олгогчид, МБСБ-ын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах<sup>27</sup> үүргээ мөн энэ салбар зөвлөлүүдээр хэрэгжүүлж байна.

МБСҮЗ нь үйл ажиллагаагаа яамдыг түшиглэн байгуулсан 6 салбарын зөвлөл, аймаг бүрт ихэвчлэн Засаг даргын орлогчоор ахлуулан байгуулсан орон нутгийн зөвлөлтэйгээр хэрэгжүүлж байна. МБС-ын аймгийн зөвлөлд боловсролын болон хөдөлмөр халамжийн үйлчилгээний албаны удирдлага, ажил олгогчдын төлөөллийг оролцуулан, мэргэжлийн сургалтын байгууллагын удирдлагыг нарийн бичгийн даргаар томилон Засаг дарга нь баталгаажуулж байна.

МБСҮЗ-ийн салбарын зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг үндэсний зөвлөл баталж, үйл ажиллагааны тайланг нь жил бүр хэлэлцэж байхаар журамлажээ. МБС-ын салбарын зөвлөлийг түшиглэсэн яамны Төрийн нарийн бичгийн дарга ахалж, төрийн болон хувийн хэвшлийг тэнцүү төлөөлсөн гишүүдтэй бөгөөд тухайн салбарын хүрээнд МБС-ын талаар төрөөс явуулах бодлогыг хэрэгжүүлэхэд талуудын оролцоо уялдааг зохицуулах, мэргэжилтэй ажилтан бэлтгэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах үндсэн үүрэгтэй байхаар дүрэмд нь тусгажээ. Салбарын зөвлөл нь дараахи бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Салбарыг мэргэжилтэй ажилтнаар хангах бодлого, стратеги боловсруулах;
- Салбарынхаа хэмжээнд мэргэшлийн түвшний тогтолцоог бүрдүүлж төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх; АМЛ, стандарт эзэмшүүлэх ур чадварыг тодорхойлох, боловсруулах ажлыг бодлогын удирдлагаар хангах, хянах, баталгаажуулах, бүртгэх, нийтэд мэдээлэх шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх санал боловсруулж төсөвт тусгах;
- Салбарын хэмжээнд эрэлттэй, шинээр үүсэх болон өөрчлөгдөх ажил, мэргэжлийн талаархи судалгаа, мэдээллийг жил бүр нэгтгэн гаргаж, МБСҮЗ, МСҮТ-д хүргүүлж ажиллах.
- Мэргэжилтэй ажилтны сургах хэрэгцээг тодорхойлох, суралцагчдын үйлдвэрлэлийн дадлагыг зохион байгуулалтын удирдлагаар хангах, МБСБ, ААН-ийн уялдаа холбоог хангах;
- Салбарын ААН, байгууллагын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, мэргэжилтэй ажилтны эрэлт, хэрэгцээний талаархи мэдээллийг жил бүр МБСҮЗ, МБСҮТ-д хүргүүлэх;
- Салбарын МБСБ-ын үйл ажиллагааны үр дүн, суралцагч, төгсөгч, ажилтны мэргэшлийн ур чадварыг үнэлэх шалгуур үзүүлэлт боловсруулахад санал өгөх.

МБС-ын орон нутгийн салбар зөвлөл нь МБС-ын талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, МБСҮЗ-ийн шийдвэрийг хэрэгжүүлэх, орон нутгийн эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй

<sup>25</sup> Засгийн газрын 2022 оны 172 дугаар тогтоол

<sup>26</sup> Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 7.1 дэх заалт

<sup>27</sup> Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6.3.2 дахь заалт

нийцүүлэн ажиллах хүчийг бэлтгэх, төгсгөгчдийн мэргэжлийн болон хөдөлмөр эрхлэх ур чадварыг нэмэгдүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэл, ажил олгогч болон МБСБ-уудын хамтын ажиллагааг дэмжин ажиллах үүрэгтэй. Эдгээр МБС-ын орон нутгийн зөвлөлүүдийн үйл ажиллагаа 2017-2018 онд нэлээд идэвхижиж тогтворжсон байв. Харин аймгийн зөвлөлийн бүрэлдэхүүн, гүйцэтгэж байгаа чиг үүрэг нь тухайн аймаг дахь МБС-ын байгууллагын Удирдах зөвлөлийнхтэй давхцсан шинжтэй байгааг анхаарч нэгтгэх, давхардалгүй болгох асуудлыг авч үзвэл зохилтой байна.

ТМБ-ын хөгжлийн хандлагыг тодорхойлж, төлөвлөх нь МБС-ын талаархи төрийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ажлын үндсэн хэсэг гэж үзвэл энэ чиг үүрэг МБС-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (яам)-ын бүрэн эрхэд хамаарч байхаар хуульчилсан байна (хуулийн 8.4.3 дахь заалт). Түүнчлэн “мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх чиглэлээр ойрын болон хэтийн төлөвлөгөө, дүрэм, журам, заавар, үзэл баримтлал, үндсэн чиглэл, хөтөлбөр, төслийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх” (хуулийн 8.4.1 дэх заалт); болон “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах” (хуулийн 8.4.2 дахь заалт), “мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоог бүрдүүлэх, үйл ажиллагааг нь зохион байгуулах” (хуулийн 8.4.21 дэх заалт), төрийн өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын Удирдах зөвлөлийг байгуулж, гүйцэтгэх удирдлагыг томилох, чөлөөлөх, энэ салбарын хөрөнгө төсвийг хуваарилах зэрэг нөлөө бүхий шийдвэр гаргах бүрэн эрхийг яаманд олгосон нь яамыг дээд удирдлагыг хэрэгжүүлэгч болгож байна. Иймд дээд удирдлагыг бодитой хэрэгжүүлэгч болон бусад субъектын хариуцах чиг үүрэг, эрх хэмжээг тодотгож, ялгаа заагтай болгох шаардлага байна. Яам нь хуулиар хариуцуулсан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах мэргэжлийн болон техникийн боловсролд холбогдох мэдээ тайлан, тооцоо судалгааг аль ч байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах эрхтэй.

#### **Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (яам) нь мэргэжлийн боловсрол, сургалтын талаарх төрийн бодлого, Засгийн газрын болон Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний Зөвлөлийн шийдвэр, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулна. Яам нь Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний Зөвлөлийн ажлын албаны үүргийг гүйцэтгэх бөгөөд дараахь бүрэн эрхтэй. Үүнд:

**а. хөгжлийн бодлого, стратегийг тодорхойлох, нийтлэг зохицуулалт хийх талаар:**

- мэргэжлийн болон техникийн боловсролын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн төлөвлөх;
- мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх чиглэлээр ойрын болон хэтийн төлөвлөгөө, дүрэм, журам, заавар, үзэл баримтлал, үндсэн чиглэл, хөтөлбөр, төслийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх;
- мэргэжлийн болон техникийн боловсролын асуудлаар олон улсын гэрээ, конвенци, хэлэлцээрээр Монгол Улсын Засгийн газрын хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх, зохицуулах;
- хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг судлах, сурталчлах, энэ чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;
- мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын хүний нөөц, суралцагчдын нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтэд зохицуулалт хийх;
- мэргэжлийн болон техникийн боловсролын чиглэлээр хийгдэх төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар хариуцуулан гүйцэтгүүлэх талаар судлах, санал боловсруулах, энэ чиглэлээр хийгдсэн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, дүгнэлт гаргах;

**б. мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга, түвшний стандартыг тогтоох, мөрдүүлэх талаар:**

- мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоог бүрдүүлэх, мэргэжлийн байгууллага, нийгэмлэг, холбоодын оролцоотойгоор ажил, мэргэжил, ур чадварын стандарт боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах;
- мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын агуулгыг тогтоох, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлах, дадлагын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журмыг батлах;
- мэргэжлийн модулийн сан, тестийн сан бүрдүүлэх, ур чадварыг үнэлэх, шалгах, баталгаажуулах хөндлөнгийн шалгалт зохион байгуулах;
- мэргэжлийн болон техникийн боловсролын хөтөлбөрийн шаардлагыг хангасан иргэдэд мэргэжлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах.

в. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг шууд удирдлагаар хангах талаар:

- мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн болон бүсийн арга зүйн төвийн бүтэц, орон тоо, дүрмийг баталж, менежерийг томилох, чөлөөлөх
- төрийн өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын захирлыг томилох, чөлөөлөх, ажлын байрын тодорхойлолтыг батлах;
- мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх, өөрчлөх, зогсоох, татан буулгах талаар дүгнэлт гаргах;
- мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагааг захиргааны болон мэргэжлийн удирдлагаар хангах, дүн шинжилгээ хийх, ангиллыг тогтоох;
- мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг аттестатчилах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах, аттестатчилах, багшид мэргэжлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах;

г. мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах талаар:

- мэргэжлийн боловсрол, сургалтад зориулан улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн санхүүжилт, зээл тусламж, хандив, аж ахуйн нэгж байгууллагаас төвлөрүүлсэн хөрөнгийг нэгтгэн Мэргэжлийн боловсрол, сургалтын сангийн санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлэх;
- сургалт-үйлдвэрлэл, үйлдвэрлэл-сургалтын явцад шинэ технологи, шинжлэх ухаан, техникийн ололт, дэвшлийг нэвтрүүлэх арга хэмжээ авах;
- мэргэжлийн сургалтын сурах бичиг, хичээлийн хэрэглэгдэхүүнээр хангах ажлыг зохион байгуулах;
- төрийн өмчийн болон төрийн өмчийн бус мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах;

(Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулиас)

Ийнхүү яам МБС-ын хөгжлийн бодлогыг тодорхойлохоос эхлэн энэ чиглэлийн үйл ажиллагааны стандарт, нийтлэг хэм хэмжээг тогтоож, энэ тогтолцоонд хамаарах гол байгууллагуудын удирдлагыг томилох, салбарын нийт хөрөнгийг удирдах эрх мэдлийг хэрэгжүүлж байна. Гэхдээ яамны бүрэн эрхийн зарим хэсэг хэрэгжихгүй байгаа ажээ. Тухайлбал, МБС-ыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх (хуулийн 21, 22, 23 дугаар зүйл), хуульд зааснаар МБСҮЗ-өөр батлуулан (хуулийн 24.3 дахь заалт) хуваарилж, зарцуулах, хэрэгжилтийг улирал, жилээр тайлагнах (хуулийн 25.1 дэх заалт) ажил хийгдэхгүй байна. Суралцагчдад олгох тэтгэлэг зэрэг МБС-ын зардлын томоохон эх үүсвэр нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хуримтлалаас бүрдэж байхаар Засгийн газраас журамласан нь МБС-д холбогдох төрийн захиргааны төв байгууллагын чиг үүргийг 2022 оноос БШУЯ-нд шилжсэний дараа шинэ зохицуулалт шаардаж байна.

МБС-ыг мэргэжлийн удирдлагаар хангах зорилгоор сургалтын байгууллагад аргазүйн туслалцаа үзүүлэх зорилготой Бүсийн аргазүйн төв (БАЗТ), мэргэжлийн ур чадварыг үнэлэн гэрчилгээжүүлэх үндсэн үүрэгтэй МБС-ын Үнэлгээний төв (МБСҮТ)-ийг 2011 оноос байгуулан ажиллуулсан байна. МБСҮТ-ийг хожим МБС-ын Үнэлгээ, мэдээлэл, аргазүйн төв болгон, БАЗТ-үүдийг харьяанд нь ажиллуулахаар тогтоожээ. Харин 2022 оны 6 дугаар сард энэ төвийг ХНХСИ-тэй нэгтгэж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ,

судалгааны институт (ХНХСҮСИ) болгон зохион байгуулсан байна. Энэхүү шинэ бүтцэд Хүний нөөц, ур чадварын сургалт үнэлгээний газрын дотор байгуулсан Үнэлгээ, баталгаажуулалтын алба нь анх МБСҮТ-ийг байгуулахад хариуцуулж байсан тохируулах шинжтэй чиг үүргийг өвлөн хэрэгжүүлэх төлөвтэй байна. Үүнтэй зэрэгцэн БШУЯ-нд МСҮТ, ПК-ийн асуудал шилжсэнтэй холбогдон ур чадварын үнэлгээ хийх чиг үүргийг Боловсролын үнэлгээний төвд хариуцуулах эсэх асуудал яригдаж байна. Хэдийгээр засгийн газрын бүтцийн байгууллагууд боловч чиг үүргийг салгаж хуваарилсанаар нэгж байгууллагатай харьцах харилцаа, түүгээр дамжин иргэдийн авах үйлчилгээний чиглэлд шинэ хуваарилалт хийхэд хүрдэг нь цаг хугацаа, институцийн чадамж, харилцагчдын хооронд үүссэн холбоо харилцаанд өөрчлөлт оруулдагийг сайтар тооцох шаардлагатай байна. Энэ байдал МБС-ын БАЗТ-үүдийн цаашдын үйл ажиллагаанд ч нөлөөлөх нь тодорхой болжээ. БАЗТ-үүд харъяалсан бүсийн хэмжээнд МБС-ын хөтөлбөрийг харгалзах мэргэжлийн стандартад нийцүүлэхэд аргазүйн удирдлагаар хангах, сургалтын үр дүн, чадамжийн сан бүрдүүлэх, багшийг чадваржуулах, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх<sup>28</sup> зэрэг хариуцлагатай үүрэг хүлээлгэсэн боловч үүнийгээ хэрэгжүүлэх бүтэц, чадавхи, хөрөнгө санхүүгийн нөхцөл харахан бүрдээгүй байгааг 2016 онд хийгдсэн судалгааны тайланд<sup>29</sup> тэмдэглэсэн нь өнөөдөр шийдэгдээгүй хэвээр байна.

МБС-ын удирдлагын тогтолцоонд шинээр бий болсон элемент бол сургалтын байгууллагын үндсэн харилцагч, сонирхлын бүлгүүдийн төлөөлөл бүхий өөрийн удирдлага юм. МСҮТ, Политехник коллежийн Удирдах зөвлөл нь тухайн байгууллагыг хөгжүүлэх стратеги, төлөвлөгөө, хөтөлбөр, дүрмийг батлах, бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлох, хөрөнгө оруулалт, жилийн төсвийн хуваарилалтыг баталж, зарцуулалтад хяналт тавих, сургалтын төлбөр, дотуур байрны үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох, сургуулийн үйл ажиллагааны үр дүнг үнэлж, дүгнэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг.<sup>37</sup>

Боловсролын тухай хуулийн дагуу МБСБ-ын өөрийн удирдлагыг үүсгэн байгуулагч, багш, суралцагчийн төлөөлөлтэй Удирдах зөвлөл хэрэгжүүлдэг.<sup>30</sup> Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 51-60 хувийг нь үүсгэн байгуулагчийн төлөөлөл бүрдүүлдэг<sup>31</sup> бөгөөд төрийн өмчийн сургалтын байгууллагын үүсгэн байгуулагчийн эрхийг Засгийн газрыг төлөөлөн МБС-ын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн хэрэгжүүлж байна. Иймд сургалтын байгууллагын өөрийн удирдлагад үүсгэн байгуулагч, төрийн өмчийн сургуулийн удирдах зөвлөлд яамны төлөөлөл саналын давуу эрхтэй шийдвэр гаргахаар хуульчилжээ. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн үүсгэн байгуулагчийн болон ажил олгогч<sup>32</sup>, багш, төгсгөгч, суралцагчдын төлөөлөлтэй байдаг. Энэ дагуу МБС-ын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төрийн өмчийн МСҮТ, Политехник коллежийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг төрийн болон төрийн бус төлөөлөлтэйгээр, орон нутаг дахь МСҮТ, Политехник коллежийн Удирдах зөвлөлд үйлдвэрлэл, ажил олгогчдын төлөөлөл болон аймгийн Засаг дарга, түүний орлогч болон Тамгын газрын удирдлага, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын удирдлагыг оруулсаны гадна нийслэл дэх политехник коллежийн Удирдах зөвлөлд ХНХЯ болон салбарын яамдын удирдах ажилтнуудаас оролцуулан томилсон байна.

<sup>28</sup> Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8.5 дахь заалт

<sup>29</sup> Матиас Фон Аселдонк (2016). *Бүсийн арга зүйн төвийн байгууллагын чадавхийн үнэлгээний тайлан*, Үйл ажиллагаа 4.1.2. <sup>37</sup> Боловсролын тухай хуулийн 36.12 дахь заалт

<sup>30</sup> Боловсролын тухай хуулийн 34.1, 36.1 дэх заалт

<sup>31</sup> Боловсролын тухай хуулийн 36.2 дахь заалт

<sup>32</sup> Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 12.10 дахь заалт

МБС-ын хөгжлийн бодлогыг улс орны болон орон нутаг, байгууллагын түвшинд тодорхойлох, мэргэшил, ур чадварын стандартыг тогтоох, түүнийг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэй байгууллагын өөрийн удирдлагыг бүрдүүлэн ажиллуулахад сонирхлын бүлгүүд, ялангуяа ажил олгогчид, үйлдвэрлэл, үйлчилгээний төлөөллийг оролцуулах эрхзүйн орчин бүрдсэн гэж үзэх боломжтой байна. Харин эдгээр эрх бүхий субъектүүдийн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхэд нь шаардагдах чадавхи бүрдүүлэх, үйл ажиллагааны уялдаа холбоо, харилцан хяналтыг тодотгон төлөвшүүлж, удирдлагын үр нөлөөг сайжруулах нөхцөл бүрдүүлэх шаардлагатай байна.

**Хүснэгт 6: МБС-ын засаглалын чиг үүрэг, талуудын оролцоо**

<b>Зорилго, чиг үүрэг</b>	<b>Талуудын оролцоотой удирдлагын байгууллага</b>	<b>Бүрэлдэхүүн</b>
<i>Улсын хэмжээнд стратеги, бодлого тодорхойлох, нийтлэг стандарт тогтоох</i>	МБСҮЗ, түүний салбарын болон орон нутгийн зөвлөл	Төрийн төлөөлөл = ажил олгогч, үйлдвэрлэлийн төлөөлөл
<i>Салбарын хэмжээнд чанар, ур, чадамжийн стандартыг мөрдүүлэх</i>	НХНСҮСИ-ийн мэргэжлийн зөвлөл БМИҮЗ-ийн МБС-ын комисс, төрөлжсөн зөвлөл	Мэргэжлийн холбооны төлөөлөл Мэргэжлийн холбоо, мэргэжлийн экспертүүд
<i>Сургуулийн түвшинд хөгжлийн стратеги чиглэлийг тодорхойлох, хөтөлбөрийн стандартыг мөрдүүлэх</i>	МБС-ын байгууллагын Удирдах зөвлөл  МБС-ын дэргэдэх мэргэжлийн болон техникийн зөвлөл	Үүсгэн байгуулагч/төрийн төлөөлөл 51-60 хувь, ажил олгогч, үйлдвэрлэлийн төлөөлөл, багш, төгсгөгч, суралцагчийн төлөөлөл  Мэргэжлийн холбоо, мэргэжлийн экспертүүд

Ийнхүү МБС-ын засаглалын хүрээнд сонирхлын бүлгүүдийн төлөөллийг оролцуулахад ахиц гарч байгаа боловч МБСБ-ын гүйцэтгэх удирдлагын түвшинд сүүлийн жилүүдэд ихээхэн хөдөлгөөнтэй байна. Зарим сургуулийн захирлыг 2012 оноос хойшхи 6 жилд арав хүртэл удаа сольсон, үүний нөлөөгөөр сургуулийн удирдах болон бусад түвшинд халаа сэлгээ ихээр хийгдсэн нь тухайн байгууллагын үйл ажиллагаанд тодорхой нөлөө үзүүлж байгааг шүүмжлэн ярилцаж байна. Сургуулийн Удирдах зөвлөлийг хөгжлийн чиг баримжаа баримталдаг болгон төлөвшүүлж, бүрэлдэхүүнийг нь тогтворжуулан гүйцэтгэх удирдлагыг томилох, чөлөөлөх, түүний үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгөхөд шийдвэрлэх үүрэгтэй болговол байгууллагын тогтвортой хөгжлийг хангахад үр нөлөөтэй болно.



## Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын баталгаажууллын өнөөгийн байдал

МБС-ын чанарын баталгаажуулал гэдэгт улс орнууд нийт системийн хэмжээнд болон сургууль, хөтөлбөр, багш сургагчдын түвшинд суралцахуйн үр дүн, түүнд хүрэх үйл явцын талаар нийтээр хүлээн зөвшөөрсөн чанарыг шалгуурыг тодорхойлох, хэрэгжилтийг үнэлэх баталгаажуулах зарчим, аргагүй, арга хэрэгслийг хамарсан цогц системийг хамаатуулан ойлгох нь нийтлэг болж байна<sup>33</sup>.

Саяхан болтол улс орнууд сургалтын байгууллагыг үнэлэх хянахад илүү анхаарч мэргэжлийн хяналт, магадлан итгэмжлэл зэрэг хөндлөнгийн (буюу гадаад) үнэлгээг нийтлэг ашиглаж байв (ETF, 2016). Ийм үнэлгээ нь ихэвчлэн чанарын мөчлөгийн орц болон процесст төвлөрч сургалтын байгууллагын удирдлага, бүтэц зохион байгуулалт, сургалтын агуулга, хөтөлбөр, сургах үйл явц, хөрөнгө, дэд бүтцийг үнэлэхэд чиглэдэг (Cedefop, 2009). Үйл ажиллагаа, түүний үр дүн нь харгалзах стандарт шаардлагыг хангаж байгаа эсэхийг чанарын аудит, үнэлгээ шинжилгээ, үргэлжилсэн хяналт, хариуцлага тооцох, үнэлгээний дүнг нийтэд мэдээлэх зэргээр тодорхойлж хэрэгжүүлдэг (Bateman et al., 2012).

Энд дурдсан хөндлөнгийн үнэлгээ, хяналт шалгалтын зэрэгцээ улс орнуудад сургалтын байгууллагад чанарын соёл бий болгоход чиглэсэн өөрийн (буюу дотоод) үнэлгээний үр нөлөөг сайжруулахад ач холбогдол өгөх нь улам бүр нэмэгдэж байна. Үүний нэг жишээ нь ЕХ-ны гишүүн орнуудын хэмжээнд ТМБС-ын Чанарын баталгаажууллын Европын референс систем (European reference framework for quality assurance in TVET) бүрдүүлэн хэрэгжүүлж байгаа практик юм. Энэхүү систем нь дотоод болон хөндлөнгийн үнэлгээнд нэгдмэл шалгуур, чанарын шинжилгээг ашиглан уялдаа холбоотой хэрэгжүүлж, улс орны хэмжээнд ч, сургалтын байгууллагын түвшинд ч (EQAVET) чанарыг баталгаажуулах, чанарыг тасралтгүй сайжруулж байх соёлыг дэмжихэд чиглэсэн системтэй хандлагыг хэрэгжүүлэх хэрэгсэл болж байна.

Түүнчлэн сургалтын орц, процесст төвлөрсөн үнэлгээ баталгаажууллаас гадна суралцагчдын сурах, ур чадвар эзэмших боломж, арга хэлбэр улам бүр олон төрөл хэлбэртэй болж байгааг харгалзан хүмүүсийн эзэмшсэн мэргэшлийг баталгаажуулахад онцгойлон анхаарах шаардлагатай болж байна (Cedefop, 2015). Энэ нь ажлын байранд дагалдан суралцах, онлайн сургалтыг ашиглах, өмнө эзэмшсэн ур чадвар, мэргэшлээ үнэлүүлж баталгаажуулах боломж хэрэгцээг тусгасан чанарын баталгаажууллын хувилбар хэрэгтэй болж байгааг нотолно.

Сүүлийн жилүүдэд мэргэшлийн нийц, үнэ цэнийг дээшлүүлэх талаар иргэд, хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ сонирхол өсөн нэмэгдсэнтэй холбоотойгоор дэлхийн улс орнууд үндэсний мэргэшлийн түвшний шатлалын систем (ҮМТШС<sup>34</sup> буюу National Qualifications Framework-NQF)-г боловсруулан албажуулж, мэргэшлийн чанарыг баталгаажуулахад (Quality Assurance of Qualifications) илүү анхаарал тавьж, хэрэгжилтийг эрчимжүүлж байна. Хүмүүсийн шилжилт хөдөлгөөн, компаниудын зүгээс ажилтнууддаа тавих шаардлага улам бүр олон улсын шинжтэй болж байгаа нь үндэсний хэмжээний мэргэшлийн ангиллыг бүс нутгийн болон олон улсын жишигт нийцүүлэх шаардлагатай болгож байна. Үүний дүнд

<sup>33</sup> Borhene Chakroun and George Kostakis (2017). Quality assurance of qualifications: building trust and enhancing value, in Cedefop (2017). *Global inventory of regional and national qualifications frameworks 2017*, pp. 82-94.

<sup>34</sup> “мэргэшлийн үндэсний хүрээ” хэмээн Хөдөлмөрийн тухай хуульд нэрлэсэн энэ ойлголтыг баримт бичгүүдэд өөр бусад нэрээр нэрлэж буй тул агуулга мөн чанарыг илүүтэй илэрхийлнэ хэмээн үзэж өөрийн томъёолсон хувилбараар хэрэглэсэн болно.



чанарыг баталгаажуулж буй албан ёсны тогтолцоо, үндэсний мэргэшлийн түвшний шатлалын системийг хэрхэн уялдуулах асуудлыг улс орнууд идэвхитэй хэлэлцэж байна.

Чанарын баталгаажуулал, мэргэшлийн түвшний тогтолцоо гэсэн хоёр хэрэгсэл нь нийтэд ойлгомжтой тодорхой байж, боловсрол, сургалтын системийн шатлал хооронд харилцан итгэлцэл бүрдүүлэх нэгдмэл зорилготой (Murray, 2013). ҮМТШС нь боловсрол, мэргэжлийн стандартыг боловсруулах, баталгаажуулах, хэрэгжүүлэхэд оролцдог бүх талуудад харилцан ойлголцол, итгэлцэл бүрдүүлэх суурь болно (Coles, 2016).

Чанарын баталгаажуулал нь нэлээд олон оронд ҮМТШС-ны гол цөм болдог бол Австрали, Шинэ Зеланд, Индонез, Филиппин, Малайз, Тайланд зэрэг оронд ҮМТШС-той холбоотой ч харьцангуй тусдаа зэрэгцэн ажилладаг систем болж байна. Гэхдээ аль ч оронд мэргэшлийн түвшний тогтолцоог хэрэгжүүлж сахиулах хамгийн нөлөөтэй байгууллага нь чанарын баталгаажууллын хөндлөнгийн үнэлгээний байгууллага байдаг.

Чанарын баталгаажуулал нь МБС-ын үндсэн зорилгын хэрэгжилт, үр дүнд хүрэх үйл явцыг үнэлж, шаардлагатай тохиргоо хийж, удирлагын шийдвэрийн үндэслэлийг сайжруулах цогц систем болно. Энэ нь сургах, суралцах процессийн үр дүнг сайжруулах аливаа бодлогын санаачилга нь чанарын талаар үндэсний хэмжээний дэмжлэгийг хүлээсэн тогтвортой бодлоготой байхад үйлчилнэ.

Чанарын баталгаажууллын үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлсэнээр МБС-ын үйл ажиллагааг олон нийтэд ил тод болгож, оролцогч талуудын итгэлцлийг бататган, хамтын ажиллагааг идэвхижүүлж, нэр хүндийг бэхжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Боловсролын тухай болон Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх бодлогын баримт бичгүүдэд “зорилгод нийцүүлсэн Чанарын баталгаажуулалтыг бүрдүүлэн бий болгох” эрх зүйн үндэс, бодлогын зорилтуудыг тодорхой тусгажээ. Үүний дотор МБС-ын салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (2016-2021)-т чанарын талаар баримтлах стратегийг 6 зорилтоор тодорхойлсон байна. Үүнд:

1. Үндэсний мэргэшлийн түвшний тогтолцоог бүрдүүлж бий болгох;
2. Чанарын баталгаажуулалт болон байгууллагын удирдлага, засаглалыг сайжруулах;
3. Чадамжид суурилсан сургалт, үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх;
4. Салбарын хүний нөөц, удирдлага, багшийн хөгжлийг тасралтгүй хангаж чадавхийг бэхжүүлэх;
5. Нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлж салбарын нэр хүндийг өргөх;
6. Санхүүгийн тогтолцоог сайжруулах.

Манай оронд байгууллагын түвшинд чанарын удирдлагын талаар баримтлах үзэл баримтлал зарчмыг Стандартчиллын үндэсний зөвлөлөөс 2016 онд баталсан **MNS ISO 9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо: шаардлага** үндэсний стандартад тодорхойлсоноор ойлгож хэрэглэхээр тогтоосон байна. Үүнээс илүүтэйгээр Олон улсын стандартчиллын байгууллагаас 2018 онд баталж, 2021 онд Монгол Улсын үндэсний стандарт болон мөрдөж буй **MNS ISO 21001:2021 Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо - Шаардлага, хэрэглэх арга зүйн заавар** стандарт нь боловсролын байгууллага сургах, сурах үйл явц, түүний үр дүнгийн тохирлыг баталгаажуулах замаар суралцагч, үйлчлүүлэгч, ажилтны сэтгэл ханамжийг дээшлүүлэх зорилгод нийцсэн менежментийн хэрэгсэл болж байна. Энэхүү MNS ISO 21001:2021 стандарт нь дараах зарчимд үндэслэсэн байна:

- Суралцагчид, бусад харилцагчид (төр засаг, хөдөлмөрийн зах, эцэг эх асран хамгаалагч г.м.)-ын ашиг сонирхлыг төвдөө тавьсан байх
- Алсын хараатай манлайлал: дээд удирдлага нь хариуцлагатай, суралцагч, харилцагчдын сэтгэл ханамжийг эрхэмлэсэн, эрх мэдлийг зохистой хуваарилсан, харилцааг үр дүнтэй болгосон
- Ажилтнууд нь чин эрмэлзэлтэй
- Процесс үйл явцыг анхаарч чухалчлах
- Ахиц сайжруулалтад тэмүүлэх
- Шийдвэр нь баримт нотолгоонд үндэслэдэг байх
- Харилцаа харьцааг зөв зохистой удирдах
- Нийгмийн хариуцлагатай байх
- Тэгш хандаж, үйлчилгээг хүртээмжтэй болгох
- Ёс суртахуунтай байх
- Мэдээ мэдээллийн үнэн зөв, хамгаалалттай байдлыг хангах

МБС-ын хүрээнд сүүлийн жилүүдэд засгийн газраас дэмжин МСС, Сингапурын Темасек, ЕХ-ны МБССДТ-1 төсөл болон бусад хөгжлийн түншүүдтэй хамтран боловсруулсан чанарын баталгаажуулал, менежментийн механизм нь дараах үндсэн зарчмуудад тулгуурласан нь дээрх үндэсний стандартын үзэл баримтлалтай нийцэж байна. Үүнд:

- Чанарын баталгаажуулал, чанарын менежментийн үндсэн зорилго нь чанарыг тасралтгүй сайжруулж байхад чиглэнэ;
- Чанарын баталгаажууллыг удирдан зохион байгуулах нь үйл ажиллагааны эцсийн үр дүнд чиглэсэн байх ба үүнийг төрийн захиргааны болон зохицуулах байгууллага, МБСБ, үйлдвэрлэл үйлчилгээний салбар, нийгмийн түншүүд хамтран тодорхойлж, боловсруулж, хэрэгжүүлнэ;
- МБСБ нь өөрийн сургалт, үйлчилгээний чанар, түүнийг баталгаажуулах ажлын үр дүнг шууд хариуцна;
- МБС-ын дотоод чанарын баталгаажууллын тогтолцоог холбогдох удирдамж, зөвлөмж, хэрэглэгдэхүүн, мэдээллээр хангаж, хөндлөнгийн хараат бус үнэлгээ шинжилгээ хийж, дүгнэлт гаргах бүтэц тогтолцоо бүрдсэн байна;
- Чанар, үр дүнд өөрийн үнэлгээ хийх ажил нь “төлөвлө – хэрэгжүүл – үнэл – сайжруул” гэсэн мөчлөг бүхий цогц үйл явц бөгөөд өөрийн үнэлгээний тайланг жил бүр гаргана;
- Суралцагчид болон бусад сонирхлын бүлгүүдийн эрх ашиг, хэрэгцээг тусгана;
- Чанарыг баталгаажуулах үйл ажиллагааны зохион байгуулалт нь сургалтыг дэмжихүйц үр ашигтай, үр дүнтэй байна;
- Чанарыг баталгаажуулах үйл явц, үр дүн нь ил тод байна;
- Гадны хөндлөнгийн үнэлгээ нь байгууллагын өөрийн үнэлгээний үйл явцыг баталгаажуулахад чиглэнэ.

МБС-ын хүрээнд чанарыг баталгаажуулахад хэрэглэж буй олон механизм нь сургалтын байгууллагын зүгээс гарах шинэ санаачилга, шийдэл, олон төрөл, хэлбэрийг хааж боогдуулж болохгүй<sup>35</sup> гэдгийг энэ чиглэлээр ажилласан олон улсын зөвлөхүүд анхааруулсан байна.

<sup>35</sup> Hammink (2017). *Quality Assurance and Quality Management in TVET: POLICY and GUIDELINES*, draft version 1.2 (drafted by STVET international senior non-key expert)

## Мэргэжлийн боловсрол сургалтын чанарын баталгаажууллын эрх зүйн зохицуулалт

ТМБС-ын харилцааг 2002 он хүртэл Боловсролын тухай болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд зохицуулж ирсэн. Үүний дотор МБС-ын бүрэн хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх байгууллагад хамаарах зохицуулалт нь Боловсролын тухай хууль тогтоомжид тодорхойлсон хүрээнд хэрэгжиж байв. Тухайлбал, 1995 оны Боловсролын тухай хуульд боловсрол нь бага, дунд, дээд гэсэн 3 түвшинтэй байхаар тогтоож (10 дугаар зүйл), техникийн болон мэргэжлийн сургууль нь дунд боловсролд хамаарахаар (12 дугаар зүйлийн 4 дүгээр заалт) зааж, үүнтэй уялдуулан Бага, дунд боловсролын тухай хуульд “ТМС нь суралцагчдад техник, технологи, мэргэжил эзэмшихэд үйлчлэх сургалт-үйлдвэрлэлийн буюу үйлдвэрлэл-сургалтын байгууллага” (16 дугаар зүйл) хэмээн тодорхойлжээ.

2002 онд Боловсролын тухай хуульд боловсролын түвшинг “сургуулийн өмнөх, бага, дунд, дээд боловсролын агуулгын стандартаар тогтоосон мэдлэгийн хэмжээ”-гээр тодорхойлно (3 дугаар зүйлийн 3.1.4) хэмээн тайлбарлажээ. Харин боловсролын агуулгын түвшинг сургуулийн өмнөх, бага, дунд, мэргэжлийн боловсрол, дээд гэж ангилахаар тогтоож, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулиар агуулгыг нарийвчлан тодорхойлох (11 дүгээр зүйлийн 11.1), МБСБ нь Политехник коллеж (техникийн боловсролын сургалт эрхлэх байгууллага), МСҮТ (мэргэжлийн боловсролын сургалт эрхлэх байгууллага) зэрэг хэв шинжтэй (14<sup>1</sup> дүгээр зүйл) байхаар заасан. Богино хугацааны мэргэжлийн сургалт эрхлэх асуудлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хуулийн дагуу хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллага бүртгэлийг хариуцаж байсан бол Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 2009 оны шинэчилсэн найруулгад мэргэжлийн сургалт нь “мэргэжлийн боловсрол, сургалт”-ын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг хэмээн тодорхойлж, 2016 оноос энэ төрлийн үйл ажиллагааг бүртгэх, төгсгөгчдийн нь чадамжийг баталгаажуулах, гэрчилгээжүүлэх ажлыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нэгдсэн удирдлага зохицуулалттай болгожээ. Харин 2022 оны эхнээс МСҮТ, политехник коллежийн асуудлыг БШУЯ-нд шилжүүлж, мэргэжлийн сургалттай холбогдох хэсгийг ХНХЯ-нд үлдээсэн нь үндсэндээ 2002 оны үеийн зохицуулалт харьцаанд буцаан шилжсэн байна. Үндсэн ялгаа нь БШУЯ болон түүний харьяа төрийн багууллага-агентлаг болох Боловсролын ерөнхий газарт мэргэжлийн боловсрол, сургалт хариуцсан хэлтэс, алба, түүний ажилтнуудын тоо ихээр нэмэгдсэн, гэхдээ БАЗТ, мэргэжлийн ур чадварын үнэлгээний чиг үүрэг хоёр яамны ижил төстэй чиг үүрэгтэй нэгжүүдэд хуваагдсан байдалтай байна.

Чанарын баталгаажууллын хүрээ, түүнд хэрэглэх хэрэгслийг чанарыг хэрхэн тодорхойлсонд үндэслэн тогтоож ашигладаг. Боловсрол, сургалтын салбарт одоо мөрдөж буй эрх зүйн баримт бичгүүдэд боловсрол, сургалтын чанарыг албан ёсны тодорхойлсон нь хараахан үгүй, иймд чанарыг баталгаажуулах системийг бүрдүүлэгч элементүүд, арга хэрэгсэл, чанарын баталгаажууллын үндсэн үүрэг функцийг уялдуулан холбосон цогц хэрхэн бүрдэж ажиллахыг шууд харах боломжгүй байна.

БШУЯ, ХНХЯ-ны дэмжлэгтэйгээр 2018, 2019 онд бэлтгэж түгээсэн нэр томъёоны тайлбарт чанар, чанарын баталгаажууллыг дараах байдлаар тодорхойлжээ:

<b>БСШУЯ (2019). Дээд боловсролын нэр томъёоны монгол-англи-орос тайлбар толь</b>	<b>ХНХЯ, МБСТ (2018). Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын нэр томъёоны монгол-англи тайлбар толь</b>
<b>Чанар</b> (сургалтын) <a href="#">Quality (academic)</a> Олон хэмжээст, олон түвшнийг хамарсан, хувьсан өөрчлөгдөж байдаг ойлголт.	<b>Чанар:</b> Зорилгодоо нийцсэн байх; тухайн сургалтын байгууллага, хөтөлбөрийн чиг

---

Энэ нь тухайн боловсролын тогтолцоо, сургалтын байгууллага, хөтөлбөр эсхүл мэргэжлийн салбарын хүрээнд боловсролыг загварчлах орчин нөхцөл, дээд боловсролын сургалтын байгууллагын эрхэм зорилго, зорилтууд болон тодорхой стандарт зэрэгт хамааралтай. Чанарын тухай ойлголтууд харилцан адилгүй байх бөгөөд зарим тохиолдолд дараах хүчин зүйлээс хамааран зөрчилдөх нь ч бий. Үүнд: дээд боловсролын оролцогч талуудын харилцан адилгүй ашиг сонирхол, түүнээс үүдэлтэй ойлголтууд (жишээлбэл, оюутан, их сургууль, мэргэжлийн чиглэл, хөдөлмөрийн зах зээл, нийгэм, засгийн газар г.м.); нөлөөлөх хүчин зүйлс (орц, үйл явц, гарц, эрхэм зорилго, зорилт г.м.); үнэлгээ хийгдэхүйц академик орчны онцлог шинэ чанар эсвэл хандлага; дээд боловсролын хөгжлийн түүхэн үе шат. (UNESCO-CEPES, 2007)

---

**Чанарын баталгаажуулалт** (Quality assurance) Дээд боловсролын тогтолцоо, сургалтын байгууллага, мөн хөтөлбөрийн чанарыг үнэлж буй (үнэлэх, хянах, баталгаажуулах, сайжруулах) тасралтгүй үргэлжлэх үйл явц. Зохицуулах механизмын хувьд чанарын баталгаажуулалт нь харилцан хүлээн зөвшөөрсөн уялдаа холбоо бүхий үйл явц, тогтсон шалгуураар дамжуулан мэдээлэл болон дүгнэлт гаргаж, хариуцлагыг дээшлүүлэх, чанарыг сайжруулахад төвлөрдөг. Ихэнх тогтолцоо чанарын дотоод баталгаажуулалт (дээд боловсролын чанарыг хянах сайжруулах байгууллагын дотоод үйл ажиллагаа) болон чанарын хөндлөнгийн баталгаажуулалт (дээд боловсролын сургалтын байгууллага, хөтөлбөрийн чанарыг баталгаажуулах байгууллага хоорондын эсвэл байгууллагын гаднах тогтолцоо)-ыг хоорондоо ялгаатай гэж үздэг. Чанарын баталгаажуулалтын үйл ажиллагаа нь тогтсон чанарын соёлын хүрээнд төлөвшин бий болдог байгууллагын зохих тогтолцооноос хамааралтай байдаг. Чанарын удирдлага, сайжруулалт, хяналт, үнэлгээ зэрэг нь чанарын баталгаажуулалтыг бий болгодог арга хэрэгслүүд юм. Чанарын баталгаажуулалтын цар хүрээ тухайн дээд боловсролын тогтолцооны хэлбэр, хамрах хүрээнээс хамаарах бөгөөд урьдач нөхцөлийг бүрдүүлдгээрээ магадлан итгэмжлэлээс ялгаатай. Энэ хоёр ойлголтын харилцан хамаарал нь улс орнуудын практикт янз бүр байдаг. Эдгээр ойлголт нь үйл ажиллагаа явуулах, боловсролын үйлчилгээ үзүүлэх, албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн боловсролын зэрэг олгох чадавх, төрөөс санхүүжилт авах эрх зэрэг олон хүчин зүйлүүдийн суурь болдог. Чанарын баталгаажуулалт болон чанарын удирдлага нь зарим тохиолдолд ижил утгаар хэрэглэгддэг хэдий ч чанарын баталгаажуулалтыг дээд боловсролын чанарын удирдлагын нэг бүрэлдэхүүн гэж үздэг. (UNESCO-CEPES, 2007)

үүрэг, үндсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх үйл явцийг үр дүнтэй болгоход чиглэсэн, магадлан итгэмжлэх эсхүл чанарыг баталгаажуулах өөр бусад байгууллагаас тогтоосон, нийтээр хүлээн зөвшөөрсөн стандартыг хангах, түүнд нийцүүлэх нь чанарын илэрхийлэл болно. Эх сурвалж: Үнэлгээ, баталгаажуулалтын бодлогын баримт бичгийн төсөл, ХНХЯ, УБ, 2017

---

**Чанарын баталгаажилт** (Quality Assurance): чанарын баталгаажилтад аливаа үйл ажиллагааны үнэ цэнэ, чанар, давуу байдлыг тогтсон стандартын дагуу үнэлэх, сайжруулахад чиглэсэн аливаа үйл ажиллагаа орно.

Тайлбар: МБС-ын салбарт, чанарын баталгаажилт гэдэг нь мэргэшил, үнэлгээ, хөтөлбөр нь тодорхой стандартыг хангаж байгаа эсэхийг баталгаажуулах журам, үйл явц.

Эх сурвалж: ОУ-ын статистикийн нэр томъёоны тайлбар толь, ЭЗХХАБ, 2010

---

Бид энэ судалгааны хүрээнд чанар, чанарын баталгаажууллыг харьцангуй нийтлэг хэрэглэж буй эх сурвалжид түшиглэн дараах байдлаар тодорхойлсоныг ашиглахыг санал болгож байна:

**Чанар** – зорилгодоо нийцсэн байхын илэрхийлэл; сургалтын байгууллага, хөтөлбөрийн чиг үүрэг, үндсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх процессийг үр дүнтэй болгоход чиглэсэн, магадлан итгэмжлэх эсхүл чанарыг баталгаажуулах эрх бүхий бусад байгууллагаас тогтоосон, нийтээр хүлээн зөвшөөрсөн стандартыг хангах, түүнд нийцүүлэх нь чанарын илэрхийлэл болно.

**Чанарын баталгаажуулал** – боловсрол, сургалтын систем, байгууллага, түүний хөтөлбөрийн чанарыг хангах (орц, явц, үр дүнг шалган дүгнэх, хянан шинжлэх, баталгаажуулах, үйлчлэх, ахиулан сайжруулах)-ад чиглэсэн тасралтгүй үргэлжлэх процесс. Чанарын баталгаажуулал нь зохицуулах шинжтэй механизм учир сайтар боловсруулсан шалгуурыг ашиглан холбогдох талууд зөвшилцөн тохиролцсон процессоор дамжуулан мэдээлэл өгч, дүгнэлт гаргах замаар чанарын төлөө хариуцлага, түүнийг сайжруулах чиглэлийг тогтооно.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд “Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын үнэлгээ” гэж гарчигласан 16 дугаар зүйлд зааснаар бол мэргэжлийн боловсрол, сургалтын чанарыг суралцагчдын эзэмшсэн мэдлэг, ур чадвар, төлөвшил, чадамжийн үнэлгээгээр тодорхойлсон байна. Олон улсын хэмжээнд боловсролын чанарын баталгаажууллын тогтолцоог тодорхойлж байгаа бүрдүүлэгч үндсэн элементүүд болох боловсрол, мэргэжлийн стандарт, тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэл, хяналт шалгалт, батламжлал/гэрчилгээжүүлэлтийн зохицуулалтыг манай холбогдох хуулиудад 1991 оноос тусгаж ирсэн юм. Чанарын баталгаажууллын эдгээр механизмыг хэрэгжүүлж буй байдал, үүнд төрийн захиргааны болон мэргэжлийн олон нийт, сонирхлын бүлгүүдийн үүрэг оролцоо, үнэлгээ дүгнэлтийн бодит, хараат биш байдлыг хэрхэн хангаж байгааг тус бүрд нь задлан шинжилж үзье.

Монгол Улсад МБС-ын чанарыг баталгаажуулахад холбогдох эрх зүйн зохицуулалтын үндсэн асуудлыг дараах хууль тогтоомжид тусгасан байна. Үүнд:

- **Тусгай зөвшөөрөл:** МБС-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн олгох нөхцөл, процедурыг Боловсролын тухай хуулийн 21, 24 дүгээр зүйл; Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн 12, 13, 14 дүгээр зүйлд тодотгон тодорхойлсон. Мөн төрийн өмчийн бус мэргэжлийн болон техникийн боловсрол олгох сургалт нь тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагаа болохыг Зөвшөөрлийн тухай хуулийн 7.4 дүгээр зүйлд заасан;
- **Магадлан итгэмжлэл:** боловсрол сургалтын байгууллага, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн зорилго, үндсэн зарчим, нийтлэг үйл явцыг Боловсролын тухай хуулийн 21.6, 26.1, 26.5, 26.6, 21.6 дугаар зүйлд тодорхойлсон;
- **Хяналт үнэлгээ:** боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагааг захиргааны болон мэргэжлийн удирдлагаар тогтмол хангах, дүн шинжилгээ хийх, ангиллыг тогтоох тухай Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн 8.4.8 дүгээр заалт болон Боловсролын тухай хуулийн 28, 37 дугаар зүйлд заасан; мөн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг холбогдох асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага аттестатчилж байхыг Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн 8.4.9, 8.4.23 дугаар зүйлд заасан;

- **Хяналт шалгалт:** боловсрол сургалтын байгууллагын үйл ажиллагаанд мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг Мэргэжлийн хяналтын тухай хууль; болон Боловсролын тухай хуулийн 24.1.1 дүгээр заалт болон Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн 26.1 дүгээр заалтад тодорхойлсон
- **Гүйцэтгэлийн аудит:** улсын төсвөөс санхүүжилт авдаг боловсрол сургалтын байгууллагад санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитыг заавал хийлгэж байх журмыг Аудитын тухай хуулийн 9.1, 10.3, 11.1 дэх заалт болон Төсвийн тухай хуулийн 8.9.8 дэх заалтаар тогтоосон;
- **Стандартчилал:** улсын боловсролын стандартуудыг Стандартчиллын Үндэсний зөвлөл улсын хэмжээнд хэрэглэхээр хүлээн зөвшөөрч үндэсний стандартаар батлахыг Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 6.2, 6.5, 9.4, 20.2.1 дэх заалтаар зохицуулсан байна;
- **Батламжлал/гэрчилгээжүүлэлт:** боловсрол сургалтын үр дүн болох суралцагчдын эзэмшсэн боловсрол, ур чадварыг үнэлж дүгнэн албан ёсоор баталгаажуулж гэрчилгээ, баримт бичиг олгохтой холбогдох зохицуулалтыг Боловсролын тухай хуулийн 9, 17<sup>1</sup>, 24 дүгээр зүйл; Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн 8.4.11, 8.4.20, 16 дугаар зүйлд тодотгон тодорхойлсон.

Боловсролын тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай болон бусад хуульд чанарын баталгаажууллын дээрх механизмыг тус бүрд нь тодорхойлсон ч тэдгээр нь харилцан уялдаа зохицуулалттай нэгдмэл цогц системийн бүрдэл хэсгүүд гэж ойлгож хэрэглэж хараахан хэвшээгүй байна. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд чанарын үнэлгээг зөвхөн суралцаж төгсгөгчдийн мэргэшил, ур чадварыг үнэлэх асуудалтай холбосон, Боловсролын хуульд заасан магадлан итгэмжлэлийн шаардлагыг харьцангуй ялгаатай зориулалт, зохион байгуулалт бүхий техникийн боловсрол, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага, хөтөлбөрт хэрхэн тавьж хэрэгжүүлэх зохицуулалтыг орхигдуулсан зэрэг нь үүнийг илтгэх жишээ юм.

### **Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын үнэлгээ**

МБС-ын стандартын хэрэгжилтийг суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг сургалтын явцад болон анги дэвших, сургууль төгсөхөд нь багш, сургалтын байгууллага болон мэргэжлийн үнэлгээний байгууллагын үнэлсэн дүнгээр тодорхойлно.

МБС-ын стандарт, хөтөлбөрийг албан болон албан бус сургалтын хэлбэрээр эзэмшиж, үнэлгээнд тэнцсэн иргэнд харгалзах мэргэжлийн диплом, мэргэжлийн үнэмлэх, чадамжийн гэрчилгээ олгоно.

Үнэлгээ, мэдээллийн төв нь хөндлөнгийн шалгалт зохион байгуулах, төгсөгч, мэргэжлийн ур чадвар эзэмшсэн иргэний мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

*(Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 16 дугаар зүйл)*

Ийнхүү боловсрол, сургалтын стандартад тодорхойлсон сургалтын үр дүн буюу суралцагчийн эзэмших мэдлэг, чадвар, төлөвшил нь чанарын хэмжүүр болох тул энэхүү стандартыг эхнээс нь хэн хэрхэн тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх бэлтгэл нөхцөлд ямар шаардлага тавьж хэрхэн хангуулах, стандартыг хэрэгжүүлэх үйл явцыг хэрхэн хянаж үнэлэхийг хамарсан цогц үйл ажиллагааг чанарын баталгаажуулал хэмээн үзэж болно.

Сүүлийн жилүүдэд төр засгийн зүгээс болон Монгол Улсын хөгжлийг дэмжигч хандивлагчдын анхаарал, хүчин чармайлт энэхүү стандартыг боловсруулахад ихээхэн чиглэсэн байна. АХБ-ны санхүүжилтээр 2012-2021 онд хэрэгжсэн “Дээд боловсролын шинэчлэлийн төсөл”-ийн хүрээнд боловсролын чанарын баталгаажууллын тогтолцоог шинэчлэх алхмууд хийгдэж, энэхүү үзэл баримтлалаар Боловсролын тухай болон Дээд боловсролын тухай хуульд 2016 онд оруулсан нэмэлт өөрчлөлтийг МБС-ын чанарын баталгаажууллын тогтолцоог бүрдүүлэн хөгжүүлэх чиг баримжаа болгох хэрэгтэй юм. Чанарын баталгаажууллын хөндлөнгийн болон байгууллагын дотоод системийн уялдаа холбоог улсын хэмжээнд, салбарын түвшинд, сургалтын байгууллагын болон хөтөлбөрийн түвшинд чанарыг баталгаажуулах оролцогч талуудын үүрэг хариуцлагыг уялдуулан тод томруун болгох хэрэгцээ байна. Эдгээр олон төрлийн үнэлгээ хяналтын механизм нь чанарын баталгаажууллын тогтолцоонд уялдаа холбоотой, давхардал, орхигдолгүй ажиллах нэгдсэн зохицуулалт шаардлагатай болно.

### Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын баталгаажууллын одоогийн байдал

Чанарын баталгаажууллын системийн үндсэн гол зорилго нь тухайн үйл ажиллагаа үр өгөөжтэй, үр ашигтай, итгэл даахуйц, хүлээн зөвшөөрөгдсөн байх нөхцлийг хангахад чиглэнэ. Энэхүү зорилгын үүднээс төр засгийн байгууллага нь чанарыг баталгаажуулах эрхзүйн орчныг бүрдүүлж, холбогдох талуудын зохистой оролцоотой механизмыг дээрх зорилгод чиглүүлэн тогтвортой, үр нөлөөтэй ажиллуулдаг. Хэрэв бид хамгийн төгс байдлаар нь төсөөлбөл чанарын баталгаажууллын тогтолцоо нь дараах гол үүрэг функцийг зайлшгүй хамрах ёстой:

- 1) Сургалтын байгууллага, эсхүл хөтөлбөрийг эхлүүлэх нөхцөл шаардлагыг хангасан байдлыг үнэлж дүгнэх;
- 2) Сургалтын байгууллага, хөтөлбөр нь холбогдох стандартыг хангаж үйл ажиллагаа нь тогтвортой явагдаж байгаа эсэх, чанараа ахиулан сайжруулж байгаа эсэхийг үнэлж дүгнэх;
- 3) Төгсгөгчид нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, чадамжийг эзэмшсэнийг үнэлж албажуулах; болон
- 4) Сургалтын байгууллага, хөтөлбөр нь чанарын шаардлага хангасаныг хүлээн зөвшөөрч, үнэлж дүгнэсэн тухай мэдээллийг нийтэд түгээх (ДБ, 2003).

Чанарын баталгаажууллын эдгээр функц нь харилцан бие биенээ дэмжин уялдаа холбоотой хэрэгжсэнээр үр дүнтэй цогц систем бүрдэж ажиллах болно. Түүнчлэн, чанарын баталгаажууллын системд эдгээр чиг үүрэг функцийг бүрэн хамруулан ажиллуулсанаар боловсрол, сургалтын үр дүнг үндсэн хэрэглэгчдэд хүлээн зөвшөөрүүлэх (ажил олгогчдын болон өөрөө хөдөлмөр эрхлэхийг эрмэлзэж байгаа иргэний итгэл хүлээж, хэрхэн яаж ажиллаж байгаа нь тод томруун байх) нөхцөл хангагдаж, нийт системийн үр өгөөж, үр ашиг, түүнд итгэх итгэл, түүнийг хүлээн зөвшөөрөх байдал баталгаажина.

Чанарын баталгаажууллын процесст энэхүү үйл явцын үр шимийг хүртэгч бүх талууд - төрийн болон төрийн бус байгууллага идэвхитэй, үр нөлөөтэй оролцогч байх хэрэгцээ сонирхол, чадавхи бүрдүүлсэнээр систем тогтвортой ажиллах нөхцөл бүрдэнэ. Энд анхаарвал зохих хамгийн чухал зүйл бол системийн үүрэг функц бүр хариуцагчтай, тэдгээр нь уялдаа холбоотой байж аль нэг функц өөрчлөгдөхөд бусдадаа ямар нэг сөрөг нөлөө, доголдол, саатал үүсгэхгүй байх шаардлагатай.



Чанарын баталгаажууллын тогтолцооны талаар өмнө өгүүлсэнтэй харьцуулах зорилгоор манай орны мэргэжлийн боловсрол сургалтын салбар дахь чанарын баталгаажууллын чиг үүргийг одоо хэрэгжүүлж буй механизмыг дараах хүснэгтэд харуулав.

**Хүснэгт 7: Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын чанарын баталгаажууллын тогтолцоо**

<b>Чанарыг баталгаажуулах механизм</b>	<b>Зорилго</b>	<b>Хэрэгжүүлэгч</b>	<b>Хэрэглэх давтамж</b>	<b>Шаардлага</b>	<b>Үр дүн</b>
<b>Тусгай зөвшөөрөл, бүртгэл</b>	МБС-ын үйл ажиллагааг эрхлэх үндсэн нөхцлийг хангуулах	Боловсролын ерөнхий газар, түүний байгуулсан ажлын хэсэг	Зөвшөөрөл олгохын өмнө нэг удаа	Заавал (холбогдох хуулийн заалт, БХ: 21, 24; МБСХ: 12, 13, 14)	Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
<b>Хөтөлбөрийг үнэлэх</b>	Сургалтын хөтөлбөрийг мэргэшлийн түвшин, боловсролын стандарт шаардлагад нийцүүлэх	Боловсролын ерөнхий газар, БАЗТ-ийн ажлын хэсэг БҮТ: хөтөлбөрийн чанарын үнэлгээ БМИҮЗ: шинэ хөтөлбөрийн урьчилсан магадлан итгэмжлэл <sup>36</sup>	Хөтөлбөрийг эхлүүлэхийн өмнө, хэрэгжүүлэх явцад	Заавал (БХ: 17 <sup>1</sup> .1; 21.6; 28.1.8, МБСХ: 6.3.4; 8.4.10; 8.4.20; 8.5; 10.1; 10.2; 16.3; 20.2.3)	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвшөөрөл, Хэрэв зөрчил илэрсэн бол захиргааны хариуцлага ногдуулна
<b>Стандартчилал</b>	MNS6541:2015 стандартыг мөрдүүлэх хянах,	БЕГ, ХНХСҮСИ, мэргэжлийн хяналт	Шинэ сургууль, хөтөлбөрийг эхлүүлэхийн өмнө стандартад нийцсэн эсэхийг хянаж дүгнэх	Заавал (Стандартчилал, хэмжилзүйн тухай хууль: 6.2, 6.5, 9.4, 20.2.1)	Стандартын нийцлийн тухай дүгнэлт
<b>Аттестатчилал</b>	Эрх бүхий байгууллагын тогтоосон шаардлагын хэрэгжилтийг шалгах	Сургуулийн өөрийн үнэлгээ, яамны ажлын хэсгийн шалгалт	5 жил тутам эсвэл яамны санаачилгаар	Заавал (МБСХ: 8.4.9)	Зөрчилтэй бол тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл захиргааны хариуцлага
<b>Яам, агентлагийн үзлэг шалгалт</b>	Хууль тогтоомж, яамны шийдвэр, үр дүнгийн гэрээний биелэлтийг шалгах	Яам/агентлагийн ажлын хэсэг	Яам/агентлагийн баталсан хуваарь, удирдамжийн дагуу	Хуваарьт заасан МБСБ заавал БХ: 28, 37; МБСХ: 8.4.8)	Зөрчил тогтоогдсон бол захиргааны хариуцлага

<sup>36</sup> БҮТ нь бүх шатны боловсролын чанарын үнэлгээ хийх (Боловсролын тухай хуулийн 17<sup>1</sup>.1 дэх заалт), шинээр эхлэх бүх хөтөлбөрт БМИҮЗ-өөр урьдчилсан магадлан итгэмжлэл хийлгэх (Боловсролын тухай хуулийн 21.6 дахь заалт) хуулийн заалт МБС-ын хүрээнд хэрэгжээгүй байна.

<b>Мэргэжлийн хяналт</b>	Хууль тогтоомж, стандарт шаардлагын хэрэгжилтийг шалгах	Мэргэжлийн хяналтын байцаагч	Мэргэжлийн хяналтын байгууллагын төлөвлөсөн хуваарь, иргэд байгууллагын гомдлын мөрөөр	Мэргэжлийн хяналтын хуваарьт орсон сургууль заавал БХ: 24.1.1; МБСХ: 26.1)	Зөрчилтэй бол санхүүжилтийг хасах, тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл захиргааны хариуцлага
<b>Магадлан итгэмжлэл</b>	Чанарыг ахицыг дэмжих, албан ёсоор хүлээн зөвшөөрөх	БМИҮЗ: өөрийн үнэлгээний тайлан мэргэжлийн шинжээчдийн үнэлгээ	5 жил тутам	Сургууль заавал, хөтөлбөр сайн дураар; БХ: 26.1; 26.5; 26.6; 21.6)	Чанарыг сайжруулах зөвлөмж, магадлан итгэмжлэгдсэн статус
<b>Аудит үнэлгээ</b>	Санхүүгийн сахилгыг сахиулах	Үндэсний аудит: Аудитор, бүртгэлтэй аудитын компаний	Жил бүр, Үндэсний аудитын тогтоосон хуваарь, эсвэл яамны захиалгаар	Заавал. Аудитын тухай хууль: 9.1, 10.3, 11.1; Төсвийн тухай хууль: 8.9.8)	Зөрчилтэй бол захиргааны хариуцлага
<b>Мэргэжлийн гэрчилгээ, диплом</b>	Суралцагчийн эзэмшсэн чадамж, ур чадварыг шалгах	Агентлаг, МБСҮТ-ийн комисс	Хөтөлбөрийн төгсгөлд	Заавал БХ: 171.1; МБСХ: 8.4.9; 8.4.11; 8.4.20; 16.1; 16.4; 16.9; 16.9; 18.6; 18.7; 20.2.6)	Мэргэжлийн ажиллагаа Мэргэжлийн үйлэрлэх зөвшөөрөл

Өнөөдөр МБС-ын хүрээнд чанарыг баталгаажуулах тогтолцоог бүрдүүлж буй хэрэгсэл механизмудыг тус бүрд нь авч үзье.

#### а) Сургалт эхлүүлэх эрх олгох шатанд чанарыг баталгаажуулах хэрэгсэл

МБС-ын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл олгох нь чанарын стандарт шаардлага, түүнийг хэрэгжүүлэх нөхцлийг хангуулах зорилготой. Чанарын стандарт шаардлага нь МБС-ын үндсэн зорилго буюу холбогдох хөтөлбөрөөр суралцаж төгсгөсөн хүмүүсийн эзэмшсэн байвал зохих мэдлэг, ур чадвар, төлөвшил, чадамжийн түвшин буюу мэргэшил болно. Энэ стандартыг жишиг болгон мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэшлийн шатлалыг МБСҮЗ 2011 онд баталсан<sup>37</sup> нь үндэсний хэмжээнд баримтлах мэргэшлийн тогтолцооны анхны албажсан хувилбар болжээ. МБС-ын 6 шатлалыг тодорхойлсон энэ загварыг Үндэсний ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолттой нийцүүлэн МБС-ын хөтөлбөрийг боловсруулахад суурь болгон мөрдөхийг хөтөлбөрийг үнэлж дүгнэдэг талуудад даалгасан байна.

#### Хүснэгт 8: Мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэшлийн түвшний загвар

Шатлал	Тодорхойлолт
VI	<p>Ажлын талбарт хийгдэх мэргэжлийн үйл ажиллагааг нарийвчлан төлөвлөн технологийн дагуу ажил гүйцэтгэх дарааллыг тогтоож, нөөцийг үр дүнтэй тооцоолох, хуваарилах, байршуулах, бүтээлчээр зохион байгуулах, мэргэжлийн өндөр түвшинд удирдлагаар хангах, асуудалтай болон тодорхой бүс нөхцөл байдал (төвөгтэй, судлагдаагүй) бий болсон тохиолдолд шинжлэх ухааны үндэстэй таамаг дүгнэлт дэвшүүлэх, шийдвэрлэх арга замыг тодорхойлох техник технологийн мэдлэг, ур чадвар, зөв арга барил хандлагыг эзэмшсэн байна.</p> <p>Энэ түвшинг зохион байгуулалттай техник, технологийн боловсролын сургалтаар эзэмшүүлнэ.</p>
V	<p>Технологийн мэдлэг, мэргэжлийн ур чадвар шаардсан үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, бие даан гүйцэтгэх, ажлын зураг, төсөл гаргах, өртөг зардлыг тооцох, асуудалтай нөхцөл байдал бий болсон үед асуудлыг шийдвэрлэхэд оролцох онолын мэдлэг, мэргэжлийн ур чадвар, зөв арга барил, хандлагыг эзэмшсэн байна.</p> <p>Энэ түвшинг зохион байгуулалттай техникийн боловсролын сургалтаар эзэмшүүлнэ.</p>
IV	<p>Мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардсан хүнд ажилбаруудыг бие даан гүйцэтгэх, холбогдох тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг бүрэн ашиглаж ажиллуулах, тодорхой ажилбарын хүрээнд бусдыг удирдан ажиллах, дэмжлэг үзүүлэх, ажлын гүйцэтгэлийг үнэлэх мэргэжлийн мэдлэг, ур чадвар, зөв хандлагыг эзэмшсэн байна.</p> <p>Энэ түвшинг зохион байгуулалттай мэргэжлийн боловсролын сургалтаар эзэмшүүлнэ.</p>
III	<p>Мэргэжлийн мэдлэг, ур чадвар шаардсан ажилбаруудыг бие даан гүйцэтгэх, хүнд ажилбаруудыг гүйцэтгэхэд бусдын удирдлага дор туслах үүргийг хүлээдэг, уг ажлыг гүйцэтгэхэд хэрэглэдэг суурилагдсан төхөөрөмж, багаж хэрэгслийг бүрэн эзэмшиж ашиглах мэдлэг, ур чадвар, хандлага эзэмшсэн байна.</p>

<sup>37</sup> “Мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэшлийн түвшний загвар батлах тухай” МБСҮЗ-ийн 2011 оны 1 дүгээр тогтоол

	Энэ түвшинг зохион байгуулалттай мэргэжлийн боловсролын сургалт болон ажлын талбарт суралцаж эзэмших боломжтой.
II	<p>Мэргэжлийн сүүр мэдлэг, үр чадвар шаардсан хязгаарлагдмал хүрээнд энгийн ажил үүрэг гүйцэтгэх чадвартай, мэргэжлийн үйл ажиллагаа нь зааварлагчийн шууд удирдлага дор тодорхой нөхцөлд хэрэгжих энгийн олон давтамжтай, нэг төрлийн ажил гүйцэтгэх мэргэжлийн үр чадвар эзэмшсэн байна.</p> <p>Энэ түвшинг чадвар эзэмшүүлэх богино хугацааны сургалт, албан бус сургалтын хэлбэрээр болон ажлын талбарт эзэмших боломжтой.</p>
I	<p>Маш тодорхой нөхцөлд зааварлагчийн шууд удирдлага хяналтын дор энгийн, өдөр дутмын олон давтамжтай, хязгаарлагдмал ажилбаруудыг гүйцэтгэх ерөнхий сүүр мэдлэг, үр чадвар эзэмшсэн байна.</p> <p>Энэ түвшинг чадамж эзэмшүүлэх богино хугацааны сургалт, албан бус сургалтын хэлбэрээр болон ажлын талбарт эзэмших боломжтой.</p>

МБСҮЗ-ийн 2011 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор “*энэхүү загвар, ҮАМАТ-ОТ-д нийцүүлж, мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, хөтөлбөрийг боловсруулах ажлыг зохион байгуулах, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажил олгогч, мэргэжлийн холбоодтой хамтран баталгаажуулж мөрдүүлэхийг*” тухайн үед ажиллаж байсан Мэргэжлийн боловсрол, сургалтын газарт хариуцуулж, хэрэгжилтийг хагас жил дутам МБСҮЗ-д танилцуулж байхыг үүрэг болгожээ.

МБСҮЗ-ийн чиг үүрэгт хамаарч байсан МБС-ын стандартын агуулга жишгийг тодорхойлогч – мэргэшлийн түвшний хүрээ, ажил мэргэжлийн лавлахыг батлах<sup>38</sup> эрхийг 2021 оны Хөдөлмөрийн хуулийн 17 дугаар зүйлд “хуулиар зохицуулах”-аар<sup>39</sup> заасан байна:

#### **17 дугаар зүйл. Мэргэшлийн үндэсний хүрээ**

- 17.1. Ажил мэргэжлийн үндэсний ангилал, тодорхойлолт, ажил мэргэжлийн стандартыг батлах, мэргэшлийн түвшнийг тогтоон хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах үйл явц мэргэшлийн үндэсний хүрээнд хамаарна.
- 17.2. Ажил мэргэжлийн стандартыг батлах, боловсрол, сургалтын үр дүн, мэргэшлийн түвшний уялдааг тодорхойлох, үнэлж баталгаажуулах, түвшин хооронд шилжих зохицуулалтыг хуулиар тогтооно.
- 17.3. Мэргэшлийн үндэсний хүрээ бүрдүүлэх, зохицуулах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ажил олгогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллага болон мэргэжлийн холбоодын саналыг үндэслэн Засгийн газар батална.
- 17.4. Хүний мэргэшлийн түвшнийг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах журмыг хөдөлмөрийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.
- 17.5. Ажил олгогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллага болон мэргэжлийн холбоод хамтран ажил мэргэжлийн стандартыг боловсруулна.

<sup>38</sup> Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6.3.8 дахь заалт

<sup>39</sup> Хөдөлмөрийн тухай хуулийн 17 дугаар зүйл

17.6. Ажил мэргэжлийн стандартаар хөдөлмөрийн нөхцөд, ажилтны ажлын дадлага, туршлага, мэдлэг, ур чадвар, чадамж, хандага, мэргэшлийн түвшин, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тогтооно.

17.7. Ажил мэргэжлийн үндэсний ангилал, тодорхойлолтыг ажил олгогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллага болон мэргэжлийн холбоодын саналыг үндэслэн тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

(Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулиас)

Хөдөлмөрийн хуульд “Мэргэшлийн үндэсний хүрээ” хэмээн нэрлэсэн нэр томьёо нь Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд дурдсан “мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоо” (6.3.8), “мэргэшлийн түвшний хүрээ” (6.3.8) гэсэн нэр томьёотой адил төстэй агуулгатай байж болох ч Хөдөлмөрийн хуулийн 17.1 дэх заалт зөвхөн хөдөлмөрийн харилцаатай холбогдох, гэхдээ өргөн хүрээтэй олон төрлийн үйл ажиллагааг хамруулан ойлгохоор томьёолжээ. Энд дурдаж буй гол нэр томьёог нэг мөр ойлгож хэрэглэхээр томьёолж, “мэргэшлийн үндэсний хүрээ”-г бүрдүүлэх, зохицуулах журмыг Засгийн газар батлахаар заасан нь Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн дагуу мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хариуцуулсан “8.4.21. мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоог бүрдүүлэх, үйл ажиллагааг нь зохион байгуулах” үүрэгтэй хэрхэн уялдахыг шинээр боловсруулж буй хууль тогтоомжид тодорхой болгох шаардлагатай болж байна.

МБСҮЗ нь Засгийн газраас баталсан дүрмийнхээ хүрээнд мэргэжлийн нарийвчилсан экспертиз бүхий 6 салбарын зөвлөлийг<sup>40</sup> яамдын дэргэд байгуулж, холбогдох салбарын мэргэшлийн түвшний тогтолцоог бүрдүүлж төлөвшүүлэх, Ажил мэргэжлийн лавлахыг батлах, бүртгэх, мэдээлэх, үнэлгээний мэргэжлийн байгууллагатай хамтран МБСБ-ын үйл ажиллагааны үр дүн, суралцагч, төгсөгч, ажилтны мэргэшлийн ур чадварыг үнэлэх шалгуур үзүүлэлт, МБС-ын стандарт боловсруулахад дэмжлэг тусалцаа үзүүлэх үүргийг хариуцуулжээ. Гэхдээ 2021 оны Хөдөлмөрийн хуульд үндэслэн ажил мэргэжлийн стандарт боловсруулах аргачлалыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын гурван талт үндэсний хороо 2022 оны 2 дугаар сард баталж, Ажил мэргэжлийн стандарт, хүний хөгжлийн хүрээлэн нь олон улсын хандивлагчдын хөрөнгийн дэмжлэгтэйгээр барилга, төмөр зам, хөнгөн үйлдвэр, үйлчилгээний салбарын ажил мэргэжлийн хөтөч шинжээчээр 40 орчим хүнийг сургаж мэргэшүүлсэн байна.

Өнөөдөр Монгол Улсад МБС-ын үйл ажиллагааг эрхлэх хоёр төрлийн байгууллага – МСҮТ, Политехник коллежийг байгуулахад тусгай зөвшөөрөл олгох ажлыг ХНХ-ын сайдын 2018 оны А/104 дүгээр тушаалаар баталсан журмаар<sup>41</sup>, мэргэжлийн сургалт эрхлэх эрх олгох ажлыг ХНХ-ын сайд, БШУ-ны сайд нарын хамтарсан 2021 оны А/97/А/231 дүгээр тушаалаар баталсан журмаар<sup>42</sup> зохицуулж байна. Тусгай зөвшөөрлийг олгохдоо Зөвшөөрлийн тухай болон Боловсролын тухай хуулиудад заасан шаардлага, зохицуулалтыг баримтлан Стандартчиллын үндэсний зөвлөлийн баталсан

<sup>40</sup> МБСҮЗ-ийн 2018 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 6 дугаар тогтоолоор баталсан Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм

<sup>41</sup> “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд тавих шаардлага, загвар батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн А/104 дүгээр тушаал

<sup>42</sup> “Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журам” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын хамтарсан 2021 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн А/97, А/231 дүгээр тушаал

“MNS 6541-2015. Мэргэжлийн боловсрол, сургалт: Ерөнхий шаардлага” хэмээх улсын стандартыг хангасан байх нөхцлийг бүрдүүлсэн эсэхийг үнэлж дүгнэлт гаргасны үндсэн шийдвэрлэдэг. Энэ стандартаар *“хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн шаардлагыг хангахуйц, мэргэшлийн түвшний тогтолцоотой уялдсан уян хатан сургалтыг зохион байгуулах мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга, орчин, багшийн мэргэшил, үнэлгээнд тавих үндсэн [шаардлагыг]”* тодорхойлсон бөгөөд МБС-ыг эрхлэн явуулж буй өмчийн бүх хэлбэрийн байгууллага, нийгмийн түнш, багш, суралцагч, судлаач, мэргэжлийн боловсрол, сургалтын асуудлаарх төрийн удирдлага, аргагүй, хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагууд заавал мөрдөх норматив шаардлага юм.

Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход тавих шаардлага нь сургалт явуулах хөтөлбөрийг үндэсний мэргэшлийн түвшин, холбогдох ажил мэргэжлийн тодорхойлолтод нийцүүлэн боловсруулж, багш, сургалтын орчныг бэлтгэсэн бөгөөд үйл ажиллагаа явуулахад шаардлагатай удирдлагын бүтэц, хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байхыг шаарддаг. Үүний дотор мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрийг чадамжид суурилсан аргачлалд үндэслэн боловсруулах, техникийн боловсролын хөтөлбөрийг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хэсгээс бүрдсэн, багц цагаар зохион байгуулах шаардлагад нийцүүлэн боловсруулж Боловсролын тухай хуулийн 21.2, 21.6 дахь заалтын дагуу БМИҮЗ-өөр урьдчилсан магадлан итгэмжлэл хийлгэх ёстой. Харин одоогоор урьдчилсан магадлан итгэмжлэлийн оронд техникийн болон мэргэжлийн боловсролын хөтөлбөрт Боловсролын ерөнхий газар (БЕГ), мэргэжлийн сургалтын хөтөлбөрт холбогдох БАЗТ (өмнө нь МБСУМАЗТ-ийн харъяанд ажиллаж байсан)-д хянуулан дүгнэлт гаргуулж байхыг шаарддаг байна. Иймд тусгай зөвшөөрөл олгох шатанд хөтөлбөрийн үр дүн буюу чанарын гол хэмжүүрийг тогтоож байна.

Шинээр мэргэжлийн сургууль байгуулахаар санаачилга гаргаж буй үүсгэн байгуулагчид тусгайлан шаардлага тавьж байгаа нь энэ журмын нэг онцлог байна. Тухайлбал, үүсгэн байгуулагч нь МБС-ын стандартын шаардлагыг хангасан мэргэжлийн сургалтын үйл ажиллагааг 3-аас доошгүй жил эрхэлсэн туршлагатай, өөрийн эзэмшлийн өмч болох зориулалтын барилга байгууламж, санхүүгийн чадавхитай, татварын байгууллагад өр төлбөргүй, үл хөдлөх хөрөнгийн барьцаагүй байхыг шаардлага болгожээ. Хэрэв тухайн байгууллага ашгийн төлөө бус бөгөөд энд дурдсан шаардлагыг хангах гишүүд бүхий Удирдах зөвлөл, гүйцэтгэх захиралтай бол МБСБ-ыг нийтийн ашиг тусын тулд байгуулах эрмэлзэлтэй үүсгэн байгуулагчаас өөрөөс нь дээрх шаардлагыг заавал биелүүлэх шаардлага тавих нь төдийлэн зохистой бус байж болох юм. Үүний хамт тусгай зөвшөөрөлд тусгасан нөхцлийг хангаж байгаа эсэхэд үйл ажиллагааных нь явцад системтэй үнэлж дүгнэх хэрэгсэл, тогтолцоо бүрдүүлж байгааг анхааран үзвэл зохино.

Тусгай зөвшөөрөл олгох процессыг шинээр сургууль байгуулах нөхцлийг хангасан байдлыг үнэлэхээс гадна нэгэнт байгуулагдсан мэргэжлийн боловсролын сургуулийн ангиллыг өөрчлөхөд мөн хэрэглэж байна. Учир нь МСҮТ, Политехник коллеж нь үйл ажиллагааны чиглэлээр ялгагдах хэв шинжийн ялгааг илэрхийлсэн ангилал бус, харин түвшний ялгаатай зэрэглэл гэсэн утгаар хэрэглэж байгаа ажээ. Тухайлбал, Политехник коллеж байгуулах тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл (загвар 15)-ийг “ангилал өөрчлөн тогтоох” гэсэн давхар гарчигтай бичсэн нь уг өргөдөлд хавсаргах баримт бичгийн жагсаалтын хамт зөвхөн МСҮТ л “Политехник коллеж” болж ангиллаа “дээшлүүлэх”



боломжтойг илэрхийлж байна. Тодруулбал, өргөдөл гаргаж буй үүсгэн байгуулагч (МСҮТ) нь МБС-ын үйл ажиллагааг 5-аас доошгүй жил эрхэлж, төгсөгчдийн ажил эрхлэлт 80 хувиас дээш болсон байх, дотоодын болон гадаадын магадлан итгэмжлэл хийлгэсэн, 2-оос багагүй техникийн боловсролын сургалтын хөтөлбөрөө магадлан итгэмжлүүлсэн байх шаардлага тавьжээ. Иймд Политехник коллежийг анхнаас нь байгуулах санаачилга дэмжигдэх боломжгүй болсон байна. Үүний нэгэн адил шинэ мэргэжлээр сургалт явуулах өргөдөл (загвар 13)-д БМИҮЗ-ийн 2016 оны 1 дүгээр тогтоолоор баталсан “МБС-ын байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага”-ын дагуу өөрийн үнэлгээний тайлан, магадлан итгэмжлэлийн гэрчилгээний хуулбарыг хавсаргахыг шаардсан нь өөр бусад хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлаас хамааралтай нөхцөл болжээ.

Мэргэжлийн сургалт эрхлэх байгууллагыг өмнө нь орон нутгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний албад бүртгэж, үйл ажиллагаа явуулах эрхийг нь нээж байсан бол 2021 оноос Хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон Боловсрол, шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан тушаалаар баталсан **“Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журам”**-ын дагуу зохион байгуулж байна. Журамд мэргэжлийн сургалтыг *“үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд шаардагдах нэгж буюу бүлэг ажилбарыг гүйцэтгэх арга барил, техник технологийн анхан шатны мэдлэг, чадвар, дадлыг тодорхой ажил мэргэжлийн суурь чадвар, чадамжийн хүрээнд эзэмшүүлэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, дадлагажуулахад чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох богино хугацааны мэргэжлийн сургалт”* гэж тодорхойлон энэ журмаар тодорхой түвшний ур чадвар эзэмшүүлэх, хөдөлмөрийн болон бизнес эрхлэх үндсэн мэдлэг, чадвар олгох сургалт эрхлэх байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулна гэжээ. Энэ журамд:

*“мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх сургалтын төрөлд мэргэжлийн болон техник технологийн суурь чадамж эзэмшүүлэх сургалтууд хамаарна.”*

*“хөдөлмөрийн болон бизнес эрхлэх үндсэн мэдлэг, чадвар эзэмшүүлэх сургалтад хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох, аж ахуй, бизнес эрхлэх чадамж олгоход чиглэсэн сургалтууд хамаарна”*

хэмээн зааж, сургалтын хөтөлбөр, сургалтын орчин, багшлах бүрэлдэхүүнд тавих шаардлагыг мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг үүсгэн байгуулахад тавьж буй шаардлагатай үндсэндээ адилаар тогтоосон нь тусгай зөвшөөрлийн шаардлагатай ижил агуулгатай болсон байна. Бүртгэлийн гэрчилгээг эхний удаад нэг жилээр, дараа нь үйл ажиллагааны үнэлгээнд үндэслэн хоёр хүртэл жилээр сунгаж байхаар журамлажээ.

ХНХСҮСИ нь мэргэжлийн сургалтын суралцагчдын мэдээллийн нэгдсэн санг хөтөлж, мэдээллийг түгээж байх үүрэгтэй. Мэргэжлийн сургалт эрхлэх байгууллагын бүртгэлд тавих шаардлагыг чангатгаж, сургалтын хөтөлбөр нь харгалзах чадамжийн стандартад нийцсэн эсэхэд холбогдох салбарын мэргэжлийн зөвлөл, холбоо дүгнэлт гаргаж байхаар журамласан байна. Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх шинэчилсэн журмын дагуу бүртгүүлсэн байгууллага Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилт авах эрхтэй юм.

МБС-ыг чанарыг баталгаажуулахад эхний шатнаас нь мэргэжил аргагүйн зөвлөгөө өгч голлох үүрэг гүйцэтгэдэг ихээхэн оролцоотой байгууллага бол БАЗТ байна. 2008-2012 онд бүсийн арга зүйн 6 төвийг АНУ-ын МСС-ийн төслийн дэмжлэгтэйгээр байгуулжээ.<sup>43</sup>

**Хүснэгт 9: БАЗТ-үүдийн харъяалалд байгаа МБСБ-ын тоо, 2016 он**

БАЗТ-ийн харъяалах бүс	Мэргэжлийн боловсролын сургууль, Политехник коллеж	Мэргэжлийн түр сургалтын байгууллага
Баруун бүс	9	40
Хангайн бүс	11	36
Говийн бүс	8	12
Зүүн бүс	4	3
Төвийн бүс	11	43
Улаанбаатар	46	400
<b>Нийт</b>	<b>89</b>	<b>534</b>

Эх сурвалж: Матиас Фон Аселдонк, 2016

БАЗТ-үүд нь “МБС-ын агуулгын хэрэгжилтийг хангах, чадамжийн сан бүрдүүлэх, багшийг чадваржуулах, хөгжүүлэх, сургалт, судалгаа эрхлэх чиг үүрэгтэй”<sup>44</sup> бөгөөд сургалтын хөтөлбөрийг эхлүүлэхийн өмнө хянаж мэргэжлийн дүгнэлт гаргах, багш бус мэргэжлийн багш нарт багшлах эрх олгох сургалт зохион байгуулах, чадамжид суурилсан хөтөлбөр боловсруулах ажлыг аргагүйн удирдлагаар хангаж, мэргэжлийн стандарт, агуулгыг боловсруулахад хувьд ажил олгогчидтой холбох зэрэг үүргийг ХНХЯ-наас гаргасан дүрэм журмын дагуу гүйцэтгэж байна. Харин энэхүү өргөн хүрээтэй үүрэг гүйцэтгэж буй төвүүдийн статус бүрэн тодорхойгүй, удирдлага (менежер)-ыг нь сайд томилж, ажилтнуудыг нь уг төвийг байрлуулж буй сургалтын байгууллагын захирал томилдог, ажилтнуудын цалингаас бусад санхүүжилтгүй, банкны бие даасан данс, хуулийн этгээдийн бүртгэлгүй, байрлуулж буй байгууллагаас хараат байгааг ТМБССД-1 төслийн хүрээнд 2016 онд ажилласан олон улсын зөвлөх нарийвчлан шинжилж бодлогын зөвлөмжүүд өгсөн<sup>45</sup> боловч байдал төдийлэн өөрчлөгдөөгүй хэвээр байна.

Олон улсын хэмжээнд бүх шатны боловсрол, сургалтын үр дүнг тодорхойлоход нийтлэг шинжтэй хэрэглэж буй шинэ чиг хандлагыг тусган Монгол Улсын ҮМТШС-г боловсруулах үйл явц өнөөдөр үргэлжилж байна. Энэ талаар ЕХ-ны ТМБССД-1 төслийн зөвлөхүүд ихээхэн идэвхитэй ажиллаж, өмнө батлагдсан МБС-ын 6 түвшний загварыг нийт боловсролын хүрээг хамарсан 10 түвшинтэй үндэсний мэргэшлийн хүрээ (шатлалын тогтолцоо) болгон баталгаажуулах зөвшилцөлд хүрчээ. Үүнийг албажуулж мөрдүүлэх шаардлагатай бөгөөд энэхүү үндэсний мэргэшлийн хүрээ нь нийт хүн амын эзэмшсэн боловсрол, мэргэшлийг бүрэн хамрах ёстой гэсэн нэгдсэн байр суурьт боловсролын болон МБС-ын асуудал эрхэлсэн яамд, ажил олгогчдын төлөөлөл хүрч чадсан нь чухал үр дүн юм.

<sup>43</sup> Матиас Фон Аселдонк (2016). *Бүсийн арга зүйн төвийн байгууллагын чадавхийн үнэлгээний тайлан*, Үйл ажиллагаа 4.1.2

<sup>44</sup> Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8.5 дахь заалт

<sup>45</sup> Матиас Фон Аселдонк (2016). *Бүсийн арга зүйн төвийн байгууллагын чадавхийн үнэлгээний тайлан*, Үйл ажиллагаа 4.1.2

**Зураг 6: Мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц (төсөл)**

МЭРГЭШЛИЙН ҮНДЭСНИЙ ШАТАЛСАН БҮТЭЦ								
Түвшин	Түвшин тодорхойлогч	СОБ	Боловсролын түвшин, шатлал (ISCED 2011)					
			Ерөнхий боловсрол	Мэргэжлийн боловсрол, сургалт	Дээд боловсрол			
					Диплом	Бакалавр	Магистр	Доктор
10	Төвөгтэй, урьдчилан таамаглах боломжгүй нөхцөлд ажиллахад шаардлагатай мэдлэг, бүтээгч байдал, манлайтлын ур чадвар шаардсан мэргэшлүүд.						Докторын	
9	Маш өндөр түвшний удирдлагын чиг үүрэг бүхий, нарийн мэргэшсэн мэдлэгт суурилсан мэргэжлийн (мэргэшсэн бусад ажилтны ажил үүргийн гүйцэтгэлийг бүрэн хариуцах) мэргэшлүүд.					Магистрын	Мэргэжлийн мэргэшил	
8	Удирдлагын чиг үүрэг бүхий, мэдлэгт суурилсан мэргэжлийн (хамт олны ажлын хүрээх үр дүнд тодорхойлох, үр дүнд хүрэх ажлыг удирдах) мэргэшлүүд.				Бакалаврын			
7	Удирдлагын хязгаарлагдмал чиг үүрэг бүхий, өндөр түвшний мэдлэг, чадвар (бусад ажилтны ажлыг удирдан, зохицуулах) шаардсан мэргэшлүүд.		Мэргэжлийн түвшин V-VI	Дипломын дээд боловсрол				
6	Нарийн ур чадвар (өөрийн ажил үүрэгтэй холбоотой гаргасан шийдвэрийнхээ хариуцлагыг хүлээх, өөрийн үйл ажиллагааг чиглүүлэх) шаардсан мэргэшлүүд.		Мэргэжлийн түвшин III-IV					
5	Ур чадвар/хагас ур чадвар шаардсан (сургалтад хамрагдаж бусад байхгүй ур чадварыг эзэмшсэн, тухайлбал хариуцсан ажлын чанарын талаар үүрэг хүлээх гэх мэт) мэргэшлүүд.		Мэргэжлийн түвшин I-II					
4	Ажил хийх мэдлэг, ур чадвар (зааварчилгааг дагах, завсан хуштаанд ажлыг хийж дуусгах, удирдлагын шаталсан бүтэц ажиллах)-уудыг эзэмшсэн байх.		Бүрэн дунд боловсрол					
3	Ажилд ороход шаардагдах мэдлэг, чадвар (онгогдсон ажил, үүргийн гүйцэтгэх боломжиг арга замуудын талаар зохих хэмжээний ойлголттой, шүүмжиг байр сууринаас ханддаг байх)-эээмшсэн байх.		Суурь боловсрол					
2	Нийгмийн амьдралд оролцоход шаардлагатай амьдрах чадвар (харилцаа холбоо, мэдээллийн технологи, багаар ажиллах, асуудал шийдвэрлэх гэх мэт)-уудыг эзэмшсэн байх.	СОБ	Бага боловсрол					
1	Өдөр тутмын амьдралд оролцох наад захын мэдлэг, чадвар (унших, бичих, тоолох, нийгмийн харилцааны суурь мэдлэг, чадварууд ...)-уудыг эзэмшсэн байх.	СОБ	Тухайн нийгэмд амьдрахтай холбоотой суурь чадваруудыг алдсрайтгах, Тухайлбал нийгмийн үйлчилгээнд хамрагдах, худалдаа хийх, мэдээлэл авах гэх мэт суурь чадварууд					

Эх сурвалж: Боловсролын хуулийн шинэчилсэн найруулгын төслийг танилцуулсан БШУЯ-ны танилцуулга, 2021 он.

Одоо үйлчилж буй хууль тогтоомжийн хүрээнд боловсролын улсын стандарт нь сургалтын хөтөлбөрийг боловсруулахад заавал баримтлан мөрдөх албан ёсны шаардлагыг илэрхийлдэг<sup>46</sup>. Эдгээр стандартыг МБС-ын хөтөлбөрт нарийвчилж тодорхойлоход хөтөлбөрийн (техникийн боловсрол, мэргэжлийн боловсрол, мэргэжлийн сургалт) болон сургалтын байгууллага (МСҮТ, ПК, мэргэжлийн сургалтын төв, тэдгээрийн хослол, коосен зэрэг шинэ төрөл хэлбэрийн МБСБ)-ын онцлог ялгааг тооцож, багш сургагчдын бүтээлч санаачилга, бие даасан байдал, өөрчлөгдөн хувьсч байгаа хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд шурхай хариу үйлчлэл үзүүлэх уян хатан чанартай, хөтөлбөрийн үр дүнгийн төлөө сургалтын байгууллагын хариуцах хариуцлагыг сулруулахгүйгээр шийдэх шаардлага бий. Өнөөдөр МБС-ын түвшинд Стандартчиллын үндэсний зөвлөлийн баталсан “MNS 6541-2015. Мэргэжлийн боловсрол сургалт: Ерөнхий шаардлага” улсын стандартад үндэслэн ХНХ-ын сайд баталж, туршилтын журмаар ашиглахыг зөвлөмж болгосон 15 мэргэжлийн сургалтын стандарт байна. МБСҮТ-ийн мэдээгээр 2019 оны эхэнд батлагдсан ажил мэргэжлийн лавлахын тоо 20 байсан бөгөөд ГХАН-ийн төслийн шугамаар 5, АХБ-ны санхүүжилттэй “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн шугамаар 15, ЕХ-ны санхүүжилттэй ТМБССД-1 төслийн шугамаар МАОЭНХ 7 ажил мэргэжлийн тодорхойлолтыг боловсруулж байсан нь нийт сургалт явуулж буй 550 мэргэжлийн 8.5 хувьтай тэнцэж байв. МБС-ын стандарт дутуу, чадамжид суурилсан сургалтын чадамжийн сан бүрдээгүйгээс нэг ижил түвшний боловсрол, мэргэжлийн баримт бичиг олгож буй сургууль, сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөр ялгаатай байгааг ажил олгогчид, мэргэжлийн холбоод, МБС-ын төлөөлөгчид онцлон тэмдэглэж байв. Энэ нь юуны өмнө төрийн өмчийн болон хувийн МСҮТ, Политехник коллеж, бүртгэлд хамрагдсан сургалтын төвийн эрхэлж буй мэргэжлийн сургалтын эцсийн үр дүн,

<sup>46</sup> Боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйл, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 10 дугаар зүйл

чанарын шалгуурын нийтлэг жишгийг тодорхойлох бенчмаркийг тогтооход ихээхэн хүчин чармайлт гаргах шаардлагатайг харуулж байна.

МБС-ын чанарын хэмжүүрийн үндсэн суурь референс болох ҮМТШС (“мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц”)-ийг албан ёсоор баталгаажуулах, суралцахуйн үр дүнг мэргэжлээр тодорхойлоход хэрэглэж буй ажил мэргэжлийн үндэсний ангилал, тодорхойлолт, лавлах, ажил мэргэжлийн стандарт, мэргэжлийн боловсрол сургалтын стандарт, хүний мэргэшлийн түвшин зэрэг хуульд заасан баримт бичгийг боловсруулах, батламжлах зохицуулалтыг бүрдүүлж, үүнийг МБС-ын үйл ажиллагаанд хэрэгжүүлэхэд боловсрол сургалтын байгууллагууд, ажил олгогч, мэргэжлийн холбоодын оролцоо, хариуцах үүргийг тодотгох хэрэгтэй юм. Ийнхүү хариуцах субъект, тэдгээрийн харилцааг тодотгон аливаа үр ашиггүй давхардлыг арилган, чиг үүргээ мэргэжлийн түвшинд тогтвортой, үр дүнтэй эрхлэн гүйцэтгэх эрхзүйн орчин, чадавхи нэн шаардлагатай байна.

МБС-ын үйл ажиллагаа эхлүүлэх шатанд чанарыг баталгаажуулахад сургалтын тусгай зөвшөөрөл олгох шалгуур, процедур тогтож хэвшсэн, чанарын стандартыг боловсруулах, батламжлахад ажил олгогчид, мэргэжлийн холбоодын оролцоо нэмэгдэж байна. Цаашид энэ талаар мэргэжлийн эрх ашгийн үүднээс тогтвортой хариуцлагатай оролцогч болох боломжтой мэргэжлийн холбоодыг чадавхитай институт болгон бэхжүүлэх, үйл ажиллагааны зардлын санхүүжилт, шийдвэр гаргах эрх хэмжээг оновчтой болгох нь чухал ач холбогдолтой болно. Түүнчлэн боловсролын хөтөлбөрийг шинээр эхлүүлэхэд урьдчилсан магадлан итгэмжлэл хийж байх хуулийн заалтыг МБС-ын хөтөлбөрийн хувьд хэрхэн хэрэгжүүлэхийг тодорхой болгох шаардлага байна.

#### **б) Мэргэжлийн боловсрол, сургалтын явцад чанарыг баталгаажуулах хэрэгсэл**

МБС-ын үйл ажиллагааг эрхлэн хэрэгжүүлэх шатанд чанарын баталгаажууллын хэд хэдэн хэрэгсэл үйлчилж байгааг *Хүснэгт 9-өөс* харж болно. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд заасанчлан УИХ, Засгийн газар, МБСҮЗ болон эрх бүхий бусад байгууллага МБС-ын үйл ажиллагааны үр дүнг хянан хэлэлцэх<sup>47</sup> бүрэн эрхтэй ч чанарын баталгаажууллын тодорхой механизмыг хэрэгжүүлэх нь асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, БМИҮЗ, мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүрэгт хамаарч байна. Төрийн захиргааны байгууллага нь МБСБ, багшийг аттестатчилах,<sup>48</sup> үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ хийх,<sup>49</sup> төрийн өмчийн сургалтын байгууллагын удирдлагатай үр дүнгийн гэрээ байгуулж, дүгнэх<sup>55</sup> зэргээр энэ үүргээ хэрэгжүүлдэг. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангаж байгаа байдалд зөвшөөрөл олгосон этгээд хяналт шинжилгээ хийж байхаар холбогдох хуульд тусгасаны зэрэгцээ хууль тогтоомжийн хэрэгжилтийг мэргэжлийн хяналтын байгууллага<sup>50</sup> хянан шалгаж байна. МБС-ын байгууллагын болон сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг БМИҮЗ-өөс баталсан шалгуур, журмын дагуу хэрэгжүүлдэг. Өнөөдөр санхүүгийн сахилга сахиулж, төсвийн эх үүсвэртэй

---

<sup>47</sup> Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6.3.3, 6.3.4, 6.3.7 дахь заалт, 7 дугаар зүйл

<sup>48</sup> Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8.4.9 дэх заалт

<sup>49</sup> Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8.4.8 дахь заалт, Боловсролын тухай хуулийн 37 дугаар зүйл <sup>55</sup> Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйл

<sup>50</sup> Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 26.1 дэх заалт

санхүүжилтийн зарцуулалтад баримтын шалгалтын шинжтэй хийгдэж байгаа аудитын үнэлгээ нь<sup>51</sup> хуульд заасан гүйцэтгэлийн аудит гэсэн утгаараа хөрөнгө, санхүүгийн хүрэлцээ, зарцуулалт тухайн байгууллагын үйл ажиллагааны чанарт хэрхэн нөлөөлж байгааг үнэлж дүгнэдэг байвал зохилтой. Мөн хэдийгээр одоогоор МБС-ын хүрээнд хэрэглэхгүй байгаа боловч Боловсролын үнэлгээний байгууллага нь бүх шатны боловсролын чанарт үнэлгээ, судалгаа хийх<sup>58</sup> чиг үүрэгтэй байгааг МБСБ-ын асуудал БШУЯ-нд шилжин эрсэнтэй холбогдуулан нягталж зохицуулах шаардлагатай болжээ.

МСҮТ, Политехник коллежид удирдах дээд байгууллага болон бусад эрх бүхий байгууллагаас үнэлгээ шалгалт хийсэн байдлыг 2019 онд төрийн өмчийн 35, хувийн хэвшлийн 15 МБСБ-ыг хамруулан судалсан дүнгээс (Хүснэгт 12) үзэхэд санхүүгийн аудит, мэргэжлийн хяналт, яам агентлагийн үзлэг шалгалт илүү ихээр хийгдсэн байна. Судалгаанд 2016-2019 оныг хамарсан бөгөөд энэ хугацаанд мэргэжлийн хяналт, аудит, яамны үзлэг шалгалтын 79-96 хувь нь хийгдсэн бөгөөд эдгээр шалгалт хийгдсэн хугацаанд төрийн өмчийн МБСБ-ын удирдлагад ихээхэн хөдөлгөөн гарсаныг тэмдэглэж байна.

**Хүснэгт 10: МБСБ-д үнэлгээ, шалгалт хийгдсэн давтамж, 2019 он**

	0	1 удаа	2 удаа	3 удаа	4 удаа	5 удаа	Хамрагд сан тоо	Хамрагд сан сур тоо
<b>Аудит</b>								
Төрийн өмчит - 35	1	6	18	8	2		74	34
Хувийн өмчит - 15	5	2	6	2			20	10
Нийт - 50	6	8	24	10	2		94	44
<b>Мэргэжлийн хяналт</b>								
Төрийн өмчит - 35	5	7	15	4	2	2	67	30
Хувийн өмчит - 15	3	2	8	2			24	12
Нийт - 50	8	9	23	6	2	2	91	42
<b>Яам/агентлагийн үзлэг шалгалт</b>								
Төрийн өмчит - 35	11	12	11	1			37	24
Хувийн өмчит - 15	3	2	9	1			23	12
Нийт - 50	14	14	20	2			60	36
<b>Сургуулийн Удирдах зөвлөлийн үзлэг шалгалт</b>								
Төрийн өмчит - 35	21	6	7	1			23	14
Хувийн өмчит - 15	3	4	6	1		1	24	12
Нийт - 50	24	10	13	2		1	47	26
<b>Аттестатчилал</b>								
Төрийн өмчит - 35	16	14	4		1		26	19
Хувийн өмчит - 15	11	3	1				5	4
Нийт - 50	27	17	5		1		31	23

Эх сурвалж: Судалгааны баг, 2019

<sup>51</sup> Аудитын тухай хуулийн 9.1, 10.3, 11.1; Төсвийн тухай хуулийн 8.9.8 дахь заалт

<sup>58</sup> Боловсролын тухай хуулийн 17<sup>1.1</sup> дэх заалт

Төрийн өмчийн 35 сургуулийн 34 (97%) нь аудитад, 30 (86%) нь мэргэжлийн хяналтын шалгалтанд тус бүр дунджаар 2.2 удаа орсон бол хувийн өмчийн 15 сургуулийн 10 (67%) нь аудит, 12 (80%) нь мэргэжлийн хяналтын шалгалтанд тус бүр 2 удаа хамрагдсан гэжээ. Яам, агентлагийн үзлэг шалгалтанд төрийн өмчийн сургуулиудын 69% нь дунджаар 1.5 удаа, хувийн сургуулиудын 80% нь 1.9 удаа хамрагдсан мэдээ байна. Судалгаанд хамрагдсан төрийн өмчийн сургуулиудын 54%, хувийн өмчийн сургуулийн 27% аттестатчилалд хамрагдсан гэжээ.

Энэ хугацаанд сургуулийн Удирдах зөвлөлийн үзлэг шалгалт ч өмнөх онуудаас эрс нэмэгдэж, нийт үзлэг шалгалтын 89 хувь нь 2016-2018 онд хийгджээ. Сургуулийн Удирдах зөвлөлөөс хийсэн үзлэг шалгалт хувийн сургуулиудад илүү олон буюу 80% нь дунджаар 2 удаа үзлэг шалгалт хийжээ. Төрийн өмчийн сургуулийн Удирдах зөвлөлөөс 14 сургууль (40%)-д дунджаар 1.6 удаа үзлэг шалгалт хийсэн байна. Үүнийг судалгаанд хариу ирүүлсэн ажилтнуудын 63 хувь нь үр дүнтэй ажил болсон гэж үнэлсэн байна.

Магадлан итгэмжлэл хийлгэх нь одоогоор сайн дурын үндсэн дээр явагдаж байгаа бөгөөд БМИҮЗ-ийн мэдээнд өнөөдөр МБС-ын 32 сургууль магадлан итгэмжлэгдсэн, 6 сургуулийн 13 хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэн байна.

### **Хүснэгт 11. Магадлан итгэмжлэгдсэн МБС-ын сургуулиуд, 2022**

<i>№</i>	<i>Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын нэрс</i>	<i>Магадлан итгэмжлэл хүчинтэй хугацаа</i>
<b>төрийн өмчийн МБСБ</b>		
1	Үйлдвэрлэл урлалын политехник коллеж	2021.06.23
2	Монгол-Солонгосын политехник коллеж	2021.12.22
3	Баянхонгор аймаг дахь политехник коллеж	2024.06.01
4	Завхан аймаг дахь политехник коллеж	2024.06.10
5	Дархан-Уул аймаг дахь Уул уурхай-Эрчим хүчний политехник коллеж	2024.06.10
6	Сэлэнгэ аймгийн Зүүн хараа сум дахь политехник коллеж	2024.06.01
7	Хэнтий аймаг дахь политехник коллеж	2024.06.10
8	Өвөрхангай аймаг дахь политехник коллеж	2024.05.14
9	Дархан-Уул аймаг дахь политехник коллеж	2024.06.19
10	Төв аймгийн Баянчандмань сум дахь политехник коллеж	2024.05.14
11	Ховд аймаг дахь Хөгжил политехник коллеж	2025.05.29
12	Барилгын политехник коллеж	2025.05.29
13	Сүхбаатар аймаг дахь МСҮТ	2024.06.19
14	Хөвсгөл аймаг дахь МСҮТ	2025.05.29
15	Архангай аймаг дахь МСҮТ	2025.05.29
16	Налайх дахь МСҮТ	2025.06.30
17	Орхон аймаг дахь МСҮТ	2025.06.30
18	Төв аймаг дахь МСҮТ	2025.06.30
19	Сэлэнгэ аймаг дахь МСҮТ	2026.06.30
20	Дорнод аймаг дахь МСҮТ	2026.01.20
21	Дорноговь аймаг дахь МСҮТ	2026.01.20



22	Төв аймгийн Эрдэнэ сум дахь МСҮТ	2026.07.08
23	Герман Монголын МСҮТ	2026.07.08
24	Төмөр замын политехник коллеж	2026.07.08
25	Говь-Алтай аймаг дахь МСҮТ	2026.12.28
26	Дундговь аймаг дахь МСҮТ	2026.12.28
<b>төрийн бус өмчийн МБСБ</b>		
27	Хүнс, технологийн политехник коллеж	2024.05.14
28	Техник технологийн политехник коллеж	2024.06.18
29	Гурвантамир МСҮТ	2025.06.30
30	Хангай МСҮТ	2022
31	Шинэ иргэншил МСҮТ	2024.02.28
32	Их засаг МСҮТ	2024.06.10

Эх сурвалж: БМИҮЗ, 2022

Мэдээнээс үзэхэд байгууллагын магадлан итгэмжлэл хийлгэх сонирхол төрийн өмчийн болон хувийн сургуулиудад харьцангуй ижил байна.

### **Хүснэгт 12. Магадлан итгэмжлэгдсэн МБС-ын хөтөлбөр, 2022**

№	Сургуулийн нэр	Хөтөлбөрийн нэр	Магадлан итгэмжлэлийн хугацаа
1	Хэнтий аймаг дахь	IM7212-14: Гагнуурчин	2022.06.28
2	Политехник коллеж	IE7533-28: Оёмол бүтээгдэхүүний оёдолчин	2022.06.28
3	Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл урлалын Политехник коллеж	IE7533-28: Оёмол бүтээгдэхүүний оёдолчин	2026.06.28
4		SO5141-11: Үсчин	2026.06.28
5		SO5141-14: Үс заслын технологич	2026.06.28
6		SO5142-11: Гоо засалч	2026.06.28
7		SO5142-21: Гоо заслын технологич	2024.06.25
8		IM3119-23: Мехатроник	2024.06.25
9	Монгол-Солонгосын политехник коллеж	ТС 8211-20: Автомашины засварчин	2026.06.28
10		IE7533-28: Оёмол бүтээгдэхүүний оёдолчин	2026.06.28
11	Өвөрхангай аймаг дахь политехник коллеж	IF 5120-11: Тогооч	2026.06.28
12		IE7533-28: Оёмол бүтээгдэхүүний оёдолчин	2022.06.28
13	Архангай аймаг дахь Гурвантамир МСҮТ	АН 3240-17: Малын бага эмч	2026.06.28

Бусад хэлбэрийн үзлэг шалгалтанд орсон тухай мэдээнд БАЗТ-ийн зөвлөн туслах үзлэг, МБСҮЗ-ийн салбарын зөвлөл болон аймгийн удирдлагаас хийсэн үзлэг шалгалтыг нэрлэжээ. Эдгээр үзлэг шалгалт сургуулийн үйл ажиллагаанд тустай, үр дүнтэй болсон хэмээн эдгээр хамрагдсан сургуулийн 53-65 хувь нь үнэлжээ.



Дээрх судалгааны мэдээг нэгтгэн үзвэл төрийн өмчийн сургуулиуд 3 жилд дунджаар 7.5 удаа, хувийн сургуулиуд 7 удаа хөндлөнгийн шинжтэй үзлэг шалгалтанд хамрагдсан дүр зураг харагдаж байна. Эдгээр үзлэг шалгалтын дийлэнх нь яам, төрийн байгууллагын санаачилга, шийдвэрийн дагуу хийгддэг аудит, мэргэжлийн хяналт, яам, агентлагийн үзлэг шалгалт бөгөөд засгийн газар солигдсоны дараа нэлээд нэмэгддэг байдалтай байна. Сургуулийн Удирдах зөвлөлийн 51-60 хувийг үүсгэн байгуулагчийн төлөөлөл, төрийн өмчийн сургуулийн хувьд асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн сайдын томилсон ажилтнууд бүрдүүлдэг. Үзлэг шалгалт нь сургуулийн үйл ажиллагаанд тустай, үр дүнтэй болсон гэж үнэлэх нь давамгайлсан мэдээ ирүүлсэн боловч энэ мэдээг тухайн үед ажиллаж байсан хүмүүс өгсөнийг тооцох шаардлагатай.

Ийнхүү МБС-ын үйл ажиллагааг эрхэлж буй МСҮТ, Политехник коллежийн хэмжээнд аттестатчилал, мэргэжлийн хяналт, аудитын шалгалт болон яамны үзлэг шалгалт нэлээд давтамжтай хийгдэж буйн зэрэгцээ сайн дурын үндсэн дээр магадлан итгэмжлэл хийлгэх хандлага төрийн өмчийн болон хувийн сургуулиудад харьцангуй ижил байна. Үүний нэгэн шалтгаан нь улсын төсвөөс суралцагчдын тоогоор хувьсах зардал, суралцагчдад тэтгэлэг олгох нөхцлийг магадлан итгэмжлэгдсэн байх шаардлагатай холбосон зохицуулалт байж болох юм.

**Аттестатчилал:** МБСБ-ыг аттестатчилах үйл ажиллагаа 2002 онд батлагдсан Боловсролын тухай хуулиар Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд тусгаснаар эхэлжээ. Хуулийн энэ заалтын дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2003 оны 450 дугаар тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийг аттестатчилах журам”-ыг мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааг үнэлэх тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийн хамтаар баталжээ. Журамд төрийн болон төрийн бус өмчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн сургалт, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагаа, түүний чанар, үр дүнгийн талаар төрөөс баталсан стандартыг хэрхэн хангаж байгааг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 5 жил тутамд нэг удаа үнэлж, аттестатчилж байхаар тусгажээ. Үнэлгээг төрийн захиргааны төв байгууллагаас томилсон төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын болон сургалт, эрдэм шинжилгээний байгууллага, ажил олгогч, мэргэжлийн холбоод, эцэг эхийн төлөөлөл бүхий аттестатчиллын комисс гүйцэтгэнэ. МСҮТ-ийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөхдөө сургалтын чанар, үр дүн (ирц, улсын болон мэргэжлийн шалгалтын дүн), багшлах боловсон хүчин (багшийн мэргэжлийн зэрэг), сургалтын орчин (ном сурах бичиг, сургалтын дадлагын газар, дотуур байрны хангамж), төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, санхүүжилт (ном хэвлэл, хичээл практикт болон нэгж суралцагчид зарцуулсан зардал)-ийг илтгэх тоон үзүүлэлт, үйл ажиллагааг үнэлэх тодорхой аргачлал бүхий чанарын үзүүлэлтүүдийг ашиглаж байв. Чанарын үзүүлэлт нь байгууллагын менежмент, сургалтын хөтөлбөр аргазүй, багшийн хөгжил, аргазүй, мэргэжлийн боловсролын үйлчилгээний хүртээмж, санхүү нөөцийн удирлага гэсэн 5 бүлэг үзүүлэлт бөгөөд магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлттэй төсөөтэй шаардлага байсан байна. Аттестатчилалд хамрагдсан сургууль эдгээр үзүүлэлтийг хангаж байгаагаа илтгэсэн тайлан ирүүлж, үүнд үндэслэн аттестатчиллын комисс газар дээр ажиллан дүгнэлт гаргаж байсан нь процедурын хувьд ч магадлан итгэмжлэлтэй төстэй байсныг тэмдэглэх хэрэгтэй.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 55 дугаар тушаалаар баталсан “Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагыг аттестатчилах түр журам”-аар аттестатчиллын хугацааг 3 жил болгож, аттестатчилалд хамрагдах МСҮТ нь:

- МСҮТ-ийн үйл ажиллагааг хэвийн, тогтвортой явуулах удирдлагын бүтэц, зохион байгуулалтыг бүрдүүлсэн байх
- Сургалтын үйл ажиллагаа хуваарийн дагуу бүрэн, чанартай явагддаг байх
- Багшлах бүрэлдэхүүнд тавих шаардлагыг хангасан байх
- Сургалтын тохилог, тавтай орчин, мэргэжлийн ур чадвар, дадлыг эзэмших лаборатори, үйлдвэрлэлийн дадлага хийх боломж, хөдөлмөр хамгааллын нөхцлийг хангасан байх
- Номын сан, мэдээллийн хангамжид тавих шаардлагыг хангасан байх
- Суралцагчид зориулсан үйлчилгээнд тавих шаардлагыг хангасан байх гэсэн 6 шаардлагыг хангаж байгаа тухай тайлан бэлтгэж ирүүлэх журам тогтоожээ.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2012 оны 130 дугаар тушаалаар баталсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг аттестатчилах журам”-аар аттестатчиллын ерөнхий зарчмыг хадгалж, аттестатчилах ажлыг МБС-ын агентлаг хариуцан гүйцэтгэж, 4 жил дутам аттестатчилж байхаар тогтоожээ. Аттестатчилал нь Хяналтын шалгуур үзүүлэлтийг дүгнэх, Үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг дүгнэх гэсэн үе шаттай явагдах бөгөөд Хяналтын шалгуур үзүүлэлт нь тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаж буй эсэхийг илтгэх үзүүлэлтүүд (нийт хүртэл 25 оноо), Үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт (нийт хүртэл 75 оноо) чанарын үнэлгээний шалгуур байхаар тодорхойлсон байна. Үйл ажиллагааг:

- Сургуулийн үйл ажиллагааг хэвийн тогтвортой явуулах, менежментийн бодлоготой байх;
- Сургалтын агуулга, арга зүй, чанарын үнэлгээ;
- Удирдах ажилтан, багшлах боловсон хүчний чадавхийг бэхжүүлсэн байдал;
- Сургалтын зорилго зорилтыг хангасан сургалтын орчин бүрдүүлсэн байх;
- Суралцагчдад зориулсан үйлчилгээ нь тэдний эрх ашигт нийцсэн байх гэсэн 5 бүлэг үзүүлэлтээр үнэлэхээр тогтоосон нь өмнөх уламжлалыг агуулсан шинжтэй байна.

МБСБ-ыг аттестатчилах ажлыг сүүлийн жилүүдэд хийгээгүй байна.

**Яамны үзлэг шалгалт, үр дүнгийн гэрээний үнэлгээ:** МБСБ-ын үйл ажиллагааны чанарт төрийн захиргааны байгууллагаас хяналт шинжилгээ, үзлэг шалгалт хийж, үнэлгээ дүгнэлт гаргах нь хэд хэдэн хуулиар тогтоосон чиг үүрэг юм. Юуны өмнө Боловсролын тухай хуулийн дагуу сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаж байгаа байдалд хяналт шинжилгээ хийх замаар хяналт тавина.<sup>52</sup> Өмчийн хэлбэр харгалзалгүй мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, ангиллыг тогтоох,<sup>53</sup> хийсэн үнэлгээг үндэслэн үйл ажиллагааг зогсоох, татан буулгах талаар дүгнэлт гаргах<sup>54</sup>

---

<sup>52</sup> Боловсролын тухай хуулийн 37.1, 37.2 дахь заалт

<sup>53</sup> Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8.4.8 дахь заалт

<sup>54</sup> Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8.4.4 дэх заалт

ажлыг зохион байгуулна. Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад хянан шалгаж, шаардлагатай бол тэдгээрийн удирдлагын илтгэл, мэдээллийг сонсоно.<sup>55</sup> Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд төсвийн шууд захирагч-мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын захиралтай байгууллагын төсвийн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, тэдгээрийн төсөв, хүрэх үр дүн, түүнийг дүгнэх талаар тусгасан үр дүнгийн гэрээг төсвийн жил эхлэхээс өмнө байгуулж, биелэлтийг нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ.<sup>56</sup> Хуулиар олгосон дээрх бүрэн эрхийг хэрэгжүүлж мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааны явцад чанарын үнэлгээг тусгайлсан удирдамжтай ажлын хэсэг, комисс байгуулан ажиллуулж зохион байгуулдаг.

**Мэргэжлийн хяналт:** Боловсролын салбарт төрийн өмчийн сургалт, боловсролын байгууллагаас гадна хувийн санаачилга, иргэд, аж ахуйн нэгжийн өмч хөрөнгөд түшиглэсэн боловсролын байгууллага үүсэн байгуулагдаж эхэлсэн 1980-аад сүүл үеэс боловсролын салбарын хяналтын бие даасан байгууллагын тухай санаа гарах болсон байна. Үүний дүнд 1991 онд Улсын бага хурлаас баталсан Боловсролын хуульд *“боловсролын мэргэжлийн хяналтыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх боловсролын хяналтын алба [хэрэгжүүлэх]”* бөгөөд дүрмийг нь Засгийн газар батлахаар тусгасан байдаг. Түүнээс хойш энэ байгууллага өсөн бэхэжсээр өнөөдөр Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын нэгэн бүрэлдэхүүн хэсэг, орон нутагт салбартай тогтолцоо болжээ. Боловсролын мэргэжлийн хяналтыг *“боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, бага, дунд боловсролын стандарт, боловсролын сургалтын ажлын түвшин, түүнтэй холбогдсон норматив, дүрэм, журмын хэрэгжилтэд мэргэжлийн хяналт”* тавих зорилгоор ажиллуулах тухай Боловсролын тухай 2002 оны хуулийн 31 дүгээр зүйлийг үндэслэн Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 26.1-д *“Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын байгууллага хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд хяналт тавина”* хэмээн заасны дагуу мэргэжлийн хяналтын байцаагч нар мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж байна.

Одоо мэргэжлийн хяналтын үйл ажиллагаа нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу *“иргэн, хуулийн этгээдийн явуулж байгаа үйл ажиллагаа (үйлдэл, эс үйлдэхүй), түүнчлэн үйлдвэрлэж байгаа болон борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, үзүүлж байгаа ажил, үйлчилгээ хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэхэд”* чиглэдэг. Мөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийдэг<sup>57</sup> байна. Мэргэжлийн хяналтын шалгалтыг улсын байцаагч гардан хэрэгжүүлэх бөгөөд *“хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллагын албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах”* бүрэн эрхтэй ажилладаг.<sup>58</sup> Энэхүү хяналт

---

<sup>55</sup> Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.3 дахь заалт

<sup>56</sup> Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйл

<sup>57</sup> Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 52.1 дэх заалт

<sup>58</sup> Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9.8 дахь заалт

шалгалтын удирдамжид МБС-ын тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, мэргэжлийн стандартын биелэлтийг үнэлж дүгнэхэд холбогдох ажлыг тусгаж болно.

**Магадлан итгэмжлэл:** Манай оронд боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагаа 1998 онд дээд боловсролын салбараас эхэлж, 2002 оноос МБСБ-ыг хамрах болсон байна. Боловсролын магадлан итгэмжлэлийг боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарт хараат бус үнэлгээ хийж, ахиц дэвшлийг дэмжин, мэргэжлийн хүрээнд хүлээн зөвшөөрөх зорилгоор БМИҮЗ-ийн тогтоосон шалгуур, журмын дагуу явуулж байна.<sup>59</sup> МБС-ын байгууллага, хөтөлбөрийг магадлан итгэмжлэх ажиллагаа нь сургуулиас сайн дураар гаргасан хүсэлтийн үндсэн дээр хийгдэж байна. Энэхүү ажиллагаа нь тогтоосон холбогдох шалгуурыг хангаж байгаа талаар сургуулийн өөрийн үнэлгээний тайлан, түүнд хараат бус хөндлөнгийн шинжээчдийн багийн хийсэн үнэлгээнд үндэслэн БМИҮЗ-ийн МБС-ын магадлан итгэмжлэх комиссын дүгнэлт гаргах шаттайгаар явагддаг.

#### **Боловсролын Магадлан Итгэмжлэл**

- 26.1. Боловсролын магадлан итгэмжлэл нь боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарт хараат бус үнэлгээ хийж, ахиц дэвшлийг дэмжин, мэргэжлийн хүрээнд хүлээн зөвшөөрөх ажиллагаа мөн.
- 26.2. Боловсролын магадлан итгэмжлэлийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон, ашгийн төлөө бус байгууллага хэрэгжүүлэх бөгөөд тус байгууллага нь үйл ажиллагааныхаа үр дүнг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.
- 26.3. Магадлан итгэмжлэх байгууллагын дүрмийг Засгийн газар батална.
- 26.4. Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагын удирдах зөвлөл төр, олон нийт, суралцагчийн төлөөллөөс бүрдэнэ.
- 26.5. Боловсролын сургалтын байгууллагыг магадлан итгэмжлэх байгууллага нь Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл байна.
- 26.6. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл магадлан итгэмжлэх шалгуур, журмыг тогтоох, сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийх байгууллагыг бүртгэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 26.7. Төрөөс боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлд бусад магадлан итгэмжлэх байгууллагыг удирдамж, нэгдсэн зохицуулалтаар хангахад дэмжлэг үзүүлнэ.
- 26.8. Монгол Улсад магадлан итгэмжлэх үйл ажиллагаа явуулах гадаадын байгууллагыг Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл бүртгэж, зөвшөөрөл олгоно.

*(Боловсролын тухай хуулиас)*

БМИҮЗ нь Монгол Улсын боловсролын чанарыг сайжруулах зорилгоор сургалтын байгууллага болон тэдгээрийн сургалтын хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийх, чанарын удирдлага, соёлыг шинэчлэн сайжруулах сургалт зохион байгуулах, магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлт, процедурыг тогтоох, магадлан итгэмжлэх үйл ажиллагаа, магадлан итгэмжлэгдсэн сургууль, хөтөлбөрийн тухай мэдээллээр олон нийтэд үйлчлэх, магадлан итгэмжлэгдсэн байгууллагуудын албан ёсны бүртгэлийг хөтлөх болон гадаадын нэр хүндтэй магадлан итгэмжлэх байгууллагуудтай хамтран

<sup>59</sup> Боловсролын тухай хуулийн 26 дугаар зүйл

ажиллаж, үнэлгээнийхээ үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцлийг хангах зэрэг ажлыг хэрэгжүүлж гүйцэтгэх үүргийг хариуцуулж дүрэмд нь тусгасан байна.

БМИҮЗ-ийн үндсэн бүтэц нь дээд болон МБСБ, хөтөлбөрийг магадлан итгэмжлэхтэй холбогдох үйл ажиллагаа хариуцсан хоёр комисс, мэргэжлийн 10 зөвлөл, ажлын албанаас бүрдэж байгаа бөгөөд удирдах дээд байгууллага нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын даргалсан, төр, олон нийтийн төлөөлөлтэй Удирдах зөвлөл юм.

БМИҮЗ-ийн үйл ажиллагаагаа явуулах орлогын үндсэн эх үүсвэр нь үйлчилгээний төлбөр байхаар хуульд заасны дагуу 2008 оныг хүртэл зөвхөн магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан байгууллагын төлбөрөөр санхүүжиж байв. Энэ нь үнэлгээний үйл явц, үр дүнд нөлөөлж байсан байж болохыг тухайн үед магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан сургалтын байгууллага, хөтөлбөрөөс маш цөөн нь сөрөг үнэлгээ авсанаас харагддаг<sup>60</sup>. Энэ дүгнэлтийг бататгах өөр нэг баримт бол магадлан итгэмжлэгдсэн сургуулиуд БМИҮЗ-тэй байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу жил жилийн ахиц дэвшлийн тайлангаа гаргаж өгөөгүй байхад дүрмийнхээ дагуу энэ үндэслэлээр магадлан итгэмжлэлийг нь цуцалсан тохиолдол гараагүй байв. Магадлан итгэмжлэх ажиллагааны хараат бус байдлыг баталгаажуулах, үр нөлөөг нь сайжруулах зорилготой зохицуулалтыг Боловсролын тухай хуульд 2016 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр хуульчилж, БМИҮЗ-ийн үйл ажиллагааны зардлын зарим хэсгийг гэрээний үндсэн дээр улсын төсвөөс санхүүжүүлэх болжээ.

Дээд, техникийн болон мэргэжлийн боловсролын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх үнэлгээг БМИҮЗ-ийн мэргэжлийн төрөлжсөн зөвлөл хариуцан гүйцэтгэж байна. Хуульчийн эрхзүйн байдлын тухай хуулиар мэргэжлийн сургалтын магадлан итгэмжлэлийг Хуульчдын холбоо хариуцан хийж байхаар заасан. Энэ нь цаашид ийнхүү мэргэжлийн үнэлгээ хийж, магадлан итгэмжлэх дүгнэлт гаргах чадамж бүхий мэргэжлийн холбоодод хөтөлбөрийн магадлан итгэмжлэх чиг үүргийг шилжүүлэх ажлыг дээд боловсролын салбараас эхлүүлсэн алхам болж байна.

БМИҮЗ-ийн үндсэн үйл ажиллагаа болох сургалтын байгууллагын болон сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлтэд үндэслэдэг. Ийнхүү чанарын үнэлгээ хийх шинжээчдийн эрхийг нь БМИҮЗ-ийн даргын тушаалаар баталж, тодорхой сургалтын байгууллага болон хөтөлбөрийн чанарт үнэлгээ хийх багийг эдгээр эрх бүхий шинжээчдээс тухай бүрд нь байгуулж ажиллуулдаг. Ийнхүү томилогдсон шинжээчдийн баг сургууль, хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланд дүн шинжилгээ хийж, шаардлагатай нэмэлт баримт нотолгоог цуглуулан, магадлан итгэмжлэх эсэх саналын үндэслэлээ баримтжуулж, чанарыг цаашид сайжруулах мэргэжлийн зөвлөмж боловсруулах нэн хариуцлагатай үүрэг гүйцэтгэдэг. БМИҮЗ-ийн дүрэмд зааснаар шинжээчид нь салбартаа тэргүүлэх мэргэжилтнүүд бөгөөд доод тал нь мэргэжлийн ажлын 10 жилийн туршлагатай байдаг. Шинжээчээр ажиллах хугацааг 3 жилээр тогтоосон бөгөөд энэ хугацааг шинэчлэн сунгах нь түгээмэл байна. Шинжээчээр ажиллуулах экспертийг сургалтын байгууллага санал болгон нэр дэвшүүлж, нэр дэвшигчдээс БМИҮЗ-ийн ажлын алба сонгон шалгаруулж, БМИҮЗ-ийн даргын тушаалаар гурван жилийн хугацаатай ажиллах эрх олгодог.

---

<sup>60</sup> Karakhanyan and Bat-Erdene (2014). Quality Assurance and Accreditation in Higher Education of Mongolia

Магадлан итгэмжлэлийн дараа хийгдэх ажил нь МБС-ын чанарыг сайжруулан бэхжүүлэхэд маш их ач холбогдолтой шат болно. Шинжээчдийн багийн гишүүд болон МБС-ын магадлан итгэмжлэх комиссын хурлаас өгч буй зөвлөмж тухайн сургууль, хөтөлбөрийн чанарыг сайжруулахад чиглэсэн хамгийн үнэ цэнэтэй мэргэжлийн туслалцаа тул үүнд тулгуурлан үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөө боловсруулж, эрх барих дээд байгууллага – Удирдах зөвлөлөөрөө хэлэлцүүлэн батлуулж ажилладаг нь нийтлэг туршлага юм. Магадлан итгэмжлэлийг тодорхой нөхцлөөр олгосон тохиолдолд шинжээчдийн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх нь заавал биелүүлэх үүрэг бөгөөд энэ үүргийн биелэлтийг ихэнх тохиолдолд 2 жилийн хугацаанд багтаж тайлагнах шаардлагатай байдаг. Бүрэн магадлан итгэмжлэл олгосон тохиолдолд шинжээчдийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн тухайгаа дараагийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайланд бүрэн тусгах хэрэгтэй болно.

БМИҮЗ-ийн дүрэмд зааснаар, сургалтын байгууллага нь үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулж буй талаар жил бүр үнэлгээ хийж, ахиц дэвшлийн тайлангаа БМИҮЗ-д ирүүлж байх үүрэг хүлээдэг. Дүрмийн дагуу жил тутам тайлан ирүүлээгүй тохиолдолд БМИҮЗ нь магадлан итгэмжилсэн шийдвэрээ цуцлах хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

БМИҮЗ нь байгуулагдсан цагаасаа олон улсын чанарын баталгаажуулалтын сүлжээнд нэгдэж, үйл ажиллагаанд нь оролцож ирсэн байна. Тухайлбал, 1999 онд INQAАНЕ (Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын агентлагуудын олон улсын сүлжээ)-гийн гишүүнээр элсэж, түүнээс хойш APQN (Ази, Номхон далайн орнуудын чанарын сүлжээ), АНУ-ын СНЕА (Дээд боловсролын магадлан итгэмжлэх зөвлөл)-ийн олон улсын чанарын групп, APACC (Ази, Номхон далайн бүсийн магадлан итгэмжлэл ба батламжлалын комисс)-ийн гишүүн болж идэвхитэй хамтран ажиллаж байна. 2015 оноос ХБНГУ-ын ASIIN (Инженер, мэдээллийн технологи, математик, байгалийн шинжлэх ухааны хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн зөвлөл)-тай ижилсэх түншлэлийн гэрээтэй ажиллаж магадлан итгэмжлэх зарчим, шалгуур, процедурыг энэхүү нэр хүндтэй байгууллагынхтай ойртуулж, шинжээчдийг сургахад хамтран ажилласан байна.

Олон улсын байгууллагатай хамтран магадлан итгэмжлэл хийх ажил 2006 онд Монгол Улс CPSC (Ази, Номхон далайн бүсийн хүний нөөцийн хөгжлийн Техникийн боловсролын ажилтны коллеги)-ийн гишүүнээр элсэн, APACC (Ази Номхон далайн бүсийн магадлан итгэмжлэл ба батламжлалын комисс)-тай БМИҮЗ хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсанаар мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт анх эхэлж, 2009 оноос хойш Улаанбаатар дахь Барилгын Политехник коллеж (2009, 2012 онд), Технологийн дээд сургууль (2011, 2013 онд), ЭМШУИС-ийн Эрүүл мэндийн технологийн сургууль (2012 онд), Техник технологийн дээд сургууль (2012, 2019 онд) магадлан итгэмжлэгдсэн байна.

#### *Магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтүүд*

Боловсрол сургалтын байгууллагын үйл ажиллагааг үнэлэх шалгуурыг байгууллагын удирдлагын бүх процесс, тухайлбал, дотоод чанарын баталгаажууллын механизм, төлөвлөлт, тайлагналт, хариуцлага тооцох механизм, сургалтын процессыг удирдах үйл явц, харилцагчдадаа болон нийгэмд үзүүлж буй үйлчилгээ, гадаад харилцаа, санхүүгийн удирдлага нь стратегийн зорилго зорилтууд, эрхэм зорилго, алсын

хараатай нь хэрхэн уялдаж буйг үнэлэхийг зорьж сонгодог. Энэ үнэлгээний үр дүнг байгууллагын нийт удирдлагыг сайжруулж, чанарын баталгаажууллын циклийг бүрэн болгоход ашигладаг.

БМИҮЗ-ийн Удирдах зөвлөл 2019 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 5 дугаар тогтоолоор **"Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага"**-ыг дараах 7 шалгууртайгаар баталжээ:

### **Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур**

#### **Шалгуур 1. Захиргаа, удирдлага**

1.1 Удирдлага болон шийдвэр гаргалтын тогтолцоо (стратеги төлөвлөлт, чанарын удирдлага, чанарын дотоод аудит, сургалт-аргазүйн болон мэргэжлийн зөвлөл)

1.2 Хөтөлбөр болон төсөв (үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөө)

#### **Шалгуур 2. Сургах ба сурах үйл ажиллагаа**

2.1 Сургалтын бодлого, үндэсний бодлогын нийцэл

2.2 Сургалтын хөтөлбөр

2.3 Чадамжийн нэгжийн төлөвлөгөө

2.4 Сургах, сурах үйл ажиллагааны материалууд

2.5 Сургах, сурах үйл ажиллагааны аргазүй, техник

2.6 Сургах, сурах үйл ажиллагааны явцын хяналт, үнэлгээ

#### **Шалгуур 3. Хүний нөөц**

3.1 Багшлах бүрэлдэхүүний мэргэшил, ур чадвар

3.2 Бусад ажиллах бүрэлдэхүүний мэргэшил, ур чадвар

3.3 Багшийн ажлын ачаалал, ажил үүргийн хуваарилалт

3.4 Багш, ажилтныг сонгон шалгаруулах, үнэлэх, хөгжүүлэх, урамшуулах тогтолцоо

#### **Шалгуур 4. Судалгаа, хөгжүүлэлт**

4.1 Судалгаа, хөгжүүлэлтийн хөтөлбөр

4.2 Судалгаа, хөгжүүлэлтэд багш, ажилтны оролцоо

4.3 Судалгаа, хөгжүүлэлтийн үр дүнг түгээх, сайжруулах

4.4 Судалгаа, хөгжүүлэлтийн удирдлага

#### **Шалгуур 5. Нийгмийн хариуцлага, нийгмийн түншлэл**

5.1 Нийгэмд чиглэсэн үйлчилгээ (үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоо – PDCA, төсөв, гүйцэтгэл, багш ажилтны оролцоо)

5.2 Нийгмийн түншлэл

5.3 Нийгэмд эзлэх байр суурь (бренд ажил үйлчилгээ, бүтээгдэхүүн)

#### **Шалгуур 6. Бусад нөөц**

6.1 Санхүүгийн эх үүсвэр, нөөц

6.2 Материаллаг бааз

6.3 Номын сан

#### **Шалгуур 7. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ**

7.1 Суралцагчдад үзүүлэх үйлчилгээний тогтолцоо

7.2 Суралцагчдад үзүүлэх үйлчилгээ

БМИҮЗ-ийн 2016 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор **"Мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага"**-ыг дараах шалгууртайгаар баталжээ:



**Мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага**

**Шалгуур 1. Хөтөлбөрийн хөдөлмөрийн зах зээлийн шинжилгээ ба нийцэл:** сургалтын хөтөлбөр нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн, ажил олгогчийн болон ажлын байранд тавигдах шаардлагыг хангахуйц байна. Хөтөлбөр нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг тодорхойлох шинжилгээ судалгаа хийдэг, өөрчлөлттэй уялдан шинэчлэгдэх механизмтэй, ажил мэргэжлийн стнадарттай нийцэлтэй, үнэлгээний шалгуур үзүүлэлт нь ажлын гүйцэтгэлийг хэмжихүйц, тухайн түвшний сургалтын чадамжийн нэгжийг үнэлэхүйц байна.

**Шалгуур 2. Хөтөлбөрийн бүтэц, агуулга:** Хөтөлбөрийн бүтэц, агуулга мэргэжлийн стандарт, мэргэжлийн боловсрол, сургалтын стандартын шаардлагад нийцсэн, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчдын хэрэгцээг хангахад чиглэсэн мэргэжлийн өндөр мэдлэг, үр чадвар бүхий зөв хандлага, төлөвшилтэй мэргэжилтэй ажилтан бэлтгэхийн үндсэн суурь нь болно. Хөтөлбөрийг MNS 6541:2015 стандартын дагуу боловсруулсан, зорилго, зорилт нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилготой уялдсан, бүтэц нь төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан загварын дагуу бүрэн боловсруулагдсан, агуулгын багтаамжийг бодитой, хэмжих нэгжээр тооцсон, дараагийн шатны болон ахисан түвшний сургалтын агуулга, мэргэшлийн түвшинтэй уялдсан, ижил түвшний дотоод, гадаадын хөтөлбөртэй уялдуулан боловсруулсан, суралцагчийн шилжин суралцах, хамтарсан хөтөлбөрт хамрагдах бололцоог нээсэн байна.

**Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх бэлтгэл хангалт:** Сургалтын байгууллага нь хөтөлбөрөөр сургалт явуулахын өмнө багш, удирдах ажилтны нөөц, сургалт явуулахад зайлшгүй шаардагдах сургалтын материаллаг орчин болон санхүүгийн нөөц, сургах, суралцахуйн зохицуулалтыг хийж хөтөлбөрөөр сургалт зохион байгуулах бэлтгэл хангасан байна. Хөтөлбөрийн зорилго, зорилт, шаардлагыг хангаж, хэрэгжүүлж чадахуйц чадавхтай хүний нөөц бүрдүүлсэн, зайлшгүй байх дадлагын газар, анги танхим, лаборатори, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, ном сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг бүрдүүлж, сургалтын ажлыг зохион байгуулдаг, хэрэгжүүлэхүйц санхүүгийн нөөцтэй суралцах хүсэлтэй, шалгуур хангасан элсэгчийг сонгох механизм, үйл ажиллагааны дүрэм журамтай, сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл, үндэсний стандартыг хангасан, суралцагчийн мэдлэг, үр чадвар, хандлага төлөвшлийг түвшин бүрээр шударга, ил тодоор үнэлэх механизм бүрдүүлсэн байна.

**Шалгуур 4. Хөтөлбөрийн хэрэгжүүлэлт:** Сургалтын хөтөлбөр нь үндэсний хэмжээний шалгуурыг хангасан, хөтөлбөрийг хэрэгжүүлэхүйц чадавхи бүхий бүтэц, нэгжтэй, суралцагчийн сурах үйлийг дэмжин ажилладаг, багш нарын заах аргыг байнга дээшлүүлдэг, суралцагчдад үзүүлэх үйлчилгээний тогтолцоотой, сургалтын уян хатан, нээлттэй байдлыг бүрдүүлсэн байна. Сургалтын стратегийг үр дүнтэй хэрэгжүүлж, нийтлэг шаардлага, хэм, хэмжээг хангасан, оновчтой зохион байгуулалт, сургалтын уян хатан байдлыг бий болгож, суралцагчид хөгжиж, төлөвших тогтолцоог бүрдүүлж, сургах, суралцахуйн оновчтой арга барил, технологийг нэвтрүүлсэн, бүхий л талуудын оролцоог хангаж, тэдний сэтгэл ханамж, хүлээгдэж буй чанарын үр дүнг бий болгох ажлыг үр дүнтэй зохион байгуулдаг байна.

**Шалгуур 5. Хөтөлбөрийн үнэлгээ, дотоод чанарын баталгаажилт:** Хөтөлбөрийн хяналт, үнэлгээний тогтвортой, үр дүнтэй байдал бий болж, тасралтгүй сайжруулалтын механизм бүрдсэн байна. Хөтөлбөрийн үнэлэх, хянах механизм, суралцагчдын чадамж, ахиц дэвшлийг үнэлж, тодорхойлох байнгын механизм, багшийн үр чадвар, ажлын гүйцэтгэлийг үнэлэх механизм, тасралтгүй хөгжих боломж, бололцоо бүрдүүлсэн байна.

Үнэлгээний ажилтныг чадавхжуулах, хариуцлага тооцох, ёс зүйн хэм, хэмжээг тодорхойлсон дүрэм бий болгосон, дотоод чанарын баталгаажууллын хөтөлбөрийн явцын чанар, үр дүнг байнга шинэчилэн сайжруулдаг байна.

Шалгуур 6. Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө: Хөтөлбөр нь суралцагчид, төгсөгчид үр дүнгээ өгөхүйц, салбартаа шилдэг байх боломжийг олгосон, нийгэм, эдийн засгийн үр ашигтай байна. Хөтөлбөрийн төгсөлтийн дараах чанар, ажил эрхлэлт, хэрэгжилтийн байдалд шинжилгээ, дүгнэлт хийдэг, төгсөлтийн үнэлгээг ажил олгогчид хүлээн зөвшөөрч, гэрчилгээжүүлдэг, төгсөгчдөө давтан сургах, эргэх холбоо бүрдүүлсэн, төгсөгчийн салбартаа болон нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг судлан, тэдний амжилтыг бүртгэлжүүлж, ажил мэргэжлийн үнэ, цэнийг ойлгуулах, тэднээр бахархах бололцоог нээж, нийгмийн тусын тулд ашигладаг байна.

Эдгээр шалгуур нь “MNS 6541-2015. Мэргэжлийн боловсрол сургалт: Ерөнхий шаардлага” улсын стандарт болон Олон улсын стандартчиллын байгууллагаас зөвлөмж болгодог чанарын удирдлагын стандартын шалгуур шаардлагатай агуулгын хувьд давхцаж байгааг ажиглаж болно. Мөн үнэлгээ хийх дүгнэлт гаргах процедур ч төстэй бөгөөд мэргэжлийн үнэлгээ хийх шинжээч экспертийн нөөц хомс байдгаас шинжээчид нь аль аль ажиллагаанд сонгогдон оролцох нь элбэг байдаг байна. Түүнчлэн эдгээр шалгуураар МСҮТ, Политехник коллежийг үнэлэхэд ялгаатай байдлууд гарч байгааг энэ процесст оролцсон мэргэжилтнүүд тэмдэглэж байв.

Хэдийгээр Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд МБСБ, хөтөлбөрийг магадлан итгэмжлэхийг шаардлага болгон хуульчлаагүй боловч Боловсролын тухай хуулийн ерөнхий зохицуулалтын хүрээнд сургуулиуд сайн дураар магадлан итгэмжлүүлэх нь үргэлжилж байна. МБСБ-ууд нь төрөл хэлбэрийн хувьд нэлээд ялгаатай, ялангуяа хөтөлбөрүүд зорилго, зохион байгуулалтын хувьд өөр болохыг тооцож магадлан итгэмжлэлийг аль хэлбэр хэв шинжийн байгууллага, хөтөлбөрт хэрхэн илүү үр нөлөөтэй байхаар зохион байгуулахыг тодорхой болгох шаардлага байна. Түүнчлэн бараг ижил шалгуур, зарчим, процессоор хийгдэж буй сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийг олон улсын чанарын удирдлагын стандарт, ялангуяа MNS ISO 21001-2021 стандартыг нэвтрүүлсэн зэрэг байгууллагад давхардуулан хийлгүй, дүйцүүлэх хүлээн зөвшөөрөх асуудлыг анхаарч үзүүштэй юм.

Магадлан итгэмжлэх үйл ажиллагаа нь харьцангуй урт хугацаанд тогтвортой үргэлжлэх бүхэллэг үйл ажиллагааг процессийн хувьд нь үнэлж, чанарын сайжруулалт хийх чиглэл, арга замыг тодорхойлоход чиглэсэн процедур бөгөөд энэ үнэлгээний дүгнэлт төдийгүй, дүгнэлт гаргасан үйл явц, шалгуур нь олон улсын нийтлэг жишиг горимтой нийцсэний үндсэн дээр харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөл бүрддэг. Иймд байгууллагын магадлан итгэмжлэлийг МСҮТ, Политехник коллежид хамааруулан дээд боловсролын байгууллагуудын нэгэн адил заавал хийлгэх шаардлага болговол илүү зохимжтой байна. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг техникийн боловсролын хөтөлбөрүүдэд үнэлгээ хийхэд хэрэглэж болно. Харин ЧСС-ын хөтөлбөр, богино хугацааны мэргэжлийн сургалт эрхэлдэг байгууллагад магадлан итгэмжлэл хийх шаардлага, боломж бага байна. Хугацааны хувьд богино, агуулга нь цомхон бөгөөд хөдөлгөөнтэй энэ сургалтын процесст магадлан итгэмжлэлийн нэлээд урт хугацаа шаарддаг, ажилбар, зардал өндөртэй үнэлгээ хийх нь илүүц бөгөөд хөтөлбөрт өөрчлөлт орох бүрт магадлан итгэмжилсэн дүгнэлт хүчингүй болж байхаар харагдаж байна. Үүний оронд аттестатчилал, хяналт шинжилгээний хэрэгслийг ашиглах, суралцан

төгсгөсөн хүмүүсийн эзэмшсэн ур чадварын үнэлгээгээр дүгнэхэд илүү анхаарч, хөдөлмөрийн зах зээл, ажлын байранд гарч байгаа өөрчлөлтийг шуурхай тусгаж, уян хатан нийлүүлэлт хийхэд нь тохирох зохицуулалт илүү үр дүнтэй байж болох юм.

Чанарын стандартыг хэрэгжүүлэх процесст чанарыг баталгаажуулах нь ийнхүү олон арга хэрэгслээр хөндлөнгийн үнэлгээгээр хэрэгжиж байгаагийн зэрэгцээ сургалтын байгууллагууд өөрөө дотооддоо чанарын баталгаажууллын чадавхи, тогтолцоо бүрдүүлэх үйл явц өрнөж байна. Хөндлөнгийн үнэлгээ нь сургалтын байгууллагын өөрийн үнэлгээнд суурилж, үүнтэй уялдаа холбоотой явагдах нь бодит шаардлага юм. МБСБ-ууд сүүлийн жилүүдэд чадамжид суурилсан хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, Сингапурын Темасек сан, Сингапурын Политехник коллеж, ГХАН-тэй хамтран боловсруулсан *чанарын баталгааны тогтолцоо*ны аргагүйг эзэмшихэд суралцаж, олон улсын чанарын удирдлагын ISO серийн стандартуудаас сонгон туршиж нэвтрүүлэх алхмуудыг эхлүүлсэн байна. Эдгээр нь бүгд үзэл баримтлал, зохион байгуулалт, аргачлалын хувьд ижил төстэй, чанарын иж бүрэн удирдлага – PDCA (*Төлөвлө – Хэрэгжүүл – Үнэл – Сайжруул*) мөчлөгт суурилсан тул өөр хоорондоо зөрчилдөхгүй, харин ч сургалтын байгууллагын санаачилга, идэвхи сонирхол, өөрийн онцлогт тохируулан нутагшуулах хүсэл эрмэлзлээс үүдэлтэй тул дэмжин урамшуулах нь зүйтэй гэж үзэж байна.

#### с) Мэргэжлийн боловсрол, сургалтын үр дүнг үнэлэх, баталгаажуулах хэрэгсэл

Чанарын баталгаажууллын тогтолцооны чанарын стандартын загварт нийцэж буй эсэхийг үнэлэн дүгнэж, дүгнэлтийг албажуулах үйл ажиллагаа нь МБС-ын хүрээнд ажил мэргэжлийн тодорхойлолтод заасан мэдлэг, ур чадвар, чадамжийг эзэмшсэн байдлыг үнэлж дүгнэн гэрчилгээжүүлэх арга замаар хэрэгжиж байна. Үүнийг чанарын үнэлгээний гол хэсэг хэмээн үзэж *Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн* “16 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын үнэлгээ” хэсэгт зохицуулалтыг нь заасан байна. Хуулийн дагуу мэргэжлийн болон техникийн боловсролын хөтөлбөрөөр суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг сургалтын явцад болон анги дэвших, сургууль төгсөхөд нь багшийн үнэлгээ, сургалтын байгууллагын шалгалтын болон мэргэжлийн үнэлгээний байгууллагын дүнгээр шалган үнэлж, МБС-ын стандартын хэрэгжилтийг дүгнэнэ. ХНХЯ-наас 2019 онд I-IV түвшний мэргэжлийн боловсрол, сургалтын 15 стандартыг баталж, сургалтанд ашиглахыг зөвшөөрсөн байна.

Мөн MAOЭНХ, Ажил мэргэжлийн стандарт, хүний хөгжлийн хүрээлэн нь БАЗТ, мэргэжлийн холбоодтой хамтран ажил мэргэжлийн стандартыг боловсруулж, хамтарсан мэргэжлийн холбоод нь батлан, ашиглах нь нэмэгдэж байна. Эдгээрээс бусад мэргэжилд харгалзах сургалтын стандарт, ажил мэргэжлийн лавлах албан ёсоор баталгаажуагүй тул сургалтыг эрхэлж буй сургалтын байгууллагын хөтөлбөрөөр төгсгөгчдийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, чадамжийг тодорхойлж, үнэлж дүгнэж байна.

*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 16.4 дүгээр зүйлд* зааснаар техникийн боловсролын хөтөлбөрийн шаардлагыг хангасан иргэнд мэргэжлийн диплом, мэргэжлийн боловсролын хөтөлбөрийн шаардлагыг хангасан иргэнд мэргэжлийн үнэмлэх, мэргэжлийн сургалтын тодорхой чадамж эзэмшүүлэх модулийг дүүргэсэн

иргэнд харгалзах чадамжийн гэрчилгээ олгохоор тогтоожээ. Мөн суурь боловсролын дараа МСҮТ-д ерөнхий боловсролын хөтөлбөрийг нэгтгэсэн 2.5 жилийн хөтөлбөр дүүргэсэн иргэдэд ерөнхий боловсролын бүрэн дунд боловсролын гэрчилгээг давхар олгодог. Одоо ерөнхий боловсролын ахлах сургуулийн хөтөлбөр Х-ХII ангийн 3 жилийг хамарсан агуулгатай атал МСҮТ-д 2.5 жилд мэргэжлийн боловсрол давхар эзэмшсэн иргэдэд бүрэн дунд боловсролын гэрчилгээ олгож байгааг тойрсон маргаан шийдэгдээгүй байна. МСҮТ-ийн багш, ажилтнууд төгсгөгчиддөө их, дээд сургуульд дэвшин суралцах эрхийг нь нээсэн одоогийн журмыг илүү хөнгөлөлттэй (бүрэн дунд боловсролын стандартын шаардлагыг хөнгөвчлөх) нөхцлөөр үргэлжлүүлэх ёстой гэсэн байр суурь илэрхийлдэг. Харин боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын ажилтнууд стандартын нэгдмэл байдлыг алдагдуулж болохгүй гэсэн байр суурьтай байна. МСҮТ-ийн багш, удирдлагын тайлбарлаж буйгаар суралцагч элсүүлэхэд ихээхэн хөшүүрэг болдог хүчин зүйл нь бүрэн дунд боловсролын гэрчилгээг давхар олгож буйтай холбоотой ажээ.

Суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлэх, дүгнэх журмыг хөдөлмөрийн болон боловсролын асуудал эрхэлсэн сайд нар хамтран баталж мөрдүүлдэг. Энэ журмыг хэрэгжүүлж, мэргэжлийн ур чадварыг үнэлэх, шалгах, баталгаажуулах хөндлөнгийн шалгалт зохион байгуулах чиг үүрэгтэй МБС-ын Үнэлгээний төвийг 2016 онд өмнө ажиллаж байсан МАЗУТ-ийн суурин дээр байгуулсан байна. Хожим энэ төвд БАЗТ-үүдийг харьяалуулж, харин энэ оны 6 дугаар сард ХНХСИ-д нэгтгэсэн байна. Одоо энэ институтын Хүний нөөц, ур чадварын сургалт, үнэлгээний газар нь Сургалт, бүртгэл мэдээллийн алба (мэргэжлийн сургалтын тусгай зөвшөөрөл, хөтөлбөр, мэдээллийн санг хөтлөх асуудлыг хариуцах) ба Үнэлгээ, баталгаажуулалтын алба (мэргэжлийн ур чадварыг үнэлэн гэрчилгээжүүлэх)-тай байхаар зохион байгуулалтаа хийж байна.

Сүүлийн жилүүдэд мэргэшсэн үнэлгээний ажилтан бэлтгэх, ур чадварын тестийн сан бүрдүүлэх, ур чадвар, чадамжийг үнэлэх ажилд мэргэжлийн холбоодын экспертизийг төвлөрүүлж Мэргэжлийн зөвлөл байгуулж ажил дээрх зохион байгуулалтын өөрчлөлтөд орсон байгууллагад түшиглэн хийгдэж байв. МБСҮМАЗТ нь мэргэжлийн ур чадварыг үнэлэх шалгах, баталгаажуулах, мэргэжлийн түвшинг тогтоох, зэрэг олгох, хөндлөнгийн үнэлгээ зохион байгуулах хүрээнд албан болон албан бус сургалт, амьдрах орчноос чадамж, мэргэжил эзэмшсэн иргэний мэргэшлийн түвшинг үнэлж баталгаажуулах, гэрчилгээжүүлэх чиг үүргийг мэргэжлийн зөвлөлүүдтэй хамтран МБС-ын чанарт хөндлөнгийн үнэлгээ хийх, сургалтын байгууллагын чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулах, агуулгад дүгнэлт гаргах, зөвлөмж гаргах, хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй, шинэ ажил, мэргэжлийн судалгаа хийх, салбарын үйл ажиллагаанд гарч буй шинэ санаа, бүтээл, брендийг дэмжиж олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зэрэг өргөн хүрээтэй, ачаалал ихтэй үнэлгээ, гэрчилгээжүүлэлтийн ажлыг эрхлэн хариуцаж байсныг шинэ зохион байгуулалтад алдагдал багатайгаар шилжүүлэх нь чухал байна.

Өмнө дурдсанчлан МБС-ын хөтөлбөр боловсруулах, ялангуяа ЧСС-ын арга зүйг нэвтрүүлэх, энэ талаар сургууль, багш нарт мэргэжлийн туслалцаа зөвлөмжөөр үйлчлэх үндсэн байгууллага болох БАЗТ-үүдийн үйл ажиллагааг жигдрүүлж, уялдаа холбоог нь зохистой болгож, статусыг нь тодотгон бэхжүүлэх нь тулгамдсан асуудал хэвээр байна. Түүнчлэн ЧСС-ын стандарт, хөтөлбөр, хэрэглэгдэхүүн, инновацийн

мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг аргагүйн байгууллагад хамтад нь шилжүүлэн хариуцуулбал зохистой. Хянан шалгах, мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх ажил нь шинж чанар, арга зүйн хувьд ялгаатай бөгөөд өөр хоорондоо зөрчилдөх тул нэг байгууллагад хамтад нь хариуцуулах нь зохимжгүй гэж үздэг.

Үнэлгээ, гэрчилгээжүүлэлтийн бие даасан мэргэжсэн чиг үүргийг ХНХСҮСИ, БҮТ-д хэрхэн хуваарилж хариуцуулах талаар ХНХЯ, БШУЯ одоо хэлэлцэж байна. Аль ч тохиолдолд сургалтын чанарын баталгаажууллын тогтолцоонд чухал үүрэгтэй энэ ажлыг иргэдийн эзэмшсэн мэргэжлийн ур чадвар, чадамжийг суралцсан арга хэлбэрээс нь хамааралгүй, хараат бусаар, шуурхай үнэлж баталгаажуулах хүртээмжтэй систем бүрдүүлэхийн зэрэгцээ МСҮТ, Политехник коллеж төдийгүй дээд боловсролын байгууллагын сургалтын үр дүн, суралцагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг үнэлж байгаа байдалд системийн мета үнэлгээ хийх зохистой чадавхи бүрдүүлэхэд анхаарч хандвал зохино. Үүний дүнд цаашдаа МБС-ын томоохон байгууллагууд эрх бүхий байгууллагын итгэмжлэлийн үндсэн дээр өөрсдийн суралцагчдын чадамжийг үнэлэн гэрчилгээжүүлэх эрхтэй төв (австралийн TAFE-тэй төстэй self-accrediting body бий болох эрхзүйн үндсийг тавих) болж, үйлчилгээний хүрээг тэлж, иргэдэд хүртээмжтэй болгох чиглэл баримталж болно.

Өнөөдөр МБС-ын хүрээнд чанарыг баталгаажуулах тогтолцооны бүрэлдэхүүн хэсгүүд байгуулагдаж, үйл ажиллагааны зааг ялгаа, уялдаа холбоо тогтож эхэлж байгаа боловч систем болж үр өгөөжтэй, үр ашигтай, итгэл даахуйц, хүлээн зөвшөөрөгдсөн байх шаардлагыг бүрэн хангаж хараахан чадахгүй байна. Учир нь ижил төстэй мэдээлэл, ажиллагаа шаардсан механизмыг өөр хоорондоо зорилго, үйл ажиллагааны шинж чанарын хувьд ялгаатай хэв шинж бүхий байгууллагуудад давхардуулан хэрэглэх нь хөрөнгө, санхүүгийн болон хүний нөөцийн ашиглалт, зарцуулалтыг нэмэгдүүлж, үүнээс шалтгаалан боловсрол сургалтын систем, байгууллагын чанарыг дэмжихэд үр ашигтай байх нөхцлийг муутгадаг.

Хяналт шалгалт, үнэлгээ хийж буй процесс, үүнд үндэслэсэн дүгнэлт нь итгэл даахуйц байх шаардлагын тухайд бол төгсгөгчдийн ажил хөдөлмөрт бэлтгэгдсэн байдлаар дүгнэвэл сургалтын чанар нь ажил олгогчдын шаардлагыг хангаж чадаагүй, түүнийг сайжруулах боломж тодорхойгүй атал эргэлзээтэй дүгнэлт гаргасан байх нь тохиолдсоор байгаа тул боловсрол сургалтын байгууллагууд болон олон нийтийн итгэлийг олж чадаагүй байна гэж дүгнэж болохоор байна.

Хүлээн зөвшөөрөгдсөн байдлын хувьд, төр засгийн байгууллага тусгай зөвшөөрөл олгон хүлээн зөвшөөрсөн атал ажил олгогчдоос мэргэжлийн төвшинд хүлээн зөвшөөрсөн эсэх нь тодорхойгүй байна. Үүний нэг шалтгаан нь ажил олгогчид сургалтын байгууллага, хөтөлбөрийг боловсруулсан, үнэлсэн тухай мэдээллээр дутмаг, хүлээн авсан олон төгсгөгч ажлын байрны шаардлага хангахгүй байгаа тул чанарыг баталгаажуулах олон механизм үүргээ гүйцэтгэж байна хэмээн итгэж чадахгүй байгаагаар холбоотой. Мэргэшил, ур чадварыг үнэлэх жишиг болох мэргэжлийн сургалтын стандарт, ажил мэргэжлийн тодорхойлолт бүрдээгүйгээс төгсгөгчид, иргэдийн чадамж, мэргэшлийг баталгаажуулан гэрчилгээжүүлэх механизм бүрэн тогтоогүй, олгож байгаа МБС-ын баримт бичгийн үнэ цэнэ тогтоогүй байна. Ажил олгогчдын хувьд чанарыг үнэлэхэд итгэж болох гол арга бол туршилтын хугацаанд чадамжийг нь өөрсдөө шалгах явдал гэж үзэх хандлага их байна.

Эцэст нь чанарын баталгаажууллын өөр нэгэн функц нь мэдээллээр хангах явдал билээ. Бүхий л түвшинд ийнхүү мэдээллээр дутмаг байгаа нь боловсрол сургалтын чанарын талаар олон нийтэд ноттой ойлголт өгөхгүй, үүгээрээ МБС-ын системд итгэх нийгмийн итгэлийг дэмжих бэхжүүлэх нөлөө үзүүлж чадахгүй байна.

#### d) Сургуулийн түвшний чанарын баталгаажуулал

Өнөөдөр МБС-ын үйл ажиллагааг гурван төрлийн МБСБ эрхэлж байна. Үүнээс уламжлалт бүрэн хэмжээний техникийн болон мэргэжлийн хөтөлбөр бүхий сургалттай 76 Политехник коллеж, МСҮТ ажиллаж байгаа юм. Эдгээрээс 43 нь төрийн өмчийн, 33 нь хувийн өмчийн МБСБ бөгөөд нийтдээ 57,929 суралцагч хүлээн авах хүчин чадал бүрдүүлсэн атал сүүлийн жилүүдэд дунджаар 40 орчим мянган суралцагчтай ажиллаж иржээ. Зөвхөн энэ мэдээнээс харахад эдгээр МБСБ бүгд хүчин чадалдаа хүргэж суралцагч элсүүлэх өрсөлдөөний дунд байна. Энэ өрсөлдөөнд амжилт олох түлхүүр нь чанарын шалгарал болох тул чанарын өндөр үзүүлэлтэд хүрэх нь эдгээр байгууллагын зорилго хэмээн үзэж болно.

Төр засгийн зүгээс эдийн засаг тэлж, хөдөлмөрийн зах зээлд мэргэжилтэй ажилтны хэрэгцээ өсөн нэмэгдэж байгааг харгалзан МБСБ-д элсэн суралцагчдад үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ МБСБ-ын хөтөлбөрийн чанарыг сайжруулж, суралцагчдын эзэмших ур чадвар, чадамжийг дээшлүүлэхэд үр нөлөөтэй үйлчлэх чанарын баталгаажууллын тогтолцоог бүрдүүлэх бодлого зорилгоо дэвшүүлээд байна. Ийнхүү чанарыг сайжруулах гадаад болон дотоод хүчин зүйлийн нөлөөгөөр МБСБ-ууд үйл ажиллагаагаа тасралтгүй чанаржуулах дотоод тогтолцоо бүрдүүлэх эрэл хайгуул өнөөдөр идэвхжсэн байгааг илтгэх олон баримт байна. МБС-ын салбарт Технологийн дээд сургууль, Техник технологийн дээд сургууль, Барилгын Политехник коллеж, Үйлдвэр урлалын Политехник коллеж зэрэг сургуулиуд Чанарын удирдлагын системийг санаачлагаараа нэвтрүүлсэн бөгөөд үндэсний хэмжээнд төдийгүй 2009 оноос олон улсын байгууллагаар магадлан итгэмжлүүлж эхэлсэн байна. Эдгээр нь сургалтын байгууллагын удирдлагын санал санаачилгын хүрээнд хийгдэж байжээ.

Үндэсний хэмжээнд МБСБ-уудын өрсөлдөх чадварыг сайжруулах, удирдлагын менежментийн оновчтой зохион байгуулалтыг бий болгох зорилгоор Хөдөлмөрийн яам, Сингапур Темасек сангийн хамтын ажиллагааны хүрээнд 2014 онд “Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагад Чанарын баталгааны тогтолцоог нэвтрүүлэх” төсөлд 52 сургуулийн удирдах ажилтныг хамруулсан. Харин тавхан жилийн дараа эдгээр сургалтанд хамрагдаж мэргэшсэн ажилтнуудын 27 хувь нь МБС-ын салбарт ажиллаж байсан мэдээ байдаг. Үүнтэй төстэйгээр өмнөх он жилүүдэд чадавхи бүрдүүлэх сургалтанд хамруулсан олон хүн өөрчлөгдөж, салбарыг орхисон нь хамгийн том алдагдал юм.

Дээрх төслийн шугамаар МБСБ өөрийн чанарын баталгаажууллын тогтолцоог бүрдүүлэн хөгжүүлэхдээ дараах зорилтыг үндэс болгосон байдаг. Үүнд:

- Өөрийн үйл ажиллагааны чанарын үзүүлэлтийг сонгож харьцуулалт үнэлгээ хийх (өөрийн үнэлгээ болон гүйцэтгэлд байнга үнэлгээ хийх замаар)
- Чанарын ахиц гаргахад чиглэсэн стратеги, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх

- Сургалтын байгууллага, хөтөлбөрийг үндэсний хэмжээнд үнэлдэг шалгуур, журмын дагуу хөндлөнгийн эрх бүхий байгууллагаар үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэх
- МБС-ын хөтөлбөр эхлүүлэх тусгай зөвшөөрөл авах
- Суралцагчдын суралцах явцын болон төгсгөлийн үнэлгээг хийж холбогдох үнэмлэх, диплом, гэрчилгээ олгох эрх эзэмших.

Иймд МБС-ын байгууллагын хэмжээнд чанарыг баталгаажуулах нь чанарын тухай нэгдсэн ойлголт, үнэлэмж бүхий чанарыг тасралтгүй сайжруулах эрмэлзэл соёл төлөвшүүлэх цогц үйл явцыг зохион байгуулах ажиллагаа гэж тодорхойлж болно. Байгууллагын түвшинд өөрийн үнэлгээ шинжилгээг хийхдээ чанарын үнэлгээний хөндлөнгийн мэргэшсэн байгууллагын шалгуур, журамтай нийцүүлэн зохион байгуулах, сургалтын ажлын үр дүн/гүйцэтгэлд хяналт шинжилгээ хийх зэрэг тусгайлсан ажил үүргийг тодорхой ажилтнуудад хариуцуулан уялдаа холбоотой ажиллуулдаг.

Сүүлийн жилүүдэд хандивлагчдын дэмжлэгтэй хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд МБСБ-ын түвшинд чанарыг баталгаажуулах чадавхи бүрдүүлэх, энэ талаар нийтлэг аргазүй, аргачлал боловсруулж нэвтрүүлэхэд ихээхэн ахиц гарсан байна. Үүнд Сингапурын Политехник коллеж, Темасек сантай хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь бүр МБСБ-ыг хамруулсан өргөн хүрээтэй ажил болжээ. Энэ ажлын дүнд МБСБ-ын удирдах ажилтнуудын шууд оролцоотойгоор “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын чанарын тогтолцоо” гарын авлагыг боловсруулж, бүх сургуулийн удирдах болон чанарын баталгаажуулалт хариуцсан ажилтныг хамруулсан сургалтыг БАЗТ-үүдэд түшиглэн зохион байгуулсан байна. Үүний дүнд МБСБ бүр чанарын асуудал хариуцсан ажилтан томилон ажиллуулах болжээ. 2021-2022 оны хичээлийн жилд МБСБ-д дотоод хяналт, чанарын үнэлгээ хариуцсан 56 ажилтан ажиллаж байв. Төрийн өмчийн бүх ПК, олонхи МСҮТ ийм орон тооны ажилтантай байна.

МБСБ-д сургалтын хөтөлбөрийг боловсруулахаас үр дүнг үнэлэх дүгнэх бүр шатанд чанарыг баталгаажуулахад аргазүйн удирдлага, зөвлөмжөөр ханган ажиллаж буй БАЗТ-үүдэд энэ үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд нь шаардлагатай эрхзүйн зохицуулалт, хүний нөөц, санхүүжилтийн асуудлыг яаралтай шийдвэрлэх шаардлагатай байна.

2019 онд судалгаанд хамрагдсан 50 МБСБ-ын ажилтнууд сургуулийн түвшинд чанарыг баталгаажуулах талаар хийж байгаа ажлынхаа зорилгыг сургуулийн стратегийн зорилтын хэрэгжилтийг хянаж үнэлэх (56%), магадлан итгэмжлүүлэх, аттестатчилалд сайн үнэлгээ авах (49.5%), хэрэглэгчийн эрэлтэд нийцсэн үйлчилгээ үзүүлэх (45.5%)-тэй ихэвчлэн холбон ойлгож байв. Энэ талаар төрийн өмчийн болон хувийн сургуулийн төлөөлөгчдийн хандлага ерөнхийдээ ижил байсан байна.

Дээрх судалгаанд оролцсон сургуулиудын дийлэнх буюу 66 хувь нь чанарыг баталгаажуулах талаар хийж буй ажил нь сургуулийн өөрийн тавьсан зорилготой нийцүүлэн сонгосон үзүүлэлтээр үнэлгээ хийхэд чиглэдэг гэжээ. Энэ хандлага хувийн сургуулиудад төрийн өмчийн сургуулиудаас арай илүү байжээ.

Судалгааны дүнгээс үзэхэд МБСБ-ын ЧБ хариуцсан ажилтнууд дараах сургалтуудад хамрагдсан байна.



**Хүснэгт 13: МБС-ын чанарын удирдлагын чиглэлээр зохион байгуулсан сургалт, оноор**

он	Сургалтын сэдэв, зохион байгуулагч
2010	“ЧСС-ын хөтөлбөр боловсруулах арга зүй” (БСШУЯ, МБСГ, Сингапур Политехник)
2011	“ТМБС-ын байгууллагуудын магадлан итгэмжлэл ба батламжлал” сургалт (CPSC, МБСГ) “Чанарын баталгаажуулалтын системийг хөгжүүлэх” сургалт (МБСГ, ММСС, СЭЗДС) “ЧСС-ын хөтөлбөр боловсруулах арга зүй” (БСШУЯ, МБСГ, Сингапур Политехник)
2012	МБСБ-ын чанарын удирдлагын менежмент сургалт (CPSC, ЗГХА МБСГ)
2013	Сингапурын Темасек сангийн сургалт Хөдөлмөрийн салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын сургалт (ХНХЯ)
2014	Улаанбаатар бүсийн арга зүйн төв Сингапурын Темасек сангийн сургалт Төлөвлөгөөт сургалт (Улаанбаатар БАЗТ)
2015	Чанарын баталгаажилтын сургалт (Хангайн БАЗТ) Чанарын баталгаажуулалт (ХНХЯ) Сингапурын Темасек сангийн сургалт Хөдөлмөрийн салбарын хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын ажилтнуудын чадавхи бэхжүүлэх
2016	Хяналт шинжилгээ үнэлгээний ажилтнуудын чадавхи бэхжүүлэх сургалт (ХНХЯ)
2017	Үнэлгээний сургалтууд (МБСҮМАЗТ) МБСБ-ын захиргаа ба удирдлага" (CPSC, ХНХЯ ХХҮЕГ)
2018	Үнэлгээний сургалтууд (МБСҮМАЗТ) Төлөвлөгөөт сургалт (Говийн БАЗТ)
2019-2020	Үнэлгээний сургалтууд (МБСҮМАЗТ)

Судалгаанд оролцсон сургуулиуд үзлэг шалгалтын дүнг удирдах дээд байгууллага (яам), сургуулийн удирдах зөвлөл, захирал, багш ажилтнуудад ихэвчлэн танилцуулдаг хэмээн хариулсан байна. Хувийн өмчийн сургуулийн удирдах зөвлөлд үнэлгээний дүнг танилцуулах харьцангуй өндөр (74% буюу төрийн өмчийн сургуулиас 14%-иар илүү) бол төрийн өмчийн сургуулийн үзлэг шалгалтын дүнг яаманд танилцуулах (63%) нь хувийн сургуулийнхаас хоёр дахин их байна. Харин энэ мэдээг олон нийтэд танилцуулах харьцангуй бага буюу гурваны нэгээс арай илүү хувь нь ийм танилцуулга хийдэг ажээ.

Үзлэг шалгалтын дүнг сургуулийн удирдах зөвлөлд бичгээр хүргүүлэхийн (43%) гадна илтгэл танилцуулга хийдэг (10%) бол яам агентлагт ихэвчлэн тайланг явуулдаг (91%) байна. Мэдээ танилцуулгыг яам агентлагт ойролцоогоор жилд нэг удаа, харин сургуулийн захирал, бүх нэгжид дунджаар улирал тутам мэдээлдэг дүр зураг харагдаж байна.

Төрийн өмчийн сургуулиудын хувьд сургуулийн стратеги төлөвлөлтийг оролцооны аргаар боловсруулах (84.6%), сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгосон болон сургуулийн түвшинд статистик мэдээллийн тогтолцоог сайжруулах (78.2%), багш ажилтнуудын цалин хангамж нэмэгдүүлэх (76.9%) зэргээр чанарын баталгаажууллыг бүрдүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн хэмээжээ. Хувийн өмчийн сургуулиудын хувьд оролцоог хангаж, харилцан хамтын ажиллагааг хөгжүүлэх (100%), сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох (94.8%), сургуулийн түвшинд аюулгүй орчинг бүрдүүлэх болон байгууллагын түвшинд ёс зүйн дээд чанар хэвшүүлэхэд (94.7%) илүү нөлөөлсөн гэж үнэлж байжээ.

Хөтөлбөр боловсруулах, сургалтын үр дүнг тодорхойлох суурь болсон мэргэжлийн сургалтын стандарт, ажил мэргэжлийн лавлах бүрэн албажиж баталгаажуулж байна. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаар бэлтгэх нийт 581 мэргэжлийн индексийг (жагсаалт)-ыг 2016 онд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын А150 дугаар тушаалаар баталсан боловч өнөөдөр МСҮТ, Политехник коллежүүд 224 мэргэжлээр сургалт явуулж байна. Эдгээрээс 6 мэргэжилд харгалзах ажил мэргэжлийн лавлахыг Хөдөлмөрийн сайдын 2014 оны А119 дүгээр тушаалаар баталсан, 20 мэргэжилд харгалзах ажил мэргэжлийн лавлахыг холбогдох мэргэжлийн холбоод 2015 онд баталсан, мэргэжлийн боловсрол, сургалтын 15 стандартыг ХНХ-ын сайд баталж сургалтанд хэрэглэхийг зөвшөөрсөн байна. Ер нь ажил мэргэжлийн лавлах, мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт болон сургалтын хөтөлбөрийг цогцоор боловсруулах ажил хандивлагчдын дэмжлэгтэйгээр хийгдэж иржээ. Үүнд 2009-2012 онд МСС-ийн шугамаар 28 мэргэжлийн ЧСС-ын хөтөлбөр, МСС-ийн тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд МБСБ-ууд өөрсдөө боловсруулан хэрэглэж буй хөтөлбөрүүд, Оюу Толгойн санхүүжилттэйгээр үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд 17 мэргэжлийн ЧСС-ын хөтөлбөр боловсруулсан мэдээ байгаа бөгөөд эдгээрийн зарим нь хожим боловсруулсан лавлах, хөтөлбөртэй нэлээд давхцалтай байсан нь нэгдсэн зохицуулалт, мэдээлэл харилцааны болон холбогдох талуудын идэвхи оролцоо, мэргэжлийн чадамжаас ихэвчлэн хамаарсан байна. Тэрчлэн жишиг баримт бичгийг баталгаажуулсан байдал нь хуулийн зохицуулалттай зөрчилтэйн гадна хамарсан тоо нь хангалтгүй байгаа тул жишиг баримт бичгийн нэршлийг албан ёсоор оноож, МБСБ ашиглахад ойлгомжтой, давхцалгүй, хялбар бөгөөд ажлын байранд гарч буй өөрчлөлтийг шуурхай тусгах боломжийг хангасан уян хатан болгоход анхаарах шаардлагатай байна.

Чанарыг баталгаажуулах нь өөрсдийн үйл ажиллагаанд ахиц гаргах хэрэгсэл гэсэн ойлголт, байр суурь МБС-ын хүрээнд бэхжиж байна. Чанарын удирдлагын бусад үнэлгээ, сертификацийг авах санаачилга өргөжиж байна. Өмнөговь дахь Скиллстек МСҮТ чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015, Хөдөлмөрийн Эрүүл мэнд аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны OHSAS 18001:2007 стандартуудыг хэрэгжүүлж гэрчилгээ авсан, хоёр дахь жилийн магадлан хийлгэсэн бол Хэнтий аймгийн МСҮТ ISO 9001, Дорнодын политехник коллеж OHSAS198001:2007 стандартыг нэвтрүүлэх шатанд явж байв. Эдгээр нь МБС-ын салбарын хэмжээнд болон МБСБ-ын түвшинд боловсрол сургалтын стандартыг мэргэжлийн түвшинд боловсруулах, чанарын баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлэхэд шаардлагатай институц болон үндэсний мэргэжилтний чадавхи бүрдэж байгааг илтгэж байна.

## МБС-ын чанарын баталгаажууллын тогтолцоо бүрдүүлэхэд хандивлагчдын дэмжлэг

МБС-ын чанарын баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэгч хэсгүүдийг байгуулах бэхжүүлэх талаар сүүлийн жилүүдэд төр засаг, хөгжлийн түншүүд, ажил олгогч, мэргэжлийн холбоодын анхаарал, хүчин чармайлт идэвхижиж байна. Энэ чиглэлээр дараах үйл ажиллагаа хэрэгжжээ:

- ГХАН-ийн Түншлэлд суурилсан МБС (cooperative TVET буюу cTVET) төслийн хүрээнд 7 политехник коллежийн чадамжийн төвийн чанарын менежментийн чадавхид (Quality Management in Capacity Development Centers-CDCs) үнэлгээ хийх аргачлал боловсруулсан (2018-2019)
- ЕХ-ны ТМБССД-1 төслийн хүрээнд үндэсний мэргэшлийн хүрээ боловсруулах үзэл баримтлал, чанарын баталгаажуулалтын 6 үндсэн элемент бүхий үндэсний тогтолцооны концепцийг боловсруулж, бодлогын болон зохицуулалтын баримт бичгүүд боловсруулж, тэдгээрт суурилсан чадавхи бэхжүүлэх сургалт, хэлэлцүүлэг өргөн зохион байгуулсан (2014-2019)
- АХБ-ны санхүүжилттэй “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дэмжих төсөл”-ийн хүрээнд МБСБ өөрийгөө үнэлэх аргачлал боловсруулан 25 сургуульд туршсан (2016-2017)
- БМИҮЗ мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага, хөтөлбөрийг магадлан итгэмжлэх шалгуур, журмыг 2016 онд шинэчлэн баталсан
- Сингапурын Темасек сан, Политехник коллежтэй хамтран МБСБ-ын түвшинд чанарын тогтолцоо бүрдүүлэх аргачлал бүхий гарын авлагыг нийт сургуулийн удирдах ажилтнуудын оролцоотой боловсруулсан (2011), АНУ-ын МСС-гийн МБСын төслийн хүрээнд нийт сургуулийн удирдах ажилтныг чанарын удирдлагын сургалтанд хамруулсан (2008-2012).

МБСБ-ын хөтөлбөрийг боловсруулахад ажил олгогчид, мэргэжлийн холбоодыг оролцоог дэмжсэн хандивлагчдын санаачилга улам бүр өргөжиж байна. Тухайлбал, ГХАН-ийн дэмжлэгтэйгээр 12 МБСБ-д мэргэжлийн зөвлөл, 7 политехник коллежид чадамжийн төвийг томоохон үйлдвэр аж ахуйн газрын тэргүүлэх мэргэжилтнүүдийн оролцоотой байгуулсан, АХБ-ны Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төслийн хүрээнд 15 хүнийг ДАКУМ чиглүүлэгчээр сургаж ХАА, барилга, зам, тээврийн салбарын тэргүүлэх 15 мэргэжлээр АМЛ, МБС-ын стандарт, хөтөлбөр зэргийг боловсруулсан. Скиллстек МСҮТ австралийн Квинсландын ТАФЕ коллеж, Холмесглен институт, Skills Recognition International болон АТТС (Australian Trades Training College), Site Work Ready зэрэг байгууллагатай туршлага солилцож хамтран ажиллаж, тус МСҮТ-ийн 7 багш, Дорнодын политехник коллежийн 3 багш, ШУТИС-ийн МИС-ийн 1 багш австралийн TAFE TA IV (training and assessment certificate) олон улсад багшлах эрхийн гэрчилгээ авсан байна. Сингапурын Темасек сангийн төслийн хүрээнд 2013-2014 онд нийт МБСБ-ын удирдлагыг хамруулсан чанарын үнэлгээ, баталгаажуулалтын сургалтын дүнд ХЯ, БАЗТ, Политехник коллеж болон МСҮТ-үүдэд мэргэшсэн ажилтантай болж байжээ. АХБ-ны Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төслийн хүрээнд ХАА, барилга, зам, тээврийн 5 салбарын зөвлөлийг байгуулахад дэмжлэг үзүүлсэн байна. Эдгээр салбар зөвлөл нь сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн шаардлага,

техник, технологийн шинэчлэлд нийцүүлэх, үйлдвэрлэлийн дадлагын сургалтыг чанаржуулах, сургалтын болон аж ахуйн нэгж, байгууллага, инженер, техникийн ажилтан, багш, суралцагчийн хамтын ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх замаар төгсөгчийн мэргэшлийн ур чадварыг өндөржүүлэх, сургуулийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд зорилготой байв.

ЕХ-ны ТМБССД-1 төслийн хүрээнд чанарын баталгаажууллын чиглэлээр сүүлийн жилүүдэд хийгдсэн ажлын дүнд үндэслэн МБС-ын чанарын баталгаажууллын менежментийн тогтолцоо (ЧБМТ) нь тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэл, мэргэшлийг албажуулах (баталгаажуулах), сургалт ба суралцахуй, үнэлгээ ба нягтлал, гэрчилгээжүүлэл<sup>61</sup> гэсэн 6 үндсэн элементтэй байх төсөл бэлтгэсэн байна. Энэ ЧБМТ-ын загвар нь үндэсний хэмжээнд болон МБСБ-ын түвшинд мэдээлэл цуглуулж, түүнийг үнэлж, тайлагнах үйл явцыг тасралтгүй (үүнийг “нотолгоонд суурилсан бодлого боловсруулах” хэмээн нэрлэдэг) үйл ажиллагаа болгон хэрэгжүүлэхийг *Зураг 7-д* дүрсэлсэн бүдүүвчээр илэрхийлжээ.

**Зураг 7: МБС-ын чанарын баталгаажуулалтын менежментийн тогтолцооны үзэл баримтлал, хамрах хүрээ** (зөвлөхүүдийн санал болгосон төсөл)



Энэхүү санал болгож буй МБС-ын чанарын баталгаажууллын менежментийн тогтолцоог бүрдүүлсэнээр төрийн захиргааны болон зохицуулах чиг үүрэгтэй байгууллагууд шууд холбогдон харилцах нөхцөл бүрдэнэ гэж үзсэн байна. Энэ загварт тусгасан бүрэлдэхүүн хэсгүүдийг нэгбүрчлэн авч үзье:

<sup>61</sup> Кэйс Хамминк (2017). *МБС-ын чанарын баталгаажуулалт ба чанарын удирдлага: бодлого, журам*, Төсөл 1.2 Үйл ажиллагаа А 3.1.3 / А 1.4.3/А.1.4.1

1. Тусгай зөвшөөрөл нь МБС-ын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас МБС-ын үйл ажиллагаа эрхийг албан ёсоор баталгаажуулан зөвшөөрөл олгож буй одоогийн процесс юм. Энд Мэргэжлийн боловсрол, сургалтын ерөнхий шаардлагыг тодорхойлсон MNS 6541: 2015 стандартыг эхлэлийн шатанд хангуулах зорилготой захиргааны процесс болно. Энэ ерөнхий шаардлага нь сургалтын байгууллагад илүү чиглэсэн бөгөөд цаашид мэргэжлийн чиглэлээс хамааран тодорхой мэргэжлийн сургалтын стандартаар нарийвчлагддаг. Боловсролын хуулийн заалтын дагуу шинээр эхлүүлэх хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэлийг тусгай зөвшөөрөл олгох нөхцөл болговол энэ нь технологийн боловсролд илүүтэй хамаарах, харин мэргэжлийн боловсрол, мэргэжлийн сургалтын чадамжид суурилсан хөтөлбөрийг урьдчилан магадлан итгэмжлэх нь төдийлэн тохиромжтой биш болохыг өмнө өгүүлсэн.
  2. Магадлан итгэмжлэл нь үндэсний хэмжээнд тодорхойлж, хүлээн зөвшөөрсөн тодорхой стандартыг хангасан эсэхийг үнэлэх үйл явц гэж төсөлд тайлбарлажээ. Магадлан итгэмжлэлийн процесс нь МБС-ын салбарт 2006 оноос эхэлсэн бөгөөд 2016 онд магадлан итгэмжлэх шалгуур, процедурыг шинэчилсэний гадна магадлан итгэмжлэх эсэх шийдвэр гаргах нөхцөл, журмыг ч шинэчилсэн байна. 2009 оноос АРАСС-тай хамтарсан магадлан итгэмжлэх ажиллагааг 4 сургуульд хэрэгжүүлсэн туршлагыг ч тусгасан байна. Одоо тогтсон энэ процесс нь МБСБ-ын хувьд сайн дурын хүсэлтээр хийлгэж байгаа бөгөөд шалгуурыг МСҮТ, Политехник коллеж, техникийн болон мэргэжлийн хөтөлбөрт нэгэн адил тогтоосон байгаа болно. Мөн одоогийн практикаар магадлан итгэмжлэлийг сургалтын бүрэн мөчлөгийг дүүргэсэн сургалтын байгууллага, хөтөлбөрт хамааруулдаг нийтлэг зарчмыг мөрдөж байгаа юм. Магадлан итгэмжлэгдсэн статус нь улсын төсвөөс санхүүжилт авах эрхийг нээж байсан өмнөх үеийн зохицуулалт цаашид үргэлжилнэ гэсэн ойлголтоор сургуулиуд магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргаж байсан нь манай судалгаанд оролцсон сургуулийн төлөөллийн байр сууринаас харагдсан болно.
  3. Мэргэшлийг баталгаажуулах нь тодорхой сургалтын хөтөлбөрийг дүүргэсэн төгсгөгчийн эзэмшсэн байх мэргэшлийг түвшний тодорхойлолтыг албан ёсоор баталгаажуулах чухал бүрэлдэхүүн хэсэг болно. Өөрөөр хэлбэл, мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн хүрэх түвшнийг илэрхийлэх тул чанарын баталгаажуулалтын **зорилгыг нарийвчлан** тодорхойлж байгаа шат юм. Үүнийг гол төлөв **шинэ** мэргэшлийг нээх эрэлт хэрэгцээ хөдөлмөрийн зах зээл дээр байгааг нотлон харуулах зоилготой гэж төсөлд тайлбарлажээ. Энэ бүрэлдэхүүн хэсгийн тайлбарт тухайн мэргэшлийг баталгаажуулсаны дараа ҮМТШС-д хэрхэн харгалзахыг тогтоож, холбогдох хөтөлбөрийг магадлан итгэмжлэх боломжтой болно гэсэн нь дарааллын хувьд зөрчилтэй болсон байна. Зүй нь ҮМТШС нь мэргэшлийн шатлалыг ерөнхийд нь илэрхийлсэн харьцангуй тогвортой баримт бичиг тул мэргэжлийн шинэ чиглэлийг тусгасан нарийвчилсан мэрэгшил үүсгэх бүрт хөдөлгөөн оруулж байх боломжгүйн гадна энэ шинэ мэргэшлийг ҮМТШС-ны харгалзах түвшинд нийцүүлэн боловсруулах учиртай. Мэргэшлийг хэрэглэхийг албан ёсоор зөвшөөрч албажуулан баталгаажуулсаны дараа түүнд үндэслэн сургалтын хөтөлбөрийг боловсруулж, мэргэжлийн дүгнэлт гаргуулсан тусгай зөвшөөрөл авах учир энэ бүрэлдэхүүн хэсэг нь тусгай зөвшөөрлийн өмнө хийгдэх процесс болно. Чанарын баталгаажуулалтын тогтолцооны тодорхойлогч рольтой
-

энэ бүрэлдэхүүн хэсгийг манайд тусад нь мэтээр хандаж албан ёсны зохицуулалт хийлгүй явж ирсэнийг засах шаардлагатайг хүлээн авах ёстой юм.

4. Сургах ба суралцах хэмээн нэрлэсэн энэ бүрэлдэхүүн хэсэг мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын үндсэн процессийг илэрхийлж байна. Сургалтын эцсийн үр дүн (өөрөөр хэлбэл, суралцагчийн заавал эзэмших мэдлэг, **чадвар**)-д чиглэсэн процесс болгохыг онцолсон чадамжид суурилсан үзэл баримтлалыг энэ процессийг ЧБМТ-ны бүрэлдэхүүн хэсэг болгон тодорхойлсоны үндэслэл хэмээн тайлбарласан байна. ЧБМТ нь бүхэлдээ сургах, суралцах үндсэн процессийг бүх үе шатанд нь хянан шинжилж, шаардлагатай засвар өөрчлөлтийг тусгах замаар чанарын стандартыг хангуулах систем хэмээн хандвал энэхүү үндсэн процессийг өөрийг нь хянах, үнэлэх, дэмжих элементүүдтэй зэрэгцүүлэн тавих нь зохимжгүй юм.
5. Үнэлгээ, үнэлгээг шалгах хэмээн орчуулж нэрлэсэн энэ бүрэлдэхүүн хэсэг бол суралцагчийн гүйцэтгэлийг үнэн зөв үнэлэх процесс гэж тайлбарласан байна. МБС-ын чанарын удирдлагын тогтолцооны нэн чухал энэхүү элементийг системийн хэмжээнд хариуцах байгууллага – МБСҮТ-ийг 2016 онд байгуулсан байна. Гэхдээ энэ нь зөвхөн эцсийн шатанд хөндлөнгийн үнэлгээ хийх төдийгүй сургалтын явцад багш, сургуулийн хийх үнэлгээг ч хамруулсан байхаар тусгажээ. Эдгээр дотоод болон хөндлөнгийн үнэлгээ нь ижил зарчимд суурилсан, найдвартай, үнэн бодит, хэрэгжихүйц байх ёстой гэсэн үзэл баримтлал зүйтэй юм. Энэ үзэл баримтлалын дагуу чадамжийн үнэлгээний нэгдсэн стратеги болон практикийг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлого, удирдамжийг<sup>62</sup> олон улсын болон үндэсний зөвлөхүүд хамтран боловсруулсан байна. Ялангуяа үнэлгээнд хамрагдах хэрэгцээ нэмэгдэж, МСҮТ, Политехник коллеж, сургалтын төвөөр хязгаарлалгүй албан болон албан бус арга замаар эзэмшсэн олон өөр агуулга, түвшний ажилбар гүйцэтгэх мэдлэг, ур чадварыг үнэлж баталгаажуулах шаардлагатай болж байгаа тул үнэлгээг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх мэргэжилтэн, байгууллагын үйлчилгээг хүртээмжтэй болгох хэрэгтэй болж байна. Үүний тулд хөндлөнгийн үнэлгээг шаардлагын түвшинд гүйцэтгэх итгэмжлэгдсэн төв, цэгүүд үүсэх хэрэгцээ байгаа тул ийнхүү итгэмжлэгдсэн субъектийн үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлэх meta-evaluation буюу “шалгах үйл явц”-ын зохицуулалт бий болгох шаардлагатай болно.
6. Гэрчилгээжүүлэлт нь үндсэндээ мэргэжлийн үнэлгээ хийж, дүгнэлт гарсаны дараа түүнд үндэслэн холбогдох байгууллага, хувь хүнд дүнг гэрчилсэн баримт бичиг олгохыг хамрахаар тайлбарлажээ. Энэхүү гэрчилгээжүүлэлтийн талаар баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх удирдамжийг<sup>63</sup> үнэлгээний бодлого, удирдамжийг боловсруулсан баг мөн боловсруулж хэлэлцүүлсэн байна. Мэргэжлийн үнэмлэх, диплом, чадамжийн гэрчилгээг олгож буй практикийг цэгцэлж, **үнэн зөв, нягталж шалгасан үнэлгээ дүгнэлтэд** үндэслэн гэрчилгээнд бичсэн тодорхойлолт нь

---

<sup>62</sup> Берт Хофма, П. Оюунаа (2017). *МБС-ын чадамжийн үнэлгээ: бодлого, журам*, Үйл ажиллагаа А1.4.1 / А3.1.2; Берт Хофма, П. Оюунаа (2017). *МБС-ын чадамжийн үнэлгээ бодлогыг хэрэгжүүлэх удирдамж*, Төсөл 1.0, А1.4.1 / А3.1.2 үйл ажиллагаа

<sup>63</sup> Берт Хофма, П. Оюунаа (2017). *МБС-ын гэрчилгээжүүлэлт: бодлогын төсөл*, 1.0, А1.4.1 / А3.1.2 үйл ажиллагаа; Берт Хофма, П. Оюунаа (2017). *МБС-ын Гэрчилгээжүүлэлт: бодлогыг хэрэгжүүлэх удирдамж*, Төсөл 1.0, А1.4.1 / А3.1.2 үйл ажиллагаа

тухайн байгууллага, хувь хүний хийж гүйцэтгэж чадах зүйлийг илэрхийлж чадахуйц болгоход чиглэсэн энэ бодлогын баримт бичгийн ач холбогдол өндөр юм.

Энэхүү төсөлд тусгасан МБС-ын ЧБМТ-ны үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийн гүйцэтгэх үүрэг, хоорондын холбоог одоо чанарын баталгаажуулалтанд оролцож буй институт, механизмын хэрэгжүүлж буй үүрэг, үйл ажиллагааны практиктай харьцуулан үзвэл дараах зүйлст анхаарах хэрэгтэй болж байна. Үүнд:

*Нэгдүгээрт*, зөвлөхүүдийн санал болгож буй МБС-ын ЧБМТ-ны загварт тусгасан бүрэлдэхүүн хэсгүүд нь зайлшгүй бүрдүүлж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг хамарсан байна. Эдгээрийн зарим хэсгийг хариуцсан үндсэн чиг үүрэгтэй байгууллагыг байгуулан, чадавхийг бэхжүүлэхэд төр засаг, хөгжлийн түншүүдээс сүүлийн жилүүдэд ач холбогдол өгч олон хөтөлбөр төсөл хэрэгжүүлсэн, хэрэгжүүлж байна. Тухайлбал, сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллагаас олгоход холбогдох зохицуулалт 1990-ээд оноос хэвшиж байгаа, магадлан итгэмжлэлийн бие даасан байгууллага 1998 онд байгуулагдаж, МБСБ-ыг магадлан итгэмжлэх процесс 2002 оноос эхэлсэн, ур чадвар, чадамжийн үнэлгээ, гэрчилгээжүүлэлтийг мэргэжлийн түвшинд зохион байгуулах МБСҮТ 2016 онд байгуулагдсан байна. Сургалт, суралцахуйн процесс нь МБСБ-ын үндсэн функц бөгөөд тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хөндлөнгийн хяналт, үнэлгээний орчинд хэрэгжиж байна. Мэргэшлийг албажуулж баталгаажуулах процесс нь дээд түвшиндээ МБСҮЗ, түүний салбарын зөвлөлүүдийн хариуцах үүрэгт хамаарч байна. Энэ загварт тусгасан үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдэд хамаарах зорилго, үүргийг хэрэгжүүлэхэд холбогдох одоогийн зарим практик, тухайлбал, аттестатчилал, яамны үзлэг шалгалт, үр дүнгийн гэрээ, мэргэжлийн хяналтыг чанарын баталгаажуулалтын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг гэж үзэж үргэлжлүүлэх эсэхийг шийдэх шаардлагатай юм.

*Хоёрдугаарт*, хэдийгээр дээрх бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлсон нь чухал боловч системийн бүрдэл хэсэгт хамааруулах эсэхийг тодруулах хэрэгтэй байна. Тухайлбал, сургалт, суралцахуй нь өөрөө энэхүү чанарын баталгаажуулалтын үндсэн объект тул хөндлөнгийн үнэлгээ, хяналт, баталгаажуулалтыг хариуцсан бүрдэл хэсгүүдийн нэг байх боломжгүй юм. Мөн мэргэшлийг албажуулж, баталгаажуулах нь цаг хугацааны хувьд тусгай зөвшөөрөл өгөхийн өмнө хийгдэх бөгөөд үр дүн нь тусгай зөвшөөрөл олгоход болон үнэлгээ, хяналтын бүх шатанд референс болох ёстой. Суралцагчдын эзэмшсэн мэдлэг, ур чадвар, ажилбар гүйцэтгэх чадамжийг үнэлэх, түүний үндсэн дээр гэрчилгээжүүлсэн баримт бичиг олгох хэсгүүдийг энэ загварт салган бие даасан бүрэлдэхүүн хэсэг болгох шаардлагагүй байж болох юм.

*Гуравдугаарт*, энэхүү загварт дүрсэлсэн дараалал нь үйл явцын дарааллыг тусгаж чадаагүй байна. Зүй нь системийн үр дүнгийн эталон буюу мэргэшлийн түвшин, түүнд нийцүүлсэн мэргэжлийн стандартыг боловсруулж, баталгаажуулах нь эхлэлийн шат, эсвэл тусгай зөвшөөрөл олгохын урьдач нөхцөл болно. Магадлан итгэмжлэл нь одоо Монгол Улсад хэрэгжүүлж буй зарчмаар бол сургалтын байгууллага хөтөлбөрөө бүрэн мөчлөгөөр нь хэрэгжүүлсэний дараа үйл ажиллагааны процесст хийх үнэлгээ бөгөөд үндсэн шалгуур нь тухайн байгууллагын эрхэм зорилгын тодорхойлолт байдаг. Тэгээд ч МСҮТ, Политехник коллеж, мэргэжлийн сургалтын төв нь үйл ажиллагааны зорилго, цар хүрээ, зохион байгуулалтын хувьд өөр хоорондоо ялгаатай байдгийг харгалзан аль хэвхийн байгууллага, хөтөлбөрт магадлан итгэмжлэл хийх, хэрэв магадлан итгэмжлэл



шаардахгүй бол одоогийн аттестатчилал, мэргэжлийн хяналтын механизмыг хэрхэн хэрэглэхийг тусгах шаардлагатай байна.

*Дөрөвдүгээрт*, хэдийгээр энэхүү чанарын баталгаажуулалтын менежментийн тогтолцоонд харагдахгүй боловч мэргэжлийн сургалтын стандарт, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд мэргэжил, аргазүйн үндсэн түшиц байгууллага болж буй БАЗТ-үүдийн чиг үүрэг, статусыг тодотгон авч үзэх шаардлагатай байна. ЧСС-ын хөтөлбөр боловсруулах, энэ талаар багш нарт мэргэжлийн туслалцаа зөвлөмжөөр үйлчлэх чадавхи, нэр хүнд эдгээр төвд бий болсоныг бүрэн дүүрэн ашиглах, шаардлагатай дэмжлэг, зохицуулалт хийх хэрэгтэй байна.

*Тавдугаарт*, энэ загварт ерөнхийдээ системийн хэмжээний хөндлөнгийн тохируулга, хяналт, үнэлгээний процессийг тусгасан байна. Харин МБСБ-ын дотоод чанарын баталгаажууллын механизмыг энэхүү гадаад хөндлөнгийн механизмтай холбосон зохицуулалтыг анхаарах шаардлагатай. Түүнчлэн МБСБ-ууд чанарын удирдлагын сайн туршлага, олон улсын стандартыг эзэмших, мөрдөх талаар санаачлага гаргах нь нэмэгдэж байгааг тооцож, ийм хувилбараар чанарын удирдлагын соёл нэвтрүүлж байгаа практикийг хөндлөнгийн үнэлгээнд хүлээн зөвшөөрөх, тооцох зохицуулалт байвал зохилтой.

ЕХ-ны орнуудад нийтлэг жишиг болж байгаа МБС-ын ЧБНК нь олон улсын ISO серийн чанарын удирдлагын стандарт, чанарын иж бүрэн удирдлага – TQM-ийн үндсэн зарчмуудад суурилсан байдаг. Манай оронд чанарын менежментийн олон улсын **ISO 9001:2016** стандартыг үндэсний стандарт<sup>64</sup> болгосноос хойш энэхүү стандартыг байгууллагадаа нэвтрүүлэхэд мэргэжлийн зөвлөгөө өгч, үнэлгээ хийж баталгаажуулах эрх бүхий үндэсний компаниуд үйл ажиллагаагаа эхэлсэн байна. **Чанарын менежментийн тогтолцоо-Шаардлага MNS ISO 9001:2016** стандартыг нэвтрүүлснээр байгууллага дараах үр ашиг хүртэх боломжтой. Үүнд:

- a) хэрэглэгчийн шаардлагад нийцэж хэрэглэх боломжтой бүтээгдэхүүн, үйлчилгээг тууштай нийлүүлэх чадвар;
- b) хуулийн болон зохицуулалтын шаардлагад нийцсэн;
- c) хэрэглэгчийн шаардлагыг хангах боломжуудыг дэмжих;
- d) байгууллагын төлөв байдал, зорилтуудтай холбоотой эрсдэл ба боломжуудыг авч үзэх;
- e) чанарын менежментийн тогтолцооны тогтоосон шаардлагад тохирсон байдлыг харуулах чадвар.

Олон улсын энэхүү стандартад **Төлөвлө – Хэрэгжүүл – Үнэл – Сайжруул** (ТХҮС буюу PDCA) мөчлөг болон эрсдлийг бууруулах хандлагад суурилсан процессийн үнэлгээ шинжилгээний аргыг хэрэглэсэн байна.

Олон улсын стандартчиллын байгууллага ISO нь 2018 оны 5 дугаар сард боловсролын байгууллагын чанарын удирдлагын *ISO 21001:2018 Боловсролын байгууллага* —

---

<sup>64</sup> Стандартчилал, хэмжил зүйн газар (2016). *Чанарын менежментийн тогтолцоо-Шаардлага MNS ISO 9001:2016* (Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2016 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан)

*Боловсролын байгууллагын удирдлагын систем — Шаардлага, ашиглах заавар*<sup>65</sup> стандартыг албан ёсоор зарласан байна. Энэхүү стандарт нь ISO 9001 стандарттай нийцүүлсэн, боловсролын салбарт зориулсан бие даасан стандарт юм байна. Боловсролын байгууллагын менежментийн системд тохируулсан, суралцагч, бусад сонирхогч талуудад өгөх үр нөлөөг дээшлүүхэд чиглэсэн стандарт гэж тайлбарласан байна. Удирдлагын менежментийн ISO стандартуудын шаардлагатай нийцүүлсэн учраас нарийвчилсан бүтэц, үндсэн текст, нэр томъёонуудын тодорхойлолт нь адил бөгөөд чанарын менежментийн бусад стандарттай хослуулан хамтад нь хэрэглэх боломжтойгоор боловсруулжээ. Түүнчлэн бүс нутгийн, улс орнуудын үндэсний болон нээлттэй, арилжааны зориулалттай зэрэг бусад стандарт, чанарын протоколуудтай нийцүүлэн хэрэглэх бүрэн боломжтой гэж үзэж байгаа ажээ. Энэ шинэ стандартын хавсралтад Европын МБС-ын чанарын баталгаажуулалтын фрэймворк (European Quality Assurance Framework for Vocational Education and Training – EQAVET)-той хэрхэн нийцүүлж ашиглахыг харуулсан жишээ оруулжээ.

Нэгтгэн дүгнэвээс, МБС-ын ЧБМТ-ны загварт тусгасан бүрэлдэхүүн хэсэг тус бүр нь манай орны МБС-ын салбарт зайлшгүй байх үндсэн процессуудыг илэрхийлж байна. Эдгээр бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр олон улсын болон үндэсний зөвлөхүүд МБС-ын салбарын удирдлага, мэрэгжилтнүүдтэй хамтран боловсруулсан бодлого, удирдамж нь практик ач холбогдолтой байна. Гэхдээ эдгээр бүрэлдэхүүн хэсэг бүрээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг чанарын менежментийн түгээмэл тогтолцоо – PDCA мөчлөгт харгалзуулан, дараалал, хариуцан гүйцэтгэх субъектийг оноож, холбогдох зохицуулалтыг бүрэн болговол ЧБМТ-ны зорилтыг хэрэгжүүлэгч талуудад илүү ойлгомжтой, үр дүнтэй болно.

Монгол Улсын МБС-ын хүрээнд чанарыг баталгаажуулж буй өнөөгийн практик, эрхзүйн зохицуулалт, хандивлагчдын дэмжлэгтэй хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд сүүлийн жилүүдэд олон улсын болон үндэсний зөвлөхүүдийн боловсруулж санал болгосон чанарын баталгаажуулалтын тогтолцооны загвар, олон улсад өргөн хүрээнд хүлээн зөвшөөрч нийтлэг жишиг болгож буй ЕХ-ны ЧБНК-ийг харьцуулан шинжилсэний үндсэн дээр манай орны мэргэжлийн боловсрол, сургалтын хүрээнд чанарыг баталгаажуулах эрхзүйн зохицуулалтыг дараах хүснэгтэд үзүүлсэнээр тодотгон шинэчилбэл зохистой гэж үзэж байна (*Хүснэгт 14*).

---

<sup>65</sup> ISO 21001:2018 Educational Organizations — Management systems for educational organizations — Requirements with guidance for use [www.iso.org/obp/ui/#iso:std:iso:21001:ed-1:v1:en](http://www.iso.org/obp/ui/#iso:std:iso:21001:ed-1:v1:en)

**Хүснэгт 14: Монгол Улсын МБС-ын чанарыг баталгаажууллын үндсэн хэрэгсэл (шинэчлэх санал)**

Үе шат	Зорилго	Хэрэгсэл	Объект	Шалгуур	Үр дүн
Төлөвлөх	Үйл ажиллагааны эрх олгох	Тусгай зөвшөөрөл	МСҮТ, политехник коллеж	Сургалт, үйл ажиллагааны минимум стандарт	Статус, зөвшөөрөл, санхүүжилт
		Улсын бүртгэл	Мэргэжлийн сургалт		
		Урьдчилсан магадлан итгэмжлэл	Техникийн боловсролын хөтөлбөр	Чанарын стандарт	
Хэрэгжүүлэх	Миниум стандарт сахиулах	аттестатчилал	Мэргэжлийн сургалтын төв, МСҮТ	Чадамжийн стандарт	Нийцлийн дүгнэлт
	Гүйцэтгэлийн гэрээний чанарын зорилтыг хангуулах	Хяналт шинжилгээ	МСҮТ, политехник, сургалтын төв	Зорилтот түвшний үзүүлэлт	Биелэлтийн тухай дүгнэлт
	Чанар сайжруулах	Магадлан итгэмжлэл	политехник коллеж	Чанарын стандарт	албан ёсоор хүлээн зөвшөөрөх, санхүүжилт
Дүгнэх	Мэргэжлийн эрх олгох	Ур чадварын шалгалт	Чадамжийн модулийг эзэмшсэн иргэд	Яам, мэргэжлийн холбооноос тогтоосон стандарт	Үйл ажиллагаа эрхлэх эрх
	Хөтөлбөрийн үр дүнг дүгнэх	Улсын шалгалт	Техникийн болон мэргэжлийн боловсролын хөтөлбөрийг төгсгөгчид	Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн	Боловсролын диплом/үнэмлэх

Хүснэгт 14-д үзүүлсэнчлэн чанарыг баталгаажуулах нь чанарын хэмжүүр – мэргэшлийн түвшин, чадамжийн стандартыг тодорхойлохоос эхлэн түүнийг хэрэгжүүлсэний үр дүнг үнэлж, албажуулах хүртэл бүх үе шатыг хамарсан тус бүрд нь хариуцах субъектийн чиг эрх үүрэг, эрх хэмжээг тодорхойлсон тогтолцоо болно.

Үүнд эхлэлийн шатанд, мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагаанд техникийн боловсрол, мэргэжлийн боловсрол олгох сургалтыг эхлүүлэхэд тусгай зөвшөөрөл, харин мэргэжлийн сургалтыг эрхлэхэд бүртгэлээр зөвшөөрөл олгож буй одоогийн зохицуулалтын хүрээнд мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцан гүйцэтгэж байгааг хэвээр үргэлжлүүлэх нь зүйтэй хэмээн тусгасан болно. Чингэхдээ техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын стандартыг хуульд<sup>66</sup> нийцүүлэн баталгаажуулах, үүний тулд МБСҮЗ нь стандартыг боловсруулах үндэслэл болсон “улсын хэмжээнд мөрдөх ажил, мэргэжлийн үндэсний ангилал, тодорхойлолт, мэргэжлийн стандарт,

<sup>66</sup> Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 10 дугаар зүйл

мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгыг хэлэлцэж дүгнэлт гаргах” (*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6.3.4 дэх заалт*), “ажил олгогч болон салбар зөвлөлийн хамтарсан дүгнэлтийг үндэслэн мэргэшлийн түвшний хүрээ, ажил мэргэжлийн лавлах батлах” (*Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6.4.8 дахь заалт*) чиг үүргээ салбарын зөвлөлүүдийн хүчээр зохион байгуулж хэрэгжүүлэх шаардлагатай болно. Эдгээр агуулын стандарт, мэргэшлийн тодорхойлолт, ажил мэргэжлийн лавлах нь мэргэжлийн боловсрол, сургалтад хамааруулсан боловсрол, сургалтаас гадна коосен, их, дээд сургууль болон дээд боловсролын коллежийн хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд, ялангуяа дипломын дээд боловсрол, ерөнхий боловсролын сургуульд мэргэжлийн суурь болон үндсэн чадамжийг бүрэн болон хэсэгчлэн олгох сургалтыг зохион байгуулахад хамаарах жишиг хэмээн үзвэл зохилтой. Мөн мэргэжлийн сургалтын хөтөлбөр (модуль эсвэл чадамжийн нэгж гэсэн нэртэй байж болно) нь мэргэжлийн үндсэн чадамжийг үргэлжүүлэн тодорхой салбар, ажлын байранд богино хугацаанд хөрвөн ажил эрхлэхэд зориулсан агуулга, түвшинтэй байхыг анхааран үзэх хэрэгтэй. Чухам үүний дүнд иргэд насан туршдаа ур чадвараа байнга баяжуулан, гүнзгийрүүлж, ажил хөдөлмөр эрхлэн гүйцэтгэх чадамжаа сэлбэн шинэчилж байх боломж бүрдэнэ. Мэргэжлийн сургалтыг эрхлэх байгууллагын хүрээ ч ихээхэн өргөжих бөгөөд түүний хөтөлбөрийн үр дүнг үнэлэн шалгаж баталгаажуулах ажлын цар хүрээ, шуурхай байдлыг сайжруулах шаардлагатай болно.

МБС-ын үйл ажиллагааг хэрэгжүүлэх шатанд чанарын баталгаажуулалтын гол чиглэл нь албан ёсны тусгай зөвшөөрөл, бүртгэлийн үндсэн дээр энэ ажлыг байнга эрхэлж байгаа байгууллагуудад төвлөрнө. Техникийн болон мэргэжлийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэгч үндсэн байгууллага – Политехник коллеж, МСҮТ-ийн зэрэгцээ дипломын дээд боловсролын хөтөлбөр хэрэгжүүлж буй сургуулиуд (коосен, их, дээд сургууль, коллеж)-ад нэгэн адил зохицуулалт байвал зохино. Эдгээр сургууль, хөтөлбөрийг магадлан итгэмжлэлд 5 жилийн мөчлөгтэйгээр заавал хамруулах шаардлага тавибал улсын хэмжээнд нэгдмэл зохицуулалт болох юм. Мөн техникийн болон мэргэжлийн боловсролын хөтөлбөрийг эхлүүлэхэд дээд боловсролын хөтөлбөрийн нэгэн адил урьдчилсан магадлан итгэмжлэл хийлгэсний үндсэн дээр тусгай зөвшөөрөл олгох зохицуулалттай байвал зохимжтой. Ийнхүү магадлан итгэмжлэлийг заавал хийлгэх шаардлага болговол ерөнхийдөө ижил ажилбартай аттестатчиллыг эдгээр сургууль, хөтөлбөрт хэрэглэх шаардлагагүй болно. Магадлан итгэмжлэлийн ийнхүү заавал хийлгэх процедур болгох тохиолдолд БМИҮЗ-ийн үнэлгээ хийх чадавхийг бэхжүүлэх, хөтөлбөрийг магадлан итгэмжлэхэд МБСҮТ, түүний мэргэжлийн зөвлөлтэй хамтран ажиллаж, цаашдаа энэ чиг үүргийг үе шаттай шилжүүлэх чиглэл баримталбал зохимжтой.

Техникийн болон мэргэжлийн боловсролын хөтөлбөртэй сургуульд хувьсах зардал, суралцагчдад нь тэтгэлэгийг улсын төсвөөс санхүүжүүлэх зарчим үйлчилж байгаа нөхцөлд Төсвийн тухай хуулийн дагуу эдгээр сургалтын байгууллагын удирдлагатай байгуулах үр дүнгийн гэрээний зорилтот түвшинг чанарын үзүүлэлттэй холбож жил дутам үнэлэх нь хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын өөр нэгэн хувилбар гэж үзэх хэрэгтэй. Үүний учир үр дүнгийн гэрээний үзүүлэлтийг МБСҮЗ-ийн бодлого, чиглэлтэй нийцүүлэн сургуулийн Удирдах зөвлөл хэлэлцэн зөвшөөрөх, хэрэгжилтийн явц үр дүнд хэлэлцэн, дүгнэлтээ төсвийн ерөнхийлэн захирагчид албан ёсоор хүргүүлж байхаар журамлах шаардлагатай. Аттестатчиллыг мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хэлбэрээр бүртгэлээр зөвшөөрөл олгосон байгууллага нь хэрэгжүүлэх бөгөөд хөтөлбөрийн

агуулга цомхон, үргэлжлэх хугацаа богино, өөрчлөлт байнга хийгддэгийг харгалзан 2 жилээс илүүгүй хугацаанд аттестатчилж байвал зохино.

МБС-ын үр дүнг үнэлж, дүгнэх шатанд суралцагчдын эзэмшсэн мэдлэг, ур чадварыг үнэлж, баталгаажуулахаар одоо хэрэгжиж байгаа зохицуулалтыг үндсэнд нь үргэлжлүүлэх нь зүйтэй байна. ТМБ-ын хөтөлбөрийг амжилттай дүүргэсэн иргэдэд харгалзан мэргэжлийн диплом, мэргэжлийн үнэмлэхийг мэргэжлийн хараат бус экспертүүдийн оролцоотой байгуулсан улсын комиссын дүгнэлтэд үндэслэн сургууль нь олгож байхаар журамлаж болно. Энэ тохиолдолд Улсын шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага томилж байж болох байна. Харин ур чадварыг үнэлэх ажлыг ХНХСҮСИ (ур чадварын үнэлгээ хийх, гэрчилгээжүүлэх чиг үүргийг бие даасан, хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг харгалзан энэ нэгжийн статусыг эргэн нягтлах хэрэгтэй юм), түүний эрх олгосон (итгэмжилсэн) байгууллага гүйцэтгэж, чадамжийн гэрчилгээг ХНХСҮСИ нэгдсэн бүртгэлтэйгээр олгоно.

Олон улсын болон үндэсний зөвлөхүүдийн боловсруулсан МБС-ын ЧБМТ-ны загварт тусгасан бүрэлдэхүүн хэсэг тус бүр нь манай орны МБС-ын салбарт зайлшгүй байх чанарын баталгаажуулалтын үндсэн процессуудыг илэрхийлсэн гэж үзэж байна. Эдгээр бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр олон улсын болон үндэсний зөвлөхүүд МБС-ын салбарын удирдлага, мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулсан бодлого, удирдамж нь практик ач холбогдолтой байна. Гэхдээ чанарын удирдлагын нийтлэг загвартай харьцуулан, эдгээр бүрэлдэхүүн хэсэг бүрээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг чанарын менежментийн түгээмэл тогтолцоо – PDCA мөчлөгт харгалзуулан, дараалал, хариуцан гүйцэтгэх субъектийг оноож, холбогдох зохицуулалтыг бүрэн болговол ЧБМТ-ны зорилтыг хэрэгжүүлэгч талуудад илүү ойлгомжтой, үр дүнтэй болно.

## МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР, АРГАЗҮЙГ БОЛОВСРУУЛСАН НЬ

Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын үнэлгээний шалгуур, аргазүйг чанарын баталгаажууллын тойм шинжилгээнд үндэслэн боловсруулав. Энэхүү ажлыг дараах хоёр шаттайгаар гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Монгол Улсад мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг үнэлж буй өнөөгийн практикт дүн шинжилгээ хийх, үнэлгээний шалгуурыг тоймлон шинжлэх
- Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын үнэлгээний шалгуур, аргазүйг дараах гурван чиглэлээр боловсруулж холбогдох талуудын оролцоотой хэлэлцүүлж, одоо бэлтгэж буй эрх зүйн шинэчлэлийн үзэл баримтлалд нийцүүлэх:

о Мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээ

о Багшийн ажлын чанарын үнэлгээ

о Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын чанарын үнэлгээ.

Чанар, чанарын баталгаажууллын тухай өмнөх илтгэлд санал болгосон дараах тодорхойлолтод тулгуурлан мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх багш, сургалтын байгууллагад чанарыг үнэлэх шалгуур, аргазүйг боловсруулав.

**Чанар** – зорилгодоо нийцсэн байхын илэрхийлэл; сургалтын байгууллага, хөтөлбөрийн чиг үүрэг, үндсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх процессийг үр дүнтэй болгоход чиглэсэн, магадлан итгэмжлэх эсхүл чанарыг баталгаажуулах эрх бүхий бусад байгууллагаас тогтоосон, нийтээр хүлээн зөвшөөрсөн стандартыг хангах, түүнд нийцүүлэх нь чанарын илэрхийлэл болно.

**Чанарын баталгаажуулал** – боловсрол, сургалтын систем, байгууллага, түүний хөтөлбөрийн чанарыг хангах (орц, явц, үр дүнг шалган дүгнэх, хянан шинжлэх, баталгаажуулах, үйлчлэх, ахиулан сайжруулах)-ад чиглэсэн тасралтгүй үргэлжлэх процесс. Чанарын баталгаажуулал нь зохицуулах шинжтэй механизм учир сайтар боловсруулсан шалгуурыг ашиглан холбогдох талууд зөвшилцөн тохиролцсон процессоор дамжуулан мэдээлэл өгч, дүгнэлт гаргах замаар чанарын төлөөх хариуцлага, түүнийг сайжруулах чиглэлийг тогтооно.


Энд дурдаж буй нийтээр хүлээн зөвшөөрсөн стандартын эх сурвалж болох мэргэшлийн үндэсний хүрээ (“мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц”)-г одоогоор албан ёсоор хараахан баталгаажуулаагүй байна. Гэхдээ энэ чиглэлээр ажилласан судалгааны баг<sup>67</sup> Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөлийн 2011 оны 1 дүгээр тогтоолоор баталсан Мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэшлийн 6 түвшний загварыг ерөнхий суурь боловсролоос дипломын дээд боловсролын шатлалд харгалзуулахаар санал болгосон баримжаалан МБС-ын хөтөлбөрүүдийн суралцахуйн үр дүнг тодорхойлох боломжтой байна. Учир нь манай оронд техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын хөгжлийн явцад хэлбэршин тогтсон ойлголцол, үүнийг хөдөлмөрийн хуваарь, ажил мэргэжил, албан тушаалын ангилал болон бодлогын шийдвэр гаргах мэдээллийг бүрдүүлэх, боловсруулахад хэрэглэж хэвшсэн байдлыг тооцон үзэхээс аргагүй юм.

<sup>67</sup> БСШУСЯ (2020). Монгол Улсын мэргэшлийн үндэсний хүрээ, “Үндэсний мэргэшлийн хүрээг бий болгож дэмжлэг үзүүлэх” багийн үйл ажиллагааны тайлан

*Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагааг үнэлж буй өнөөгийн практикт дүн шинжилгээ хийх, үнэлгээний шалгуурын тойм шинжилгээ*

Монгол улсын МҮХ-ний үндсэн баримт бичгийг боловсруулах ажлын хэсгийг 2015 онд Хөдөлмөрийн сайдын тушаалаар ХЯ, БСШУЯ, Европын холбооны ТМБСДТ-1 төсөл, АХБ-ны ДБШТ-ийн ажилтнуудын бүрэлдэхүүнтэй байгуулж, Монгол Улсын хэмжээнд мөрдөх МҮХ боловсруулах даалгавартай ажиллуулжээ. Энэ ажлын хэсэг ажил олгогчид, мэргэжлийн холбоодын төлөөлөл хамтран Монгол Улсын МҮХ-ний 10 түвшинт загварыг боловсруулсан байна.

*Зураг 8. Мэргэшлийн үндэсний хүрээний 10 түвшинт хувилбарын дэлгэрэнгүй зураглал*



Эх сурвалж: Т.Амаржаргалан нар (2020). Мэргэшлийн үндэсний хүрээ MNQF, Улаанбаатар, х. 42.

*Зураг 9: Мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийн төсөл (Боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалыг танилцуулсан БШУЯ-ны танилцуулгаас авав)*



### МЭРГЭШЛИЙН ҮНДЭСНИЙ ШАТАЛСАН БҮТЭЦ

Түвшин	Түвшин тодорхойлогч	СОБ	Боловсролын түвшин, шатлал (ISCED 2011)						
			Ерөнхий боловсрол	Мэргэжлийн боловсрол, сургалт	Дээд боловсрол			Доктор	
					Диплом	Бакалавр	Магистр		
10	Төвөгтэй, урьдчилан таамаглах боломжгүй ноцлолд ажиллахад шаардлагатай мэдлэг, бүтээхтэй байдал, манлайллын ур чадвар шаардсан мэргэшлүүд.								Докторын
9	Мөн өндөр түвшний удирдлагын чиг үүрэг бүхий, нарийн мэргэжсэн мэдлэгт суурилсан мэргэжлийн (мэргэжсэн бусад ажилтны ажил үүргийн гүйцэтгэлийг бүрэн хариуцах) мэргэшлүүд.							Магистрын	
8	Удирдлагын чиг үүрэг бүхий, мэдлэгт суурилсан мэргэжлийн (хамт оны ажлын хүрэх үр дүнг тодорхойлох, үр дүнд хүрэх ажлыг удирдах) мэргэшлүүд.						Бакалаврын		
7	Удирдлагын хэргээр ажиллах чиг үүрэг бүхий, өндөр түвшний мэдлэг, чадвар (бусад ажилтны ажлыг удирдан, зохицуулах) шаардсан мэргэшлүүд.			Мэргэжлийн түвшин V-VI		Дипломны дээд боловсрол			
6	Нарийн ур чадвар (өөрийн ажил үүрэгтэй холбоотой гаргасан шийдвэрийнхээ хариуцлагыг хүлээх, өөрийн үйл ажиллагааг чиглүүлэх) шаардсан мэргэшлүүд.			Мэргэжлийн түвшин III-IV					
5	Ур чадвар/лагас ур чадвар шаардсан (сургалтад хамрагдаж бусдад байхгүй ур чадварыг эзэмшсэн, тухайлбал хариуцсан ажлын чанарын талаар үүрэг хүлээх гэх мэт) мэргэшлүүд.			Мэргэжлийн түвшин I-II					
4	Ажил хийх мэдлэг, ур чадвар (заварчлалыг дагах, зөвхөн хугацаанд ажлыг хийж дуусгах, удирдлагын шаталсан бүтэц ажиллах)-уудыг эзэмшсэн байх.			Бүрэн дунд боловсрол					
3	Ажил ороход шаардагдах мэдлэг, чадвар (оногдсон ажил, үүргийг гүйцэтгэх боломжтой арга замуудын талаар зохих хэмжээний ойлголттой, шүүмжлэг байр суурынаас ханддаг байх)-эзэмшсэн байх.			Суурь боловсрол					
2	Нийгмийн амьдралд оролцоход шаардлагатай амьдрах чадвар (харилцаа холбоо, мэдээллийн технологи, багаар ажиллах, асуудал шийдвэрлэх гэх мэт)-уудыг эзэмшсэн байх.			Бага боловсрол					
1	Өдөр тутмын амьдралд оролцох наад захын мэдлэг, чадвар (унших, бичих, тоолох, нийгмийн харилцааны суурь мэдлэг, чадварууд ...)-уудыг эзэмшсэн байх.	СОБ	Тухайн нийгэмд амьдрахтай холбоотой суурь чадваруудыг илэрхийлэх, Тухайлбал нийгмийн үйлчилгээнд хамрагдах, худалдаа хийх, мэдээлэл авах гэх мэт суурь чадварууд						

Хүснэгт 14. Мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэшлийн түвшний загвар

Шатлал	[Төгсгөгчийн] тодорхойлолт	Суралцах хэлбэр
VI	Ажлын талбарт хийгдэх мэргэжлийн үйл ажиллагааг нарийвчлан төлөвлөн технологийн дагуу ажил гүйцэтгэх дарааллыг тогтоож, нөөцийг үр дүнтэй тооцоолох, хуваарилах, байршуулах, бүтээлчээр зохион байгуулах, мэргэжлийн өндөр түвшинд удирдлагаар хангах, асуудалтай болон тодорхой бус нөхцөл байдал (төвөгтэй, судлагдаагүй) бий болсон тохиолдолд шинжлэх ухааны үндэстэй таамаг дүгнэлт дэвшүүлэх, шийдвэрлэх арга замыг тодорхойлох техник технологийн мэдлэг, ур чадвар, зөв арга барил хандлагыг эзэмшсэн байна.	Энэ түвшинг зохион байгуулалттай техник, технологийн боловсролын сургалтаар эзэмшүүлнэ.
V	Технологийн мэдлэг, мэргэжлийн ур чадвар шаардсан үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, бие даан гүйцэтгэх, ажлын зураг, төсөл гаргах, өртөг зардлыг тооцох, асуудалтай нөхцөл байдал бий болсон үед асуудлыг шийдвэрлэхэд оролцох онолын мэдлэг, мэргэжлийн ур чадвар, зөв арга барил, хандлагыг эзэмшсэн байна.	Энэ түвшинг зохион байгуулалттай техникийн боловсролын сургалтаар эзэмшүүлнэ.
IV	Мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардсан хүнд ажилбаруудыг бие даан гүйцэтгэх, холбогдох тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг бүрэн ашиглаж ажиллуулах, тодорхой ажилбарын хүрээнд бусдыг удирдан ажиллах,	Энэ түвшинг зохион байгуулалттай мэргэжлийн боловсролын

	дэмжлэг үзүүлэх, ажлын гүйцэтгэлийг үнэлэх мэргэжлийн мэдлэг, ур чадвар, зөв хандлагыг эзэмшсэн байна.	сургалтаар эзэмшүүлнэ.
III	Мэргэжлийн мэдлэг, ур чадвар шаардсан ажилбаруудыг бие даан гүйцэтгэх, хүнд ажилбаруудыг гүйцэтгэхэд бусдын удирдлага дор туслах үүргийг хүлээдэг, уг ажлыг гүйцэтгэхэд хэрэглэдэг суурилагдсан төхөөрөмж, багаж хэрэгслийг бүрэн эзэмшиж ашиглах мэдлэг, ур чадвар, хандлага эзэмшсэн байна.	Энэ түвшинг зохион байгуулалттай мэргэжлийн боловсролын сургалт болон ажлын талбарт суралцаж эзэмших боломжтой.
II	Мэргэжлийн суурь мэдлэг, ур чадвар шаардсан хязгаарлагдмал хүрээнд энгийн ажил үүрэг гүйцэтгэх чадвартай, мэргэжлийн үйл ажиллагаа нь зааварлагчийн шууд удирдлага дор тодорхой нөхцөлд хэрэгжих энгийн олон давтамжтай, нэг төрлийн ажил гүйцэтгэх мэргэжлийн ур чадвар эзэмшсэн байна.	Энэ түвшинг чадвар эзэмшүүлэх богино хугацааны сургалт, албан бус сургалтын хэлбэрээр болон ажлын талбарт эзэмших боломжтой.
I	Маш тодорхой нөхцөлд зааварлагчийн шууд удирдлага хяналтын дор энгийн, өдөр дутмын олон давтамжтай, хязгаарлагдмал ажилбаруудыг гүйцэтгэх ерөнхий суурь мэдлэг, ур чадвар эзэмшсэн байна.	Энэ түвшинг чадамж эзэмшүүлэх богино хугацааны сургалт, албан бус сургалтын хэлбэрээр болон ажлын талбарт эзэмших боломжтой.

МБСҮЗ-ийн 2011 оны 1 дүгээр тогтоолоор “энэхүү загвар, YAMAT-OT-д нийцүүлж, мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, хөтөлбөрийг боловсруулах ажлыг зохион байгуулах, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажил олгогч, мэргэжлийн холбоодтой хамтран баталгаажуулж мөрдүүлэхийг” тухайн үед ажиллаж байсан Мэргэжлийн боловсрол, сургалтын газарт хариуцуулж, хэрэгжилтийг хагас жил дутам МБСҮЗ-д танилцуулж байхыг үүрэг болгожээ. Мэргэжлийн боловсрол, сургалтын газрыг 2012 онд татан буулгаснаас хойш мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, хөтөлбөрийг боловсруулахад Бүсийн арга зүйн төвүүд<sup>68</sup> аргазүйн удирдамж чиглэлээр хангах ажлыг хариуцан хэрэгжүүлж, харин дээрх тогтоолын хэрэгжилтийг бүхэлд нь нэгтгэн дүгнэж МБСҮЗ-д тайлагнах ажил хийгдээгүй байна. энэ үүрэг одоо шинээр байгуулагдсан Боловсролын ерөнхий газарт албан ёсоор шилжих эсэх, энэ загварын эхний шатлалуудад харгалзах мэдлэг, ур чадвар, чадамжийг эзэмшүүлэх ажлыг боловсролын болон мэргэжлийн сургалтын байгууллагуудад хэрхэн харьяалуулж хэрэгжүүлэх асуудлыг шинээр хэлэлцүүлж буй боловсролын хууль тогтоомжид тодорхой тусгах хэрэгтэй байна. Мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрийг боловсруулах анхдагч эх сурвалж-удирдамж нь *Мэргэшлийн үндэсний хүрээ* (National Qualifications Framework)-нд эдгээр хөтөлбөрт харгалзах суралцахуйн үр дүнг мэргэшлийн аль түвшинд харгалзуулан тодорхойлох

<sup>68</sup> Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль: “8.5. Мэргэжлийн боловсрол, сургалтын бүсийн арга зүйн төв нь мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгын хэрэгжилтийг хангах, чадамжийн сан бүрдүүлэх, багшийг чадваржуулах, хөгжүүлэх, сургалт, судалгаа эрхлэх чиг үүрэгтэй байна.”

ёстой. Гэтэл энэхүү Мэргэшлийн үндэсний хүрээ гэдэгт юуг хамруулан ойлгож хэрэглэхийг өнөөгийн хууль тогтоомж, албан ёсны баримт бичигт өөр өөрөөр тодорхойлсоныг дараах жишээнээс харж болно:

а) Хөдөлмөрийн тухай хуульд мэргэшлийн үндэсний хүрээ нь ажил мэргэжлийн үндэсний ангилал, тодорхойлолт, ажил мэргэжлийн стандартыг батлах, мэргэшлийн түвшнийг тогтоон хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах үйл явц хэмээн тодорхойлсон нь чанарыг баталгаажуулах цогц үйл ажиллагааг бүхэлд нь хамарсан утгатай байна:

#### **17 дугаар зүйл. Мэргэшлийн үндэсний хүрээ**

- 17.1. Ажил мэргэжлийн үндэсний ангилал, тодорхойлолт, ажил мэргэжлийн стандартыг батлах, мэргэшлийн түвшнийг тогтоон хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах үйл явц мэргэшлийн үндэсний хүрээнд хамаарна.
- 17.2. Ажил мэргэжлийн стандартыг батлах, боловсрол, сургалтын үр дүн, мэргэшлийн түвшний уялдааг тодорхойлох, үнэлж баталгаажуулах, түвшин хооронд шилжих зохицуулалтыг хуулиар тогтооно.
- 17.3. Мэргэшлийн үндэсний хүрээг бүрдүүлэх, зохицуулах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ажил олгогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллага болон мэргэжлийн холбоодын саналыг үндэслэн Засгийн газар батална.
- 17.4. Хүний мэргэшлийн түвшнийг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах журмыг хөдөлмөрийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.
- 17.5. Ажил олгогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллага болон мэргэжлийн холбоод хамтран ажил мэргэжлийн стандартыг боловсруулна.
- 17.6. Ажил мэргэжлийн стандартаар хөдөлмөрийн нөхцөл, ажилтны ажлын дадлага, туршлага, мэдлэг, ур чадвар, чадамж, хандлага, мэргэшлийн түвшин, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тогтооно.
- 17.7. Ажил мэргэжлийн үндэсний ангилал, тодорхойлолтыг ажил олгогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллага болон мэргэжлийн холбоодын саналыг үндэслэн тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

б) Алсын хараа – 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх 2021-2030 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд “мэргэшлийн үндэсний хүрээг тогтоож, хэрэгжүүлэх” үүргийг “төрөөс хараат бус” Хүний нөөцийн бодлогын үндэсний зөвлөлд хариуцуулсан нь мэргэшлийн үндэсний хүрээ бол мэргэшлийн түвшнийг ангилан тодорхойлсон баримт бичиг байх агуулгыг илэрхийлж байна:

2.1.6. Төрөөс хараат бус бие даасан хүний нөөцийн бодлогын үндэсний зөвлөл байгуулан салбар бүрийн мэргэжлийн холбоодтой хамтран мэргэшлийн үндэсний хүрээг тогтоож, хэрэгжүүлэх...

с) Засгийн газраас УИХ-д өргөн барьсан Боловсролын ерөнхий хуулийн төсөлд мэргэшлийн үндэсний хүрээг “мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц” хэмээн нэрлэж, чанарын баталгаажууллын үйл ажиллагаа гэх агуулгатай тодорхойлсон байна:

3.1.16. “мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц” гэж иргэний эзэмшсэн мэдлэг, чадвар, төлөвшлийг ангилан төрөлжүүлэх, түвшнээр нь эрэмбэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах үйл ажиллагааны нэгдлийг;

д) Боловсрол, шинжлэх ухааны яамнаас эрхлэн хэвлүүлсэн *Дээд боловсролын нэр томъёоны монгол-англи-орос тайлбар тольд* “Мэргэшлийн үндэсний хүрээ” нь бодлогын баримт бичиг хэмээн тодорхойлжээ:

Мэргэшлийн үндэсний хүрээ (шаталсан бүтэц) National qualifications framework Үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрсөн нийтлэг стандарт, мэргэшлийг тогтоох, эзэмшсэн мэдлэг болон чадамжийг хүлээн зөвшөөрөх, одоо байгаа болон цаашид гарч ирэх мэргэшлийг тодорхойлох, хөгжүүлэх, үнэлэхэд чиглэсэн бодлогын баримт бичиг. Энэхүү баримт бичиг нь сургалтын хөтөлбөрийн өөрчлөлтийг зохицуулж, хувьсан өөрчлөгдөж буй нийгмийн хэрэгцээ шаардлага, хөгжлийг дэмжих зорилготой. Дунд хугацааны бодлого боловсруулалтын түвшинд олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнд үндэсний мэргэшлийн хүрээ (шаталсан бүтэц)-г боловсруулдаг. Европын дээд боловсролын талбар дах улс орнууд мэргэшлийн үндэсний хүрээгээ боловсруулахдаа Европын мэргэшлийн хүрээг жишиг болгон авч, бодлогодоо нийцүүлэн ашиглаж байна. Түүнчлэн Азийн мэргэшлийн хүрээ, Австралийн мэргэшлийн хүрээ гэх зэргээр бүс нутгийн шинжтэй байдаг. (UNESCO-CEPES, 2007)

е) ХНХЯ-наас эрхлэн хэвлүүлсэн *Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын нэр томъёоны монгол-англи тайлбар тольд* мэргэшлийн үндэсний хүрээг “арга хэрэгсэл” гэж тодорхойлжээ:

Мэргэшлийн үндэсний хүрээ: Хүлээн зөвшөөрөгдсөн түвшингүүдэд нийцүүлэн ур чадвар, мэдлэг, чадамжийг боловсруулах, ангилах, баталгаажуулах арга хэрэгсэл. Энэ нь урьд нь эзэмшсэн болон сургалтын үр дүнд шинээр эзэмших мэргэшлүүдийг шатлан ангилж, бүтэцжүүлэх арга зам бөгөөд өөрөөр хэлбэл анги танхим, ажлын байранд, эсвэл албан бус хэлбэрээр сурснаас үл хамааран суралцагч юу мэдэх ёстой, юу хийж чадах ёстойг тодорхой заасан мэдээллийг агуулна. Мэргэшлийн түвшний хүрээ нь янз бүрийн мэргэшлүүдийг хооронд нь харьцуулах, нэг мэргэжил, үйлдвэрлэлийн салбар дотор болон мэргэжил, салбаруудын хооронд нэг түвшнээс нөгөө түвшинд хэрхэн шилжиж, дэвшиж болохыг тодорхойлно. (хэрэв тухайн МТХ-нд мэргэжлийн болон академик мэргэшлүүд аль нь багтсан бол мэргэжлийн болон академик мэргэшлүүдийн хооронд шилжих боломж байдаг). Эх сурвалж: ОУХБ (SED), 2007, Женев

Ийнхүү албан ёсны болон мэргэжлийн лавлах болох баримт бичгүүдэд өөр өөр агуулга утгатай тодорхойлсоныг нэг мөр ойлгож хэрэглэхээр албажуулах шаардлагатай байна. Түүнчлэн мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрийг боловсруулахад удирдамж болгох үндсэн баримт бичгүүд нь Ажил мэргэжлийн стандарт, Мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт болно. Ажил мэргэжлийн стандарт, хүний хөгжлийн хүрээлэн ТББ-аас ирүүлсэн мэдээгээр 2014 оноос мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд МБС-иар бэлтгэж буй 99 мэргэжилд харгалзах “ажил мэргэжлийн лавлах”-ыг боловсруулж Хөдөлмөрийн сайдын тушаал болон МБС-ын үндэсний зөвлөлийн тогтоолоор батлан мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөр боловсруулах үндсэн удирдамж баримт бичгийн хэмжээнд мөрдүүлж байна. Харин Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг мөрдөж эхэлсэнээр ажил мэргэжлийн лавлахыг “ажил мэргэжлийн стандарт” болгон харгалзах ажилтны мэргэшлийн түвшин, гүйцэтгэх ажилбарыг илүү нарийвчлан тодорхойлсон баримт бичиг байхаар шинэчлэн боловсруулж байна:

**Ажил мэргэжлийн стандарт** (Хөдөлмөрийн тухай хуулийн 103.2.3 дахь хэсгийг үндэслэн Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор баталсан “Ажил мэргэжлийн стандарт боловсруулах аргачлал”):

4. Ажил мэргэжлийн стандартыг дараах чиглэлээр хэрэглэнэ. Үүнд:

- YAMAT-08 шинэчлэх сайжруулах
- Ажлын байрны тодохойлолт боловсруулах
- Мэргэшлийн үндэсний хүрээнд байрших мэргэшлийн түвшинг тогтоох
- Ажил, мэргэжлийн үндсэн хэв шинж тогтоох
- Ажил мэргэжлийн ур чадварын матриц буюу үүрэг, ажилбарын зураглал гаргах

- Чадамжийн нэгжийн жагсаалт, мэргэшлийн түвшин бүрт байрших чадамжийн багцыг тодорхойлох
- Чадамжийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулах
- Сургалтын хэрэгцээг тодорхойлох
- Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах
- Мэргэжлийн чадамжийн үнэлгээ хийх
- Гүйцэтгэлд суурилсан цалин хөлсийг тооцох
- Хөдөлмөрийн бүтээмж, нормыг тогтоох
- Ажлын байрны эрсдлийн өөрийн үнэлгээг гаргах гэх мэт.

3.2.2. Ажил мэргэжлийн дүн шинжилгээ, үүрэг, ажилбарын бүдүүвч зураглал, ур чадварын матриц боловсруулах үйл ажиллагааг эрх бүхий чиглүүлэгч гүйцэтгэнэ.

3.2.3. Чадамжийн нэгж үүсгэх, чадамжийн нэгжийг багцлах, мэргэшлийн түвшинд байршуулахыг эрх бүхий хөтөлбөр хөгжүүлэгч гүйцэтгэнэ.

3.2.4. Тухайн мэргэжилд хамаарах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, материалын жагсаалтыг чухлын зэрэг, аюулын зэрэг, хэрэглээний давтамжийн зэрэг, аюулын зэргийг тодорхойлж гаргасан байна.

3.2.5. Ажил мэргэжлийн стандартад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой чадамжийн нэгжийг заавал тусгах ба нийтлэг болон үндсэн чадамжийн нэгж тус бүрт салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой онцлог агуулгыг тусгасан байна.

3.2.6. Чадамжийн нэгж дэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага бүхий өндөр эрсдэлтэй алхмыг эрх бүхий мэргэшүүлэх сургалтанд хамарагдсан ажилтан гүйцэтгэнэ.

4.1. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл нь ажил мэргэжлийн стандарт боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах, салбар зөвлөлөөс ирүүлсэн ажил мэргэжлийн стандартын бүрдлийг хянан батална.

4.2. Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл нь салбарын хөгжлийн бодлого, хүний нөөцийн төлөвлөлт, эрэлт хэрэгцээнд үндэслэн ажил мэргэжлийн стандартын хэрэгцээг тодорхойлох, боловсруулсан стандартад хөндлөнгийн дүгнэлт гаргах, үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулах ажлыг хариуцна.

4.3. Ажил олгогч, мэргэжлийн холбоод нь ажил мэргэжлийн стандарт боловсруулах, нэгдсэн санг баяжуулах, түгээх сурталчлах ажлыг хариуцна.

Өмнөх тойм шинжилгээнд үндэслэн мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх байгууллага, багшийн үйл ажиллагааны чанарыг үнэлэх шалгуур, аргагүйг дараах байдлаар шинэчлэх саналыг бэлтгэв. Энэхүү саналыг бэлтгэхдээ одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, эрх бүхий байгууллагын баталсан дүрэм журмын зохицуулалт, УИХ-д өргөн бариад буй хуулийн төслүүдийн холбогдох заалтын утга агуулгыг тусгаж, Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл, Боловсролын ерөнхий газар, Боловсролын үнэлгээний төв, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн ажилтнуудад танилцуулж хэлэлцүүлсэн болно.

МБСБ-ын үйл ажиллагааны чанарын үнэлгээний шалгуур шаардлагыг тодорхойлсон дараах баримт бичиг өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байна. Үүнд:

- *MNS 6541: 2015 Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага стандарт* Стандартчиллын Үндэсний зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 45 дугаар тогтоолоор улсын хэмжээнд хэрэглэх заавал мөрдөх үндэсний стандарт

- *Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд тавих шаардлага, загвар* (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн А/104 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт)
- *Техникийн боловсрол, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн загвар, шаардлага, загварыг ашиглах зөвлөмж* (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн А/134 дүгээр тушаалын нэг, хоёр, гуравдугаар хавсралт)
- *Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журам* (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн А/97, А/231 дүгээр хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт)
- *Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага* (Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2019 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 5 дугаар тогтоолын хавсралт)
- *Мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага* (Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2016 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 1 дүгээр тогтоолын хавсралт)
- *Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч, мэргэжлийн ур чадвар эзэмшсэн иргэний мэргэшлийн түвшинг үнэлэх, үнэлгээг баталгаажуулах, хөндлөнгийн шалгалт зохион байгуулах журам* (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн А/50 дугаар тушаалын хавсралт)
- *Суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлэх, дүгнэх журам* (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн А/506, А/266 дугаар хамтарсан тушаалын хавсралт)
- *Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг аттестатчилах журам, Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын аттестатчиллын шалгуур үзүүлэлт* (Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2012 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 130 дугаар тушаалын нэг, хоёрдугаар хавсралт)
- *Ажил мэргэжлийн лавлах: Техник мэргэжлийн боловсрол. Техник мэргэжлийн боловсролын багш* (Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөлийн 2020 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны 1 дүгээр тогтоол)

Мэргэжлийн сургалт, мэргэжлийн боловсрол, техникийн боловсролын хөтөлбөр нь мэргэшүүлэх чадамжийг шатлан олгох зориулалттай болохыг илэрхийлсэн *Мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэшлийн 6 түвшний загварыг* МБСҮЗ 2011 онд баталж, сургалтын хөтөлбөрийг боловсруулах баримт бичгүүдэд энэ байр суурьнаас зохицуулалт хийсэн заалтыг тусгажээ. Эдгээрээс мэргэжлийн боловсрол, мэргэжлийн сургалтын хөтөлбөр нь чадамжид суурилсан<sup>69</sup> бүтэцтэй, харин техникийн боловсролын хөтөлбөр нь багц цагаар<sup>70</sup> зохион байгуулсан дээд боловсролын хөтөлбөрийн бүтэцтэй. Элсэгчдийн боловсрол, мэдлэг, ур чадвараас хамааран суралцах хугацааг 1.5-2 жилийн зөрөөтэй байхаар тогтоосон байна. Мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэшлийн эхний 2 түвшинд харгалзах мэдлэг, ур чадвар, ялангуяа бусадтай харилцах, багаар ажиллах, хариуцлага хүлээх зэрэг ажил олгогчдын зүгээс ихээхэн онцолж буй зөөлөн ур чадвар-хандлагыг эзэмшүүлж төлөвшүүлэхэд ерөнхий боловсрол (суурь боловсрол), албан бус боловсролын институцийн үүрэг роль, чиг үүргийг одоо хэлэлцүүлж буй боловсролын хууль тогтоомжид тодорхой болгох хэрэгтэй байна.

<sup>69</sup> Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн 9.1, 9.4 дэх заалт

<sup>70</sup> Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн 9.2, 9.5 дахь заалт

Мэргэжлийн боловсрол нь техникийн боловсролын өмнөх шатлал хэмээн нэг утгатай тодорхойлох боломжгүйг *Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад бэлтгэх мэргэжлийн чиглэл, индекс* (Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2016 оны А/150 дугаар тушаал)-ийн жишээнээс харж болохоор байна. Тухайлбал, эдгээр мэргэжлийн чиглэл, индексийн цөөнгүй хэсгийг албан тушаалаар оноож нэрлэсэн, ажилтан өөрөө гардан гүйцэтгэдэг зураач, барималч, жүжигчин, дуучны мэргэшлийг техникийн боловсрол (V-VI түвшин)-д хамааруулсан атал техникчийн түвшний зарим оператор, механикчдийг мэргэжлийн боловсрол (III-IV түвшин)-д хамаатуулсан байна. Мэргэжлийн боловсролыг чадамжид суурилсан модулийн бүтэцтэй бөгөөд суралцагчид өөрсдийн сонирхол, хэрэгцээний дагуу чадамжийн нэгжээс сонгон суралцаж, богино хугацаанд мэдлэг, ур чадвараа сэлбэн хөрвөх насан туршийн боловсролын хэрэгцээнд үйлчлэх уян хатан чанартай байх нөхцлийг тооцож анги-бүлгийн когорт системээс өөрчлөх хэрэгтэй болно. Нөгөө талаас, мэргэжлийн сургалтын энэ зорилгод үйлчлэх өндөр түвшний нарийн төвөгшилтэй мэдлэг, ур чадвар эзэмших эрэлт хэрэгцээнд чиглэсэн модул нь түвшний хувьд техникийн боловсролтой ч дүйх боломжтойг тооцох хэрэгтэй юм.

Монгол Улсад мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааны чанарын үнэлэх, баталгаажуулахад баримталж буй шалгуур шаардлага, аргагүй:

Монгол Улсын *Үндэсний Ажил, Мэргэжлийн Ангилал ба Тодорхойлолт* YAMAT-08 (ISCO – 08) (Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 16 дугаар тушаал)

Олон улсын Ажил, мэргэжлийн Стандарт Ангилал-08 (ISCO-08)-тай нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын Үндэсний Ажил, Мэргэжлийн Ангилал, Тодорхойлолт-08 (“YAMAT-08”)-ын нэг гол зорилго бол мэргэшсэн ажиллах хүчнийг олон улсын зөвшөөрөгдөх түвшинд бэлтгэх үндсэн лавлахын хэмжээнд ажил мэргэжлийг ангилан тодорхойлсон явдал юм. Ийнхүү “YAMAT-08”-ын 3-8 дугаар үндсэн бүлэгт 277 нэгж бүлгийн мэргэжлийн болон техникийн боловсрол шаардах ажил, мэргэжлийг тодорхойлжээ. Үүнд үндэслэн МБС-ын хөтөлбөрт харгалзах ажил мэргэжлийн лавлахыг боловсруулах ажлыг 2014-2021 онд хандивлагчдын дэмжлэгтэйгээр зохион байгуулж МБСУЗ баталж байсан бол 2022 оноос Хөдөлмөрийн тухай хуулийн шинэ зохицуулалтаар “ажил мэргэжлийн стандарт” болгон АМСХХХ ТББ ахлан мэргэжлийн зөвлөлийн оролцоотойгоор боловсруулж буй. Одоогоор 16 стандартын төсөл бэлтгэгдсэн. Эдгээр ажил мэргэжлийн лавлах, стандарт боловсруулах ажлыг хүрээнд мэргэжлийн зөвлөлүүдийн оролцоо, энэ чиглэлээр мэргэшсэн сургагч, шинжээч, үнэлээч нарыг бэлтгэхэд ихээхэн ахиц гарчээ. Мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадвар, чадамжийг ажил мэргэжлийн үүрэгтэй холбон хэрэглэх зориулалт, төвөгшлийн зэргээр 6 түвшинд ангилсан *Мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэшлийн түвшний загвар* (Мэргэжлийн боловсрол сургалтын үндэсний зөвлөлийн 2011 оны 1 дүгээр тогтоол) нь мэргэшлийн үндэсний хүрээг мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын хувьд тодорхойлсон баримт бичиг хэмээн үзэж болно. Эдгээр баримт бичигт үндэслэн Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад бэлтгэх мэргэжлийн чиглэл, индекс (Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2016 оны А/150 дугаар тушаал)-ийг батлан МБС-ын хөтөлбөрийг боловсруулах, батламжлах үндэслэл болгож байна.

*MNS 6541:2015. Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага* улсын стандарт (Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 45 дугаар тогтоолоор баталсан улсын хэмжээнд хэрэглэх заавал мөрдөх үндэсний стандарт)



Мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрийг боловсруулах, үнэлж дүгнэх, эдгээр хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрхлэх байгууллага, түүний үйл ажиллагаанд тавих нийтлэг шаардлага, зохион байгуулалтыг тодорхойлсон баримт бичиг. Энэ нь заавал мөрдөх үндэсний стандарт бөгөөд чанарын иж бүрэн удирдлага (Total Quality Management – TQM)-ын үзэл баримтлал, зарчимтай төстэй зохицуулалтыг тусгасан байна. Иймд зарим сургуулийн санаачлан нэвтрүүлж буй “MNS ISO 9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо-Шаардлага” стандартыг байгууллагын түвшний чанарын үнэлгээнд адилтган тооцох нөхцлийг анхаарч үзвэл зохино. Ялангуяа боловсролын байгууллагад зориулан боловсруулж санал болгож буй “MNS ISO 21001:2021 Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо: Шаардлага, хэрэглэх аргазүйн заавар” стандартыг нэвтрүүлэх санаачлагыг урамшуулан дэмжих албан ёсны зохицуулалт шаардлагатай.

*Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд тавих шаардлага, загвар (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/104 дүгээр тушаал)*

Мэргэжлийн болон техникийн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрхлэх байгууллагад “MNS 6541:2015. Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага” улсын стандартын шалгуур шаардлагыг хангуулах зорилготой зохицуулалтыг тусгасан. Ийнхүү зөвшөөрөл олгоход тавьж буй үндсэн шаардлага нь МСҮТ-ийг байгуулахад тавих шаардлагын агуулгатай, харин политехник коллеж ангилалд хамаарах сургалтын байгууллага үүсгэн байгуулах бол өмнө нь МСҮТ хэлбэрээр ажиллаж байсан туршлага шаардлагатай болно. Сургалт эрхлэх чиглэлээр МБС-ын хөтөлбөрийг бэлтгэн харъяалах БАЗТ-өөр үнэлгээ хийлгэж эерэг дүгнэлт гаргуулсан байхын гадна байгууллагын тогтвортой ажиллах удирдлага, хөрөнгө, санхүүгийн баталгаа бүрдүүлэхийг шаардана. Техникийн боловсролын хөтөлбөрийг эхлүүлэхийн өмнө БМИҮЗ-өөр урьдчилсан магадлан итгэмжлэл хийлгэсэн байх хуулийн заалт одоогоор бүрэн хэрэгжээгүй байна.

*Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журам (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А97/А231 дүгээр хамтарсан тушаал)*

Мэргэжлийн богино хугацааны (“мэргэжлийн анхан шатны”, “түр”, “хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” гэсэн нэртэйгээр төвөгшил багатай, энгийн ажил мэргэжилд бэлтгэх сургалт гэж хандах нь нийтлэг) сургалтыг дагнан эрхлэх байгууллагад зөвшөөрөл олгох харилцааг зохицуулсан. Бие даасан хуулийн этгээдэд хамаарах энэ зохицуулалтад цаашид аж ахуйн нэгж, байгууллагын бүрэлдэхүүн, харъяалалд ажиллах мэргэшлийн өндөр түвшний чадамж эзэмшүүлэх сургалтын модулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хамруулан Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн шинэчлэх асуудлыг одоо УИХ-аар хэлэлцэж буй боловсролын тухай хуулиудын шинэчилсэн найруулгад тусгах шаардлагатай.

*Техникийн боловсрол, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн загвар, тэдгээрт тавигдах шаардлага (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/134 дүгээр тушаалын нэг, хоёрдугаар хавсралт)*

Техникийн боловсролыг илүү нарийвчлан тодорхойлж, мэргэжлийн боловсролоос ялгагдах онцлогийг тодотгон хөтөлбөрийг шинэчлэх шаардлагад тусгах хэрэгтэй байна. Адилтгах түвшний техникийн коосений хөтөлбөрийн агуулгатай харьцуулах, ижил

мэргэжлийн дээд боловсролын хөтөлбөртэй зохистой уялдуулах хэрэгцээ буй. Одоогоор дээд боловсролын бакалаврын хөтөлбөрийн ерөнхий суурийн хичээлийг бүрэн оруулахаар тусгасан, элсэгчид нь мэргэжлийн боловсролтой байхаар заасныг хянан нягтлах хэрэгцээ үүсч байна. Түүнчлэн хуульд заасан Хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага нь техникийн боловсролын хөтөлбөрт хамаарахыг нэг мөр баримталж хэрэгжүүлэх шаардлагатай.

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага (Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2019 оны 5 дугаар тогтоолын хавсралт),

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг аттестатчилах журам, Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын аттестатчиллын шалгуур үзүүлэлт (Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2012 оны 130 дугаар тушаалын нэг, хоёрдугаар хавсралт) МБС-ын байгууллагыг магадлан итгэмжлэх нь заавал хийлгэх хөндлөнгийн үнэлгээ хараахан биш боловч өнөөдөр 32 сургууль, эдгээрээс нь 15 нь политехник коллеж өөрийн санаачилгаар магадлан итгэмжлүүлсэн, эдгээрээс 4 сургууль бүс нутгийн магадлан итгэмжлэлийн байгууллага АРАСС-аар магадлан итгэмжлүүлсэн байна. Магадлан итгэмжлэлийг бүрэн хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлсэн сургалтын байгууллагын өөрийн үнэлгээний тайланд үндэслэн БМИУЗ-ийн хөндлөнгийн шинжээчид дүгнэлт гаргаж байгаа нь олон улсын нийтлэг практиктэй хэлбэрийн хувьд нэгэн адил юм. МБСБ-ыг нийт 7 бүлэг, 22 шалгуур үзүүлэлтийг 71 үзүүлэлтээр үнэлэн дүгнэлт гаргаж байна. Эдгээр үзүүлэлт нь Сингапурын Темасек-тэй хамтран боловсруулж нийт МБСБ-ын удирдлагад эрчимтэй сургалт зохион байгуулж танилцуулсан МБСБ-ын чанарын баталгааны тогтолцооны үзэл баримтлал, ГХАН-ийн шугамаар байгуулсан 7 чадамжийн төвийн чадавхид хийсэн үнэлгээний үндсэн санаа, зарчмуудтай ижил төстэй агуулгатай байна. Мөн 2012 оныг хүртэл МБСБ-ыг аттестатчилж байсан хяналтын болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт нь чанарын үнэлгээ хийхэд чиглэсэн агуулгатай байв. Тухайлбал, сургуулийн үйл ажиллагааг хэвийн тогтвортой явуулах, менежментийн бодлоготой байх (14 оноо), сургалтын агуулга, арга зүйг үр дүнтэй болгох чанарын үнэлгээ (25 оноо), удирдах ажилтан, багшлах бүрэлдэхүүний чадавхийг бэхжүүлэх (15 оноо), сургалтын зорилго, зорилтыг хангасан сургалтын орчин бүрдүүлсэн байх (15 оноо), суралцагчдад зориулсан үйлчилгээ нь тэдний эрх ашигт нийцсэн байх (6 оноо) шаардлага нь чанарын удирдлагын нийтлэг шаардлага шалгууртай агуулгын хувьд нийцэж байна.

Харьцуулан үзвээс, *MNS ISO 21001:2021 Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо - Шаардлага, хэрэглэх арга зүйн заавар* стандарт нь дараах зарчимд үндэслэсэн байна. Үүнд:

- Суралцагчид, бусад харилцагчид (төр засаг, хөдөлмөрийн зах, эцэг эх асран хамгаалагч г.м.)-ын ашиг сонирхлыг төвдөө тавьсан байх
- Алсын хараатай манлайлал: дээд удирдлага нь хариуцлагатай, суралцагч, харилцагчдын сэтгэл ханамжийг эрхэмлэсэн, эрх мэдлийг зохистой хуваарилсан, харилцааг үр дүнтэй болгосон
- Ажилтнууд нь чин эрмэлзэлтэй
- Процесс үйл явцыг анхаарч чухалчлах
- Ахиц сайжруулалтад тэмүүлэх
- Шийдвэр нь баримт нотолгоонд үндэслэдэг байх
- Харилцаа харьцааг зөв зохистой удирдах
- Нийгмийн хариуцлагатай байх

- Тэгш хандаж, үйлчилгээг хүртээмжтэй болгох
- Ёс суртахуунтай байх
- Мэдээ мэдээллийн үнэн зөв, хамгаалалттай байдлыг хангах

Чадамжийн төвийн чанарын үнэлгээний аргачлал нь сургалтын байгууллагын менежментийг бүхэлд нь хамарсан магадлан итгэмжлэлийн процесс болох нь уг үнэлгээний шалгуур, тэдгээрт харгалзах шаардлага, үнэлгээнд авч үзэх нотлох мэдээлэл баримтаас тодорхой харагдаж байна:

Үнэлгээ хийх чиглэл	Үнэлгээний шалгуур	Харгалзах шаардлага
1. ЗАСАГЛАЛ БА МЕНЕЖМЕНТ	ШАЛГУУР 1. ЗАСАГЛАЛ, МАНЛАЙЛАЛ, МЕНЕЖМЕНТ	1. засаглал ба менежментийн тогтолцоо нь өнөөгийн үйл ажиллагааг удирдах, хөгжил болон өөрчлөлтөнд хариу үйлдэл үзүүлэх чадамжтай байна.
2. СУРГАХ, СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ШАЛГУУР 2. СУРГАХ, СУРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	сургах, суралцах судалгаа шинжилгээг хийх замаар хөдөлмөрийн зах зээл, суралцагч болон нийгмийн хэрэгцээнд нийцсэн, тэдний оролцоог хангасан сургалтын бүтээгдэхүүн, үйлчилгээг тогтвортой нийлүүлж, түүнийгээ тасралтгүй сайжруулах үйл явцыг үр нөлөөтэй хэрэглэх чадамжтай байна.
	ШАЛГУУР 3. СУРАЛЦАГЧДАД ЧИГЛЭСЭН ҮЙЛЧИЛГЭЭ	өөр өөр зорилтот бүлгийн суралцагч, иргэд, мэргэжилтэй ажилтнуудад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ялгаатай хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадамжтай байна.
3. ДЭМЖИХ ҮЙЛ ЯВЦУУД	ШАЛГУУР 4. ХҮНИЙ НӨӨЦ	мэдлэг, боловсрол, ажлын туршлагатай, мэргэжлийн хувьд өрсөлдөхүйц багш, ажилтнуудтай байна.
	ШАЛГУУР 5. БУСАД НӨӨЦ	сургалтын бүтээгдэхүүн үйлчилгээг үр дүнтэй дэмжих үйл явцууд болон дэд бүтэцтэй, түүнийгээ зохистой удирдан зохион байгуулах чадамжтай байна.
4. ХАМТЫН АЖИЛЛАГАА БА ТҮНШЛЭЛ	ШАЛГУУР 6. ХАМТЫН АЖИЛЛАГАА БА НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ	засгийн газрын байгууллага, хувийн хэвшлийн ажил олгогчид, иргэний нийгэм, бусад боловсролын болон эрдэм шинжилгээний байгууллагууд зэрэг олон оролцогч талуудын оролцоог ханган хамтран ажиллах чадамжтай байна.

Хэдийгээр магадлан итгэмжлүүлэхийг хуулиар заавал хийлгэх процесс болгон шаардаагүй ч сургуулиуд өөрийн санаачилгаар дотоодын төдийгүй гадаадын магадлан итгэмжлэлийн байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, зарим нь хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны олон улсын ISO 45001:2018 стандартыг хангасан хэрэгжүүлэгч байгууллага болсон байна. Энэ бүхэн МБСБ-ын зүгээс хөндлөнгийн үнэлгээгээр чанараа баталгаажуулж, нэр хүндээ өсгөхийг эрмэлзэх нь нэмэгдэж байгааг илтгэнэ. Харин сургалтын ажил эрхлэх зөвшөөрөл олгоход тавьж буй шаардлага шалгуур нь МБСБ-ын ангиллыг зэрэглэл мэтээр ойлгогдоход хүргэж байгаа, МСҮТ, политехник коллеж нь эрхэлж буй ажлын чиглэл, түвшний хувьд ялгаагүй байгааг залруулан, чанарын үнэлгээг оновчтой болгоход чиглүүлэн тодруулж сайжруулах, сургуулийн бүтээлч хандлагыг дэмжих, уян хатан болгох шаардлага байна.

*Мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага* (Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2016 оны 1 дүгээр тогтоолын хавсралт) *Суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлэх, дүгнэх журам* (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А506/А266 дугаар хамтарсан тушаалын хавсралт)

Мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх нь заавал биелүүлэх шаардлагатай биш боловч өнөөдөр 5 сургуулийн мэргэжлийн болон техникийн боловсролын 13 хөтөлбөр БМИҮЗ-өөр магадлан итгэмжлэгдсэн байна. Эдгээр магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийг Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад бэлтгэх мэргэжлийн чиглэл, индекс (Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2016 оны А/150 дугаар тушаал)-тэй харьцуулбал 4 нь техникийн боловсролын (механиктроникч, малын бага эмч, үс заслын технологич, гоо заслын технологич), 9 нь мэргэжлийн боловсролын (тогооч, оёдолчин, үсчин, гоо засалч, гагнуурчин, автомашины засварчин) хөтөлбөр байна. Хөтөлбөрийг магадлан итгэмжилж байгаа шалгуур, шаардлага, процедур нь мэргэжлийн болон техникийн хөтөлбөрт нэгэн адил, хөндлөнгийн үнэлгээ хийх шинжээчдийг БМИҮЗ-ийн төрөлжсөн 10 мэргэжлийн зөвлөлөөс санал болгон томилж үнэлгээ хийдэг. Гэтэл мэргэжлийн боловсролын хөтөлбөр нь чадамжид суурилсан, чадамжийн нэгжүүдээс бүрдэх, харин техникийн боловсролын хөтөлбөр нь дээд боловсролын хөтөлбөртэй уялдсан, багц цагаар зохион байгуулсанаараа ялгаатай байх шаардлагатай болно. Мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрөөр суралцан төгсгөгчид болон иргэдийн эзэмшсэн мэргэжлийн ур чадварыг үнэлэхэд *Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч, мэргэжлийн ур чадвар эзэмшсэн иргэний мэргэшлийн түвшинг үнэлэх, үнэлгээг баталгаажуулах, хөндлөнгийн шалгалт зохион байгуулах журам* (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/50 дугаар тушаалын хавсралт), *Суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлэх, дүгнэх журам* (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А506/А266 дугаар хамтарсан тушаалын хавсралт)-ыг баримталж МБС-ын Үнэлгээ, мэдээлэл, аргазүйн төв нийтлэг удирдамж, зохицуулалтаар хангаж ажиллах хуваарь тогтсон байна. Мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрөөр суралцан төгсгөгчдийн мэргэжлийн ур чадвар, чадамжийг үнэлэх хөндлөнгийн үнэлгээний сорилыг бэлтгэхэд МБСҮМАЗТ-ийн дэргэд байгуулсан түгээмэл мэргэжлийн 37 зөвлөл үндсэн үүрэг гүйцэтгэж байна. Суралцагчдын эзэмшсэн онолын мэдлэг, ур чадвар, хандлага төлөвшилийг хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн ялгаа, онцлогийг тусган сургалтын явцад болон төгсгөлд үнэлэх арга хэлбэр, үнэлгээний орчин, үнэлгээний ажилтанд тавих шаардлагыг нарийвчлан тодорхойлж, мэргэжлийн зөвлөлийн оролцоог идэвхижүүлэн зохион байгуулж байсан МБСҮМАЗТ-ийн үйл ажиллагааны хуримтлуулсан туршлагыг асуудал хариуцсан байгууллагуудын чиг үүрэг өөрчлөгдсөн нөхцөлд алдагдалгүй үргэлжлүүлэн чанаржуулах нь гол зорилт болж байна. БШУЯ-нд Боловсролын чанарын үнэлгээний хэлтэс байгуулж, олон улсын сурлагын амжилтын аргачлал, зарчимд баримжаалан ерөнхий боловсролын чанарыг үнэлэх хөндлөнгийн үнэлгээ хийх ажлыг БҮТ зохион байгуулж байгаа бөгөөд үүнд мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын үнэлгээг хамруулахаар төлөвлөсөн байна. Бидний бэлтгэсэн чанарын үнэлгээний нэгдсэн удирдамж энэхүү нөхцөл байдлыг тусгасан болно.

*Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшийн сургалтын ажлыг багц цагаар тооцох журам* (Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 284/А345

дугаар хамтарсан тушаалын нэг, хоёрдугаар хавсралт) *Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшийн сургалтын цагийн ачааллыг тогтоох, тооцох журам* (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А87 дугаар хамтарсан тушаал) *Ажил мэргэжлийн лавлах: Техник мэргэжлийн боловсрол. Техник мэргэжлийн боловсролын багш* (Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөлийн 2020 оны 1 дүгээр тогтоол)

Мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрийн багшийн мэргэшилд тавих шаардлага, үндсэн ажлын агуулга, гүйцэтгэлийн үнэлгээний зарчим, зохицуулалтыг шинэчилсэн хувилбарыг 2019 оноос мөрдөж байна. Үүний дотор “техник мэргэжлийн боловсролын багш” мэргэжлийн лавлах (стандарт)-ыг 2020 онд баталж МБС-ын багшийг бэлтгэх, ажлыг агуулга, ачааллыг тогтоож, гүйцэтгэлийн явц, үр дүнг нь үнэлэх тодорхой шалгуур тогтоосон байна. Харин мэргэжлийн сургалтын чадамжийн нэгжид харгалзах сургалтыг хөтлөн явуулах сургагч багш, мэргэжлийн боловсролын хөтөлбөрийн онолын ба дадлагын сургалтыг хөтлөн удирдах багш, техникийн боловсролын хөтөлбөрийн багшийн мэргэшилд тавих шаардлага, хариуцах ажил үүргийн ялгаа заагийг тодотгох, мэргэжлийн зэрэг, албан тушаалын ангиллын үндэслэл, суралцахуйн үр дүнд үзүүлэх нөлөөллийг үнэлэн тооцож зохистой тогтоох шаардлагатай байна. Ялангуяа мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах ажилтан, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг улирлаар дүгнэж, үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох журамд шилжихээр (Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “*Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам*”, түүнд 2022 оны 252 дугаар тогтоолоор оруулсан өөрчлөлт) бэлтгэж байгаа энэ үед ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын үр дүнг үнэлэхэд баримталж байгаа шалгуур үзүүлэлтийг адилтган үзэх үндэслэл байна. Үүнд:

Суралцагчид боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааны ахиц, үр дүн

- Хичээл сургалтын үйл ажиллагааны төлөвлөлт, үр дүн
- Суралцагчийн сурлагын ахиц
- Сургалтын хэрэглэгдэхүүний ашиглалт, үр дүн
- Сургалтын материал, нөөц, тохирох хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, баяжуулсан байдал

Суралцагчийг хөгжүүлэх, төлөвшүүлэх үйл ажиллагааны ахиц, үр дүн

- Сургуулийн орчинд суралцагчийг болзошгүй эрсдэлд өртөхөөс сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээ, түүний гүйцэтгэл, үр дүн
- Хүүхдийн хөгжил, хамгаалал, оролцооны талаар эцэг эх, асран хамгаалагчийг зөвлөгөө, мэдээллээр хангаж хамтран ажилласан арга хэмжээний гүйцэтгэл, үр дүн
- Хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар суралцагч бүрийн онцлог хэрэгцээг харгалзан хөгжүүлж буй байдал (дотуур байранд амьдарч байгаа суралцагч, ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн хөгжлийг дэмжихэд оруулсан хувь нэмрийг хамруулна)

Багшийн мэргэжлийн хөгжлийн ахиц, үр дүн

- Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн /мэргэжлийн, мэргэшлийн, хувь хүний/ төлөвлөлт, биелэлт, үр дүн
- Багшийн мэргэжлийн ёсзүйн хэм хэмжээг мөрдөж, үг хэллэг, харилцаа, хандоога, үйлдлээр үлгэрлэн манлайлж буй байдал
- Ажлын байранд мэргэжил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх, мэргэжлийн бүлгээр хамтран суралцах, хөгжих үйл ажиллагаанд оролцсон байдал

- Сургалт, үйл ажиллагааны технологи ашиглах мэдлэг, ур чадвараа хөгжүүлж, бүтээлчээр ашиглаж буй байдал

Сургуулийн болон олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал, оруулсан хувь нэмэр

- Сургуулиас зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцсон байдал

- Багшийн ажлын үндсэн үүргийн хүрээнд мэргэжлийн байгууллага, эцэг эх, асран хамгаалагч, олон нийттэй хамтран хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл, үр дүн

Засгийн газрын тогтоолоор баталсан энэхүү журамд төрийн өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, албан хаагчдыг хамруулан сургуулийн өөрийн зохион байгуулсан үнэлгээнд үндэслэн албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгохоор заасан. Цаашид сургалтын байгууллагын өмчийн хэлбэрээр ялгалгүй багшийн ажлыг үнэлэх, урамшуулахад нэгэн ижил шалгуур, зарчмаар хандах, үнэлгээнд хөтөлбөр, суралцагчдын ялгаатай байдлыг тусгах, хөндлөнгийн хараат бус үнэлгээний дүнг тооцож ашиглах зэрэг асуудлыг холбогдох эрхзүйн орчны шинэчлэлд хамтатган авч үзэх шаардлагатай байна. МБС-ын салбарын хэмжээний төлөвлөлт, үнэлгээнд хэрэглэж буй суурь үзүүлэлт, статистик мэдээний бүтэц нь бодлогын шийдвэр гаргахад хүрэлцээтэй, шаардлагатай мэдээллийг бүрэн хамарсан, цаг хугацааны хувьд алдагдал хоцрогдолгүй, үнэн бодитой байх хэрэгцээнд нийцсэн өөрчлөлт сайжруулалт хийхэд чиглэсэн саналыг чанарын үнэлгээний нэгдсэн аргачлалд тусгасан болно.

Эдгээр дүн шинжилгээнд үндэслэн мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөр, үүнийг эрхлэх байгууллага, багшийн үйл ажиллагааны чанарт үнэлгээ хийх нэгдсэн аргачлалыг боловсруулж, БШУЯ-ны холбогдох удирдах ажилтан, мэргэжилтнүүдтэй цуврал уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, тэдний өгсөн чиглэлийн дагуу Улаанбаатар хот дахь Монгол-Солонгосын политехник коллеж, Үйлдвэрлэл, урлалын политехник коллеж, Хангай МСҮТ-ийн сургалт, чанарын үнэлгээний мэргэжилтнүүдийн саналыг тусгасан хувилбарыг Хавсралт 1-д тусгасан болно. Энэхүү аргачлалын үндсэн агуулга нь чанарын үнэлгээг зорилго, зориулалт, бүтцийн хувьд ялгаатай техникийн боловсрол, мэргэжлийн боловсрол, мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг эхлүүлэх, хэрэгжүүлэх, үр дүнг тодорхойлох шатанд харилцан уялдаа холбоотой чанарын өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний хэрэгслийг үр ашигтай, давхардалгүйгээр ажиллуулахад чиглэсэн болно. Чингэхдээ суралцагчдын сурах хэрэгцээний ялгаатай байдал, багш, сургуулийн бүтээлч хандлагыг дэмжин, тэдэнд итгэл өгч уян хатан хандах нөхцлийг бүрдүүлэхийг чухалчлав.

## БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

Өнөөдөр Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг БШУЯ бэлтгээд байна. Энэ төсөлд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн үндсэн үзэл баримтлалыг цаашид үргэлжлүүлэх чиг баримталсан гэж харагдаж байна. Иймд 2009 оны хууль хэрэгжсэн хугацаанд хуримтлагдсан туршлага, сургамжид үндэслэн МБС-ын үр өгөөжийг дээшлүүлэх чанарын баталгаажууллын тогтолцоог бэхжүүлэхэд дараах саналыг анхааран үзэхийг зөвлөж байна.

**ЗӨВЛӨМЖ 1:** МБС-ын Үндэсний зөвлөл нь МБС-ын удирдах дээд байгууллага байх статусыг бүрэн баталгаажуулж, хөгжлийн бодлогыг тодорхойлох, жишиг шаардлага, стандартыг тогтоох, нийтлэг зохицуулалт хийх, МБС-ыг дэмжих санг удирдах чиг үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхийг олгох; МБС нь иргэдэд насан туршдаа мэдлэг, ур чадвараа баяжуулан шинэчилж, ахиулан хөгжүүлэхэд нь нийцсэн уян хатан, олон хувилбартай байх; чадамжид суурилсан боловсролын зарчимд нийцүүлэн иргэдийн эзэмшсэн ур чадварыг үнэлэн баталгаажуулах хараат бус, хүртээмжтэй үнэлгээний систем бүрдүүлэх, удирдлага, чанарын баталгаажууллын бүх шатанд мэргэжлийн олон нийт, ажил олгогчдын оролцоог бодитой, үр нөлөөтэй болгох эрхзүй, эдийн засгийн механизм бий болгох зохицуулалтыг тусгах. Ажил мэргэжлийн тодорхойлолт нь МБСБ-аас харгалзах МБС-ын хөтөлбөрийг боловсруулахад баримтлах албан ёсны үндсэн баримт бичиг байхаар албажуулах. МБСҮЗ-ийн ажлын алба нь МБС-ын асуудал эрхэлсэн салбар дундын агентлаг хэлбэрээр 2012 оныг хүртэл ажиллаж байсан практикийг сэргээх боломжийг засгийн газар, ажил олгогчид, хувийн салбарын төлөөлөлтэй хэлэлцэн зөвшилцөх.

МБС-ын чанарын баталгаажууллын эхлэлийн цэг нь чанарыг илэрхийлэх жишиг буюу иргэдийн эзэмших мэргэжлийн мэдлэг, ур чадвар, чадамжийг тодорхойлсон мэргэшлийн стандартыг албажуулан баталгаажуулахтай холбоотой.

**ЗӨВЛӨМЖ 2:** Хөдөлмөрийн хуульд *“17.1. Ажил мэргэжлийн үндэсний ангилал, тодорхойлолт, ажил мэргэжлийн стандартыг батлах, мэргэшлийн түвшнийг тогтоон хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах үйл явц мэргэшлийн үндэсний хүрээнд хамаарна”* гэсэн нь үндсэндээ ЧБ-ын хүрээг тодорхойлсон байгааг нэг мөр ойлгож хэрэглэх, харин мэргэшлийн шатлалыг тодорхойлсон баримт бичгийг улсын хэмжээнд боловсролын бүх салбарыг хамруулсан үндэсний мэргэшлийн түвшний шатлалын систем (ҮМТШС) гэх агуулгаар батламжлан албажуулахыг Засгийн газарт, үүнд үндэслэн МБС-ын стандартыг боловсруулж, баталгаажуулах бүрэн эрхийг МБСҮЗ-д, эдгээрт нийцүүлэн техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөрийн боловсруулахад арга зүйн удирдамж зөвлөмжөөр хангах үүргийг БАЗТ, мэргэжлийн сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийх үүргийг мэргэжлийн холбоодод хариуцуулах. Мэргэжлийн мэдлэг, ур чадварыг эзэмшсэн арга хэлбэрээс нь хамааралгүй үнэлж баталгаажуулах ажлыг мэргэжил аргазүйн удирдлагаар хангах үүргийг БҮТ-д шилжүүлж, сургалтын хөтөлбөрөө боловсруулахад МБСБ-ын мэргэжлийн санаачилга, эрх чөлөөг хүндэтгэхийн хамт үр дүнг нь хариуцах үүрэг хариуцлагыг тодотгон журамлах. БАЗТ-ийг чиг үүргийн адил төстэй бөгөөд уялдаа холбоотой байдлыг харгалзан БСҮХ-нд харьяалуулан бэхжүүлбэл боловсролын бүх түвшинд иргэдийг хөдөлмөрийн харилцаанд бэлтгэн, насан туршийн боловсролын үйлчилгээнд хамруулахад баримтлах аргазүйн нэгдмэл удирдлага хангагдана.



Сургалтын байгууллагын Удирдах зөвлөлийн чиг үүрэг, эрх мэдлийг бодитой, нөлөөтэй, хариуцлагатай болгосноор хөгжлийн бодлогын тогтвортой байдлыг хангаж, МБСБ-ын түвшинд чанарын баталгаажууллыг хэрэгжүүлэх мөчлөгийг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

**ЗӨВЛӨМЖ 3:** МСҮТ, Политехник коллеж, тэдгээртэй адилтгах хэв шинжийн МБСБ-ийн Удирдах сургуулийн хөгжлийн стратегийг тодорхойлох, түүнд нийцүүлэн үйл ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгө оруулалт, санхүүжилтийг хуваарилах, сургуулийн менежментийн бүтэц зохион байгуулалтыг чанарыг баталгаажуулах зорилттой уялдуулан оновчтой тогтоох, хөгжлийн болон үйл ажиллагааны зорилт, түүний хүрэх түвшний үзүүлэлтийг чанарын үзүүлэлттэй холбон баталж, хэрэгжилт, үр дүнд хяналт тавихад мэргэжлийн туслалцаа үзүүлэх.

Чанарын баталгаажууллын тогтолцооны бүрдэл хэсгүүдийн чиг үүргийг санал болгож буй бүдүүвчид тусгаснаар хуваарилж, холбогдох зохицуулалтыг хууль тогтоомж, бусад баримт бичигт тусган албажуулж, эдгээр чиг үүргээ гүйцэтгэхэд шаардагдах дэмжлэгийг хандивлагчидтай хамтран зохион байгуулах нь зүйтэй байна.

**ЗӨВЛӨМЖ 4:** МБС эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, бүртгэхэд техникийн боловсрол, мэргэжлийн боловсрол, мэргэжлийн сургалтын онцлогийг тусгаж зохицуулсан журам тогтоох,

МБС-ын хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж хянах, чанарыг тасралтгүй сайжруулах чиглэлээр тусгай зөвшөөрөл олгосон субъект хяналт шинжилгээ, аттестатчилал, үр дүнгийн гэрээний үнэлгээ, дүгнэлт, магадлан итгэмжлэлийн хэрэгслийг уялдаа холбоотойгоор давхардал, орхигдолгүйгээр хэрэгжүүлэх. Политехник коллеж, техникийн боловсролын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг заавал хийж байх шаардлага тавих нь Боловсролын тухай хуулийн зохицуулалттай нийцэх бөгөөд энэ тохиолдолд аттестатчиллыг давхардуулан хэрэглэх шаардлагагүй болно. Харин МСҮТ, мэргэжлийн боловсролын хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарыг үнэлэхэд аттестатчиллын механизм илүү тохиромжтой. Цаашид чанарын удирдлагын нэр хүндтэй стандартыг хэрэгжүүлж, магадлан итгэмжлэгдсэн, аттестатчилагдсан МБСБ нь тодорхой шаардлагыг хангаж, нөхцөл бүрдүүлсэнээ нотолсон тохиолдолд өөрийгөө магадлан итгэмжлэх эрх олгох (австралийн TAFE-тэй төстэйгээр) боломжийг судлах хэрэгтэй байна. Мэргэжлийн сургалтын төв, чадамжийн сургалтын хөтөлбөрийг 2 хүртэл жилд заавал аттестатчилж байх, төгсгөгчдийн нь ур чадварын үнэлгээг голлох шалгуур болгох нь тохиромжтой болно. Техникийн боловсролын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг цаашдаа харгалзах дээд боловсролын мэргэжлийн зөвлөлд түшиглэн хэрэгжүүлэх чиглэл баримталж, энэ чиг үүргийг үе шаттай шилжүүлэх тусгай хөтөлбөр хэрэгжүүлбэл илүү зохимжтой байна. Мэргэжлийн боловсролын чадамжид суурилсан хөтөлбөрт харгалзах мэргэжлийн чадамж, ур чадварыг үнэлэх төстийн сан бүрдүүлэх, МБСБ-д түшиглэсэн үнэлгээний төвүүдийг байгуулан итгэмжлэх үйл ажиллагааг зүгшрүүлж, чадавхийг нь сайжруулахад ХНХСҮСИ-ийн үнэлгээний алба, түүний дэргэд байгуулсан мэргэжлийн зөвлөлүүдийн үйл ажиллагааг БҮТ-ийн үйл ажиллагаатай ойртуулах, цаашид аль байгууллагад хариуцуулах талаах БШУЯ, ХНХЯ зөвшилцөж шийдэл гаргавал зохино.

БАЗТ-ийг БСҮХ-гийн харъяанд удирдлага, менежментийн хувьд бие даан ажиллаж, хөтөлбөр боловсруулах, үнэлж шинжлэх, багш нарт аргагүйн туслалцаа үзүүлэх

мэргэжлийн чиг үүргийг хариуцаж, хяналт шалгалтын шинжтэй захиргааны чиг үүргээс нь чөлөөлбөл зохимжтой болно.

Мэргэшил, ур чадвар, чадамжийг үнэлэх, гэрчилгээжүүлэхэд МБСҮМАЗТ-ийн хэрэгжүүлж байсан үүргийг БҮТ-ийн мэргэжлийн экспертизтэй зохистой хослуулж, харгалзах мэргэжлийн холбоод, МБСБ-ын хариуцах үүрэг, зохион байгуулалтыг тодотгон, иргэдэд хүртээмжтэй үйлчлэх тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай. Үүнд цаг хугацаа, үйл ажиллагааны алдагдал гаргахаас сэргийлж үе шаттай алхмууд төлөвлөн хэрэгжүүлбэл зохилтой.

**ЗӨВЛӨМЖ 5:** Мэргэжлийн боловсролын үнэмлэх, техникийн боловсролын дипломыг сургууль олгохдоо улсын шалгалтын комиссын үнэлгээнд үндэслэх, комиссыг мэргэжлийн хөндлөнгийн экспертийн оролцоотой байгуулж байх; Мэргэжлийн ур чадварын үнэлгээ хийх, гэрчилгээжүүлэх ажлын мэргэжлийн удирдлагыг БҮТ-д хариуцуулж, үнэлгээний сорил, тест бэлтгэхэд МБСҮМАЗТ-тэй хамтран ажиллаж байсан мэргэжлийн холбоодын харилцааг уламжлан бэхжүүлж хөгжүүлэх. Ийнхүү чадамжийн гэрчилгээг итгэмжлэгдсэн үнэлгээний төв олгох журамд шилжих, гэхдээ итгэмжлэгдсэн байгууллагад эрх өгөхийн хамт гүйцэтгэлд нь мета үнэлгээ хийж байх: итгэмжлэгдсэн байгууллага нь мэргэшсэн үнэлээчтэй, тестийг явуулах шаардлага хангасан төвтэй, мэдээг бүрэн дүүрэн системд оруулдаг гэрээтэй байх бөгөөд ихэвчлэн энэ шаардлагыг хангасан Политехник коллежид түшиглэсэн байвал зохимжтой байна.

Чанарын удирдлагын стандартыг нэвтрүүлэх, чанарын соёл бүрдүүлэх талаар МБСБ-ын санаачилга, бүтээлч хандлагыг дэмжсэн бодлого, зохицуулалтыг албажуулбал зохилтой.

**ЗӨВЛӨМЖ 6:** Үнэлгээний шалгуур, процедур, шинжээчдийн чадавхи нь хөндлөнгийн чанарын үнэлгээний албан ёсны механизмтай адил төстэй, нэр хүндтэй, нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн ISO9001, 21001:2018 серийн чанарын удирдлагын стандарт, TQM буюу чанарын удирдлагын иж бүрэн системийн үзэл баримтлал, аргачлалтай төстэй нийтлэг шинжтэй практикийг туршин нэвтрүүлэхийг дэмжиж, үр дүнг нь хүлээн зөвшөөрч албан ёсны аттестатчилал, магадлан итгэмжлэлийн дүгнэлттэй адилтган дүйцүүлэх зохицуулалт бий болгох.

Чанарыг баталгаажуулахад хэрэглэгч, мэргэжлийн олон нийтийн үүрэг оролцоог бодитой, үр нөлөөтэй болгох зохицуулалтыг сайжруулах шаардлага байна.

**ЗӨВЛӨМЖ 7:** Мэргэжлийн холбоодын зүгээс мэргэжлийн стандартыг боловсруулах, батламжлах, ур чадвар, чадамжийн үнэлгээ хийх, дүгнэлт гаргахад оролцоо нь нэмэгдэж, эдгээр үүргээ хэрэгжүүлэхэд туршлагажиж байна. Гэхдээ байнга, тогвортой ажиллуулах нөхцөлийг сайжруулах шаардлагатай. Идэвхитэй, нэр хүндтэй цөөн хүн мэргэжлийн хэд хэдэн байгууллагад уригдаж давхар үүрэг хүлээх нь олонтаа тохиолдож байгаа бөгөөд үүний дүнд тухайн хүний цаг боломж хүрэлцэхгүй болох, сонирхлын зөрчилд өртөх магадлал өндөр байна. Иймд ижил төстэй, нийтлэг зорилго чиглэлтэй ажлын хэсэг, зөвлөлийг нэгтгэх, уялдуулах, төлөөлөх ажилтныг өргөтгөх, гишүүд мэргэшиж ажиллах, зөвлөлүүдийн ажиллагааг тогтвортой, үр нөлөөтэй болгох зохицуулалт шаардлагатай.

Үнэлгээ дүгнэлт гаргах, үүндээ үндэслэн чанарын баталгаажуулалтын гэрчилгээ баримт бичиг олгох эрх мэдлийг мэргэжлийн холбоо байгууллагад шилжүүлбэл тогтвортой ажиллагаатай, үнэлгээ бодитой байх, салбарт хүлээн зөвшөөрөгдөж, итгэл бэхжих илүү нөхцөл бүрдэнэ. Энэ тохиолдолд шилжүүлэн өгсөн чиг үүргийг мэргэжлийн түвшинд

хэрэгжүүлэх чадавхитай бүрэлдэхүүн, тогтвортой бүтэцтэй, үнэлгээ дүгнэлтийг хараат бусаар бодитой хэрэгжүүлэх хариуцлага хүлээх, гаргасан дүгнэлт, шийдвэрийн үр дагаврыг хариуцах чадварыг нь үнэлж, чиг үүргээ хэрхэн биелүүлж байгаад мета үнэлгээ хийж байх журмыг тогтоох шаардлагатай болно. Шилжүүлэн өгсөн чиг үүргийн хэрэгжилтэд хяналт тавих, meta-evaluation хийх боломжтой субъект нь яам, БМИҮЗ, мэргэжлийн холбоодын зөвлөл байж болох хувилбарыг харьцуулан үзэх хэрэгтэй.

Олон жилийн турш улсын төсөв, хөрөнгө оруулалт, хандивлагч, хөгжлийн түншүүдийн дэмжлэг, хүчин чармайлтаар бүрдүүлсэн чадавхийг үнэлж, үр дүнтэй ашиглах, институцийн ой санамжийг алдагдуулахгүй байхад анхаарах: мэргэжлийн сургалтад хамрагдсан багш ажилтнууд, нийлүүлсэн өндөр өртөгтэй лаборатори, багаж тоног төхөөрөмж, олон улсын болон үндэсний зөвлөхүүдийн судалгааны тайлан, баримт бичгийн бүртгэл, гүйцэтгэлийн мэдээллийн санг БСҮХ болон МБСТүншлэл зэрэг холбогдох бусад байгууллагад хариуцуулан байгуулах, хөтлөх хэрэгтэй байна.

## ХАВСРАЛТ 1

### МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ЧАНАРЫГ ҮНЭЛЭХ НЭГДСЭН АРГАЧЛАЛ (ТӨСӨЛ)

#### Нийтлэг үндэслэл

Мэргэжлийн боловсрол, сургалтын үр дүнг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн суурь болох мэдээллийн бүрдэл, боловсруулалтыг сайжруулан аливаа шийдвэрийг судалгаа, нотолгоонд суурилах, түүний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх удирдлагын тогтолцоог сайжруулах, боловсролын байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоо, чиг үүргийг оновчтой болгож, мэргэжлийн холбоод болон бусад түнштэй хамтын ажиллагааг бэхжүүлж, сургалтын байгууллагын дотоод хяналт шинжилгээ, өөрийн болон хөндлөнгийн хараат бус үнэлгээний тогтолцоог олон улсын жишиг аргачлалаар байгуулан, чанарын соёл бүрдүүлэх цогц шинжтэй байхаар тусгасан байна<sup>71</sup>. Ийнхүү Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх эхний шатны үйл ажиллагааны хүрээнд иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн зорилтуудыг хангахад мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын баталгаажууллын тогтолцоог үр нөлөөтэй болгох бодит шаардлага тавигдаж байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарыг баталгаажууллын тогтолцоог сүүлийн жилүүдэд ЕХ, АХБ, ЮНЕСКО, АНУ-ын МСС болон ГХАН, ШХАХБ, Сингапурын Темасек зэрэг хөгжлийн түншүүдтэй хамтран хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн хүрээнд хийсэн судалгаа, хуримтлуулсан туршлагад түшиглэн дараах байдлаар харилцан уялдаатай үйл ажиллагаа болгох зорилгоор энэхүү нэгдсэн аргачлалыг боловсруулсан болно.

Зураг 1. Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын баталгаажууллын тогтолцоо

Үе шат	Зорилго	Хэрэгсэл	Объект	Шалгуур	Үр дүн
Төлөвлөх	Үйл ажиллагааны эрх олгох	Тусгай зөвшөөрөл	МСҮТ, политехник коллеж	Сургалт, үйл ажиллагааны минимум стандарт	Статус, зөвшөөрөл, санхүүжилт
		Улсын бүртгэл	Мэргэжлийн сургалт		
		Урьдчилсан магадлан итгэмжлэл	Техникийн боловсролын хөтөлбөр	Чанарын стандарт	
Хэрэгжүүлэх	Минимум стандарт сахиулах	аттестатчилал	Мэргэжлийн сургалтын төв, МСҮТ	Чадамжийн стандарт	Нийцлийн дүгнэлт
	Гүйцэтгэлийн гэрээний чанарын зорилтыг хангуулах	Хяналт шинжилгээ	МСҮТ, политехник, сургалтын төв	Зорилтот түвшний үзүүлэлт	Биелэлтийн тухай дүгнэлт

<sup>71</sup> “Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

	Чанар сайжруулах	Магадлан итгэмжлэл	политехник коллеж	Чанарын стандарт	албан ёсоор хүлээн зөвшөөрөх, санхүүжилт
			Техникийн боловсролын хөтөлбөр	Чанарын стандарт Мэргэжлийн стандарт	
Дүгнэх	Мэргэжлийн эрх олгох	Ур чадварын шалгалт	Чадамжийн модулийг эзэмшсэн иргэд	Яам, мэргэжлийн холбооноос тогтоосон стандарт	Үйл ажиллагаа эрхлэх эрх
	Хөтөлбөрийн үр дүнг дүгнэх	Улсын шалгалт	Техникийн болон мэргэжлийн боловсролын хөтөлбөрийг төгсгөгчид	Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн	Боловсролын диплом/үнэмлэх

Зураг 1-д мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг хөтөлбөрийн ялгаатай байдлыг тусган хөтөлбөрийг эхлүүлэх, хэрэгжүүлэх, дүгнэх шатанд чанарын үнэлгээ хийх арга хэрэгслийг өөр хооронд нь уялдаа холбоотойгоор тусгасан байна. Энд чанарын үнэлгээг хэрэгжүүлэхээр нэрлэсэн байгууллагуудын чиг үүрэг, чанарын шалгуур болох бенчмарк ч өнөөдөр шинэчлэн боловсруулах, хэлэлцэж зөвшилцөх шатанд байгааг тэмдэглэж байна.

## Зорилго

Мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааны бүх шатанд холбогдох талуудын зөвшилцөн тогтсон чанарын шалгуурыг хангаж байхад зохистой нөлөөлөх чанарын үнэлгээний цогц систем бүрдүүлж, иргэдийн хөтөлбөр эрхлэх чадамжийг баталгаажуулах Энэ зорилгоор мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрөөр суралцан төгсгөгчдийн мэдлэг, ур чадвар ажлын байрны шаардлагад хэрхэн нийцэж байгааг мэргэжлийн сургалтын хөтөлбөр, багшийн чадвар, сургалтын орчинд чанарын үнэлгээ хийж тодорхойлно.

## Хамрах хүрээ

Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын үнэлгээ нь өмчийн бүх хэлбэрийн боловсрол, сургалтын байгууллага мэргэжлийн сургалт, мэргэжлийн боловсрол, техникийн боловсролын хөтөлбөрийг боловсруулах, хөтөлбөрийг эхлүүлэх нөхцлийг бүрдүүлэх, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөтөлбөрийн үр дүнг дүгнэх бүх шатыг хамарна.

Энэхүү аргачлалын хүрээнд чанар, чанарын баталгаажууллын тухай дараах тодорхойлолтод тулгуурлан мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх багш, сургалтын байгууллагад чанарыг үнэлэх шалгуур, аргагүйг боловсруулав.

**Чанар** – зорилгодоо нийцсэн байхын илэрхийлэл; сургалтын байгууллага, хөтөлбөрийн чиг үүрэг, үндсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх процессийг үр дүнтэй болгоход чиглэсэн, магадлан итгэмжлэх эсхүл чанарыг баталгаажуулах эрх бүхий бусад байгууллагаас тогтоосон, нийтээр хүлээн зөвшөөрсөн стандартыг хангах, түүнд нийцүүлэх нь чанарын илэрхийлэл болно.

**Чанарын баталгаажуулал** – боловсрол, сургалтын систем, байгууллага, түүний хөтөлбөрийн чанарыг хангах (орц, явц, үр дүнг шалган дүгнэх, хянан шинжлэх, баталгаажуулах, үйлчлэх, ахиулан сайжруулах)-ад чиглэсэн тасралтгүй үргэлжлэх процесс. Чанарын баталгаажуулал нь зохицуулах шинжтэй механизм учир сайтар боловсруулсан шалгуурыг ашиглан холбогдох талууд зөвшилцөн

тохиролцсон процессоор дамжуулан мэдээлэл өгч, дүгнэлт гаргах замаар чанарын төлөөх хариуцлага, түүнийг сайжруулах чиглэлийг тогтооно.

**А. Мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрийн чанарыг үнэлэх шалгуур, аргазүй**

	<i>Мэргэжлийн сургалтын хөтөлбөр</i>	<i>Мэргэжлийн боловсролын хөтөлбөр</i>	<i>Техникийн боловсролын хөтөлбөр</i>
<i>Хөтөлбөрийг эхлүүлэхэд тавих шалгуур шаардлага</i>	<p>Мэргэжлийн боловсрол, сургалтын MNS 6541:2015 стандарт, холбогдох чадамжийн нэгжтэй нийцлийг үнэлэх:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Чадамжийн нэгжийн суралцахуйн үр дүнд харгалзах ажилбар, аюулгүй ажиллагааны нөхцлийг бүрэн тусгасан байх</li> <li>- Ажилбарыг хийж гүйцэтгэх орчин нөхцөл, багаж төхөөрөмж, материал хэрэгсэл</li> <li>- Ажилбарыг зааж зааварлах мэдлэг туршлагатай сургагч багшийг ажиллуулах нөхцөл</li> <li>- Суралцагчийн гарын авлага, зааварчилга</li> <li>- Суралцагчийн өмнө эзэмшсэн мэдлэг ур чадварыг үнэлж тооцох, сонирхсон иргэдийг элсүүлэн сургах стратеги бодлого</li> <li>- суралцагчийн нас, хүйс, хөгжлийн онцлогтой холбоотой ялгаатай хэрэгцээг тусгаж, сургалтын арга хэлбэрийг нийцүүлсэн байдал</li> </ul>	<p>MNS 6541:2015 стандарттай нийцлийг үнэлэх:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Чадамжид суурилсан хөтөлбөрт суралцахуйн үр дүнд харгалзах ажилбар, аюулгүй ажиллагааны нөхцлийг бүрэн тусгасан байх</li> <li>- Ажилбарыг хийж гүйцэтгэх орчин нөхцөл, багаж төхөөрөмж, материал хэрэгсэл</li> <li>- Чадамжид суурилсан сургалтыг хөтлөн явуулах онол, практикийн мэдлэг туршлагатай багшийг ажиллуулах нөхцөл</li> <li>- Суралцагчийн сурах бичиг, гарын авлага, зааварчилга</li> <li>- Суралцагчийн өмнө эзэмшсэн мэдлэг ур чадварыг үнэлж тооцох, сонирхсон иргэдийг элсүүлэн сургах стратеги бодлого</li> <li>- суралцагчийн нас, хүйс, хөгжлийн онцлогтой холбоотой ялгаатай хэрэгцээг тусгаж, сургалтын арга хэлбэрийг нийцүүлсэн байдал</li> </ul>	<p>MNS 6541:2015 стандарттай нийцлийг үнэлэх, урьдчилсан магадлан итгэмжлэх:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Техникийн боловсролын хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд харгалзах ажилбар, аюулгүй ажиллагааны нөхцлийг бүрэн тусгасан байх</li> <li>- Хөтөлбөрт шаардлагатай орчин нөхцөл, багаж төхөөрөмж, материал хэрэгсэл</li> <li>- Мэргэшсэн, багшлах эрх бүхий багшийг ажиллуулах нөхцөл</li> <li>- Суралцагчийн сурах бичиг, эх сурвалж</li> <li>- Элсэгчдийн онол, практикийн бэлтгэлийг үнэлж тооцох стратеги бодлого</li> <li>- Дараагийн шатны хөтөлбөртэй уялдуулсан байдал, багц цагийг шилжүүлэн тооцох нөхцлийг хангах</li> <li>- суралцагчийн нас, хүйс, хөгжлийн онцлогтой холбоотой ялгаатай хэрэгцээг тусгаж, сургалтын арга хэлбэрийг нийцүүлсэн байдал</li> </ul>
<i>Хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих шалгуур шаардлага</i>	<p>Сургалтын явцыг үнэлэх, аттестатчилах:</p> <ul style="list-style-type: none"> <li>- чадамжийн нэгжийн суралцахуйн үр дүнд харгалзах ажилбар, аюулгүй ажиллагааны нөхцлийг бүрэн тусгаж, харгалзах ажлын байранд гарч буй өөрчлөлттэй нийцүүлж байх</li> <li>- ажилбарыг хийж гүйцэтгэх орчин нөхцөл, багаж төхөөрөмж,</li> </ul>	<p>Хөтөлбөрийн хэрэгжилтийг хянаж шинжлэх, аттестатчилах:</p> <ul style="list-style-type: none"> <li>- чадамжийн нэгжийн суралцахуйн үр дүнд харгалзах ажилбар, аюулгүй ажиллагааны нөхцлийг бүрэн тусгаж, холбогдох мэргэжлийн стандарт, ажлын байрны эрэлттэй нийцүүлж буй</li> </ul>	<p>Хөтөлбөрийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээ, магадлан итгэмжлэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хөтөлбөрийг холбогдох мэргэжлийн стандарт, ажлын байрны эрэлттэй нийцүүлж буй</li> <li>- дадлагын сургалтын орчин нөхцөл, багаж төхөөрөмж, материал хэрэгслийн хангамж, ашиглалт</li> </ul>

	<p>материал хэрэгслийн хангамж, бэлэн байдал, ашиглалт</p> <p>- Хөтөлбөр төлөвлөсөн хуваарь, хугацааны хүрээнд бүрэн хэрэгжиж буйг хянаж, үнэлэх</p> <p>- хяналт, үнэлгээний дүнг шийдвэр гаргах, зохион байгуулахад тусгаж буй</p> <p>- Мэргэжлийн холбоо, нийгмийн түншлэлийн дэмжлэг</p>	<p>- дадлагын сургалтын орчин нөхцөл, багаж төхөөрөмж, материал хэрэгслийн хангамж, ашиглалт</p> <p>- Хөтөлбөр төлөвлөсөн хуваарь, хугацааны хүрээнд бүрэн хэрэгжиж буйг хянаж, үнэлэх дотоод чанарын баталгаажуулал хэвшсэн байдал</p> <p>- Чанарын өөрийн хяналт, үнэлгээний дүнг шийдвэр гаргах, зохион байгуулахад тусгаж буй</p> <p>- Мэргэжлийн холбоо, нийгмийн түншлэлийг үйлдвэрлэл дээрх болон хосмог сургалт, ажил хөдөлмөрт зуучлахад уялдуулан зохицуулж буй</p>	<p>- Хөтөлбөр төлөвлөсөн хуваарь, хугацааны хүрээнд бүрэн хэрэгжиж буйг хянаж, үнэлэх дотоод чанарын баталгаажуулал хэвшсэн байдал</p> <p>- Чанарын өөрийн хяналт, үнэлгээний дүнг шийдвэр гаргах, зохион байгуулахад тусгаж буй</p> <p>- Мэргэжлийн холбоо, нийгмийн түншлэлийг үйлдвэрлэл дээрх болон хосмог сургалт, ажил хөдөлмөрт зуучлахад уялдуулан зохицуулж буй</p>
<p><i>Хөтөлбөрийг үнэлэх, үр дүнг дүгнэхэд тавих шалгуур шаардлага</i></p>	<p>Төгсгөгчийн чадамж/ ур чадварын үнэлгээ: (чадамжийн гэрчилгээ)</p> <p>- Чадамжийг эзэмшсэн төгсгөгчдийн эзлэх хувь</p> <p>- Төгсгөснөөс хойш 6, 12 сарын дотор ажилд орсон төгсгөгчид: суралцсан чиглэлээр, ажлын гарааны албан тушаал, ажлын байран дахь сургалт, карьерийн өсөлт, шилжилт хөдөлгөөн</p>	<p>Итгэмжлэгдсэн үнэлээч, мэргэжлийн холбооны төлөөлөлтэй Улсын шалгалт (Мэргэжлийн үнэмлэх + Бүрэн дунд боловсролын гэрчилгээ)</p> <p>- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг хангасан төгсгөгчдийн хувийн жин</p> <p>- Төгсгөснөөс хойш 6, 12 сарын дотор ажилд орсон төгсгөгчдийг мөшгих судалгаа: суралцсан чиглэл, ажлын гарааны албан тушаал, ажлын байран дахь сургалт, карьерийн өсөлт, шилжилт хөдөлгөөн</p>	<p>Улсын шалгалт/ төгсгөлтийн ажил - төсөл (техникийн боловсролын диплом)</p> <p>- Хөтөлбөрт тодорхойлсон суралцахуйн үр дүнг хангасан төгсгөгчдийн хувийн жин</p> <p>- Төгсгөснөөс хойш 6, 12, 24 сарын дотор ажилд орсон төгсгөгчдийг мөшгих судалгаа: суралцсан чиглэл, ажлын гарааны албан тушаал, ажлын байран дахь сургалт, карьерийн өсөлт, шилжилт хөдөлгөөн</p>

Хөтөлбөрийг эхлүүлэх, мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох зохицуулалтыг тусгасан Зөвшөөрлийн тухай хууль 2023 оны нэгдүгээр сараас хэрэгжиж эхэлнэ. Мөн хөтөлбөрийг боловсруулахад удирдамж болох ажил мэргэжлийн стандарт, ажил мэргэжлийн лавлах, мэргэжлийн чадамжийн иж бүрэн гарын авлагыг хөтөлбөр боловсруулах үндсэн эх сурвалж болгон ашиглана.

Хөтөлбөрийг боловсруулахад аргазүйн зөвлөмжөөр хангах, хөтөлбөрийн төсөлд үнэлгээ хийж дүгнэлт гаргах чиг үүргийг МБС-ын Бүсийн аргазүйн төв хариуцан гүйцэтгэнэ. Цаашид энэ чиг үүргийг холбогдох мэргэжлийн зөвлөлтэй хамтран ижил төстэй үүрэг бүхий Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Боловсролын үнэлгээний төвийн ажилтнуудын оролцоотой ажлын хэсэг хэлбэрээр зохион байгуулах нь зохимжтой болно.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийх чанарын үнэлгээг сургалтын байгууллага өөрийн дотоод чанарын баталгаажууллын нэгж, ажилтны хүчээр байнга хийхийн зэрэгцээ зөвшөөрөл олгосон байгууллага, хөндлөнгийн үнэлгээний байгууллагын үнэлгээг тогтсон журмын дагуу



зохион байгуулна. Үүнд мэргэжлийн сургалтын хөтөлбөр, мэргэжлийн боловсролын хөтөлбөрийн хэрэгжилтэд БСШУ-ны сайдын 2012 оны 130 дугаар тушаалаар баталсан шалгуурыг суурь болгон аттестатчилахыг сэргээх, харин техникийн боловсролын хөтөлбөрт БМИҮЗ-ийн хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, процессийг ашиглана.

Хөтөлбөрийн үр дүнг үнэлэхэд суралцаж төгсгөгчдийн эзэмшсэн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлэх талаар тогтсон практикийг үндэс болгоно. Чадамжийн нэгж, мэргэжлийн боловсролын хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг үнэлэхэд мэргэжлийн холбоодын оролцоотойгоор боловсруулсан ур чадварын сорилыг ашиглан, энэхүү сорил тестийг зохих шаардлага хангасан (холбогдох сургалтанд хамрагдаж мэргэшсэн үнэлээчийн гэрчилгээ авсан мэргэжилтэн, тест авах анги танхим, техник багаж хэрэгсэл, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах журам хэм хэмжээ тогтсон) МБСБ-ын хүрээнд зохион байгуулахыг дэмжинэ. Мэргэжлийн болон техникийн боловсролын хөтөлбөрийн төгсгөлд мэргэжлийн холбоо, ажил олгогчийн төлөөлөл бүхий Улсын шалгалтын комисс байгуулж болно. Техникийн боловсролын хөтөлбөрөөр суралцагчид төгсгөлтийн дипломын ажил бичиж хамгаалахыг дэмжинэ.

Хөтөлбөрийн үр дүнг үнэлэх нэг чухал хэрэгсэл нь төгсгөгчдийг мөшгих судалгаа болно. Энэхүү судалгааг МБСБ бүр байнга хийж хэвшсэн байхын хамт энэхүү аргачлалын *Г. Мэргэжлийн боловсрол, сургалтын үр дүнг бүс нутаг, улс орны хэмжээнд хянан шинжилж, дүгнэх шалгуур үзүүлэлт, аргазүй* хэсэгт дурдсан 4, 5, 6, 7, 9 дүгээр шалгуур үзүүлэлтэд харгалзах мэдээллийг цуглуулж боловруулалт хийхийг чухалчилна. Энэ судалгааг эрхлэн хариуцах ажилтнуудыг сургах, мэдээлэл цуглуулах механизмыг бүрдүүлэх, үүнд шаардагдах санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг баталгаажуулахад эрх бүхий байгууллага, төслийг дэмжигчдийн хамтын үйл ажиллагаа, дэмжлэг хэрэгтэй болно.

#### **Б. Мэргэжлийн боловсрол, сургалтын Багшийн ажлын чанарыг үнэлэх шалгуур, аргазүй**

	<i>Мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн багш</i>	<i>Мэргэжлийн боловсролын хөтөлбөрийн багш</i>	<i>Техникийн боловсролын хөтөлбөрийн багш</i>
<i>Багшаар ажиллуулахад тавих шаардлага, шалгуур</i>	Харгалзах мэргэжлийн зэрэг	Харгалзах мэргэжлийн дээд боловсролтой (бакалавр), үйлдвэрлэлийн ажлын туршлага + багшлах эрх	Харгалзах мэргэжлийн дээд боловсрол (магистр) + багшлах эрх
<i>Багшийн ажлын гүйцэтгэлд тавих шаардлага, шалгуур</i>	Аттестатчилал: - сургалтын үр дүн - мэргэшлийн ахиц	Аттестатчилал: - сургалтын ахиц, үр дүн - суралцагчийг хөгжүүлэх төлөвшүүлэх ажлын ахиц, үр дүн - ур чадвар, мэргэшлийн ахиц - мэргэжлийн хүрээнд байр суурь, хувь нэмэр	Үр дүнгийн үнэлгээ, аттестатчилал: - сургалтын ахиц, үр дүн - суралцагчийг хөгжүүлэх төлөвшүүлэх ажлын ахиц, үр дүн - ур чадвар, мэргэшлийн ахиц - мэргэжлийн хүрээнд байр суурь, хувь нэмэр - судалгаа, инновацийн үр дүн

Мэргэжлийн боловсрол, сургалтын багшийн мэргэшил, эрхлэх ажлын агуулга, ачааллыг тодорхойлоход МБС-ын үндэсний зөвлөлийн 2020 оны 1 дүгээр тогтоолоор баталсан *"Техник*

мэргэжлийн боловсролын багш” ажил мэргэжлийн лавлах, Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 284/А375 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшийн сургалтын ажлыг багц цагаар тооцох журам”-ыг үндэслэнэ. Удирдамжийн хүрээнд багшийн ажлын агуулга, ачааллыг хариуцах ажил үүргийн мөн чанартай нийцүүлэн, гүйцэтгэлд суурилсан үр дүнгийн үнэлгээ хийх арга замыг тодорхойлно. Тухайлбал, онолын болон мэргэжлийн мастер багшийн мэргэшил, эрхлэх ажлын агуулгыг хөтөлбөртэй нийцүүлэх, мэргэшлийн зэрэг олгож буй практикийн үр нөлөөг үнэлэн тогтооно. Техникийн боловсролын хөтөлбөрийн багшид тавих шаардлага, гүйцэтгэлийн үнэлгээг дээд боловсролын хөтөлбөрийн багшид тавьж буй шаардлага, үнэлгээний практиктай харьцуулан дүгнэнэ. Багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ тухайн багшийн ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээний нөхцлийг суурь болгох тул тухайн сургалтын байгууллагын дүрэм, дотоод журам болон бусад баримт бичигт үндэслэн сургуулийн захиргаа, тэнхим, нэгжийн үнэлгээ болон холбогдох мэргэжлийн байгууллагын хөндлөнгийн үнэлгээг тооцож болно. Ялангуяа сүүлийн жилүүдэд мэргэшлийн зэрэг олгох мэргэжлийн холбоо, нийгэмлэгийн аттестатчилал, австралийн TAFE IV түвшний гэрчилгээ олгох сургалтанд мэргэжлийн боловсрол, сургалтын багш нар хамрагдах нь нэмэгдэж байгааг урамшуулан дэмжих чиглэл баримтлах нь үр дүнтэй юм.

**В. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагааны чанарыг үнэлэх шалгуур, аргазүй**

	<i>Мэргэжлийн сургалтын байгууллага</i>	<i>Мэргэжлийн боловсролын байгууллага - МСҮТ</i>	<i>Техникийн боловсролын байгууллага – Политехник коллеж, коосен</i>
<i>Үйл ажиллагааг эхлүүлэхэд тавих шаардлага, шалгуур</i>	MNS 6541:2015 стандарттай нийцлийг үнэлэх: Улсын бүртгэл - байгуулах үндэслэл, тооцоо; - сургалтын төлөвлөгөө; - багшлах бүрэлдэхүүн, тэдний боловсрол, мэргэшил; - сургалтын барилга байгууламж, техник хэрэгсэл, ном, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн; - санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх баталгаа	MNS 6541:2015 стандарттай нийцлийг үнэлэх: Тусгай зөвшөөрөл - байгуулах үндэслэл, тооцоо; - сургалтын төлөвлөгөө; - багшлах бүрэлдэхүүн, тэдний боловсрол, мэргэшил; - сургалтын барилга байгууламж, техник хэрэгсэл, ном, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн; - санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх баталгаа	урьдчилсан магадлан итгэмжлэлийн дүгнэлт: Тусгай зөвшөөрөл - байгуулах үндэслэл, тооцоо; - сургалтын төлөвлөгөө; - багшлах бүрэлдэхүүн, тэдний боловсрол, мэргэшил; - сургалтын барилга байгууламж, техник хэрэгсэл, ном, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн; - санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх баталгаа
<i>Үйл ажиллагааны хэрэгжилтэд тавих шаардлага, шалгуур</i>	Аттестатчилал, хяналт шинжилгээ: - Чанарын баталгаажуулал: шаардлагатай мэдээ мэдээллийн бүрдэл, боловсруулалт, ашиглалт - үйл ажиллагааг хэвийн, тогтвортой явуулах сургалтын орчин, санхүүгийн боломж бүрдүүлсэн - Хүний нөөц: багш ажилтны ажлын хуваарь, ачаалал зохимжтой, бүтээлч,	Аттестатчилал/ Тусгай зөвшөөрлийн хяналтын үзүүлэлтийн үнэлгээ: - Засаглал, стратегийн удирдлага: шийдвэрийн үндэслэл нотолгоотой, холбогдох талуудад ойлгомжтой, дэмжлэг хүлээсэн, хэрэгжих баталгаа бүрдсэн - Чанарын баталгаажуулал: шаардлагатай мэдээ мэдээллийн бүрдэл, боловсруулалт, ашиглалт	Магадлан итгэмжлэл, Чанарын удирдлагын стандарт: - Засаглал, стратегийн удирдлага: шийдвэрийн үндэслэл нотолгоотой, холбогдох талуудад ойлгомжтой, дэмжлэг хүлээсэн, хэрэгжих баталгаа бүрдсэн - Чанарын баталгаажуулал: шаардлагатай мэдээ мэдээллийн бүрдэл, боловсруулалт, ашиглалт

	<p>хамтач, үр бүтээлтэй ажиллагааг дэмжсэн урамшууллын систем тогтсон</p> <p>- Түншлэл: хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх бүх шатанд зохимжтой оролцоо, хамтын ажиллагаа, итгэлцэл тогтсон</p> <p>- Аюулгүй ажиллагаа: сургуулийн орчин, бүхий л үйл ажиллагаанд аюулгүй байдлын мэдрэмж, эрсдлийг бууруулах мэдлэг баримжаа хэвшсэн</p>	<p>- үйл ажиллагааг хэвийн, тогтвортой явуулах сургалтын орчин, санхүүгийн боломж бүрдүүлсэн</p> <p>- Суралцагчдын сонирхол, онцлогийг тусгасан үйлчилгээ</p> <p>- Хүний нөөц: багш ажилтны ажлын хуваарь, ачаалал зохимжтой, бүтээлч, хамтач, үр бүтээлтэй ажиллагааг дэмжсэн урамшууллын систем тогтсон</p> <p>- Түншлэл: хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх бүх шатанд зохимжтой оролцоо, хамтын ажиллагаа, итгэлцэл тогтсон</p> <p>- Аюулгүй ажиллагаа: сургуулийн орчин, бүхий л үйл ажиллагаанд аюулгүй байдлын мэдрэмж, эрсдлийг бууруулах мэдлэг баримжаа хэвшсэн</p>	<p>- үйл ажиллагааг хэвийн, тогтвортой явуулах сургалтын орчин, санхүүгийн боломж бүрдүүлсэн</p> <p>- Суралцагчдын сонирхол, онцлогийг тусгасан үйлчилгээ</p> <p>- Хүний нөөц: багш ажилтны ажлын хуваарь, ачаалал зохимжтой, бүтээлч, хамтач, үр бүтээлтэй ажиллагааг дэмжсэн урамшууллын систем тогтсон</p> <p>- Түншлэл: хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх бүх шатанд зохимжтой оролцоо, хамтын ажиллагаа, итгэлцэл тогтсон</p> <p>- Аюулгүй ажиллагаа: сургуулийн орчин, бүхий л үйл ажиллагаанд аюулгүй байдлын мэдрэмж, эрсдлийг бууруулах мэдлэг баримжаа хэвшсэн</p>
<p><i>Үйл ажиллагааны үр дүнг дүгнэхэд тавих шаардлага, шалгуур</i></p>	<p>Үйл ажиллагааны тайлан: төгсгөгчдийн ур чадвар, хөдөлмөр эрхлэлт</p>	<p>Гүйцэтгэлийн гэрээний биелэлт: KPI</p> <p>- төгсгөгчдийн ур чадвар, хөдөлмөр эрхлэлт</p> <p>- түншлэлийн үр өгөөж</p>	<p>Гүйцэтгэлийн гэрээний биелэлт: KPI</p> <p>- төгсгөгчдийн ур чадвар, хөдөлмөр эрхлэлт</p> <p>- түншлэлийн үр өгөөж</p>

МБС-ын үйл ажиллагааны чанарыг үнэлэхэд сургалтын хөтөлбөрийг төв болгох бөгөөд энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн зорилго, чиг үүрэгтэй байгууллагын хувьд сайн засаглал, чанарын удирдлагын үр нөлөөтэй зарчим, стандартыг бүтээлчээр сонгон хэрэглэх боломжийг өргөжүүлж, урамшуулан дэмжихийг чухалчилна. Чанарын хөндлөнгийн үнэлгээний хэрэгслийг хөтөлбөрийг онцлогийг харгалзан ялгамжтай хэрэглэх бөгөөд давхардуулагүй, ижил төстэй зарчим, шалгуураар гаргасан үнэлгээ, дүгнэлтийг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцлийг холбогдох байгууллагууд зөвшилцөн тогтооно. Энэ зорилгоор зарим сургуулийн санаачлан нэвтрүүлж буй чанарын удирдлагын олон улсын болон үндэсний стандартыг магадлан итгэмжлэл, аттестатчиллын үнэлгээний шалгуур үзүүлэлттэй адилтган тооцох боломжийг бүрдүүлнэ.

**Г. Мэргэжлийн боловсрол, сургалтын үр дүнг бүс нутаг, улс орны хэмжээнд хянан шинжилж, дүгнэх шалгуур үзүүлэлт, аргагүй**

Улс орон, бүс нутаг, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын түвшинд мэргэжлийн боловсрол, сургалтын үр дүнг хянан шинжилж, үнэлж дүгнэхэд олон улсын хэмжээнд нийтлэг хэрэглэж буй шалгуур үзүүлэлтийг авч үзэх нь олон талын практик ач холбогдолтой. Эдгээрээс Европын Холбооны гишүүн орнуудад ашиглаж буй дараах нийтлэг шалгуур<sup>72</sup> үзүүлэлтийг ажил олгогчид, хөрөнгө оруулагчид, хөгжлийн түншүүдтэй ойлголцож зөвшилцөх, бодлогын шийдвэр гаргах, бусад улс оронтой харьцуулах мэдээллийн суурь болгон сонгохыг санал болгож байна.

**Хүснэгт 2. Европын холбооны МБС-ын чанарын баталгаажууллын байгууллага EQAVET-ийн шалгуур үзүүлэлт**

<b>Шалгуур үзүүлэлт 1</b> Чанарын баталгаажууллын систем нь МБСБ-ын практикт тохирч байгаа эсэх:	(a) холбогдох хууль тогтоомж, баримт бичигт тодорхойлсон дотоод чанарын баталгаажууллын зарчим, зөвлөмжийг сайн дурын үндсэн дээр ашиглаж хэрэгжүүлж буй МБСБ-ын эзлэх хувь; (b) магадлан итгэмжлэгдсэн МБСБ, хөтөлбөрийн эзлэх хувь.
<b>Шалгуур үзүүлэлт 2</b> Багш, сургагчдад зориулж буй хөрөнгө:	(a) мэргэшлээ дээшлүүлэх сургалтанд хамрагдсан багш, сургагчдын хувийн жин (b) үүнд зориулсан хөрөнгийн хэмжээ
<b>Шалгуур үзүүлэлт 3</b> МБС-ын хөтөлбөрт хамарч буй хувь хэмжээ:	МБС-ын хөтөлбөрт суралцагчид <sup>(1)</sup> , хөтөлбөрийн төрөл, суралцагчдын ялгаатай байдлаар ангилан харуулсанаар <sup>(2)</sup> <sup>(1)</sup> МБС-нд анх удаа хамрагдаж буй бол: 6 долоо хоногоос дээш хугацаагаар сургалтанд хамрагдаж буй бол суралцагч гэж тооцно. Насан туршийн боловсролын хөтөлбөрийн тухайд: албан ёсны МБС-ын хөтөлбөрт элссэн хүний эзлэх хувь. <sup>(2)</sup> суралцагчийн нас, хүйсээс гадна нийгмийн байдлыг нь илтгэх бусад үзүүлэлт, жишээлбэл, сургуулиас эрт завсардсан, эзэмшсэн боловсрол, дүрвэгч, хөгжлийн бэрхшээлтэй, ажилгүй байсан хугацаа зэрэг үзүүлэлтээр ангилан үзүүлэх.
<b>Шалгуур үзүүлэлт 4</b> МБС-ын хөтөлбөрийг төгсгөгчдийн хувь хэмжээ:	МБС-ын хөтөлбөрийг амжилттай дүүргэсэн/орхисон хүний тоог хөтөлбөрийн төрөл, хувь хүний ялгаатай байдлаар нь ангилан мэдээлэх
<b>Шалгуур үзүүлэлт 5</b> МБС-ын хөтөлбөрийн хүрээнд ажил хөдөлмөрт шилжүүлсэн хувь хэмжээ:	(a) МБС-ын суралцагчид хөтөлбөрөө дүүргээд хаана очиж байгааг суралцсан хөтөлбөрийн төрөл, хувь хүний ялгаатай байдлаар нь ангилан мэдээлэх <sup>(3)</sup> ; (b) хөтөлбөрөө дүүргээд очсон газартаа ажилд орсон хүмүүсийн эзлэх хувь, хөтөлбөрийн төрөл, хувь хүний ялгаатай байдлаар ангилан харуулна <sup>(3)</sup> МБС-нд анх удаа хамрагдаж буй бол: сургалтаа орхисон хүмүүс хаана очиж байгаа тухай мэдээллийг нэмж оруулна.

<sup>72</sup> Энэхүү шалгуур үзүүлэлтийг Европын холбооны МБС-ын чанарын баталгаажууллын байгууллага – EQAVET-аас гишүүн орнууддаа зөвлөмж болгосон хувилбараас авав:  
[https://skillman.eu/wpcontent/uploads/2015/10/EQAVET\\_Indicators\\_Toolkit\\_final.pdf](https://skillman.eu/wpcontent/uploads/2015/10/EQAVET_Indicators_Toolkit_final.pdf).

<b>Шалгуур үзүүлэлт 6</b> Суралцах үедээ эзэмшсэн чадварыг ажлын талбарт хэрэглэж буй байдал:	(a) суралцаж төгсгөөд эзэмшсэн мэргэжлийн тухай мэдээлэл суралцсан хэлбэр, хувь хүний ялгаатай байдлаар (b) төгсгөгчдийн эзэмшсэн ур чадвар/чадамжийн талаар иргэд, ажил олгогчдын сэтгэл ханамж
<b>Шалгуур үзүүлэлт 7</b> Ажилгүйдлийн түвшин <sup>(4)</sup>	хувь хүний ялгаатай байдлаар нь ангилсан мэдээ <sup>(4)</sup> ОУХБ, ЭЗХАХБ-ын тодорхойлолт: 18-60 насны ажил эрхлээгүй, идэвхитэйгээр ажил хайж буй, ажиллахад бэлэн байгаа хүмүүс
<b>Шалгуур үзүүлэлт 8</b> Эмзэг бүлгийн суралцагчид	(a) эмзэг бүлгийн хэмээн бүртгэгдсэн МБС-ын суралцагчид (засаг захиргааны нэгж, оршин суугаа бүсчлэлээр) нас, хүйсээр (b) эмзэг бүлгийн суралцагчдын сурлагын амжилт нас, хүйсээр
<b>Шалгуур үзүүлэлт 9</b> Хөдөлмөрийн зах зээлийн сургалтын эрэлт хэрэгцээг тодруулах механизм	(a) ажлын байрны түвшин бүрээр өөрчлөгдөж байгаа хэрэгцээг тодруулахад ашиглаж байгаа механизмын тухай мэдээлэл (b) эдгээр механизмын үр нөлөөг илтгэх мэдээ мэдээлэл.
<b>Шалгуур үзүүлэлт 10</b> МБС-ын хөтөлбөрт хамрагдахыг дэмжих арга зам	(a) хөтөлбөрт хамрагдахад үзүүлж буй дэмжлэгийн тухай мэдээлэл (b) эдгээр дэмжлэг хэр үр дүнтэй байгааг илтгэх мэдээ мэдээлэл

Эдгээр шалгуур үзүүлэлтээр мэдээ цуглуулах ажлыг сонгон авсан сургууль, хөтөлбөрийн хүрээнд туршилтын журмаар эхлүүлж, холбогдох ажилтнуудад аргазүйн сургалт зохион байгуулах, мэдээлэл цуглуулах, боловсруулахад шаардлагатай хөрөнгийг сургуулийн болон салбарын төсөвт тусгана.

## ХАВСРАЛТ 2

### НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Чанарын баталгаажууллын тогтолцоог бүрдүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэхэд оролцогчид хэрэглэж буй гол нэр томъёог хэрхэн ойлгох талаар саналаа нэгтгэж тодорхойлох нь энэхүү системийн үйл ажиллагаа, түүний үр дүн амжилттай байхын нэн чухал нөхцөл билээ. Бид чанарын баталгаажуулалтай холбогдох доорх нэр томъёог холбогдох хуулиудад тодорхойлсоны дагуу дараах утгаар хэрэглэсэн болохыг тайлбарлаж байна.

**Чанар** – зорилгодоо нийцсэн байх; тухайн сургалтын байгууллага, хөтөлбөрийн чиг үүрэг, үндсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх процессийг үр дүнтэй болгоход чиглэсэн, магадлан итгэмжлэх эсхүл чанарыг баталгаажуулах өөр бусад байгууллагаас тогтоосон, нийтээр хүлээн зөвшөөрсөн стандартыг хангах, түүнд нийцүүлэх нь чанарын илэрхийлэл болно.

**Чанарын баталгаажуулал** – боловсрол, сургалтын систем, байгууллага, түүний хөтөлбөрийн чанарыг үнэлэх (шалган дүгнэх, хянан шинжлэх, баталгаажуулах, үйлчлэх, ахиулан сайжруулах) тасралтгүй үргэлжлэх процесс. Чанарын баталгаажуулалт нь зохицуулах шинжтэй механизм учир сайтар боловсруулсан шалгуурыг ашиглан холбогдох талууд зөвшилцөн тохиролцсон процессор дамжуулан мэдээлэл өгч, дүгнэлт гаргах замаар чанарын төлөөх хариуцлага, түүнийг сайжруулах чиглэлийг тогтоодог.

**Чанарын гадаад (хөндлөнгийн) баталгаажуулал** – боловсрол сургалтын байгууллага, хөтөлбөрийн чанарыг баталгаажуулах байгууллага дундын эсхүл дээд шатны эрх мэдэл бүхий байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа. Энэхүү үйл ажиллагаа нь боловсрол, сургалтын байгууллагын сургалт, судалгаа, захиргааны процессийн гүйцэтгэлийн чанарыг сайжруулахад чиглэсэн олон төрлийн үечилсэн арга хэмжээнээс бүрддэг.

**Чанарыг баталгаажуулах процедур** – боловсрол сургалтын байгууллага, хөтөлбөр, эсхүл боловсролын байгууллагын чанарын менежментийн үйл ажиллагаа нь холбогдох байгууллагаас урьдчилан тогтоосон шалгуур, стандартыг хэрхэн хангаж буйг хөндлөнгийн бие даасан хараат бус мэргэжилтэн үнэлж дүгнэх албан ёсны процесс.

**Магадлан итгэмжлэл** – боловсрол сургалтын байгууллагыг бүхэлд нь, эсхүл түүний тухайлсан хөтөлбөрийн чанарыг засгийн газрын (бус), эсвэл төрөлжсөн бие даасан байгууллага үнэлж дүгнэн, холбогдох чанарын шалгуур, стандартыг хангасан талаар дүгнэлт гаргаж албан ёсоор хүлээн зөвшөөрөх процесс. Энэ процессийн үр дүнд тухайн байгууллага, хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэн эсэх статусыг (тийм/үгүй алин болохыг зааж) албажуулан хүлээн зөвшөөрч, зарим тохиолдолд тодорхой хугацаанд тусгай нөхцөлтэйгээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог.

**Урьдчилсан магадлан итгэмжлэл** – шинээр эхлүүлэхээр төлөвлөсөн хөтөлбөрийн бэлтгэл шатанд уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөхцлийг хангасан болон хангаж байгаа байдлыг үнэлэн дүгнэх зорилготой магадлан итгэмжлэлийн төрөл. Энэ хэлбэрийн магадлан итгэмжлэлийг бүрэн хэмжээгээр хараахан хэрэгжээгүй хөтөлбөрт завсрын үнэлгээ хийх зорилгоор зохион байгуулж болно.

**Төрөлжсөн магадлан итгэмжлэл** – сургалтын хөтөлбөр, сургалтын нэгжийн үйл ажиллагаа нь холбогдох мэргэжлийн боловсрол сургалтын агуулга, стандартад хэрхэн нийцэж буйг энэ чиглэлээр мэргэшсэн магадлан итгэмжлэлийн төрөлжсөн байгууллага үнэлэн дүгнэх процесс.

**Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл** – сургалтын хөтөлбөрийн академик түвшин, энэ хөтөлбөрөөр суралцан төгсгөгчид нь харгалзах мэргэжлийн чадамжийг хэрхэн эзэмшсэнийг үнэлж дүгнэх магадлан итгэмжлэлийн процесс.

**Байгууллагын (сургуулийн) магадлан итгэмжлэл** – боловсрол сургалтын байгууллагын бүх хөтөлбөр, сургалт явагдаж буй талбар, орчин, сургалтыг зохион байгуулж буй арга хэлбэрийг хамруулан бүхэлд нь үнэлж магадлан итгэмжлэх процесс. Гэхдээ тодорхой хөтөлбөрийн чанарын тухайд тусгайлсан дүгнэлт гаргадаггүй.

**Чанарын дотоод (өөрийн) баталгаажуулал (ЧДБ)** – сургалт боловсролын байгууллага, түүний хөтөлбөрөө хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь өөрсдийн тодорхойлсон зорилгод нийцэж, холбогдох эрх бүхий байгууллагаас тогтоосон боловсрол сургалтын ерөнхий болон тодорхой мэргэжилд тавих тусгайлсан стандарт, шаардлагыг хангаж байхад хяналт дүн шинжилгээ хийж шуурхай зохицуулах бодлого, механизмын цогц систем.



## Уулзаж ярилцсан, мэдээлэл солилцсон хүмүүс

- П. Оюунаа, БШУЯ-ны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
- Х. Тамир, БШУЯ-ны Дээд болон мэргэжлийн боловсролын бодлого, зохицуулалтын газрын дарга
- М. Гантуяа, БШУЯ-ны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Боловсролын чанарын үнэлгээний хэлтсийн дарга
- Э. Түмэндэмбэрэл, БШУЯ-ны Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын Мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтсийн дарга
- Д. Адилбиш, БШУЯ-ны Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын Мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтсийн шинжээч
- Ц. Отгонмягмар, БШУЯ-ны Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын Мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтсийн шинжээч
- Ж. Цэцэгжаргал, БШУЯ-ны Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын Мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтсийн шинжээч
- Батсэлэм, БШУЯ-ны Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын Мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтсийн шинжээч
- Ч. Ганцэцэг, БШУЯ-ны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Боловсролын чанарын үнэлгээний хэлтсийн ахлах шинжээч
- Б. Мянган, БШУЯ-ны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч
- Ч. Тунгалаг, Мэргэжлийн боловсрол сургалтын түншлэл ТББ-ын гүйцэтгэх захирал
- Б. Батцэцэг, ХНХЯ-ны ХНХСҮСИ-ийн захирал
- Д. Наранбүлэг, ХНХЯ-ны ХНХСҮСИ-ийн ахлах аргазүйч
- Л. Ганбат, Боловсролын үнэлгээний төвийн захирал
- Оюунбилэг, Боловсролын үнэлгээний төвийн гүйцэтгэлийн үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн
- Г. Энхбат, Ажил мэргэжлийн стандарт, хүний хөгжлийн хүрээнг ТББ-ын гүйцэтгэх захирал
- Д. Энхбаатар, АХБ-ны Хө
- Д. Буяндэлгэр, Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн захирал
- С. Лувсанвандан, Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн чанарын баталгаажуулалт, статистик хариуцсан ахлах ажилтан
- Д. Отгонбузмаа, Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн гадаад харилцааны ажилтан
- Б. Баттогтох, Монгол-Солонгосын политехник коллежийн сургалтын албаны дарга
- Д. Дулаанцэцэг, Хангай МСҮТ-ийн сургалтын албаны дарга

## **ЛАВЛАХ МАТЕРИАЛ, АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ**

### ***Мэргэжлийн боловсрол сургалтад холбогдох хууль, эрх зүйн болон бодлогын баримт бичиг***

Боловсролын тухай хууль, 2002 он

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль (шинэчилсэн найруулга), 2009 он

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль

Зөвшөөрлийн тухай хууль, (шинэчилсэн найруулга), 2022 он

Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль

Хөдөлмөрийн тухай хууль, (шинэчилсэн найруулга), 2021 он

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль

Алсын хараа – 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024 он)

Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр /2016-2021 он/

Монгол Улсын Үндэсний Ажил, Мэргэжлийн Ангилал ба Тодорхойлолт YAMAT-08 (ISCO – 08)  
(Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 16 дугаар тушаал)

MNS 6541:2015. Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага улсын стандарт  
(Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 45 дугаар тогтоолоор баталсан улсын хэмжээнд хэрэглэх заавал мөрдөх үндэсний стандарт)

Мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэшлийн түвшний загвар (Мэргэжлийн боловсрол сургалтын үндэсний зөвлөлийн 2011 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 1 дүгээр тогтоол)

Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд тавих шаардлага, загвар (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн А/104 дүгээр тушаал)

Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журам (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн А97/А231 дүгээр хамтарсан тушаал)

Ажил мэргэжлийн стандарт боловсруулах аргачлал (Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 4 дүгээр тогтоол)

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад бэлтгэх мэргэжлийн чиглэл, индекс (Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2016 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн А/150 дугаар тушаал)

Техникийн боловсрол, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн загвар, тэдгээрт тавигдах шаардлага (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн А/134 дүгээр тушаалын нэг, хоёрдугаар хавсралт)

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшийн сургалтын ажлыг багц цагаар тооцох журам (Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 284/А345 дугаар хамтарсан тушаалын нэг, хоёрдугаар хавсралт)

Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшийн сургалтын цагийн ачааллыг тогтоох, тооцох журам (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн А87 дугаар хамтарсан тушаал)

Суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлэх, дүгнэх журам (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн А506/А266 дугаар хамтарсан тушаалын хавсралт)

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг аттестатчилах журам, Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын аттестатчиллын шалгуур үзүүлэлт (Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2012 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 130 дугаар тушаалын нэг, хоёрдугаар хавсралт)

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага (Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2019 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 5 дугаар тогтоолын хавсралт)

Мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага (Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2016 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 1 дүгээр тогтоолын хавсралт)

MNS ISO 21001:2021 Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо - Шаардлага, хэрэглэх арга зүйн заавар

### ***Холбогдох судалгааны тайлан:***

БСШУСЯ (2020). Монгол Улсын мэргэшлийн үндэсний хүрээ, “Үндэсний мэргэшлийн хүрээг бий болгож дэмжлэг үзүүлэх” багийн үйл ажиллагааны тайлан

Чадамжийн төвүүдийн нөхцөл байдлын үнэлгээний тайлан, GiZ 2019

Чадамжийн төвийн чанарын үнэлгээний шалгуур, БШУЯ, Германы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (GiZ), БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны агентлаг (KOICA)-ийн Түншлэлд суурилсан мэргэжлийн боловсрол сургалт төслийн шугамаар Чанарын менежментийн зөвлөхүүдийн холбоо боловсруулсан, 2022 он

STVET-1 Project Support to Mongolia’s Technical and Vocational Education and Training Sector (2020). *National Qualifications Framework: handbook*, EuropeAID/132815/C/SER/MN: Definitions of qualification, occupation and profession

- Матиас Фон Аселдонк (2016). *Бүсийн арга зүйн төвийн байгууллагын чадавхийн үнэлгээний тайлан*, Үйл ажиллагаа 4.1.2, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам МБС-ын Хэлтэс (ICA of RMCs)
- Кэйс Хамминк (2017). *МБС-ын чанарын баталгаажуулалт ба чанарын удирдлага: бодлого, журам* Европын холбооны ТМБССД-1 төсөл 1.2 Үйл ажиллагаа А 3.1.3 / А 1.4.3/А.1.4.1 (ХНХЯ, МБМИҮЗ, Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон, Булган аймгууд дахь БАЗТ-үүд болон МСҮТ-үүдтэй хамтран ажиллаж боловсруулсан)
- ETF (2015). *Promoting quality assurance in vocational education and training the ETF approach*, ETF working paper
- ILO (2016). *Compilation of assessment studies on TVET for Lao Democratic Republic, Mongolia, the Philippines, Thailand, and Vietnam* (Souleima El Achkar Hilal (June 2011). *An assessment of the TVET system in Mongolia: Policies, structure, outputs, implications, and recommendations for the country's employment and socio-economic development*)
- International Labour Organization (ILO) (2011). Skills and Employability Programme for Asia and the Pacific (SKILLS-AP)/Japan Regional Workshop on Addressing Skills Mismatch through Public Private Partnerships: Background note, *Mongolia Country Paper and Action Plan, Skills and Employability Network Updates*, June 2011, Issue#2 (Bangkok).
- Interagency Group on Technical and Vocational Education and Training (IAG-TVET) July 2016 Newsletter
- Millennium Challenge Account-Mongolia (MCA-Mongolia) (2009). *TVET Project quarterly progress reports* (Washington, DC).
- Millennium Challenge Account-Mongolia (MCA-Mongolia) (2010). *Labour market study in support of the Technical and Vocational Education Project: Final report* (Ulaanbaatar).
- Millennium Challenge Account-Mongolia (MCA-Mongolia) (2010). *Public perception survey of the Technical and Vocational Education and Training Project: Final report – data and analysis* (Paris).
- Millennium Challenge Account-Mongolia (MCA-Mongolia) (2012) *Concept paper for the quality assurance system for VET in Mongolia*
- Ministry of Education, Culture, and Science (MECS): Chimid, T. (2009). *Mongolia Country Paper for the International Experts' Meeting on Reorienting TVET Policy Towards Education for Sustainable Development*, Berlin, Aug. 2009.
- Ministry of Social Welfare and Labor (MSWL) (2009). *Annual report* (Ulaanbaatar).
- OECD (2010). *Learning for Jobs: Synthesis Report of the OECD Reviews of Vocational Education and Training*
- OECD (2014). *Skills Beyond School: Synthesis Report*, OECD Reviews of Vocational education and training, OECD publishing. <http://dx.doi.org/10.1787/9789264214682-en>
- OECD (2015). *OECD Reviews of Vocational Education and Training: KEY MESSAGES AND COUNTRY SUMMARIES*
- R.Bat-Erdene, J. Sukhbaatar, John Weidman and others (2012). *Assessment of current and future Mongolian education system capacity for Labor Force Supply in Mongolia*
- Saha Meyanathan (2016). *TVET financing in Mongolia*

Susanna Karakhanyan and R.Bat-Erdene (2014). *Mongolia Higher Education Reform Project: Quality Assurance and Accreditation*

World Bank (2010). *Mongolian policy note: Tertiary education in Mongolia*

ММСС ба ШУТИС-ийн УБ хот дахь Политехник коллеж, "Мэргэжлийн сургуулиудын магадлан итгэмжлэлийн анхдагч", УБ, 2011

Матиас Фон Аселдонк (2016). Бүсийн арга зүйн төвийн байгууллагын чадавхийн үнэлгээний тайлан, Үйл ажиллагаа 4.1.2, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам МБС-ын Хэлтэс (ICA of RMCs) Кэйс Хамминк (2017). МБС-ын чанарын баталгаажуулалт ба чанарын удирдлага: бодлого, журам Европын холбооны ТТМБССД-1 төсөл 1.2 Үйл ажиллагаа А 3.1.3 / А 1.4.3/А.1.4.1 (ХНХЯ, МБМИҮЗ, Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон, Булган аймгууд дахь БАЗТ-үүд болон МСҮТүүдтэй хамтран ажиллаж боловсруулав)

Томас Ёо (2018). АХБ-ны хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төслийн олон улсын зөвлөх АХБ-ны хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл (2018). *Төгсгөгчдийн мөшгих судалгаа, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааны тайлан*

Хөдөлмөрийн судалгааны институт (2020). *Төгсгөгчдийн мөшгих судалгаа*

Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын баталгаажууллын бодлогын тойм судалгааны тайлан, Улаанбаатар, 2019

ЮНЕСКО (2019). Монгол Улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ: насан туршийн суралцахуйн тогтолцоог бүрдүүлэх нь ([https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000373687\\_mon](https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000373687_mon))

ЮНЕСКО (2019). Монгол Улсын техник, мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын тойм шинжилгээ ([https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374199\\_mon](https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000374199_mon))

АХБ Loan 3243 MON (SF) – Хөдөлмөр Эрхлэх Ур Чадварыг Дээшлүүлэх Төсөл: Чадамжид Суурилсан Сургалт, Үнэлгээ – Өргөтгөл, Эцсийн тайлан, 2019 он (Эйч Ар Ди Консалтинг Кореа, Эм Си Ди Эс ХХК)

### *Гарын авлага, материал*

Bert Hofma and P.Oyunaа (2017). *TVET Certification: POLICY and GUIDELINES* (drafted by STVET international senior non-key expert and national expert)

Bert Hofma and P.Oyunaа (2017). *TVET Competence Assessment: POLICY and GUIDELINES* (drafted by STVET international senior non-key expert and national expert)

Bert Hofma and P.Oyunaа (2017). *TVET Verification: POLICY and GUIDELINES* (drafted by STVET international senior non-key expert and national expert) ETAS\_OT Assessment Lesson Guide (Үнэлгээний даалгаврын удирдамж) - ETAS\_OT - MNG

ETAS\_OT Assessment Lesson Guide, Planning Assessment Activity and Process (Үнэлгээний даалгаврын удирдамж, Үнэлгээний ү.а ба ү.я-г төлөвлөх) - ETAS\_OT - MNG

GIZ - Monika Ellinger - *Assessment of the Quality of TVET in the partner TVET Schools of the CVT Project*

Kees Hammink (2017). *Quality Assurance and Quality Management in TVET: POLICY and GUIDELINES*, draft version 1.2 (drafted by STVET international senior non-key expert)

Kees Hammink and D. Buyandelger (2017). *TVET Validation of qualifications: Policy procedures* (drafted by STVET international senior non-key expert)

MCA- MNG *Competency Based Training and Assessment* (Чадамжид суурилсан сургалт ба үнэлгээ) - MCA- MNG

MCA- MNG *Concept Paper for VET Quality Assurance System* (МБС Чанарын хяналт, баталгаажилтын тогтолцооны баримт бичиг) - MCA - 2012-05-29 - ENG

MCA- MNG *Final Report on Training Impact Assessment* (Сургалтын үр өгөөжийн үнэлгээ) - 2013-03 - MCA - ENG

SDC *Handout Quality Framework\_Self Assessment* MON-SDC

SDC *Key Task Modell*-SDC

SDC *Key Tasks 1-7\_Results*-SDC

SDC *Quality framework for school quality*-SDC

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл (2015). *Боловсролын магадлан итгэмжлэл, Эрх зүйн баримт бичгүүдийн эмхэтгэл*

БСШУЯ (2015). *Их, дээд сургууль, техникийн болон мэргэжлийн сургуулиудаар бэлтгэж байгаа мэргэжилтэн, мэргэжилтэй ажилчдын мэргэжлийн индекс*

Мэргэжлийн боловсрол, сургалтын газар ба БМИҮЗ (2012). *Мэргэжлийн боловсрол-Магадлан итгэмжлэл, УБ.*

ММСС ба ШУТИС-ийн УБ хот дахь Политехник коллеж (2011). *Мэргэжлийн боловсролын сургалтын магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагууд*

Хөдөлмөрийн яам (2014). *Чадамжид суурилсан сургалтын үнэлгээний гарын авлага, УБ*

Хөдөлмөрийн яам, Темасек сан, Сингапур Политехник (2015). *Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын чанарын баталгааны тогтолцооны удирдамж*

Хөдөлмөрийн яам, Темасек сан, Сингапур Политехник: М.Жадамба нар (2014). *Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын чанарын баталгаа: гарын авлага*

Ажил мэргэжлийн стандарт боловсруулах аргачлал, Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 4 дүгээр тогтоолын хавсралт

Үндэсний аудитын газар (2022). Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн, АГГ/2022/20-ШТА-ГА <https://audit.mn/wp-content/uploads/2022/08/Хөдөлмөр-эрхлэлт-хураангуй-тайлан.сайтад.pdf>

### ***Олон улсын судалгаа, гарын авлага материалууд***

Andrea Batemen (2013). *Qualifications framework and quality assurance of education and training, prepared for the World bank*

ASEAN (2017). *ASEAN qualifications reference framework, briefing paper No1, Qualifications frameworks and quality assurance system,*

- Cedefop (2015). *Handbook for VET providers: Supporting internal quality management and quality culture*. Luxembourg: Publications Office of the European Union. Cedefop Reference series; No 99
- European Training Fund (ETF) (2014). *Quality assurance in vocational education and training: a collection of articles: Making the case for vocational education and training improvement: issues and challenges* by Maria Emília Galvão; *Supporting the implementation of the European Quality Assurance Reference Framework for vocational education and training: the experience of EU-28 and candidate countries* by Sean Feerick and Arancha Oviedo
- ETF (2015). Promoting quality assurance in vocational education and training the ETF approach, ETF working paper
- European Centre for the Development of Vocational Training (CEDEFOP) (2009). *Accreditation and quality assurance in vocational education and training: Selected European Approaches*. Luxembourg: Publications Office of the European Union.
- EUROPEAN COMMISSION (2010). *Fundamentals of a common quality assurance framework for VET in Europe*
- European Quality Assurance in Vocational Education and Training – EQAVET (2011). *VET providers' self-monitoring by using the EQAVET toolbox of indicators (A Guide for National Reference Points)* drafted by Maria Emília Galvão, Expert under contract for the EQAVET Secretariat
- Inter-Agency Working Group on TVET Indicators (2014). *Proposed indicators for assessing technical and vocational education and training*, Working Document
- OECD (2014), *Skills Beyond School: Synthesis Report*, OECD Reviews of Vocational education and training, OECD publishing. <http://dx.doi.org/10.1787/9789264214682-en>
- UNESCO (2010). *Guidelines for TVET Policy Review*.
- UNESCO (2017). *Guidelines for the Quality Assurance of TVET Qualifications in the Asia-Pacific Region*, UNESCO Bangkok Office.
- UNESCO (2017). *Towards Quality Assurance of Technical and Vocational Education and Training*, UNESCO Bangkok Office.
- UNESCO-CEPES (2007). *Quality assurance and accreditation: Glossary of basic terms and definitions*
- UNESCO-UNEVOC International Centre for Technical and Vocational Education and Training (2015). *UNESCO TVET Strategy 2016-2021, Report of the UNESCO-UNIVOC virtual conference*
- UNESCO-UNEVOC (2021). *Medium-Term Strategy for 2021-2023 (MTS-III)*
- Standards for Registered Training Organisations (RTOs), Australia  
<https://www.legislation.gov.au/Details/F2019C00503/Download>